МОНГОЛБАНК

ЖИЛИЙН ТАЙЛАН 2016

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ҮГ

Монголбанкны
Ерөнхийлөгч Н.Баяртсайхан

Эрхэмсэг хатагтай, ноёдоо!

Монголбанкнаас 2016 онд хийж гүйцэтгэсэн ажлаа дүгнэж, жилийн тайлангаа Та бүхэнд танилцуулж байна.

Монгол улсын эдийн засаг 2016 онд томоохон хүндрэлтэй тулгараад байв. Үүнд эдийн засгийн өсөлт огцом буурсан, төсвийн алдагдал нэмэгдсэн, гадаадын хөрөнгө оруулалт хумигдсан, үнэ ханш өндөр хэлбэлзэлтэй байсан, гадаад өр зээлийн дарамт эрс нэмэгдсэн зэрэг асуудлууд байв.

Иймд Монголбанк Сангийн яамтай хамтран Эдийн засгийн хүндрэлийг даван туулах хөтөлбөрийг боловсруулж, УИХ-д өргөн барьсан. УИХ-аас энэхүү хөтөлбөрийг баталснаар эдийн засгийг тогтворжуулах арга хэмжээг цогц байдлаар авч хэрэгжүүлэх бололцоо бүрдсэн болно. Монголбанкнаас энэ хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. **Нэг**, гадаад валютын ханшны уян хатан байдлыг хангах арга хэмжээг авав. Энэ нь Монгол улсын экспортыг урамшуулж, гадаад валютын гадагшлах урсгалыг бууруулж, гадаад валютын нөөцийг тогтвортой түвшинд барихад жинтэй хувь нэмэр үзүүлэв. **Хоёр**, Монголбанкны бодлогын хүүг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан тогтоож байсан нь үр дүнгээ өгөв. Тухайлбал, үнэ ханш огцом хэлбэлзэлтэй үед бодлогын хүүг 4.5 хувиар нэмэгдүүлсэн нь гадаад валютын ханшийг богино хугацаанд тогтворжуулаад зогсохгүй банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэлээ. **Гурав**, өмнөх жилүүдэд гарч байсан бодлогын алдаанд дүн шинжилгээ хийж, Монголбанкны засаглалыг сайжруулах, хараат бус байдлыг дээшлүүлэх үүднээс Төв банкны тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулав. **Дөрөв**, дотоод гадаад төлбөр тооцоог түргэн шуурхай гүйцэтгэх үүднээс холбогдох дэд бүтцийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох үүднээс Үндэсний төлбөр тооцооны тухай хуулийг шинэчлэн боловсруулж, Засгийн газраар дамжуулан УИХ-д өргөн батлуулав. Монголбанкны харьяа Үндэсний төлбөр тооцооны төвийн тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулах, ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх замаар тус төвийн найдвартай бөгөөд тасралтгүй ажиллагааг хангах арга хэмжээг олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байна.

Тайлант онд болсон онцлох үйл явдлын нэг бол Сангийн яам, Монголбанк хамтран ОУВС-тай Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр тохирсон явдал юм. Уг хөтөлбөрийн хүрээнд эдийн засагт тулгараад байсан гол гол хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх, тухайлбал, өрийн дарамтыг бууруулах, үнэ ханшны тогтвортой байдлыг хангах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, төсвийн алдагдлыг зохистой түвшинд барих, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, банк санхүүгийн салбарын

бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тохиролцов. Монгол улстай нийгэм, эдийн засгийн чиглэлээр өргөн харилцаатай улс орнууд санхүүгийн дэмжлэг үзүүлж байгаа нь ОУВС-ийн хөтөлбөр батлагдахад чухал үүрэгтэй байв. Уг хөтөлбөрийн хүрээнд олон улсын санхүүгийн байгууллагуудаас хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл, санхүүжилт олгохоор тохиролцсон нь Монгол улсын гадаад өрийн зохистой бүтцийг хангахад чухал ач холбогдолтой байна.

Эдийн засгийн хүндрэлийг даван туулах хөтөлбөрийг баталж хэрэгжүүлж эхэлсэн, мөн түүнчлэн ОУВС-тай хөтөлбөр тохирсон зэрэг нь эдийн засагт нааштай үр дүнгээ өгч эхэллээ. Жилийн тайланг Та бүхэнд танилцуулах энэ цаг мөчид эдийн засгийн өсөлт сэргэсэн, төсвийн алдагдал буурсан, үнэ ханш болон гадаад валютын нөөцөд ирэх дарамт суларсан зэрэг эерэг үр дүн гарсан байна. Энэ эерэг үр дүнг өргөжүүлэн бататгах бололцоо байгаа бөгөөд үүний тулд төрийн болон хувийн хэвшлийн зүгээс хичээл чармайлт гарган ажиллах шаардлагатай байна. Та бүхний ажилд амжилт хүсье!

Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан

МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ (2016)

ГАРЧИГ

1. МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ 9

1.1 Бодит сектор 9
1.2 Гадаад сектор 13
1.3 Мөнгө, санхүүгийн сектор 19
1.4 Монгол Улсын нэгдсэн төсөв 26

2. ТӨРИЙН МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ 29

2.1 Мөнгөний бодлогын үндсэн зорилт, арга хэмжээ, үр дүн 29
2.2 Банкны салбарын тогвортой байдлыг хангах бодлогын хэрэгжилт 32
2.3 Гадаад валютын улсын нөөцийн удирдлага 33
2.4 Монгол улсын үндэсний төлбөрийн систем 34
2.5 Банк, санхүүгийн салбарын хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэл 36
2.6 Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр 37

3. МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 41

3.1 Төв банкны үнэт цаас 41
3.2 Төв банкны санхүүжилт 41
3.3 Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ) 42
3.4 Гадаад валютын дуудлага худалдаа 43
3.5 Дотоод зах зээлээс алт худалдан авах үйл ажиллагаа 45

4. МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮГИЙН ТАЙЛАН 47

4.1 Монголбанкны үйл ажиллагаа 47
4.2 Гадаад харилцаа 47
4.3 Олон нийттэй харилцах харилцаа 48
4.4 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээ 49
4.5 Дотоод аудит 51
4.6 Эрсдэлийн удирдлага 52
4.7 Бэлэн мөнгөний хангалт 53
4.8 Мэдээллийн технологи 53
4.9 Монголбанкнаас 2016 онд баталсан эрх зүйн баримт бичгүүд 54

5. АУДИТААР БАТАЛГААЖСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН 57

6. СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТУУД 157

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

1

1.1 БОДИТ СЕКТОР

Эдийн засгийн бодит сектор

Монгол Улсын бодит дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий өсөлт 2016 онд өмнөх оноос 1.4 нэгж хувиар буурч, 1.0%-тай гарлаа. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлтийн дийлэнх хувийг бүрдүүлж байсан уул уурхайн салбарын өсөлт 2016 онд өмнөх оноос 13 орчим нэгж хувиар огцом саарч 0.7%-д хүрээд байна. Харин өмнөх онд уналттай байсан уул уурхайн бус салбарын өсөлт 2016 онд сэргэж 1.1%-д хүрэв (Зураг 1).

Эдийн засгийн өсөлтөд нийлүүлэлт буюу үйлдвэрлэл талаас тээвэр, хөдөө аж ахуйн салбарууд нийт өсөлтийг сааруулах нөлөө үзүүлжээ. Тодруулбал, эдийн засгийн өсөлтөд тээвэр, агуулах хамгийн өндөр буюу 0.9 нэгж хувь, хөдөө аж ахуй 0.6 нэгж хувь, уул уурхай болон бусад үйлчилгээ[1] тус бүр 0.2 нэгж хувь, эрчим хүч болон бүтээгдэхүүний цэвэр татвар[2] тус бүр 0.1 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлсэн бол нөгөөтэйгүүр, барилга 0.6 нэгж хувь, худалдаа 0.4 нэгж хувь, боловсруулах 0.1 нэгж хувийн сөрөг нөлөө тус тус үзүүлсэн байна (Зураг 2).

Уул уурхайн салбарын өсөлтийг нүүрс, алт болон төмрийн хүдэр, баяжмалын олборлолт голлон бүрдүүлсэн бол зэсийн баяжмал, газрын тосны олборлолт өсөлтийг сааруулах нөлөө үзүүлжээ. Тухайлбал, 2016 онд нүүрсний олборлолт 35.4 сая тонн (46.7%), алтны олборлолт 18.4 тонн (26.7%), төмрийн хүдэр, баяжмалын олборлолт 7.1 сая тонн (15.8%)-д хүрч өмнөх оноос нэмэгдсэн бол газрын тосны олборлолт 8.2 сая баррел (-5.9%) болж буурсан. Оюу толгойн зэсийн баяжмал дахь металлын агууламж үлэмж хэмжээгээр багассан уул уурхайн салбарын нийт өсөлт сөрөг гарахад голлон нөлөөллөө.

Зураг 1. **Бодит ДНБ-ий өсөлт /уул уурхайн ба уул уурхайн бус/**

Зураг 2. **Бодит ДНБ-ий өсөлт /үйлдвэрлэлийн салбаруудаар/**

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эдийн засгийн өсөлтийг эрэлт буюу эцсийн ашиглалт талаас авч үзвэл бараа, үйлчилгээний экспорт хамгийн их буюу 9.4 нэгж хувь, хөрөнгө оруулалт 3.6 нэгж хувь, Засгийн газрын хэрэглээ 1.2 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлсэн бол бараа, үйлчилгээний импортын өсөлт 8.1 нэгж хувь, өрхийн хэрэглээний бууралт 5.1 нэгж хувийн бууруулах нөлөө үзүүлсэн (Зураг 3).

[1] Бусад үйлчилгээний салбаруудын өсөлтийн дийлэнх хувийг санхүү, даатгалын болон үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны өсөлт бүрдүүлдэг.

[2] Бүтээгдэхүүний цэвэр татварт улсын нэгдсэн төсөвт төвлөрч буй НӨАТ, онцгой албан татвар болон гаалийн албан татвараас гадна татаасууд багтдаг.

Зураг 3. **Бодит ДНБ-ий өсөлт /эцсийн ашиглалтын бүрэлдэхүүнээр/**

Зураг 4. **Эцсийн ашиглалтын бүрэлдэхүүнүүдийн өсөлт**

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Сүүлийн 6 жилийн турш эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлж байсан өрхийн хэрэглээ 2016 онд өмнөх оноос 8.8%-иар буурсан. Энэ нь өрхийн орлого буурч, улмаар өрхүүдийн хүнсний бараа, бүтээгдэхүүнд зарцуулж буй зардал голлон буурсантай холбоотой байна.[3] Харин Засгийн газрын хэрэглээ 2016 онд бодит дүнгээр өмнөх оноос 8.9%-иар өсөхөд оны эхний хагаст төсвийн тэлэх бодлого хэрэгжүүлж, улсын нэгдсэн төсвийн бараа, ажил үйлчилгээний зардал нэрлэсэн дүнгээр өмнөх оноос 12.9%-иар, урсгал шилжүүлэг 41.7%-иар тус тус нэмэгдэж, улсын өрийн ДНБ-д эзлэх хувь (цэвэр өнөөгийн үнэ цэнээр) 79.4% болж, өнөх оноос 27 нэгж хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна .

Сүүлийн 2 жилийн турш эдийн засгийн өсөлт саарахад голлох нөлөө үзүүлж байсан хөрөнгө оруулалт буюу нийт хуримтлал 2016 онд бодит дүнгээр өмнөх оноос 14.3%-иар өссөн. Үүнд: материаллаг эргэлтийн хөрөнгийн өсөлт дийлэнх буюу 10.6 нэгж хувь, үндсэн хөрөнгийн хуримтлалын өсөлт 3.7 нэгж хувийг бүрдүүлсэн. Түүнчлэн Засгийн газрын хөрөнгө оруулалтын зардал 2016 онд нэрлэсэн дүнгээр өмнөх оноос 65%-иар нэмэгдсэн нь нийт хөрөнгө оруулалтын өсөлтийг тайлбарлах том хүчин зүйл болсон.

Гадаад худалдааны үзүүлэлтүүдийг авч үзвэл бараа, үйлчилгээний экспорт болон импорт 2016 онд бодит дүнгээр өмнөх оноос тус бүр 13-15%-иар өслөө. Нүүрс, алтны экспорт 2016 онд өмнөх оноос 70-80%-иар огцом өссөн бол үйлчилгээний импортын өсөлөөр нийт бараа, үйлчилгээний импортын өсөлтийг тайлбарлаж байна (Зураг 4).

Эрдэс баялгийн бус сектор

Уул уурхайн бус салбарын 2016 оны өсөлтийг тээвэр, хөдөө аж ахуйн салбарууд голлон бүрдүүлсэн бол барилга, худалдааны салбарууд өсөлтийг сааруулах нөлөө үзүүллээ.

Тээврийн салбарын өсөлт 2016 онд өмнөх оноос эрчимжиж 14.8%-д хүрэхэд уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн нөлөөгөөр авто замын тээврээр тээсэн ачаа эргэлт 27.3%-иар, төмөр замын тээврээр тээсэн ачаа эргэлт 8.5%-иар тус тус өссөн нь нөлөөлсөн (Зураг 2).

Сүүлийн жилүүдэд тогтмол 10 гаруй хувийн өсөлттэй байсан хөдөө аж ахуйн салбарын өсөлт 2016 онд удааширч 4.8%-д хүрсэн хэдий ч уул уурхайн бус салбарын өсөлтийг голлон бүрдүүлсэн салбаруудын нэг хэвээр байлаа. Энэ нь газар тариалангийн салбарын үйлдвэрлэл 2016 онд эрчимжсэнтэй холбоотой байсан бөгөөд гантай байсан өмнөх онтой харьцуулахад үр тариа, улаан буудайн хураасан ургац 2.2-2.3 дахин, хүнсний ногооны ургац 30.5%-иар, төмсний ургац 1.0%-иар тус тус нэмэгдсэн (Зураг 1).

[3] ҮСХ-ноос явуулдаг өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны үр дүнгээс авч үзэхэд

Зураг 1. **Хөдөө аж ахуй, аж үйлдвэрлэлийн салбаруудын өсөлт**

Зураг 2. **Үйлчилгээний салбаруудын өсөлт**

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2013 оноос хойш өсөлт нь саарч, уналттай байгаа барилгын салбар 2016 онд 15.9%-иар агшсан нь уул уурхайн бус салбарын өсөлтийг сааруулахад голлон нөлөөлөө. Уг бууралтыг орон сууцны зориулалттай барилгын ажил нэрлэсэн дүнгээр өмнөх оноос 16.0%-иар, авто зам, далан суваг шугам сүлжээ зэрэг инженерийн барилга, байгууламжийн ажил өмнөх оноос 3.7%-иар буурснаар голлон тайлбарлаж байгаа бол худалдаа, үйлчилгээ болон бусад орон сууцны бус зориулалттай барилга, байгууламжийн ажил 2016 онд 2.5%-иар өсч, тус салбарын өсөлтийг тэтгэх нөлөөтэй байлаа (Зураг 1).

Түүнчлэн, сүүлийн 2 жилийн турш идэвхжил нь сулраад байгаа худалдааны салбар 2016 онд 3.2%-иар буурсан нь уул уурхайн бус салбарын өсөлтийг сааруулах нөлөө үзүүлсэн. Үүнд жижиглэн худалдааны борлуулалтын орлого 2016 онд өмнөх оноос нэрлэсэн дүнгээр 7.0%-иар буурсан нь голлон нөлөөлсөн бол бөөний худалдааны орлого нэрлэсэн дүнгээр 1.8%-ийн өсөлттэй гараад байна (Зураг 2).

Инфляци

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэлд инфляцийг нам, дор түвшинд тогтворжуулах хүрээнд Монголбанкнаас дунд хугацааны зорилтыг 7%-д тодорхойлсон бөгөөд инфляци 2016 оны туршид энэхүү зорилтоос доогуур, нам, тогтвортой түвшинд байсан төдийгүй оны сүүлийн хагаст ихэвчлэн дефляцитай байв. Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх жилийн инфляци 2016 оны эцэст улсын хэмжээнд өнгөрсөн оны мөн үеэс 0.8 нэгж хувиар буурч 1.1%, Улаанбаатар хотын хэмжээнд 0.6 нэгж хувиар буурч 0.5%-д хүрлээ. Эдийн засгийн агшилт, ажилгүйдлийн өсөлт, өрхийн орлогын бууралт инфляцийг үргэлжлүүлэн бууруулах нөлөө үзүүлж, махны үнэ оны туршид хямд байж, төрийн зохицуулалттай болон автобензин, шатахууны үнэ өөрчлөгдөөгүй зэрэг хүчин зүйлс нь нийлүүлэлтийн шинжтэй инфляцийг бий болгоогүй байна. Эдгээр нь инфляци 2016 оны туршид нам түвшинд, зарим саруудад дефляцитай гарахад нөлөөллөө..

Хэрэглээний сагснаас үнийн өндөр хэлбэлзэлтэй бараа, бүтээгдэхүүнийг хасч тооцсон суурь инфляци 2016 оны эцэст өнгөрсөн оны мөн үеэс 4.3 нэгж хувиар буурч 0.5%-д хүрлээ. Сүүлийн 2 жилийн туршид хүнсний бараа, бүтээгдэхүүний үнэ, тэр дундаа үнийн өндөр хэлбэлзэлтэй мах, сүү, хүнсний ногооны үнэ саарснаар инфляцийг бууруулах гол нөлөө үзүүлж байв. Эдгээр бүтээгдэхүүний дундаж үнэ 2016 оны туршид өмнөх оны мөн үеэс буурах хандлагатай байсан ч оны эцэст махны үнэ нэмэгдснээс шалтгаалж 0.4%-иар өсч, улмаар суурь болон ерөнхий инфляцийн зөрүү арилсан. (Зураг 2).

Зураг 1. **Улаанбаатар хотын сарын болон жилийн инфляци**

Зураг 2. **Суурь болон ерөнхий инфляцийн зөрүү**

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Улаанбаатар хотын 2016 оны жилийн эцсийн инфляци (0.5%)-ийг бүтцээр нь задлан авч үзвэл мах, махан бүтээгдэхүүн 0.45 нэгж хувь (өмнөх оноос 3.11 нэгж хувиар их), төрийн зохицуулалттай үйлчилгээ 0.04 нэгж хувь (өмнөх оноос 1.40 нэгж хувиар бага), бусад бараа, бүтээгдэхүүний үнэ 0.29 нэгж хувь (өмнөх оноос 1.53 нэгж хувиар бага)-аар тус тус инфляцийг нэмэгдүүлэх нөлөө үзүүлсэн бол махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн 0.06 нэгж хувь (өмнөх оноос 0.58 нэгж хувиар бага), шатахууны үнэ 0.23 нэгж хувь (өмнөх оноос 0.23 нэгж хувиар бага)-аар тус тус инфляцийг бууруулах нөлөө үзүүлжээ. Сүүлийн 16 сарын хугацаанд инфляцийг бууруулах нөлөө үзүүлж байсан хүнсний бараа, бүтээгдэхүүний үнэ 2016 оны эцсээс инфляцийг нэмэгдүүлж эхэлсэн бол хүнснээс бусад бараа, бүтээгдэхүүний үнийн инфляцид үзүүлэх нөлөө сүүлийн 2 гаруй жилийн турш буурсаар 2016 оны эцэст тэг орчимд хүрээд байна.

Зураг 3. **Улаанбаатар хотын жилийн инфляци, бүтцээр**

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Ажил эрхлэлт

Хөдөлмөрийн насны хүн амын тоо 2016 оны эцсийн байдлаар өмнөх оноос 6.7%-иар өсч, 2 сая 54 мянгад хүрлээ. Үүнээс эдийн засгийн идэвхитэй хүн ам нийт ажиллах хүчний 60.4%-ийг эзэлж байгаа бөгөөд уг ажиллах хүчний оролцооны түвшин[4] өмнөх оноос 0.1 нэгж хувиар буурсан (Зураг 1). Харин нийт ажиллагчдын тоо 2016 оны эцэст өмнөх оноос 65.3 мянгаар өсч 1 сая 133 мянгад хүрсэн бол нийт ажилгүй иргэдийн тоо өмнөх оноос 10.5 мянгаар нэмэгдэж, улмаар ажилгүйдлийн түвшин 8.6%-д хүрсэн байна (Зураг 2). Ажиллагчдын тооны өсөлт импортын орц бага салбарт харьцангуй өндөр, импортын орц өндөртэй салбарт харьцангуй бага байлаа. Тухайлбал, тайлант онд барилга, тээврийн салбарт ажиллагчдын тоо буурсан бол боловсруулах, хөдөө аж ахуй болон төрийн удирдлагын салбарт ажиллагчдын тоо нэмэгджээ.

[4] Ажиллах хүчний оролцооны түвшин нь эдийн засгийн идэвхтэй хүн амын нийт хөдөлмөрийн насны буюу 15-аас дээш насны хүн амд эзлэх хувийг илэрхийлнэ.

Зураг 1. **Ажиллах хүчний оролцооны түвшин**

Зураг 2. **Ажилгүйдлийн түвшин**

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нийт ажиллагчдыг эдийн засгийн үйл ажиллагааны гол салбаруудаар авч үзвэл 2016 онд 398.9 мянга буюу 35.2% нь үйлчилгээний салбарт, 352 мянга буюу 31.1% нь хөдөө аж ахуйн салбарт, 209.2 мянга буюу 18.5% нь аж үйлдвэрлэлийн салбарт тус тус ажиллаж байна (Зураг 3). Нийт ажиллагчдыг хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжээр ангилан авч үзвэл 621.5 мянга буюу 54.9% нь цалин хөлстэй ажиллагчид, 19.6 мянга буюу 1.7% нь ажил олгогчид, 165.7 мянга буюу 14.6% нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 35.7 мянга буюу 3.2% нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогчид, 287.8 мянга буюу 25.4% нь мал аж ахуй эрхлэгчид тус тус байлаа (Зураг 4).

Зураг 3. **Ажиллагчдын тоо, эдийн засгийн салбараар**

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 4. **Ажиллагчдын тоо, хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжээр**

1.2 ГАДААД СЕКТОР

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн статистикийн 2016 оны гүйцэтгэлээр урсгал ба хөрөнгийн данс 609 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 812 сая ам.долларын ашигтай, статистикийн алдаа ба орхигдуулга -221 сая ам.доллар гарснаар нийт тэнцэл 18.2 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ 2015 оноос 93%-иар буюу 250 сая ам.долларaар буурсан үзүүлэлттэй байна.

Монгол Улс нь 2016 оны 4 дүгээр улиралд ОУВС-гаас гаргасан “Төлбөрийн тэнцэл ба Гадаад хөрөнгө оруулалтын позицийг боловсруулах 6 дугаар аргачлал”-д шилжсэн бөгөөд статистикийн чанар, хамрах хүрээг сайжруулах зорилгоор Монголбанкнаас 2012-2015 оны хооронд хийсэн 20 гаруй түүвэр, судалгаанд үндэслэн 2011 оноос хойшхи статистикийг шинэчилсэн билээ.

Зураг 1. **Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл**

Зураг 2. **Урсгал ба Хөрөнгийн дансны тэнцлийн бүтэц**

Эх сурвалж: Монголбанк

Урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 2016 онд өмнөх оноос 27%-иар буюу 224 сая ам.долларaар буурсан бөгөөд үүнд барааны гадаад худалдааны ашиг 138%-иар буюу 775 сая ам.долларaар өсч, үйлчилгээний худалдааны алдагдал 87%-иар буюу 623 сая ам.долларaар буурсан нь голлон нөлөөлжээ.

Урсгал ба хөрөнгийн дансны алдагдлын ДНБ-д эзлэх хувь 2011-2014 онд дунджаар 40% байсан бол 2015 онд 7%, 2016 онд 5% болж буурсан байна.

Зураг 3. **Санхүүгийн дансны тэнцлийн бүтэц**

Зураг 4. **Гадаадын шууд хөрөнгө оруулалтын бүтэц**

* 2016 оны II-р улиралд "Оюу Толгой" ХХК-ын 4.3 тэрбум ам.доллар арилжааны зээл авж 4.2 тэрбум ам.доллар хөрөнгө оруулагчдийн зээлийг төлсөнг дээрх зургуудад харуулаагүй болно.

Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн дансны тэнцлийн ашиг 2016 онд өмнөх оноос 3%-иар буюу 24 сая ам.долларaар буурч, 812 сая ам.долларт хүрсэн бөгөөд төлбөрийн тэнцлийн статистикийг боловсруулах 6 дугаар аргачлалын нэр томьёоллоор Монгол Улс гадаад эх үүсвэрээс цэвэр дүнгээр зээллэгтэй буюу өр төлбөртэй гарчээ.

Барааны гадаад худалдаа

Монгол Улсын барааны гадаад худалдааны тэнцэл сүүлийн гурван жил дараалан ашигтай гарсан болно. Үүнд 2016 онд ашиг 1558 сая ам.долларт хүрэв.

Хүснэгт 1. **Барааны гадаад худалдааны гүйцэтгэл (сая ам.доллар)**

Төрөл	2014	2015	2016	Өөрчлөлт (16'/15')	
				Мөнгөн дүн	Хувь
Эргэлт	**11,011**	**8,467**	**8,274**	**-192**	**-2%**
Экспорт	5,774	4,669	4,916	247	5%
Импорт	5,237	3,798	3,358	-439	-12%
Тэнцэл	**538**	**872**	**1,558**	**686**	

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Худалдааны тэнцэл ашигтай гарахад импорт 12%-иар буурсан, экспорт 5%-иар өссөн нь тус тус нөлөөлжээ. Хэдийгээр худалдааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 686 сая ам.доллараар сайжирсан ч нийт эргэлт өмнөх оноос 2%-иар буурсан байна.

Экспорт: 2016 онд экспорт 5%-иар буюу 247 сая ам.доллараар нэмэгдсэн нь чулуун нүүрс 413 сая, мөнгөжөөгүй алт 338 сая ам.доллар, тоног төхөөрөмжийн экспорт 79 сая ам.доллараар тус тус өссөнтэй холбоотой байна. Энэ нь дээрх бүтээгдэхүүнүүдийн экспорт биет хэмжээгээр өссөнтэй холбоотой юм.

Алтны үнэ: Алтны үнийн индекс 2016 онд 8%-иар өссөн нь АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн болон дэлхийн улс төр, эдийн засгийн тодорхой бус байдал нэмэгдсэнээр хөрөнгө оруулагчид алтыг ихээр худалдан авах болсонтой холбоотой байна.

Зэсийн үнэ: Дэлхийн зэсийн хэрэглээний 45-50 хувийг бүрдүүлдэг БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2015 онд үргэлжлэн удааширснаас аж үйлдвэрлэл суларч, суурь металын эрэлт буурсан байна. Гэвч 2016 оны 11 дүгээр сард явагдсан АНУ-ын сонгуулийн үр дүнтэй холбоотойгоор тус улсын дэд бүтцийн хөрөнгө оруулалт нэмэгдэх хүлээлт бий болж, улмаар Лондонгийн металын бирж дэх цэвэршүүлсэн зэсийн үнэ 2016 оны 4 дүгээр улиралд өмнөх оноос 22%-иар өсчээ.

Зураг 1. **Дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн индекс (2010/12=1.0)**

Эх сурвлж: Блүмберг

Коксжих нүүрс, төмрийн хүдрийн үнэ: БНХАУ-д хийгдэж буй эдийн засгийн бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор тус улсын хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан нь гангийн үйлдвэрлэл буурах, улмаар түүний эрэлтээр тодорхойлогдох коксжих нүүрсний эрэлт буурахад нөлөөлөв. Гэсэн ч тус улсын Засгийн газрын зүгээс 2016 оны 4 дүгээр улиралд нүүрсний дотоодын олборлолтоо огцом бууруулснаас шалтгаалан Монгол улсаас нийлүүлж буй бүх төрлийн нүүрсний хилийн үнэ, төмрийн хүдрийн үнийн индекс 2016 оны эцэст өмнөх оноос харгалзан 87%, 97%-иар өссөн байна.

Түүхий нефтийн үнэ: Боловсруулаагүй нефтийн үнийн индекс 2016 онд 41%-иар өссөн нь ОПЕК-ийн орнууд болон ОХУ-аар тэргүүлүүлсэн нефть олборлогч 11 улс өдрийн гарцаа 1.2 сая баррелиар бууруулахаар тохирсонтой холбоотой байв.

Хүснэгт 2. **Экспорт, голлох ангиллаар (сая ам.доллар)**

Төрөл	2015			2016			Өөрчлөлт	
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт
1. Уул уурхай		**4,092**	**88%**		**4,238**	**86%**	**146**	**4%**
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	1,478	2,280	49%	1,554	1,606	33%	(674)	-30%
1.2. Чулуун нүүрс	14,426	555	12%	25,607	968	20%	413	74%
1.3. Боловсруулаагүй нефть	8,135	387	8%	7,977	336	7%	(52)	-13%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	5,065	227	5%	6,425	261	5%	33	15%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	11,343	421	9%	19,169	758	15%	338	80%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	84	102	2%	126	144	3%	42	41%
1.7. Жонш, лейцит, нефелинт	280	65	1%	247	59	1%	(7)	-10%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	5	29	1%	6	26	1%	(3)	-10%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	2	14	0%	1	10	0%	(4)	-26%
1.10. Мөнгө /тонн/	54	10	0%	95	39	1%	29	278%
1.11. Бусад	53	2	0%	133	31	1%	30	
2. Мал аж, ахуй		**329**	**7%**		**316**	**6%**	**(13)**	**-4%**
2.1. Амьд мал, малын мах	5	14	0%	9	19	0%	5	37%
2.2. Арьс, шир	340	33	1%	173	24	0%	(9)	-26%
2.3. Малын өлөн гэдэс	0	9	0%	0	7	0%	(2)	-26%
2.4. Ноолуур	7	252	5%	7	242	5%	(10)	-4%
2.5. Ноос, бусад үс, хялгас	14	21	0%	16	22	0%	1	5%
2.6. Бусад	0	1	0%	1	2	0%	1	242%
3. Газар тариалан		**27**	**1%**		**24**	**0%**	**(3)**	**-12%**
4. Аж үйлдвэрлэл		**219**	**5%**		**337**	**7%**	**118**	**54%**
4.1. Хүнс	4	26	1%	9	43	1%	17	67%
4.2. Ноолууран эдлэл	1	25	1%	1	26	1%	1	3%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	1	10	0%	2	20	0%	9	x5
4.4. Уул уурхай	35	78	2%	31	88	2%	9	12%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	4	0%	0	5	0%	1	25%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	1	70	1%	1	148	3%	78	x3
4.7. Бусад	185	6	0%	237	8	0%	2	36%
5. Бусад		**2**	**0%**		**1**	**0%**	**(1)**	**-59%**
Нийт дүн		**4,669**			**4,916**		**247**	**5%**

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк

Импорт: 2016 онд импорт 12%-иар буюу 439 сая ам.долларaар буурахад дараах хүчин зүйлс голлон нөлөөлөв. Үүнд:

- Уул уурхайн салбарт ашиглагддаг тоног төхөөрөмж болон тэдгээрийн сэлбэг, эд ангийн импорт буурав. Энэ өөрчлөлт нь гадаадын хөрөнгө оруулалтын уналттай шууд холбоотой.
- Дотоодын барилгын материалын үйлдвэрлэл нэмэгдсэнтэй холбоотойгоор барилгын материалын импорт 190 сая ам.долларaар буурав.
- Нефтийн бүтээгдэхүүний импорт 174 сая ам.долларaар буурсан нь дэлхийн зах зээл дээрх нефтийн бүтээгдэхүүний үнийн уналттай холбоотой байна.

Хүснэгт 3. **Импорт, голлох ангиллаар (сая ам.доллар)**

Төрөл	2015		2016		Өөрчлөлт	
	Дүн	%	Дүн	%	Дүн	Өсөлт
Хэрэглээний бүтээгдэхүүн	**1,101**	**29%**	**1,159**	**35%**	**58**	**5%**
Түргэн эдэлгээтэй	643	17%	652	19%	9	1%
Хүнс	445	12%	453	13%	*8*	*2%*
Эм, тариа	75	2%	90	3%	*16*	*21%*
Бусад түргэн эдэлгээтэй бараа	123	3%	109	3%	*(15)*	*-12%*
Удаан эдэлгээтэй	459	12%	507	15%	49	11%
Гутал, хувцас, цүнх	49	1%	53	2%	*4*	*8%*
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	94	2%	97	3%	*3*	*3%*
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	254	7%	294	9%	*41*	*16%*
Бусад удаан эдэлгээтэй бараа	62	2%	63	2%	*1*	*2%*
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	**1,447**	**38%**	**1,152**	**34%**	**(295)**	**-20%**
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	757	20%	685	20%	(72)	-10%
Барилгын материал	473	12%	283	8%	(190)	-40%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	218	6%	185	6%	(33)	-15%
Аж үйлдвэрлэлийн орц	**512**	**13%**	**508**	**15%**	**(4)**	**-1%**
Нефтийн бүтээгдэхүүн	**707**	**19%**	**533**	**16%**	**(174)**	**-25%**
Дизель түлш	377	10%	257	8%	(119)	-32%
АИ-92, АИ-95	228	6%	165	5%	(63)	-28%
А-80 болон бусад	103	3%	111	3%	8	8%
Бусад	**29**	**1%**	**6**	**0%**	**(23)**	**-80%**
Нийт дүн	3,798		3,358		(439)	-12%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк

Харин хэрэглээний барааны импортын хувьд өнгөрсөн оны хэмжээнээс 58 сая ам.долларaар өндөр гарсан нь авто машин, түүний сэлбэг хэрэгслийн импорт болон эм тарианы импортын бүтээгдэхүүний үнэ өссөнөөс шалтгаалсан байна.

Үйлчилгээний гадаад худалдаа

Үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 2016 онд өмнөх оноос 87%-иар өсч 1,338 сая ам.долларт хүрлээ.

Үйлчилгээний дансны алдагдал өсөхөд нөлөөлсөн гол хүчин зүйлс нь уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн архитектур, инженер, техник, бизнесийн удирдлагын зөвлөх үйлчилгээний алдагдал 203%-иар өсч 529 сая ам.долларт, санхүүгийн үйлчилгээний алдагдал 294%-иар өсч 205 сая ам.долларт тус тус хүрсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 4. **Үйлчилгээний гадаад худалдаа (сая ам.доллар)**

Үйлчилгээний гадаад худалдааны дансны нэр төрөл	2014	2015	2016	Өөрчлөлт (16'/15')	
				Дүн	%
1. Тээвэр	-190	-106	-176	70	66%
2. Аялал жуулчлал	-258	-176	-166	-10	-6%
3. Барилга, барилгын ажил үйлчилгээ	-91	-81	-137	56	70%
4. Даатгал болон тэтгэврийн үйлчилгээ	-12	-24	-15	-9	-36%
5. Санхүүгийн үйлчилгээ	-100	-52	-205	153	294%
6. Оюуны өмч ашиглах эрхийн төлбөр	-11	-13	-23	9	72%
7. Харилцаа холбоо, компьютер, мэдээллийн үйлчилгээ	-102	-72	-69	-3	-4%
8. Бизнесийн бусад үйлчилгээ	-472	-174	-529	355	203%
13. Бусад үйлчилгээ	-55	-18	-18	1	3%
Нийт үйлчилгээ	**-1289**	**-715**	**-1338**	**623**	**87%**

Эх сурвалж: Монголбанк

Гадаад хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2016 оны эцэст -29,353 сая ам.долларын үлдэгдэлтэй байна. Монгол Улсаас гадагш хийсэн нийт хөрөнгө оруулалтын дүн буюу гадаад актив 4,309 сая ам.доллар, үүний 51%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 30%-ийг гадаад валютын улсын нөөц, 11%-ийг шууд хөрөнгө оруулалт, 6%-ийг багцын хөрөнгө оруулалт, үлдсэн 2%-ийг санхүүгийн дериватив тус тус бүрдүүлж байна.

Монгол Улсад оруулсан гадаадын хөрөнгө оруулалтын нийт дүн 33,662 сая ам.доллар, үүний 48%-ийг шууд хөрөнгө оруулалт, 41%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 11%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 54% буюу 8,851 сая ам.долларыг хувьцаа хэлбэрийн хөрөнгө оруулалт, 46% буюу 7,426 сая ам.долларыг охин компанийн толгой компаниасаа авсан зээл буюу компани хоорондын өглөг, санхүүжилт эзэлж байна.

Хүснэгт 5. **Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц, 2016 оны эцэст (сая ам.доллар)**

А. ГАДААД АКТИВ	**4,309**	**Б. ГАДААД ПАССИВ**	**33,662**
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)	455	1. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)	16,277
2. Багцын хөрөнгө оруулалт	280	2. Багцын хөрөнгө оруулалт	3,631
3. Санхүүгийн дериватив	100	3. Санхүүгийн дериватив	116
4. Бусад хөрөнгө оруулалт	2,178	4. Бусад хөрөнгө оруулалт	13,638
5. Нөөц актив	1,296		
		В. ПОЗИЦ	**-29,353**

Эх сурвалж: Монголбанк

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц 2016 онд өмнөх онтой харьцуулахад 3%-иар буюу 721 сая ам.долларaар нэмэгджээ.

- Гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 4,434 сая ам.долларaар буурч, харин бусад хөрөнгө оруулалтын богино позиц 4,658 сая ам.долларaар нэмэгдсэн;
- Багцын хөрөнгө оруулалтын богино позиц 507 сая ам.долларaар өссөн;
- Гадаад валютын улсын нөөц 2%-иар буюу 27 сая ам.долларaар буурсан.

Хүснэгт 6. **Гадаад хөрөнгө оруулалтын позицын өөрчлөлт (сая ам.доллар)**

Үзүүлэлтүүд	**2014**	**2015**	**2016**	**Өөрчлөлт (16'/15')**	
				Дүн	*%*
Гадаадын шууд хөрөнгө оруулалтын позиц	-19,820	-20,257	-15,822	*-4,434*	*-22%*
Багцын хөрөнгө оруулалтын позиц	-2,659	-2,844	-3,351	*507*	*18%*
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн позиц	-4	-51	-15	*36*	*-70%*
Бусад хөрөнгө оруулалтын позиц	-6,397	-6,802	-11,460	*4,658*	*68%*
Гадаад валютын улсын нөөц	1,650	1,323	1,296	*-27*	*-2%*
Нийт позиц	**-27,230**	**-28,632**	**-29,353**	***721***	***3%***

Гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2016 оны эцэст 24,625 сая ам.доллар болж, өмнөх оноос 8%-иар буюу 1,907 сая ам.долларaар өсөв. Үүнд:

- Оюутолгой компанийн гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан урт хугацаат зээлийн ашиглалт нь бусад секторын гадаад өрийг 117%-иар өсөхөд гол нөлөө үзүүлэв.

- Монгол Улсын Засгийн газрын гадаад эх үүсвэрээс авсан зээл, өрийн бичгийн өсөлтөөс шалтгаалан Засгийн газрын гадаад өр 29%-иар буюу 1,109 сая ам.долларaар өссөн байна.

Хүснэгт 7. **Монгол Улсын нийт гадаад өр (сая ам.доллар)**

Үзүүлэлт	**2014**	**2015**	**2016**	**Өөрчлөлт (16'/15')**	
				Дүн	*%*
Нийт гадаад өр	**21,851**	**22,718**	**24,625**	*1,907*	*8%*
I. Засгийн газар	3,501	3,760	4,869	*1,109*	*29%*
Засгийн газрын гадаад өр/ДНБ (%)	*28%*	*31%*	*41%*	*10.7%*	
II. Төв банк	1,570	1,960	1,791	*-169*	*-9%*
III. Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	1,762	2,129	2,417	*289*	*14%*
Богино хугацаат	357	407	469	*62*	*15%*
Урт хугацаат	1,406	1,721	1,948	*227*	*13%*
IV. Бусад сектор	3,977	3,749	8,121	*4,373*	*117%*
Богино хугацаат	555	326	394	*68*	*21%*
Урт хугацаат	3,421	3,423	7,727	*4,304*	*126%*
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	11,041	11,121	7,426	*-3,695*	*-33%*

Эх сурвалж: ЗГ-ын мэдээллийг Сангийн яам, бусад мэдээллийг Монголбанк боловсруулав.

Засгийн газрын гадаад өр[5]-ийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2013-2015 онуудад 29%-31% хооронд тогтвортой түвшинд байсан бол 2016 онд 41% болж өссөн байна.

1.3 МӨНГӨ, САНХҮҮГИЙН СЕКТОР

Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд

Мөнгөний нийлүүлэлт буюу М2 агрегат өмнөх жилээс 20.2 хувиар өсч 12.1 их наяд төгрөгт хүрэв. Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл 2016 оны эцэст 6.1 хувиар нэмэгдэж (Монголын Ипотетикийн Корпорацид шилжүүлсэн зээлийг оруулснаар) 14.5 их наяд төгрөг болсон байна.

Эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт ийнхүү өсч байгаа нь банкны системийн эх үүсвэрүүд нэмэгдэж, нийт хадгаламж өссөнтэй холбоотой. Үүнд иргэдийн хадгаламжийн өсөлт гол нөлөө үзүүлэв. Тухайлбал, иргэдийн төгрөгийн хадгаламж 826.4 тэрбум төгрөг, гадаад валютын хадгаламж 907.6 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ. Мөн хөрвөх чадвар өндөр М1 мөнгө буюу төгрөгийн харилцах, банкнаас гадуурх мөнгө 24.0 хувиар өслөө.

Зураг 1. **М2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн: актив, пассив**

Дотоод цэвэр актив (ДЦА)-ын жилийн өсөлт 2016 онд 12.3 хувиас 17.2 хувь болж өссөн бөгөөд ДЦА М2 мөнгөний нийлүүлэлтийн 138.0 хувийг бүрдүүлж байна. Харин хөрөнгийн дотогшлох урсгал татарч валютын орох урсгал төдийлөн нэмэгдэхгүй байгаагаас гадаад цэвэр актив (ГЦА)-ын жилийн өсөлт 2015 оныхоос нэмэгдсэн ч 2016 онд 10.1 хувиар буурав.

Зураг 2. **М2 мөнгөний нийлүүлэлтийн бүтэц: актив, пассив**

[5] Олон улсын аргачлалын дагуу Хөгжлийн банкны гадаад өрийг бусад сектор хэсэгт ангилсан болно.

Санхүүгийн байгууллагуудын[6] зээлийн үлдэгдэл өмнөх оноос 9.2 хувиар өсөв. Нийт санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдлийн 63.3 хувь нь хадгаламжийн байгууллагуудын, 15.9 хувь нь Хөгжлийн банкнаас Засгийн газарт шилжүүлсэн, 10.9 хувь Монголын Ипотекийн Корпорацийн, 9.9 хувь нь Хөгжлийн банкны зээл тус тус бүрдүүлж байна.

Банкуудаас шинээр олгосон зээл 2016 онд 18.9 хувиар өсөв. Зээлийн үлдэгдлийг салбараар авч үзвэл, уул уурхай, барилгын салбарт олгосон зээл өмнөх оноос буурсан бол хэрэглээ, цалин тэтгэвэрийн зээл, үл хөдлөх хөрөнгө, санхүү даатгалын салбарт олгосон зээл нэмэгджээ.

Зураг 3. **Санхүүгийн байгууллагуудын зээлийн жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр**

Зураг 4. **Банкуудын шинээр олгосон зээлийн жилийн өсөлт, салбараар**

Банкуудын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2016 онд өмнөх жилээс 1.4 нэгж хувиар өсч 8.5 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь 0.1 нэгж хувиар буурч 7.3 хувьд хүрлээ. Эдийн засгийн салбараар авч үзвэл уул уурхайн чиглэлээр олгосон зээлийн чанар харьцангуй муу байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 81.0 хувь нь төгрөгийн, 19.0 хувь нь валютаар олгогдсон зээл байна.

Санхүүгийн салбар

Улс орнуудын санхүүгийн салбарыг бүтцээр нь авч үзвэл банк эсвэл хөрөнгийн зах зээл дээр төвлөрсөн байдаг байна. Энэхүү бүтцийг банк, банк бус санхүүгийн байгууллага, даатгал, хадгаламж зээлийн хоршоо, үнэт цаасны мэргэжлийн оролцогч компаниудын нийт актив, тайлант хугацааны ашиг, өөрийн хөрөнгө зэрэг олон үзүүлэлтийг ашиглан тодорхойлдог билээ. Манай улсын хувьд санхүүгийн салбарын бүтцийг сүүлийн 2 жилийн тоон мэдээлэлд үндэслэн дээрх үзүүлэлтээр тодорхойлбол банкны салбар нь 2016 оны эцсийн байдлаар санхүүгийн салбарын нийт активын 95.5 хувь, нийт ашгийн 70.1 хувь, нийт өөрийн хөрөнгийн 79.1 хувийг тус тус бүрдүүлж байна.

[6] Санхүүгийн байгууллагууд нь банк, хадгаламж, зээлийн хоршоо, Монголын Ипотекийн Корпораци, Хөгжлийн банк болон банк бус санхүүгийн байгууллагаас бүрдэж байна. Хөгжлийн банкны олгосон улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийг Засгийн газарт 2016 оны эцэст шилжүүлснийг оруулж тооцов.

Хүснэгт 1. **Санхүүгийн салбарын бүтэц, тэрбум төгрөг**

	Актив		Ашиг		Өөрийн хөрөнгө	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
	2016 он					
Банк	25,338	95.5%	176	70.1%	2,936	79.1%
ББСБ	787	3.0%	59	23.5%	578	19.1%
Даатгал	208	0.8%	11.4	4.5%	105.8	3.5%
ХЗХ	113	0.4%	3.8	1.5%	24.3	0.8%
Үнэт цаасны оролцогч	91	0.3%	1.0	0.4%	66.8	2.2%
	2015 он					
Банк	21,521	95.7%	218	79.9%	2,427	80.1%
ББСБ	623	2.8%	46	17.0%	424	14.0%
Даатгал	173	0.8%	7.1	2.6%	94	3.1%
ХЗХ	98	0.4%	2.2	0.8%	21	0.7%
Үнэт цаасны оролцогч	68	0.3%	-0.7	-0.3%	62	2.0%

Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо.

Санхүүгийн салбар нь санхүүгийн байгууллага, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ, зах зээл, хууль эрхзүйн орчин зэрэг олон хэмжээст тогтолцоо юм. Түүнчлэн, санхүүгийн салбарын хөгжлийг санхүүгийн салбарт үүсч буй зардлыг хэрхэн бууруулж байгаагаар нь тодорхойлдог байна. Тухайлбал, мэдээлэл олж авах, гэрээ хэлэлцээрийг хуулийн дагуу хэрэгжүүлэх, санхүүгийн гэрээ хэлцэл, зуучлалаас үүдэлтэй ажил гүйлгээг гүйцэтгэхтэй холбогдсон зардлыг хэрхэн бууруулснаар нь санхүүгийн салбарын хөгжлийг хэмжих боломжтой юм. Санхүүгийн салбарын хөгжлийг хэмжих зорилго бүхий Дэлхийн банкны “Дэлхийн санхүүгийн хөгжлийн тоон мэдээллийн сан (Global Financial Development Database)”-д улс орнуудын санхүүгийн хүртээмж, гүнзгийрэлт, үр ашигт байдал болон тогтвортой байдлыг илэрхийлэх үзүүлэлтийг нэгтгэсэн байна. Тус мэдээллийн сангийн зарим үзүүлэлтийг (2014 оны эцсийн байдлаар) Монгол Улсын санхүүгийн салбарын 2016 оны эцсийн байдлаарх үзүүлэлтүүдтэй харьцуулахад дараах байдалтай байна.

Зураг 1. **Санхүүгийн үйлчилгээний хүртээмж**

(Насанд хүрсэн 100,000 хүн тутам дахь АТМ-ийн тоо)

Зураг 2. **Санхүүгийн гүнзгийрэлт**

(Санхүүгийн салбарын дотоод зээлийн ДНБ-д эзлэх хувь)

Зураг 3. **Салбарын үр ашигт байдал**

(Хадгаламж зээлийн хүүгийн зөрүү)

Зураг 4. **Тогтвортой байдал**

(Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь)

Эх сурвалж: Дэлхийн банк, Global Financial Development Database (GFDD), Монголбанк
Тайлбар: Монгол Улсын хувьд 2016 оны байдлаар тооцсон үзүүлэлтүүдийг тоон мэдээллийн боломжит байдлаас шалтгаалан бусад улс орнуудын 2014 оны тоон мэдээлэлтэй харьцуулсан болно.

Манай улсын хувьд банкны салбарын үйлчилгээний хүртээмж сүүлийн жилүүдэд сайжирч байна. Түүнчлэн санхүүгийн байгууллагуудаас олгосон зээлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ дундаж орлоготой улс орнуудын үзүүлэлтээс харьцангуй өндөр байгаа нь санхүүгийн гүнзгийрэлт өндөр байгааг илтгэнэ. Салбарын үр ашигт байдлыг илэрхийлэх үзүүлэлтүүдийн нэг бол хадгаламж зээлийн хүүгийн зөрүү юм. Түс үзүүлэлт 2016 оны эцсийн байдлаар 6.4 хувь буюу өндөр орлоготой улс орнуудын 2-3 хувийн үзүүлэлтээс ойролцоогоор 2.3 дахин өндөр байгаа ч дундаас дээгүүр орлоготой улс орнуудтай харьцуулахад ойролцоо түвшинд байна. Харин санхүүгийн байгууллагуудын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь хэмжээ сүүлийн 2 жилд дараалан өсч 2016 онд 7.6 хувьд хүрсэн байна.

Монгол Улсын хувьд банкны салбарын хөгжил бусад санхүүгийн байгууллагын хөгжлөөс түрүүлэн олон улсын хөгжлийн түвшинтэй зэрэгцэн хөгжиж байгаа бол банкнаас бусад санхүүгийн салбарын нийт салбарт эзлэх хувь хэмжээ бага түвшинд байсаар байна. Тухайлбал, 2016 оны эцсийн байдлаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээ ДНБ-ий 6.2 хувьд хүрсэн нь өндөр орлоготой улс орнуудтай харьцуулахад 11 дахин бага байгаа, түүнчлэн дундаж орлоготой улс орнуудтай харьцуулахад 9.1 дахин бага үзүүлэлт юм.

Санхүүгийн салбарын тэнцвэртэй хөгжлийг хангахад хууль эрхзүйн орчны хөгжил, санхүүгийн байгууллагуудын институцийн хөгжил, иргэдийн санхүүгийн боловсрол болон орлогын түвшин чухал ач холбогдолтой байдаг байна. Түүнчлэн олон улсын түвшинд хийгдсэн эмпирик судалгаануудаас харахад санхүүгийн салбарын хөгжилд өрсөлдөөн, институцийн тогтолцоо, үүний дотор зээлдүүлэгчийн эрхийг хамгаалах, зээлийн мэдээллийн сангийн хөгжил болон нягтлан бодох бүртгэлийн стандартын хэрэгжилт зэрэг нь санхүүгийн салбарын хөгжилд чухал үүрэгтэй байдаг[7] байна.

[7] "Synthesizing a Giant Literature on Causes and Consequences of Financial Sector Development", Selahattin Selşah Paşalı, World bank (2013)

Монгол Улсын хувьд цаашид санхүүгийн салбарын тэнцвэртэй хөгжлийг хангах үүднээс банкнаас бусад салбарын хөгжлийг дэмжин салбарын бүтцийг өөрчлөх зайлшгүй шаардлага тулгарч байна. Салбарын бүтцийг өөрчлөх ажлын хүрээнд хууль эрх зүйн орчныг сайжруулах, салбарын өрсөлдөөнийг урамшуулах болон иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зэрэг алхмуудыг хийх зайлшгүй шаардлага үүсч байна.

Банкны салбар

Банкны салбарт 2016 оны эцсийн байдлаар нийт 14 банк, 1,492 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 2.8 сая, нийт зээлдэгчдийн тоо 820 мянгад хүрлээ.

Активын бүтэц, өөрчлөлт

Банкны салбарын нийт активын хэмжээ 2016 оны эцэст 25.1[8] их наяд төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 22.2 хувиар буюу 4.6 их наяд төгрөгөөр өслөө. Активын өсөлтөд банкны салбарт байршиж буй мөнгөн хөрөнгө, Засгийн газрын үнэт цаас харгалзан 56.8, 38.6 хувиар тус тус өссөн нь голлох нөлөөг үзүүлжээ (Зураг 1). Нийт активыг бүтцээр нь авч үзвэл 46.0 хувь нь зээл, 21.8 хувь нь мөнгөн хөрөнгө, 14.2 хувь нь Засгийн газрын үнэт цаас, 2.3 хувь нь Төв банкны үнэт цаас, үлдэх 15.7 хувь нь бусад төрлийн хөрөнгө байна (Зураг 2).

Зураг 1. **Активын өсөлт (%)**

Зураг 2. **Активын бүтэц, өөрчлөлт (%)**

Эх сурвалж: Монголбанк

Чанаргүй зээл нэмэгдэж, эрсдэл даах чадвар сулрахад банк зээл олголтоо хумьж, эрсдэл өндөртэй салбарт нэмэлт санхүүжилт олгохоос зайлсхийдэг. Манай орны банкны салбарт энэ чиг хандлага мөн ажиглагдаж байгаа бөгөөд өмнөх оны эцэст зээл нь банкны салбарын нийт активын 53.0 хувийг бүрдүүлж байсан бол 2016 оны эцэст 46.0 хувьд хүрч 7.0 нэгжээр буурлаа. Харин тайлант онд банкууд эрсдэл багатай активууд болох мөнгөн хөрөнгө, Засгийн газрын үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх хандлага ажиглагдсан. Үүний үр дүнд нийт активд эзлэх мөнгөн хөрөнгө, Засгийн газрын үнэт цаасны хэмжээ 21.8, 14.2 хувьд тус тус хүрч өнгөрсөн оноос 4.8, 1.7 нэгж хувиар тус тус нэмэгджээ.

Нийт зээлийн 85.8 хувь буюу 10.5 их наяд төгрөгийн зээл хэвийн, 7.1 хувь буюу 866.6 тэрбум төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, 7.2[9] хувь буюу 879.6 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд тус тус байна (Зураг 3). Эдийн засгийн өсөлт саарснаас шалтгаалан хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл өнгөрсөн оны эцсээс 34.1 хувь, чанаргүй зээлийн хэмжээ 5.0 хувиар тус тус өсчээ.

Тайлант онд төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулрал үргэлжилсэнтэй холбоотойгоор валютаар олгосон зээлийн чанар муудах хандлага үргэлжилж, 2016 оны эцсийн байдлаар төгрөгөөр олгосон нийт зээлийн 5.6 хувь, харин валютаар олгосон нийт зээлийн 13.4 хувь нь чанаргүй ангилалд байна (Зураг 4).

[8] Монголбанкнаас банкуудад хийсэн хяналт шалгалтад үндэслэсэн тохируулгын дараах үр дүн
[9] Монголбанкнаас банкуудад хийсэн хяналт шалгалтад үндэслэсэн тохируулгын дараах үр дүн

Зураг 3. **Зээлийн чанар (%)**

Зураг 4. **Валютын зээлийн чанар (%)**

Эх сурвалж: Монголбанк

2016 онд эдийн засгийн голлох салбарууд болох уул уурхай, барилга, боловсруулах үйлдвэрлэл, худалдааны салбарын зээлийн нийт зээлд эзлэх хувь 6 нэгжээр буурч 40 хувьд хүрсэн бол хэрэглээ, орон сууц санхүүжүүлэх зорилготой иргэдийн зээлийн хувь 4 нэгжээр нэмэгдэн 46 хувьд хүрлээ. Ирээдүйд баялаг бүтээх, нэмүү өртөг бий болгох бодит секторын зээл хумигдаж буй шалтгаан нь аж ахуйн нэгжид олгосон зээлийн эрсдэл нь иргэдийн зээлийн эрсдэлээс харьцангуй өндөр байгаатай холбоотой. Тодруулбал, 2016 оны эцэст аж ахуйн нэгжийн зээлийн 9.7 хувь, иргэдийн зээлийн 3.4 хувь нь чанаргүй болжээ. Түүнчлэн 2016 онд дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ унаснаас шалтгаалан уул уурхайн салбарт олгосон зээлийн 56.1 хувь нь хугацаа хэтэрсэн ангилалд багтсан байна.

Зураг 5. **Зээлийн чанар, эдийн засгийн салбараар (%)**

Эх сурвалж: Монголбанк

*-Зураг 5-д тод өнгөөр илэрхийлсэн нь чанаргүй зээлийн хувь, бүдэг өнгөөр илэрхийлсэн нь хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэмжээг харуулж байна.

Иргэдийн зээл, хадгаламж

Тайлант оны эцсийн байдлаар банкны салбарт иргэдээс татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийн хэмжээ 8.0 их наяд төгрөг, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 8.4[10] их наяд төгрөг байна (Зураг 1). Иргэдэд олгосон зээлийг бүтцээр нь авч үзвэл 31 хувь нь ипотекийн, 28 хувь нь цалингийн, 12 хувь нь жижиг, дунд өрхийн аж ахуйн, 11 хувь нь тэтгэврийн, 5 хувь нь малчны, үлдэх 13 хувь бусад төрлийн зээл байна (Зураг 2). 2016 оны эцсийн байдлаар Монгол Улсын нийт өрхийн тоо 869.8 мянгад хүрч нэг өрхөд дунджаар 9.6 сая төгрөгийн зээл ногдож байна. Үүнтэй холбоотойгоор нэг зээлдэгчид ногдож буй зээлийн хэмжээг 2015[11] оны Монгол Улсын өрхийн дундаж орлого болох 12.6 сая төгрөгтэй харьцуулбал 76.4 орчим хувьтай байгаа нь иргэдийн үүрч буй төлбөрийн дарамт өндөр байгааг харуулж байна.

Зураг 1. **Иргэдийн хадгаламж, зээл (тэрбум ₮)**

Зураг 2. **Иргэдийн зээлийн бүтэц (%)**

Эх сурвалж: Монголбанк

Ашигт ажиллагаа

Банкны салбар 2016 оны эцсийн байдлаар 147.7 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс 22.7 хувиар буюу 51.3 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Ашиг ийнхүү буурахад тайлант онд банкны салбарын нийт орлого 3.8 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 49.0 хувиар өссөн хэдий ч нийт зардал 3.7 их наяд төгрөгт хүрч 55.9 хувиар өссөн нь нөлөөлжээ (зураг 1).

Чанаргүй зээлийн хэмжээнээс шалтгаалан учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах сангийн зардал 635.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 21.7 хувиар буюу 113.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь банкны салбарын нийт зардал нь нийт орлогоос илүү хурдацтай өсөхөд хүргэсэн байна. Үүний үр дүнд банкны салбарын ашигт ажиллагааны үзүүлэлтүүд болох активын болон өөрийн хөрөнгийн өгөөж өнгөрсөн оны мөн үеэс 0.4, 2.0 нэгж хувиар буурч харгалзан 0.8, 6.9 хувь болжээ (зураг 2).

Зураг 1. **Цэвэр ашиг (тэрбум, ₮)**

Зураг 2. **Активын болон өөрийн хөрөнгийн өгөөж (%)**

Эх сурвалж: Монголбанк

[10] Банкуудаас МИК-д худалдсан ипотекийн зээл болон ББСБ-ын иргэдэд олгосон зээлийг оруулан тооцсон болно.
[11] http://1212.mn/statHtml/statHtml.do

Эх үүсвэрийн бүтэц, өөрчлөлт

Банкны салбарын нийт эх үүсвэрийн хэмжээ тайлант оны эцэст 22.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 22.1 хувиар буюу 4.0 их наяд төгрөгөөр өслөө (зураг 1) . Эх үүсвэр ийнхүү өсөхөд банкуудын иргэд, аж ахуй нэгжээс татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийн хэмжээ 12.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 13.6 хувиар буюу 1.5 их наяд төгрөгөөр өссөнөөс гадна банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн хэмжээ 6.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 58.3 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлэв. Банкны салбарын нийт эх үүсвэрийн 56.3 хувийг иргэд аж ахуй нэгж, төрийн байгууллагуудаас татсан харилцах, хадгаламж, 27.2 хувийг банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, үлдэх 16.5 хувийг банкнаас гаргасан үнэт цаас, төслийн санхүүжилт зэрэг бусад төрлийн эх үүсвэрүүд бүрдүүлж байна (зураг 2).

Зураг 1. **Эх үүсвэрийн өсөлт (%)**

Зураг 2. **Эх үүсвэрийн бүтэц (%)**

Эх сурвалж: Монголбанк

Нийт банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн 16.5 хувь буюу 998.3 тэрбум төгрөгийг Монголбанкнаас татсан эх үүсвэр, 51.0 хувь буюу 3.0 их наяд төгрөгийг гадаадын банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, 32.5 хувь буюу 2.0 их наяд төгрөгийг дотоодын бусад банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр бүрдүүлж байна.

1.4 МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Засгийн газрын санхүү

Гадаад, дотоод эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас эдийн засгийн идэвхжил суларч төсвийн орлого тасалдахад хүрсэн, төсвийн нэгдмэл бус байдлаас шалтгаалж төсөвт тусгагдаагүй, төсөвтэй адилтгах зардлууд их хэмжээгээр гарсан, мөн Засгийн газрын бүтэц өөрчлөгдөн төсвийн ерөнхийлөн захирагч нарын хооронд төсвийн зохицуулалт хийх зайлшгүй шаардлага гарсан зэрэгт үндэслэн[12] 2016 оны 9 дүгээр сард улсын төсвийг тодотгосон. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 5,852.1 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 9,519.9 тэрбум төгрөгт хүрч, улмаар төсвийн алдагдал 3,667.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 15.3 хувьтай тэнцэх хэмжээнд гарав.

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2016 онд төсвийн тодотголоос 9.4 хувиар буюу 503.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ч, өмнөх оноос 2.2 хувиар буюу 129.0 тэрбум төгрөгөөр бага байв.

Тайлант онд төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнгийн 85.4 хувийг татварын орлого, үлдсэн 14.6 хувийг татварын бус орлого тус тус бүрдүүллээ. 2016 онд татварын орлого 110.8 хувь, татварын бус орлого 102.1 хувийн гүйцэтгэлтэй гарч төсвийн тодотголоос 487.1 тэрбум болон 17.7 тэрбум төгрөгөөр тус тус давсан. Гэхдээ төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оноос

[12] “Төсвийн тухай хууль”-ийн 6.2.3, 34.1.2, 34.1.4 дэх заалтуудад үндэслэн

буурахад аж ахуйн нэгжийн орлогын албан татвар өмнөх оноос 177.0 тэрбум төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 314.9 тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Нэгдсэн төсвийн нийт зардал

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зардал 2016 оны төсвийн тодотголоор 9,694.4 тэрбум төгрөг байхаар батлагдсанаас 98.2 хувийн гүйцэтгэлтэй буюу 9,519.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 33.4 хувиар буюу 2,381.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэв.

Тайлант онд төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 70.5 хувийг урсгал зардал, 24.2 хувийг хөрөнгийн зардал, 5.3 хувийг цэвэр зээл бүрдүүлсэн. Төсвийн тодотголтой харьцуулахад эргэж төлөгдөх зээл 126.6 тэрбум төгрөг, төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт 75.0 тэрбум төгрөгөөр танагдсан нь нийт зардал төсвийн тодотголоос дутуу гүйцэтгэлтэй гарахад гол нөлөө үзүүлэв.

Өнгөрсөн оны гүйцэтгэлтэй харьцуулахад урсгал зардал 995.3 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 907.9 тэрбум төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээл 478.7 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нийт зардал өнгөрсөн оноос нэмэгдэхэд голлон нөлөөлжээ. Эдгээр нь концесс, векселийн эргэн төлөлттэй холбогдох зардал, “Сайн” хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл, гадаад валютын ханшийн өөрчлөлт болон Засгийн газрын өр нэмэгдсэнтэй холбогдон зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оноос 35.1 хувиар буюу 256.5 тэрбум төгрөгөөр өссөн зэрэгтэй холбоотой юм.

Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Тайлант онд нийт 5,058.3 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаас, 1,778.5 тэрбум төгрөгийн Засгийн газрын зээл шинээр авч, үнэт цаас болон зээлийн үндсэн төлбөрт нийт 2,061.1 тэрбум төгрөг төлөв. Цэвэр дүнгээр 4,775.7 тэрбум төгрөгийн Засгийн газрын зээл болон үнэт цаас шинээр гаргаснаас төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд 3,667.8 тэрбум төгрөг зарцуулж, Засгийн газраас Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд 1.0 их наяд төгрөгийн бичилт хийв.

Зээлийн үйлчилгээний төлбөр, валютын ханшийн өөрчлөлт болон концесс, векселийн төлбөрөөс үүдэн нийт зардлын ихэнх хэсэг нь 2016 оны 4 дүгээр улиралд гарсан. Тухайлбал, нийт хөрөнгийн зардлын 59.5 хувь буюу 1,371.7 тэрбум төгрөг, нийт зээлийн үйлчилгээний төлбөрийн 47.2 хувь буюу 466.1 тэрбум төгрөгийг 4 дүгээр улиралд зарцуулжээ.

ТӨРИЙН МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

2

2.1 МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ҮНДСЭН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2016 оны эцэст 7 хувьд, 2017-2018 онд 5-7 хувьд тогтворжуулсны үндсэн дээр эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг ханган эдийн засаг тогтвортой өсөх нөхцөл бүрдүүлнэ.

Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх жилийн инфляци 2016 оны эцэст улсын хэмжээнд өнгөрсөн оны мөн үеэс 0.8 нэгж хувиар буурч 1.1%, Улаанбаатар хотод 0.6 нэгж хувиар буурч 0.5%-д тус тус хүрлээ. Харин хэрэглээний сагснаас үнийн өндөр хэлбэлзэлтэй бараа, бүтээгдэхүүнийг хасч тооцсон суурь инфляци 2014 оны эцэст 12.6%, 2015 оны эцэст 4.8% байсан бол 2016 оны эцэст 0.5%-д хүрч үргэлжлэн буурчээ. Ийнхүү инфляци 2016 оны туршид улсын болон Улаанбаатар хотын хэмжээнд нам түвшинд байлаа.

Улаанбаатар хотын жилийн инфляци (0.5%)-ийг бүтцээр нь задлан авч үзвэл мах, махан бүтээгдэхүүн 0.45, төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ 0.04, бусад бараа, үйлчилгээ 0.29 нэгж хувиар инфляцийг нэмэгдүүлэх нөлөө үзүүлсэн бол махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн 0.06, шатахуун 0.23 нэгж хувиар инфляцийг бууруулах нөлөө үзүүлжээ. Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн 2016 оны ерөнхий хандлагыг харвал махны үнэ дийлэнх хугацаанд өмнөх оноос бага түвшинд байж инфляцийг бууруулах чиглэлд нөлөөлж байснаас гадна бусад бүлгүүдийн үнийн өсөлт мөн адил саарах хандлагатай байв.

Хэрэглээний сагсан дахь бараа, бүтээгдэхүүнүүдээс худалдаалагддаг бараа 2016 оны туршид инфляцийг бууруулах нөлөө үзүүлж байсан бөгөөд уг нөлөө 3 дугаар улирлаас багасч, оны эцэст инфляцийг бага зэрэг нэмэгдүүлж эхэлсэн нь махны үнийн огцом өсөлттэй холбоотой байв.

Зураг 1. **УБ хотын жилийн инфляци, худалдаалагддаг болон худалдаалагддаггүй бараа, бүтээгдэхүүнээр**

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт 2016 онд саарч, инфляци зорилтот түвшнээс бага, нам дор түвшинд хадгалагдсан нь мөнгөний бодлогыг зөөлрүүлэх нөхцөлийг бүрдүүлж байсан хэдий ч төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулрах дарамт өндөр төдийгүй инфляцийн нам, дор түвшин цаашид хэр тогтвортой үргэлжлэх эсэх талаар тодорхой бус байдал их байв. Ялангуяа, улсын

төсвийн болон төлбөрийн тэнцлийн хосолсон алдагдал, Засгийн газрын гадаад, дотоод өрийн асуудал нь макро эдийн засгийн тогтвортой байдалд эрсдэл дагуулж байлаа.

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2016 оны 1 болон 5 дугаар саруудад мөнгөний бодлогын хүүг харгалзан 1.0, 1.5 нэгж хувиар бууруулж 10.5 хувь болгосон. Инфляци 2016 онд зорилтот түвшинг хангахаар хүлээгдэж байсан нөхцөлд ийнхүү мөнгөний бодлогын төлөвийг сулруулсан нь мөнгө, зээлийн өсөлт, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн бодит секторын идэвхжилийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ байв. Түүнчлэн Мөнгөний бодлогын зөвлөлийн 2016 оны 7 дугаар сарын хуралдаанаар бодлогын хүүг өөрчлөлгүй, хэвээр хадгалах шийдвэр гаргасан нь хувийн хэвшлийн зээлээр дамжуулан мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, бодит секторын идэвхжилийг дэмжих боломжийг хадгалах зорилготой байлаа.

УИХ-ын 2016 оны сонгуулийн өмнө Монголбанк болон Хөгжлийн банкны санхүүжилттэйгээр Засгийн газраас “Сайн” гэх зэрэг хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлсэн нь эдийн засаг дахь төгрөгийн нийлүүлэлтийг их хэмжээгээр нэмэгдүүлсэн. Үүнтэй зэрэгцээд, дотоодын захаас их хэмжээний валют бөөн дүнгээр 6 дугаар сарын сүүлээр гадагшилсан нь гадаад валютын хомсдолыг бий болгож, төгрөгийн ханшид их хэмжээний сулрах дарамтыг үүсгэв. Түүнчлэн ханшийн дарамт нэмэгдэх бүрт төв банк гадаад валютын зах дээр интервенци хийж байсан нь гадаад валютын нөөцийг бууруулж, валютын ханш макро суурь хүчин зүйлстэй нийцгүй, хэт үнэлэгдсэн түвшинд хадгалагдах нөхцлийг бүрдүүлж, улмаар гадаад худалдааны нөхцөлд сөргөөр нөлөөлж байв. Эдгээр хүчин зүйлсийн нөлөөгөөр төгрөгийн гадаад валюттай харьцах ханш 2016 оны 7-8 дугаар саруудад богино хугацааны дотор огцом суларч, улмаар төгрөгийн активын цэвэр өгөөж -6 хувь хүртэл буурсан. Уг бууралт нь цаашлаад банкуудын эх үүсвэрийн долларжилт нэмэгдэж, төгрөгт итгэх итгэл сулрах, улмаар төгрөгөөс зугтаж ам.долларт хөрвөх эрсдэлийг нэмэгдүүлэв.

Иймд Монголбанкнаас эдийн засгийг богино хугацаанд тогтворжуулах, ирээдүйд учрах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангах зорилгоор бодлогын томоохон өөрчлөлтүүдийг авч хэрэгжүүлсэн. Тодруулбал, төсвийн шинж чанартай төв банкны санхүүжилтийг хязгаарлах, валютын ханшийн уян хатан байдлыг хангах, гадаад валютын албан нөөцийг хамгаалах, төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэх, үндэсний мөнгөн тэмдэгтийн хямрал болон банкны салбарын тогтвортой байдал алдагдах зэрэг эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэхийн тулд 2016 оны 8 дугаар сарын сүүлчээр бодлогын цогц арга хэмжээг авсан. Үүнд бодлогын хүүг 4.5 нэгж хувиар нэмэгдүүлж 15 хувьд хүргэх, банк хоорондын захын хүүний коридорыг дээшээ өргөн тэгш бус хэмтэй тогтоох, урт хугацаатай бөгөөд өндөр өгөөжтэй үнэт цаас гаргах замаар үүсч болзошгүй спекуляци довтолгоог бууруулах, зээлийн хүү өсөх дарамтыг бууруулах зорилгоор заавал байлгах нөөцийн урамшууллын хүүг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээнүүд багтсан.

Эдгээр бодлогын цогц арга хэмжээ нь үндэсний мөнгөн тэмдэгтийн болон банкны салбарт үүсч болзошгүй хямралаас сэргийлэхэд үр дүнгээ өгсөн оновчтой арга хэмжээ болсон. Тухайлбал, төгрөгийн харьцангуй өгөөж 2016 оны 9 дүгээр сараас эхлэн эерэг болж, банкуудын төгрөг болон гадаад валютын хадгаламжийн хүүний зөрүү 2016 оны 11 дүгээр сарын байдлаар 3 орчим нэгж хувиар нэмэгдэв. Бодлогын хүүг нэмэгдүүлж, валютын ханшийн уян хатан байдлыг макро суурь нөхцөлтэй нийцүүлэн хангасны үр дүнд төгрөгийн хэт үнэлэгдсэн байдлыг залруулав.

Хэдийгээр төгрөгийн гадаад валюттай харьцах ханш өнгөрсөн оны эцсээс 20 гаруй хувиар суларсан нь импортын үнээр дамжин инфляцийг нэмэгдүүлэх нөлөөтэй байсан ч нөгөөтэйгүүр, энэ нь экспортын болон импорттой өрсөлдөх дотоодын салбаруудыг ханшийн бодлогоор дэмжиж, гадаад валютын урсгал болон гадаад валютын нөөц сайжрах, улмаар гадаад тэнцэл хангагдахад эерэг нөлөө үзүүлсэн. Тухайлбал, экспортын компаниудын борлуулалтын орлого 25 орчим хувиар нэмэгдэж, импортыг орлох салбаруудын бараа, бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн үнэ импортын барааны үнэтэй харьцуулахад 20 орчим хувиар хямдарч, үнийн давуу тал үүссэнээр худалдаалагддаг секторт эерэг нөлөө үзүүлсэн. Олон улсын зах зээл дээр түүхий эдийн үнэ сэргэснээс гадна төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларсан нөлөөгөөр экспорт урамшигдаж, улмаар урсгал тэнцэл 2016 онд ашигтай гарлаа.

Бодлогын цогц арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Монголбанкнаас бодит секторт ирэх дарамтыг аль болох

бага байлгахыг зорьж ажиллав. Энэ хүрээнд банк хоорондын захын хүүний коридорыг тэгш бус хэмтэй тогтоож, төгрөгийн заавал байлгах нөөцөд төлж буй урамшууллын хүүг өсгөх, хөрвөх чадвартай активын өгөөжийг нэмэгдүүлэх замаар банкны зээлийн хүүнд шингэх эх үүсвэрийн зардлыг бууруулах арга хэмжээ авсан. Уг арга хэмжээний хүрээнд банкуудад 25 орчим тэрбум төгрөгтэй тэнцэх заавал байлгах нөөцийн урамшуулал төлсөн нь зээлийн хүү нэмэгдэх дарамтыг ойролцоогоор 0.5-0.7 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлжээ.

Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн дээрх бодлогын цогц арга хэмжээний үр дүн болон тухайн үеийн макро эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж 2016 оны 12 дугаар сард мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлэх чиглэлд өөрчилсөн. Гадаад худалдааны нөхцөл хүлээгдэж байснаас сайжирсан нь гадаад валютын дотогшлох урсгал болон төсвийн орлогыг нэмэгдүүлж, төлбөрийн тэнцэлд эерэг нөлөө үзүүлсэн төдийгүй төсвийн сахилга бат дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017 оны улсын төсвийн тухай хуулийн хүрээнд сайжирсан зэргийг харгалзан үзэж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, бодит секторын идэвхжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор Мөнгөний бодлогын зөвлөлөөс ийнхүү бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулах шийдвэрийг гаргав.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох зарчмыг баримтална.

Монголбанкнаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханш эдийн засгийн суурь нөхцөлд нийцтэй, уян хатан тогтох зарчмыг үргэлжлүүлэн баримталж, шаардлагатай тохиолдолд ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад оролцож ирлээ.

2016 оны 4 дүгээр сард Засгийн газар гадаад зах зээлээс нийт 750.0 сая ам.долларын эх үүсвэрийг зээл, бонд хэлбэрээр бүрдүүлж, үүнээс дотоодын захад нийлүүлсэн нь ханш 6 дугаар сарын дунд хүртэл хугацаанд 5.4 хувиар чангарахад нөлөөлөв. Харин 6 дугаар сарын эцэст гадаад валютын гарах урсгал богино хугацаанд огцом нэмэгдсэн, “Сайн” хөтөлбөрийн хүрээнд 596.0 тэрбум төгрөгийг эдийн засагт нийлүүлсэн нь ханш огцом сулрах нөхцөл байдлыг үүсгэсэн байна.

Улмаар ханшийн сулралт 2016 оны 7, 8 дугаар саруудад дамжирч, төгрөгийн активын цэвэр өгөөж жилийн -5% болж буурсан. Энэ нь эдийн засаг, санхүүгийн систем долларжиж, валютын хямрал үүсч болзошгүй нөхцөл байдлыг үүсгэсэн. Иймд болзошгүй хямралаас сэргийлж, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хадгалах зорилгоор Монголбанкны Захирлуудын зөвлөл 2016 оны 8 дугаар сарын 18-ны өдөр бодлогын хүүг 4.5 хувиар нэмэгдүүлж, 15.0 хувьд хүргэх шийдвэр гаргасан юм. Бодлогын хүүг өсгөснөөр өмнөх 2 сарын хугацаанд 300 орчим төгрөгөөр сулраад байсан ханш 9, 10 дугаар саруудад тогтворжих хандлагатай болсон. Гэвч валютын нөөцийн хүрэлцээт байдал, Хөгжлийн банкны 2017 оны 3 дугаар сард төлөгдөх 580 сая ам.долларын бондын эргэн төлөлттэй холбоотой үүссэн тодорхойгүй байдал зэргээс шалтгаалан ханш оны эцэст дахин суларсан.

Иймд ханшийн огцом хэлбэлзлийг тогтворжуулах зорилгоор Монголбанк 2016 онд 127 удаагийн гадаад валютын дуудлага худалдаагаар 1,706.1 сая ам.доллар валютын захад нийлүүлсэн байна. Үүний зэрэгцээ банк болон тэдгээрийн харилцагчдын ханшийн эрсдэлийг бууруулах, богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт дэмжлэг үзүүлэх зорилгоор санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг идэвхтэй арилжаалж, банкуудтай төгрөг, ам.долларын своп хэлцлүүдийг байгуулж ажиллав. Тухайлбал, 2016 онд давхардсан тоогоор төв банк арилжааны банкуудтай нийт 3,738.5 сая ам.долларын богино хугацаат своп хэлцэл, 358.0 сая ам.долларын урт хугацаат своп хэлцлийг байгуулсан байна. Мөн валютын зах дахь төв банкны оролцоог сайжруулах, санхүүгийн үүсмэл хэрэгслийн үнэлгээг зах зээлийн зарчимд нийцүүлэх зорилгоор Монголбанк 2016 оны 12 сард “Урт хугацаат своп хэлцлийн журам”, “Валютын своп, форвард хэлцлийн журам”-ыг шинэчлэн баталсан.

Оны эцэст төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2489.53 төгрөгт хүрч, тайлант хугацаанд нэг өдөрт хамгийн ихдээ 0.90%-иар буюу 22.12 төгрөгөөр чангарч, 2.28%-иар буюу 49.94 төгрөгөөр суларч, өдрийн дундаж хэлбэлзэл 0.21% байв. Мөн тайлант хугацааны 91 хувьд ханш өдөрт ±0.4%-д хэлбэлзсэн байна. Ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл 2015 онтой харьцуулахад 0.087 нэгж хувиар, 2014 онтой харьцуулбал 0.038 нэгж хувиар өссөн.

Зураг 2. **Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкны зарласан ханшийн хэлбэлзэл (төгрөгөөр)**

Зураг 3: **Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өдрийн хэлбэлзлийн давтамж**

Эх сурвалж: Монголбанк

2.2 БАНКНЫ САЛБАРЫН ТОГВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

Тайлант онд аж ахуй нэгжид олгосон зээлийн эргэн төлөлт доголдож, зээлийн чанар муудсан нь банкны салбарын тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх гол эрсдэл байлаа. Үүнд чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь хэмжээ 2016 оны эцэст 7.2 хувьд хүрэв. Эдийн засаг, гадаад секторын таагүй байдал, төгрөгийн ханшийн огцом сулрал нь зээлийн чанар муудахад голлон нөлөөлсөн байна.

Банкуудын эрдсэл даах чадварыг хадгалах, цаашид зээлийн эргэн төлөлтөөс бий болох алдагдлыг бууруулах зорилгоор 2015 оны 4 дүгээр сард банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 50 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэх шийдвэрийг Монголбанк гаргаж, уг шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахаар тайлант онд шаардлагатай арга хэмжээ авлаа. Үүний үр дүнд системд нөлөө бүхий томоохон банкууд тус шаардлагыг бүрэн хангасан бол бусад банкууд хуваарийн дагуу хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Эдийн засгийн идэвхжил саарч, зээлийн эрсдэл нэмэгдэж байгааг харгалзан, банкуудын үйл ажиллагааны эрсдэлийн түвшинг системийн хэмжээнд алгуур бууруулах зорилгоор Монголбанк 2015 оноос хойш банкны зээл, активын харьцааг хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Тус хязгаарыг банк тус бүрийн эрсдэлийн түвшинтэй уялдуулан 55-60 хувийн хооронд тогтоон мөрдүүлж банкуудын эрсдэл даах чадварт ирж байсан дарамтыг багассан.

Монголбанк банкуудын эрсдэл, төлбөрийн чадварт газар дээр нь иж бүрэн, хэсэгчилсэн, гэнэтийн шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг эдийн засгийн нөхцөл байдал, тухайн банкны санхүүгийн чадвар, үйл ажиллагааны онцлог, зөрчлийн шинж байдал, системд үзүүлэх нөлөөллийг харгалзан хэрэгжүүллээ. Мөн банкуудын үйл ажиллагаа нь Банкны тухай хууль тогтоомж, Монголбанкнаас баталсан журам, заавар, зохистой харьцааны хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэхэд зайнаас тогтмол хяналт тавьж ажиллаа.

Санхүү, эдийн засгийн таагүй нөхцөл байдал ирэх жилүүдэд үргэлжлэх төлөвтэй байгааг харгалзан Монголбанк банкны үйл ажиллагааг тодорхой бодлогын шийдвэрээр дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Тухайлбал, Зээлийн эрсдэлийн түвшинг банкуудаас олгож буй актив хөрөнгүүдийн хувьд үнэн зөв тооцох, боломжит эрсдэлээс хамгаалах хангалттай санг банкуудад бүрдүүлж, оновчтой зарцуулах зорилгоор “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг Монголбанк, Сангийн яамтай хамтран шинэчлэн баталж, банкуудад мөрдүүлж эхэлсэн. Шинэчилсэн журмын хүрээнд зээлийн барьцаа хөрөнгийн хасагдуулга, бүтэц өөрчлөгдсөн актив болон активын ангилал дээшлүүлэх нөхцөлийг тодорхой болгосон бөгөөд санхүүгийн салбарын мөчлөг сөрсөн бодлогыг эдийн засгийн мөчлөгтэй уялдуулан оновчтой хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн болно.

Санхүүгийн салбарт хуримтлагдаад буй чанаргүй зээлийг үр ашигтай, зардал багатай шийдвэрлэх зорилгоор чанаргүй активын эргэн төлөлтийг гүйцэтгэх чиглэлд мэргэшсэн, төрийн дэмжлэгтэй, мэргэжлийн байгууллага байгуулахаар тайлант онд Азийн Хөгжлийн Банктай хамтран ажиллаа. Энэ ажлын хүрээнд активын удирдлагын тогтолцоонд шаардлагатай эрх зүйн орчинг бүрдүүлэх хуулийн төслийг боловсруулж, 2017 оны УИХ-ын намрын чуулганд өргөн барихаар төлөвлөж байна. Энэ тогтолцоо нь системийн хэмжээнд активын чанар алдагдах хямралын үед банк чанаргүй активаасаа шуурхай салах боломж олгож, санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэх бололцоог хангах онцгой ач холбогдолтой.

Монгол Улсад нүүрлээд буй эдийн засгийн хүндрэлүүдийг давах зорилтын хүрээнд ОУВС-тай хийсэн хэлэлцээрийн явцад банкны салбарын эрсдэл даах чадварын үзүүлэлтийг тогтвортой байлгах, банкны хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах чиглэл баримтласан. Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрөөр Банкны активын чанарт нарийвчилсан үнэлгээ хийх, хяналт, шалгалтыг сайжруулах, чанаргүй активыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг цогц арга хэмжээ авахаар тохиролцсон болно.

2.3 ГАДААД ВАЛЮТЫН УЛСЫН НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Монголбанк нь гадаад валютын улсын нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ "Төв банкны тухай хууль"-ийн 21 дүгээр зүйлд заасны дагуу нөөцийн найдвартай байдлыг хангах, хөрвөх чадварыг алдагдуулахгүй байх, дээрх нөхцлүүд бүрэн хангагдсан тохиолдолд үр өгөөжийг нэмэгдүүлэх гэсэн зарчмыг баримталж ажилладаг. Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт нь олон улсын жишигт нийцсэн, нөөцийн удирдлагад оролцогч талуудын эрх, үүргийг нарийвчлан тодорхойлсон давхар хяналтын тогтолцоог бий болгоход чиглэсэн байдаг.

Монголбанк 2016 онд гадаад валютын улсын нөөцийн бүтцийг хүлээн зөвшөөрөгдөхүйц эрсдэлийн түвшинд баталж, түүний хүрээнд нөөцийн актив, хөрөнгө оруулалтын тохиромжтой хугацаа, хэрэгслүүдийг тус тус тодорхойлон ажиллалаа. Валютын нөөцийн удирдлагын хүрээнд хийсэн хөрөнгө оруулалтын зах зээлийн үнэлгээ, эрсдэлийн удирдлагыг сайжруулах, хяналтын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн ажлуудыг хэрэгжүүлэв.

Тайлант онд Монголбанкнаас валютын нөөцийг дэлхийн эдийн засагт тэргүүлэгч АНУ, Япон, Франц, Англи гэх мэт орнуудын төв банк, Засгийн газар, Олон улсын төлбөр тооцооны банк (ОУСБ) зэрэг зээлжих зэрэглэл өндөртэй улс орон, байгууллагуудад харилцах, хадгаламж, үнэт цаас хэлбэрээр байршуулж удирдлаа. Харин нөөцийн урт хугацаат багцыг АНУ-ын Засгийн газар, олон улсын санхүүгийн корпорацийн 0-3 жилийн хугацаатай үнэт цаасанд хөрөнгө оруулах замаар удирдав.

Мөн хугацаанд валютын нөөцөд еврогийн багцын эзлэх хэмжээг ИБУИНВУ-ын Европын холбооноос гарах шийдвэр, тус валютын өгөөж сөрөг болсон зэрэгтэй уялдуулан бууруулах арга хэмжээг авав. Харин БНХАУ-ын юань ОУВС-гийн зээлжих тусгай эрхийн багцад 2016 оны 10 дугаар сараас эхлэн нэмэгдэж орсон, юаниар нэрлэсэн гадаад өр өссөнөөс шалтгаалан валютын нөөцөд эзлэх юанийн багцын хэмжээг голч түвшнөөс нэмэгдүүллээ.

Монгол Улсын валютын нөөц 2016 оны эцэст 1296.4 сая ам.долларт хүрч оны эхнээс 2.0 хувиар буюу 26.8 сая ам.доллараар буурсан. Энэ нь олон улсын жишиг доод түвшин болох импортын 3 сарын буюу 12 долоо хоногийн хэрэгцээг дараах байдлаар хангаж байна (Зураг 1).

- Валютын төлбөртэй импортын сүүлийн 3 сарын дундаж гүйцэтгэлээр авч үзэхэд 3.4 сарын буюу 13.6 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшинд,
- Валютын төлбөртэй импортын сүүлийн 12 сарын дундаж гүйцэтгэлээр авч үзэхэд 3.6 сарын буюу 14.4 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшинд тус тус байв.

Монгол Улсын Их хурлын 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор батлагдсан Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл (ҮАБЗ)-ийн үзэл баримтлалд заасан “Гадаад валютын улсын нөөц нь валютын төлбөртэй импортын нэг жил буюу 52 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшнээс багагүй байх” тухай шаардлагыг хангахгүй байна.

Зураг 1. **Гадаад валютын улсын нөөц (сая ам.доллар) ба импортын хэрэгцээг хангах түвшин (сараар)**

2.4 МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМ

Монгол Улсын төлбөрийн системийг 2015-2020 онд хөгжүүлэх Стратегийн баримт бичгийг Монголбанкнаас Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй техник туслалцааны төслийн хүрээнд боловсруулж, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, батлуулсан. Стратегийн баримт бичигт тусгасан хууль эрх зүйн орчныг сайжруулах, хяналтын чадавхийг бэхжүүлэх зорилтын дагуу Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын их хуралд өргөн барьсан.

Монголбанкнаас төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор оролцогч, операторын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамжийн дагуу төлбөрийн системийн оролцогч банкуудад төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрт нь залруулах арга хэмжээ авч ажиллалаа.

Олон улсын төлбөр тооцооны банкнаас гаргасан Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн 24 зарчим, 5 үүрэг хариуцлагыг их дүнтэй төлбөр тооцооны системийн түвшинд хэрхэн хангаж байгааг тодорхойлж, хэрэгжилтийн түвшинг ахиулж, тогтмол хангуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Банксүлжээ системийн үнэлгээ”-г хийсэн. Энэхүү үнэлгээг хийснээр төлбөрийн системд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлон, түүнийг үнэлэх, бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломж бүрдэж байна.

Тайлант онд мобайл болон интернет хандалтаар хийсэн гүйлгээг мөнгөн дүнгийн хязгаарлалтгүйгээр бага дүнтэй гүйлгээний системээр дамжуулах програм хангамжийн шийдлийг бий болгож, гүйлгээг сувгаар ялган гүйцэтгэж эхэлсэн.

Төрийн үйлчилгээний цахим портал системийн төлбөр тооцоог Үндэсний цахим гүйлгээний төвөөр дамжуулан гүйцэтгэх ажлын хүрээнд Монголбанк, Сангийн яамны Төрийн сангийн газар, Цагдаагийн ерөнхий газрын Лицензийн төв хамтран “Төрийн үйлчилгээний цахим системийн төлбөр тооцоог гүйцэтгэх гэрээ”-г байгуулсан. Мөн Үндэсний цахим гүйлгээний төв нь мэдээллийн технологийн дэд бүтцийг хариуцан ажиллах тул Монголбанк, Үндэсний дата төвтэй “Мэдээллийн технологийн дэд бүтцийг хариуцан ажиллах гэрээ”-г байгуулсан.

Засгийн газрын 2016 оны 334 дүгээр тогтоолоор баталсан "Сайн хувьцаа" арга хэмжээний хувьцааны төлбөр шилжүүлэх ажлын хүрээнд оролцогч хоорондын мэдээлэл солилцох дэд бүтцийг банк хоорондын бага дүнтэй гүйлгээ болон картын системд хамааралгүй байхаар зохион байгуулж, хувьцааны олголтын

програм хангамж, тайланг боловсруулах, хувьцааны төлбөрийн олголтыг хийж гүйцэтгэсэн. Тус ажлын хүрээнд 2016 оны 7 дугаар сард ҮЦГТ нь нийт 820,701 иргэний 34 тэрбум төгрөгийн дүн бүхий хувьцааны төлбөрийн олголтыг хийсэн.

Монголбанк нь Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр "Төлбөрийн системийн шинэчлэл" төслийг хэрэгжүүлэхээр тусгай нэгж байгуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн. Төслийн бичиг баримтанд заасны дагуу төслийн худалдан авалтын эхний шатны ажлуудыг гүйцэтгэсэн ба шинэ дэвшилтэт технологид суурилсан төлбөрийн системүүдийг суурилуулан, шинэчлэхээр ажиллаж байна.

Хүснэгт 1. **Банк хоорондын 2013-2016 оны гүйлгээний тоо, дүн (мянган ширхэг, их наяд төгрөг)**

	2013		2014		2015		2016	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
I улирал	3,846.3	9.0	4,513.4	13.3	5,231.4	12.0	7,323.2	11.3
өсөлт (%)	*320.4*	*58.4*	*17.3*	*48.1*	*15.9*	*-9.7*	*40.0*	*-5.9*
II улирал	4,664.1	13.3	5,087.2	15.0	5,824.7	15.9	11,082.4	17.5
өсөлт (%)	*273.3*	*77.7*	*9.1*	*12.7*	*14.5*	*5.8*	*90.3*	*10.4*
III улирал	4,524.5	16.1	4,789.2	13.9	5,844.0	17.7	5,186.8	15.0
өсөлт (%)	*344.2*	*91.7*	*5.8*	*-13.6*	*22.0*	*27.5*	*-11.2*	*-15.2*
IV улирал	4,780.1	17.5	5,466.5	22.8	5,313.9	14.1	8,277.2	13.3
өсөлт (%)	*20.9*	*94.2*	14.4	30.4	-2.8	-38.3	55.8	-5.3
Нийт	**17,815.0**	**55.9**	**19,856.3**	**65.0**	**22,213.9**	**59.7**	**31,869.5**	**57.2**
өсөлт (%)	*149.6*	*82.8*	*11.5*	*16.3*	*11.9*	*-8.2*	*43.5*	*-4.2*

Эх сурвалж: Монголбанк

Зураг 1. **Банк хоорондын 2013-2016 оны гүйлгээний тоо, дүн**

Тайлант хугацаанд хийгдсэн банк хоорондын нийт гүйлгээний тоо 2013 оноос хойш тогтмол өссөөр 2016 онд 31.9 сая ширхэг гүйлгээ хийгдэж, 43.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Харин банк хоорондын нийт гүйлгээний дүн 57.2 их наяд төгрөг болж, өмнөх оныхтой харьцуулахад 4.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Төлбөрийн карт

Төлбөрийн картын хэрэглээний үзүүлэлт жил тутамд өсөж байгаа нь бэлэн бус төлбөрийн хэрэгслийг өдөр тутмын төлбөр тооцоонд ашиглах иргэдийн сонирхол өндөр байгааг харуулж байна. Банкууд Виза, Мастеркарт, Юнионпэй, ₮ карт болон Американ экспресс, Жей Си Би гэсэн 6 төрлийн төлбөрийн картыг өөрийн оноосон нэрээр гаргаж байгаа боловч 2016 оны байдлаар нийт картын 68.4 хувийг үндэсний брэнд ₮ карт дангаар эзэлж, зах зээлд түлхүү ашиглагдаж байна.

Хүснэгт 2. **Төлбөрийн картын хэрэглээ 2014-2016 онд.**

Картын хэрэглээний тоо		2014	2015	2016	Орон нутаг	*Өсөлт (%)*
	Картын тоо	3,590,646	4,058,900	3,953,989	1,165,027	*-2.6*
	Идэвхтэй ашиглагдаж буй картын тоо	1,361,630	2,289,811	1,468,376	349,740	*-35.9*
Төхөөрөмжийн тоо		2 014	2 015	2 016	Орон нутаг	*Өсөлт (%)*
	ПОС	12,015	14,780	21,325	4,888	*44.3*
	МПОС	2,084	4,381	3,796	333	*-13.4*
	ПОБ	1,848	1,930	1,872	966	*-3.0*
	АТМ	1,229	1,545	1,897	413	*22.8*
	Бусад	24	41			*-100.0*
Гүйлгээний тоо, дүн		2 014	2 015	2 016	Орон нутаг	*Өсөлт (%)*
ПОС	Тоо, сая ширхэг	24.1	38.1	65.7	11.6	*72.4*
	Дүн, тэрбум төгрөг	1,099.0	1,571.9	1,949.9	213.2	*24.0*
МПОС	Тоо, сая ширхэг	0.0	0.2	0.7	0.1	*250.0*
	Дүн, тэрбум төгрөг	0.9	4.6	8.8	3.6	*91.3*
ПОБ	Тоо, сая ширхэг	3.8	1.0	0.8	0.2	*-20.0*
	Дүн, тэрбум төгрөг	972.9	191.2	200.6	41.1	*4.9*
АТМ	Тоо, сая ширхэг	103.1	117.2	83.9	13.6	*-28.4*
	Дүн, тэрбум төгрөг	6,392.1	6,863.5	10,525.3	1,512.7	*53.4*
Нийт	**Тоо, сая ширхэг**	**131.0**	**156.5**	**151.1**	**25.6**	***-3.5***
	Дүн, тэрбум төгрөг	**8,464.9**	**8,631.2**	**12,684.6**	**1,770.6**	***47.0***

Эх сурвалж: Монголбанк

2.5 БАНК, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛ

Тайлант онд Монгол Улсын Их Хурлаас Монголбанкны орон сууцны ипотекийн санхүүжилтийн харилцааг зохицуулах Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хууль шинээр баталж, банк, санхүүгийн салбарт холбогдох хууль тогтоомжийг сайжруулах хүрээнд Иргэний хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг батлан гаргажээ.

Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хууль

Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийг баталсан. Энэ хуулийн зорилго нь “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-д тусгасан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд тэтгэврийн шинэчлэлийг эрчимжүүлэх зорилгоор ирээдүйн тэтгэврийн нөөц сан байгуулах, түүний хөрөнгийг бүрдүүлэх, удирдах, зарцуулах, гүйцэтгэлийг нь тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байна.

Хүн амын насжилт, эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан зайлшгүй тохиолдож болзошгүй тэтгэврийн даатгалын сангийн ирээдүйн алдагдал, нэрийн дансны тогтолцооноос хагас хуримтлалын тогтолцоонд шилжих тохиолдолд шаардагдах шилжилтийн зардлыг тус тус санхүүжүүлэх зорилгоор тэтгэврийн нөөц сан байгуулах шаардлагатай болсон гэж хууль санаачлагчид үзжээ.

Монгол Улсын хувьд ирээдүйн тэтгэврийн нөөц санг орон сууцны ипотекийн зээлийн одоогийн бий болсон хуримтлал /1.8 их наяд төгрөг/ дээр үндэслэн байгуулж, орон сууцны болон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор бизнесийн ипотекийн зээлийн тогтолцоогоор дамжуулан урт хугацааны, тогтвортой хуримтлалтай болж, улмаар 2030 оноос эхлэн хагас болон бүрэн хуримтлалын тогтолцоондоо шилжих нь манай улсын хувьд оновчтой хувилбар гэж тооцсон байна.

Ирээдүйн нөөц сангийн тухай хуульд зааснаар уг сангийн хөрөнгө, орлого нь дээр дурдсанчлан дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Тус хууль нь гурван бүлэг, есөн зүйлтэй. Үүнд:

- Монголбанкнаас шилжүүлсэн орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас;
- Орон сууцны ипотекийн зээлийг санхүүжүүлэх зориулалтаар Монголбанкнаас банкинд олгосон зээлийн шаардах эрх;
- Ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасны үндсэн төлбөр;
- Ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасны хүүгийн орлого;
- Ипотекийн зээлийг санхүүжүүлэх зориулалтаар банкинд олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр;
- Ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас худалдсаны орлого;
- Ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас барьцаалсан зээлийн эх үүсвэр;
- Улсын төсвөөс хуваарилсан мөнгөн хөрөнгө;
- Гадаад улс, олон улсын байгууллагаас Засгийн газрын шугамаар олгосон зээл, тусламж зэрэг юм. Харин сангийн хөрөнгийн удирдлагыг Засгийн газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Монголбанк хэрэгжүүлнэ.

Иргэний хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.”, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж заасны үндэслэн өмчлөгч нь ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг гуравдагч этгээдийн өмчлөлд шилжүүлэх хэлцэл хийх тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгчээс зөвшөөрөл авах эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлага үүссэн. Дээрх хууль зүйн болон практик үндэслэл, шаардлагын дагуу 2016 оны 1 дүгээр сарын 19-ны өдөр Иргэний хууль болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд дараахь өөрчлөлтүүд орсон байна.

Иргэний хуулийн 170.6.-д “Өмчлөгч нь ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэх хэлцэл хийх бол үүрэг гүйцэтгүүлэгчээс зөвшөөрөл авах үүрэгтэй.” гэсэн нэмэлт, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27.1.-д “Барьцаалуулагч үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны зүйлийг бусдын өмчлөлд шилжүүлэхдээ барьцаалагчийн зөвшөөрөл авна.” гэсэн өөрчлөлтийг тус тус оруулжээ.

Эдгээр эрх зүйн зохицуулалтыг хийснээр үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн харилцааны эрх зүйн орчин тогтворжиж, ипотекийн зээлээр баталгаажсан бондоос эргэн төлөгдөх нөхцөлтэй орон сууцны зээлийн эх үүсвэрийг хэвийн олгох нөхцөл бүрдэж байна.

2.6 ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

“Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, БСШУЯ-ны хамтарсан тушаалаар баталсан. Энэхүү хөтөлбөрийг дараах 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлж буй:

- Сургуулийн насныханд санхүүгийн мэдлэг олгох;
- Залуу үед санхүүгийн мэдлэг олгох;
- Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох;
- Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр санхүүгийн мэдлэг олгох.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр иргэдийн санхүүгийн сахилга батыг сайжруулах, санхүүгийн оновчтой шийдвэр гаргах чадварыг дээшлүүлэх, урт хугацаатай хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, олон нийтийн банк, санхүүгийн системд итгэх итгэлийг дээшлүүлэх, улмаар мөнгөний бодлогын үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх, цаашлаад Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлт хөгжлийг дэмжих ээрэг эерэг үр дагаврыг бий болгох боломжтой.

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дараах гол сэдвүүдэд чиглэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн талаар суурь ойлголтууд
- Төсөв болон санхүүгийн төлөвлөлт
- Хадгаламж
- Зээл
- Хөрөнгө оруулалт
- Санхүүгийн эрсдэлээс хамгаалах арга хэрэгсэл (Даатгал гэх мэт)
- Тэтгэврийн хуримтлал
- Нийгмийн даатгал болон татварын талаарх ойлголтууд
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын талаарх ойлголтууд

2016 онд тус хөтөлбөрийн хүрээнд дараах ажлууд хийгдсэн болно:

Сургуулийн насны хүүхдүүдэд санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр боловсруулагдан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/275 тоот “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” тушаалаар санхүүгийн боловсрол олгох “Бизнес судлал” хичээлийг ерөнхий боловсролын сургуулийн 10 дугаар ангид заавал сонгон судлах хичээл болгон гүнзгийрүүлж судлуулахаар шийдвэрлэгдсэн.
- “Бизнес судлал” хичээлийг улсын хэмжээнд нийт 1050 багш, 22,124 сурагчдад заахаар БСШУЯ-наас “Бүрэн дунд боловсрол-Бизнес судлалын сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх арга зүй” сургалтыг орон нутгийн 10 бүсэд зохион байгуулсан.
- Ерөнхий боловсролын сургуулиудын 10-р ангийн “Бизнес судлал” сонгон судлах хичээлийн сурах бичгийг боловсруулав.
- Хүүхдүүдэд зориулсан санхүүгийн боловсрол олгох зурагт ном “Анар, Ану 2”, “Хүсэл үү, хэрэгцээ юу?”, “Мөнгө бол мөрөөдөлд хүрэх хэрэгсэл” 2 цувралыг хэвлүүлэн орон нутгийн хүүхэд, сурагчдад түгээв.
- Олон улсын хүүхэд, залуучуудын санхүүгийн боловсролын байгууллага /Child&Youth Finance International/-аас “Дэлхий нийтийн санхүүгийн хүртээмжийн шагнал” гардуулах ёслолыг жил бүр зохион байгуулдаг бөгөөд Монгол Улс 2016 онд Ази - Номхон далайн орнуудын хүүхэд, залуучуудын санхүүгийн болвсролыг дэмжигч “Бүсийн аварга” боллоо. Дээрх арга хэмжээнд нийт 500 гаруй байгууллага нэр дэвшиж, 132 орны санхүүгийн байгууллагын төлөөлөл оролцсон болно.
- Монголбанк Монголын банкны холбоотой хамтран “Дэлхийн мөнгөний долоо хоног” олон улсын арга хэмжээг “Санхүүгийн боловсрол - Миний амьдралд” уриан доор зохион байгуулав.
- Санхүүгийн Зохицуулах Хорооноос зохион байгуулсан “Монгол Улсын санхүүгийн захын дунд хугацааны хөгжил” форумд оролцож “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг олон нийтэд танилцуулав.
- Ерөнхий боловсролын сургуулийн бага ангиудад (I-Y анги) санхүүгийн суурь мэдлэг олгоход

зориулсан багшийн зөвлөмжийг боловсруулав.

- Ерөнхий боловсролын сургуулийн суурь боловсролын ангиудад (YI-IX анги) санхүүгийн суурь мэдлэг олгоход зориулсан багшийн зөвлөмжийг боловсруулав.

Залуучуудад санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд

- Залуу үед санхүүгийн мэдлэг олгох "Хувь хүний санхүү" сэдэвт хичээлийг (1 кредит) бүх их дээд сургуулийн хөтөлбөрт мэргэжил харгалзахгүй тусгуулах зорилгоор сурах бичиг, дасгал ажлын номыг МУИС-ийн Бизнесийн сургууль, Санхүү эдийн засгийн их сургууль, ХААИС-ийн багш нарын бүрэлдэхүүнтэй баг боловсруулав.
- Монголбанк Монгол улсын их сургуулийн Бизнесийн сургуультай хамтран "Хэн сайн санхүүч болох вэ?" сэдэвт уламжлал болсон АХА тэмцээнийг их дээд сургуулиудын оюутнуудын дунд санхүүгийн мэдлэгийг түгээх зорилгоор зохион байгуулав.
- "Банкны ажилтны өдөр"-ийг тохиолдуулан Банк санхүүгийн академитэй хамтран "Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх нь" сэдэвт хэлэлцүүлэгт арилжааны банкуудын харилцагчийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд тулгамдаж байгаа асуудлууд, тэдгээрийн шийдэл, цаашдын хамтын ажиллагааг сайжруулах талаар санал солилцов.

Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд

- Монголбанк болон БСШУЯ-ны харъяа Насан туршийн боловсролын төвтэй хамтран насанд хүрэгчдэд зориулсан санхүүгийн мэдлэг олгох хөтөлбөрийн агуулга, 11 сэдэв бүхий гарын авлагыг бэлэн болгов.
- Монголбанкны орон нутгийн салбаруудаараа дамжуулан орон нутгийн иргэд, банк санхүүгийн салбарын ажилтнууд болон сурагчдад санхүүгийн боловсролыг түгээн ажиллаж байна.

Цахим хуудас, олон нийтийн хэрэгслээр санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд

- Санхүүгийн мэдлэг олгох www.sankhuugiinbolovsrol.mn цахим хуудсыг Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд боловсруулан, олон нийтэд түгээхэд бэлэн болоод байна.
- Иргэдэд хувийн болон өрхийн санхүүгээ удирдах, хяналттай төсөв зохиоход туслах "Төсөвчин" аппликейшнийг боловсруулав.
- "Монголбанкны мэдээлэл" сар бүрийн товхимолд санхүүгийн боловсрол олгох буланг тогтмол ажиллуулж байна.

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 3

3.1 ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААС

Монголбанкнаас банкны системийн нөөцийг удирдах гол хэрэгсэл нь Төв банкны үнэт цаас (ТБҮЦ) юм. ТБҮЦ-ны хүүг зах зээлийн зарчимд илүү нийцтэй болгох, төгрөг болон валютын захын өгөөжийн тэнцвэр тогтох боломжийг бүрдүүлэх зорилгоор 2013 оны 3 дугаар сараас эхлэн 7 хоногийн хугацаатай ТБҮЦ-ыг долоо хоногт гурван удаа арилжаалж байгаа бөгөөд банкны нөөцийн эрэлт, нийлүүлэлт дээр үндэслэн 28 хоногийн хугацаатай ТБҮЦ-ыг 8 дугаар сарын 2-ны өдөр хүртэл, 84 хоногийн хугацаатай ТБҮЦ-ыг 8 дугаар сарын 19-нөөс 11 дүгээр сарын 3-ны өдрийн хооронд 2 долоо хоногт нэг удаагийн давтамжтайгаар арилжаалсан.

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ТБҮЦ-ны үлдэгдэл нэрлэсэн дүнгээр 578.3 тэрбум төгрөг байсан бөгөөд үүний 83%-ийг 7 хоногийн хугацаатай, 17%-ийг 84 хоногийн хугацаатай үнэт цаас эзэлж байв.

Зураг 1. **ТБҮЦ-ны үлдэгдэл (тэрбум төгрөг, хугацаагаар)**

Эх сурвалж: Монголбанк

3.2 ТӨВ БАНКНЫ САНХҮҮЖИЛТ

Монголбанкнаас мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, банк хоорондын захын хүүг зохистой түвшинд удирдах зорилгоор банкны системд мөнгөн хөрөнгө нийлүүлэхдээ өдрийн зээл, овернайт репо санхүүжилт, репо арилжаа, барьцаат зээл зэрэг хэрэгслүүдийг ашиглаж байна. Эдгээр нь хугацаа, хэлбэр, хүү, зориулалтаараа ялгаатай юм. Монголбанкны санхүүжилтийн хэрэгслүүд бүгд барьцаа хөрөнгө шаарддаг бөгөөд барьцаа нь Монголбанкны Эрсдэлийн удирдлагын албанаас гаргасан барьцааны жагсаалтад орсон актив байна. Тайлант онд Монголбанк мөнгөний бодлогын хэрэгслүүдээр дамжуулан банкуудад нийт 3.3 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгосноос 85.2 хувийг овернайт репо санхүүжилт, 10.6 хувийг өдрийн зээл, үлдсэн 4.1 хувийг барьцаат зээл эзэлж байв.

Өдрийн зээл

Өдрийн зээл нь тухайн өдрөө эргэн төлөгддөг онцлогтой бөгөөд түүнийг төлбөр тооцооны хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ашигладаг хүүгүй зээл юм. Тайлант онд Монголбанк нийт 347.7 тэрбум төгрөгийн өдрийн зээлийг банкуудад олгосон байна.

Овернайт репо санхүүжилт

Монголбанкнаас олгох овернайт репо санхүүжилт нь мөнгөний бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор, банк хоорондын захын хүүг зорилтот түвшинд хүргэх, банкуудад заавал байлгах нөөцийн шаардлага хангахад дэмжлэг үзүүлэх клирингийн гүйлгээ хаахаас дараагийн ажлын өдрийн клирингийн гүйлгээ нээх хүртэл хугацаагаар банкинд олгож байгаа санхүүжилтийн байнгын хэрэгсэл юм. Овернайт репо хүү нь Төв банкны хүүгийн коридорын дээд хязгаар болох ба мөнгөний бодлогын хүүн дээр 3 нэгж хувийг нэмсэнтэй тэнцүү байдаг. Монголбанкнаас 2016 онд 2.8 их наяд төгрөгийн овернаит репо санхүүжилтийг банкуудад олгожээ.

Репо арилжаа

Төв банкны репо арилжаа нь банкны эзэмшиж буй үнэт цаасыг хугацааны эцэст урьдчилан тохиролцсон үнээр буцаан худалдах нөхцөлтэйгөөр худалдан авах хэлцэл юм. Банкны системд хөрөнгийн дутагдал бий болсон, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар муудсан тохиолдолд 7 хүртэл хоногийн хугацаатай санхүүжилтийг банкуудад репо арилжаагаар төв банк олгодог. Тайлант онд репо арилжаа хийгээгүй байна.

Барьцаат зээл

Монголбанк нь банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг богино хугацаанд хангах эцсийн зээлдүүлэгчийн хувиар банкинд барьцаат зээл олгодог. Барьцаат зээлийн хүүг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны А-226 дугаар тушаалаар мөнгөний бодлогын хүүгийн коридорын дээд хувь хэмжээтэй тэнцүү байхаар тогтоосон. Монголбанк 2016 онд 135.2 тэрбум төгрөгийн барьцаат зээл олгосон бөгөөд 2016 оны эцсийн байдлаар 14.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Овернайт хадгаламж

Төв банкны овернайт хадгаламж нь банк хоорондын илүүдэл нөөцийг татан төвлөрүүлэх хэрэгсэл юм. Тус хэлцлийг банкны хүсэлтээр, тухайн ажлын өдрийн хамгийн сүүлийн, дараагийн ажлын өдрийн өдрийн хамгийн эхний гүйлгээ байхаар тогтоосон байдаг. Овернайт хадгаламжийн хүү нь Төв банкны хүүний коридорын доод хязгаар болох бөгөөд бодлогын хүүнээс 1 хувийг хассантай тэнцүү байна. Тайлант онд Монголбанк 3,655.2 тэрбум төгрөгийн овернайт хадгаламжийн хэлцлийг банкуудтай хийсэн байна.

3.3 ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС (ЗГҮЦ)

ЗГҮЦ нь тухайн валютын хамгийн эрсдэл багатай хөрөнгө оруулалтын хэрэгсэлд тооцогдож, хүүгийн орлого нь татвараас чөлөөлөгддөг давуу талтай. Иргэд, ААНБ-ууд өөрсдийн харилцагч брокер, дилерийн компани болон банкаар дамжуулан ЗГҮЦ-ны арилжаанд оролцож байна. Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ээр дамжин арилжаалж байгаа ЗГҮЦ-ны нэгжийн нэрлэсэн үнэ 100 мянган төгрөг байгаа бол Монголбанкаар дамжин арилжаалж байгаа ЗГҮЦ-ны нэгжийн нэрлэсэн үнэ 1 сая төгрөг байна.

Сангийн яамнаас ЗГҮЦ–ны арилжааг 2016 оны 4 дүгээр сард түр зогсоож, 9 дүгээр сараас арилжааг 3, 6, 12 сар хүртэлх хугацаатайгаар дахин эхлүүлж, 273 хоног буюу 9 сарын хугацаатай ЗГҮЦ-ыг шинээр арилжаалж эхэлсэн. Монголбанк 2016 онд анхдагч зах дээр нийт 47 удаагийн ЗГҮЦ-ны арилжааг зохион байгуулсан бөгөөд тайлант онд Монголбанкаар дамжуулан арилжаалсан ЗГҮЦ-ны идэвхитэй үлдэгдэл 2.3 их наяд төгрөгт хүрсэн байна.

Зураг 1. **Монголбанкаар дамжин арилжаалагдсан ЗГҮЦ-ны үлдэгдэл (тэрбум төгрөг)**

Зураг 2. **Монголбанкаар дамжин арилжаалагдсан ЗГҮЦ-ны ЖДХүүний өөрчлөлт**

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 1. **ЗГҮЦ-ны хоёрдогч захын үйл ажиллагаа**

Огноо	I/ Богино хугацаат	II/ Урт хугацаат	/I+II/ Нийт
2016 оны 1 сар	13,000,00	-	13,000.00
2016 оны 2 сар	2,000,00	1,500.00	3,500.00
2016 оны 3 сар	-	1,500.00	1,500.00
2016 оны 4 сар	-	-	-
2016 оны 5 сар	-	35,000.00	35,000.00
2016 оны 6 сар	-	5,000.00	5,000.00
2016 оны 7 сар	-	-	-
2016 оны 8 сар	-	-	-
2016 оны 6 сар	-	-	-
2016 оны 10 сар	-	14,800.00	14,800.00
2016 оны 11 сар	-	-	-
2016 оны 12 сар	50,000,00	500.00	50,500.00
Нийт	65,000.00	58,300.00	123,300.00

Эх сурвалж: Монголбанк

Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар 2013 онд батлагдсан “ЗГҮЦ-ыг хоёрдогч зах зээлд арилжих журам”-ын дагуу 2016 онд нийт 123.3 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий ЗГҮЦ хоёрдогч зах дээр арилжаалагдсан байна. Үүнээс 65.0 тэрбум нь Засгийн газрын богино хугацаат, 58.3 тэрбум нь Засгийн газрын урт хугацаат үнэт цаас байв.

3.4 ГАДААД ВАЛЮТЫН ДУУДЛАГА ХУДАЛДАА

Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлд нийцтэй, уян хатан тогтох зарчмыг баримтлан эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны зөрүүнээс үүсэх ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай үед тухай бүр оролцож ирлээ.

Гадаад валютын дуудлага худалдаанд банкуудын нэг удаад ирүүлэх саналын тоог Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн А-136 дугаар тушаалаар таваас гурав болгож бууруулсан бөгөөд энэ нь банк хоорондын валют арилжааг идэвхижүүлэх зорилготой байв.

Монголбанк тайлант хугацаанд нийт 127 удаагийн гадаад валютын дуудлага худалдааг зохион байгуулж цэвэр дүнгээр 1,427.6 сая ам.доллар, 1,855.3 сая юань буюу 278.5 сая ам.доллартай тэнцэх хэмжээний юань, нийтдээ 1,706.0 сая ам.доллартай тэнцэх хэмжээний гадаад валютыг нийлүүлсэн байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад нийт ам.долларын арилжаа 79.4 хувь буюу 631.7 сая ам.доллараар нэмэгдэж, юанийн арилжаа 38.1 хувь буюу 171.5 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм.

Зураг 3. **Ам.долларын дуудлага худалдаа /сая ам.доллар/**

Зураг 4. **Юанийн дуудлага худалдаа /сая ам.доллар/**

Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн үүсмэл хэрэгсэл

Монголбанк банкуудын богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт дэмжлэг үзүүлэх, ханшийн эрсдэл, спот захын дарамтыг бууруулах зорилгоор банкуудтай богино хугацааны санхүүгийн үүсмэл хэрэгслийг 2010 оноос, урт хугацаат своп хэлцлийг 2014 оноос хийж эхэлсэн.

Монголбанкнаас 2016 оны 12-р сард арилжааны банкуудтай байгуулах урт, богино хугацаат санхүүгийн үүсмэл хэрэгслийн мөнгөн урсгал, нөхцөлийг олон улсын стандартад нийцүүлэх, арбитражийн боломжийг бууруулах зорилгоор “Урт хугацаат своп хэлцлийн журам”, “Валютын своп, форвард хэлцлийн журам”-ыг тус тус шинэчлэн баталсан.

Зураг 5. **Гадаад валютын своп хэлцэл**

Монголбанк 2016 онд нийт 3,493.8 сая ам.доллартай хэмжээний төгрөгийн своп, 235.7 сая тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний ам.долларын своп хэлцэл 63.0 сая юанийн своп хэлцлийг банкуудтай тус тус байгуулсан байна. Богино хугацаат своп хэлцлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 28.1 хувь буюу 1,456.2 сая ам.долларaар буурсан байна.

Эх сурвалж: Монголбанк

Урт хугацаат своп хэлцлийн хүрээнд банкуудын гадаад зах зээлээс татсан нэгээс дээш жилийн хугацаатай эх үүсвэрт Монголбанкнаас ам.долларын урт хугацаат своп хэлцэл байгуулж байгаа бөгөөд 2016 онд нийт 358.0 сая ам.долларын дүнтэй урт хугацаат своп хэлцлийг байгуулж 85.1 сая ам.долларын урт хугацаат своп хэлцлийн төлбөр тооцоог гүйцэтгэснээр урт хугацаат своп хэлцлийн хэмжээ 272.9 сая ам.долларaар нэмэгдсэн.

3.5 ДОТООД ЗАХ ЗЭЭЛЭЭС АЛТ ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль” 2014 оны 1 дүгээр сард батлагдсанаар, Монголбанкинд худалдах алтны хэмжээ 2014 оноос тогтмол нэмэгдсэн. Энэ дүн 2016 онд 18.3 тонн буюу 658.2 сая ам.долларт хүрсэн (Зураг 2).

Зураг 1. **Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ (жилээр)**

МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4

4.1 МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, ШИНЭЧЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монголбанк нь 10 газар, 1 төв, 3 бие даасан алба, орон нутаг дахь 5 хэлтэс, 12 салбар, 1 төлөөлөгчийн газартайгаар үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Монголбанкны газар, нэгжүүдийн үйл ажиллагааны давхардлыг арилгах, уялдаа холбоог сайжруулах үүднээс 2016 онд бүтэц, зохион байгуулалтын шинэчлэл хийснээс Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газрын Үйл ажиллагааны эрсдэлийн хэлтсийг Эрсдэлийн удирдлагын албанд, Мөнгөн тэмдэгт, үнэт зүйлсийн газрын Эрдэнэсийн санг Зах зээлийн газарт шилжүүлж, Тамгын газрын бүтцэд Гадаад харилцааны албыг шинээр бий болгосон. Гадаад харилцаа, Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр Лондон хотноо Европын төлөөлөгчийн газрыг байгуулж үйл ажиллагааг эхлүүлсэн.

Хүний нөөцийн удирдлагыг боловсронгуй болгож, өндөр мэдлэг чадвартай чадварлаг боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого баримталж, ажилтнуудаа тасралтгүй сурган хөгжүүлж, тэдний ажиллах нөхцөл, цалин урамшуулал, нийгмийн асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. Хүний нөөцийн бодлогын хүрээнд ажлын гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний боловсронгуй системийг олон улсын төв банкны жишигт хүргэх зорилт тавин ажиллаж байна.

Сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх замаар Монголбанкны ажилтнуудыг цахим орчинд үр ашигтай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ажлын хэрэгцээнд цуглуулсан бүх төрлийн мэдээллийг цахим хэлбэрээр хадгалах, түгээх, ашиглах, түүнд үндэслэн шинжилгээ хийхэд чиглэсэн мэдээллийн технологийн шинэчлэлийг үе шаттайгаар хийж эхлээд байна.

Монголбанкны үйл ажиллагааг илүү тодорхой болгох, шийдвэр гаргах хэлбэр, үйл явцыг ил тод болгох, хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж байна.

4.2 ГАДААД ХАРИЛЦАА

Монголбанкны Гадаад харилцааны алба нь 2016 онд Олон Улсын Валютын Сан, Дэлхийн банкны жилийн уулзалт, ЗӨАТБХ (Зүүн Өмнөд Азийн Төв Банкуудын Холбоо)-ны 52 дахь удаагийн дээд түвшний уулзалт, Хятадын Ардын Банк, ОХУ-ын Төв банктай хийсэн дээд түвшний уулзалтын бэлтгэл ажлыг хангаж амжилттай зохион байгуулав.

ЗӨАТБХ-ны Сургалт, судалгааны төвтэй хамтран Манлайллын дунд шатны 10 дахь удаагийн семинарыг “Төв банкин дахь манлайлал” сэдвийн дор Улаанбаатар хотноо 2016 оны 6 дугаар сарын 12-17-ны өдрүүдэд зохион байгуулсан. Семинарт 11 орны Төв банкны 25 гаруй төлөөлөлөгч оролцож Шри Ланк Улсын Төв банкны Ерөнхийлөгч А.Кабраал, “ICLIF” засаглал, манлайллын сургалтын төвийн багш нар лекц уншлаа.

Монголбанк, ХБНГУ-ын Дойче Бундесбанк хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Техник туслалцаа, хамтын ажиллагааны төвийн захирал Н.Динкельборг 2016 оны 6 дугаар сард Монгол Улсад зочилон Монголбанкны удирдлагуудтай уулзах уулзалтыг зохион байгуулав. Монголбанкны Төв аппарат, орон нутаг дахь салбар, хэлтсийн хянан шалгагч нарт зориулсан семинарыг ХБНГУ-ын Бундесбанктай хамтран Улаанбаатар хотноо 9 дүгээр сард, нягтлан бодогч нарт зориулсан “Төв банкны нягтлан бодох бүртгэл” сэдэвт сургалтыг 10 дугаар сард ХБНГУ-ын Франкфурт хотноо тус тус зохион байгууллаа. ОУВС-гийн Ази, Номхон далайн орнуудын Солонгос, Монголыг хариуцсан газрын дэд дарга Коши Матай, Монгол дахь суурин төлөөлөгч Нил Сакэр тэргүүтэй төлөөлөгчдийг Улаанбаатар хотноо Монголбанкны удирдлагатай уулзах уулзалт, айлчлал, Бүгд Найрамдах Чех Улсын Төв банкны

хүний нөөцийн гүйцэтгэл болон аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах сургалтыг тус тус зохион байгуулав. Бүгд Найрамдах Солонгос Улсын Төв банкнаас мэргэжилтэн урин Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвд сургалт зохион байгууллаа.

4.3 ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА

Төв банкны олон нийттэй харилцах харилцаа

Өнөөдөр төв банкуудын хувьд олон нийттэй харилцах харилцаа нь институцийн үндсэн зорилго зорилт, түүнийгээ хэрхэн хэрэгжүүлэх стратеги, эдийн засагт тулгарч буй асуудлууд ба тэдгээрийг шийдэхэд чиглэсэн бодлого, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэргийг тайлбарлах үйл ажиллагааны цогц болоод байна. Эдгээр зүйлсийг олон нийтэд тайлбарласнаар төв банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, зах зээл дээрх хүлээлтийг үр дүнтэй удирдах, улмаар мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулах зэрэг эерэг үр дүнгүүд бий болно гэж үздэг.

Ялангуяа 2008-09 оны дэлхийн санхүүгийн хямралаас хойш зах зээл маш эмзэг болж, бага ч гэсэн тодорхой бус байдал үүсэх нь ханш, хүү, хөрөнгийн үнэлгээнд хүчтэй нөлөөлж, улмаар санхүүгийн системийн тогтвортой байдлыг өндөр эрсдэлд оруулах боломжтой болсон байдаг. Гэтэл дэлхийн олон улс орнуудад мөнгөний уламжалт бодлогын арга хэрэгслүүд орон зайгүй болж, төв банкууд мөнгөний бодлогын уламжлалт бус арга хэрэгслүүдийг ашиглаж эхэлсэн. Энэ үед төв банкууд эдийн засагт үүссэн тодорхой бус байдлыг бууруулах, тогтвортой байдлыг бий болгохын тулд гаргаж буй бодлого шийдвэр, цаашдын үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг идэвхтэй түгээх болсноор олон нийттэй харилцах харилцаа нь төв банкны нэг чухал арга хэрэгсэл болоод байна.

Монголбанкны олон нийттэй харилцах харилцаа

Монголбанк 2016 онд ил тод байдал, олон нийттэй харилцах харилцаа харилцаагаа цоо шинэ шатанд хүргэхийг зорин ажиллалаа. Үүний тулд түүвэр судалгаа явуулан Монголбанкны олон нийттэй харилцах харилцааг үнэлэх, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, дэлхийн шилдэг туршлагуудаас нэвтрүүлэх, Монголбанкны олон нийттэй харилцах нэгжийг илүү оновчтой бүтэц зохион байгуулалтанд оруулах, олон нийтэд мэдээлэл түгээх үр дүнтэй сувгуудыг шинээр бий болгох, зорилтот бүлгүүдэд хандсан үйл ажиллагаа илүү идэвхжүүлэх г.м. ажлуудыг туршиж хэрэгжүүллээ.

Бүтэц зохион байгуулалтын шинэчлэлт

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 9 дүгээр сарын 2-ний өдрийн А-235 дугаар тушаалаар Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвийг (ОНБМТ) өөрчлөн зохион байгуулснаар төв банкны олон нийттэй харилцах нэгжийн хүчин чадал сайжирч, илүү өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулах боломжтой болов. Түүнчлэн Монголбанк Хэвлэлийн бодлогын зөвлөлтэй болсноор олон нийтэд хүргэх мэдээ мэдээллийн агуулгыг илүү оновчтой тодорхойлох, мэдээллийг нэг дуу хоолойгоор хүргэх бололцоо хангагдаж байна.

Монголбанкны хэвлэлийн хурал

Монголбанкнаас бэлтгэн гаргадаг статистик мэдээллийг танилцуулах, бодлогын шийдвэр болон цаг үеийн шинжтэй мэдээллийг олон нийтэд шуурхай хүргэж байх зорилгоор хэвлэлийн бага хурлыг сар тутам зохион байгуулдаг болов. Хэвлэлийн хурлын үеэр телевиз, сонин, вебсайт г.м. хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл, сэтгүүлч нар эдийн засгийн сүүлийн үеийн тоон мэдээлэл, судалгааг сурвалжлахаас гадна, мөнгөний бодлого, валютын зах, санхүүгийн системийн талаар Монголбанкнаас баримталж буй байр суурийг нээлттэй асууж лавлан олон нийтэд түгээх бололцоо бүрдлээ.

“Монголбанкы мэдээлэл” товхимол

Төв банк, мөнгөний бодлого, санхүүгийн боловсрол, судалгаа, эдийн засагтай холбоотой танин мэдэхүй зэрэг өргөн хүрээний мэдээллийг агуулсан “Монголбанкны мэдээлэл” товхимлыг сар тутам бэлтгэн гаргадаг болсон нь олон нийт Монголбанктай холбогдох нэг чухал гүүр болж буй. Товхимлын цахим хувилбарыг Монголбанкны албан ёсны вебсайт дээр байршуулж, хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллалаа.

Сургалтууд: Сэтгүүлчдийн сургалт

Монголбанк мэргэжлийн сэтгүүлчдийн эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх, эдийн засгийн чиглэлээр мэргэшихэд нь хувь нэмэр оруулах зорилгоор сард 2 удаагийн давтамжтайгаар сургалтуудыг зохион байгуулдаг болов. Эдгээр сургалтуудад 2016 оны 9, 10, 11-р саруудад давхардсан тоогоор нийт 90 сэтгүүлч хамрагдсан байна. Сургалтанд суусан сэтгүүлчдийн дунд санал асуулга явуулахад сэтгэл ханамж өндөр, талаас илүү нь 2 долоо хоног тутам ийм төрлийн сургалтанд хамрагдах хүсэлтэйгээ илэрхийлсэн байв. Түүнчлэн, ирээдүйд сэтгүүлч болохыг зорин сэтгүүл зүйн мэргэжлээр их дээд сургуулиудад суралцаж буй оюутнуудад хандсан эдийн засгийн суурь мэдлэг олгох сургалтуудыг сар тутам зохион байгуулж эхлээд байна.

Лекц, хэлэлцүүлэг

Монголбанк эдийн засгийн нөхцөл байдал, мөнгөний бодлогыг олон нийтэд тайлбарлан ойлгуулах зорилгоор мэргэжлилйн эдийн засагчид, судлаачид, санхүүгийн зах зээлийн мэргэжилтнүүд оролцсон нээлттэй хэлэлцүүлгүүдийг идэвхтэй зохион байгуулж, оролцож байна. Тухайлбал, “Discover Mongolia 2016”, “Монголын эдийн засгийн өнөөгийн байдал, хүндрэл, гарц, шийдэл”, “Валютын ханшийн савлагаа ба шийдэл” г.м. хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах, панелистаар оролцлоо.

Цахим орчин, сошиал нетворк

Сүүлийн үеийн технологийн хөгжил дэвшлийг дагаад мэдээлэл авах, түгээх сувгууд ч хурдацтай өөрчлөгдөж, цахим орчин болон сошиал нетворкуудын ач холбогдол эрс нэмэгдсээр байна. Энэ нөхцөлд Монголбанк мэдээллийг олон нийтэд үр дүнтэй түгээх үүднээс албан ёсны вебсайтын загвар, түүгээр дамжих мэдээллийн урсгалыг тогтмол сайжруулах, Фейсбүүк, Твиттер хуудсуудаараа дамжуулан мэдээллийг идэвхтэй түгээж байна.

“Төв банкны ил тод байдал, олон нийттэй харилцах харилцааны үнэлгээ” судалгаа

Монголбанкны олон нийттэй харилцах харилцааг үнэлэх, судалгааны үр дүнд тулгуурлан цаашид сайжруулах зүйлсийг тодорхойлох зорилгоор анх удаа түүвэр судалгааг явуулав. Судалгааны үр дүнд Монголбанкны үндсэн зорилт, үйл ажиллагааны талаарх олон нийтийн мэдлэг, ойлголт төдийлөн сайн биш байна гэдэг нь харагдсан. Энэ нь Монголбанк цаашид олон нийттэй харилцах харилцаагаа үргэлжлүүлэн сайжруулах, иргэдийн санхүүгийн мэдлэгийг дэмжих чиглэлд хийх шаардлагатай зүйлс олон гэдгийг илэрхийлж байна.

4.4 МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭ

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (FATF буюу ФАТФ)-аас улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог тодорхой хугацааны давтамжтайгаар үнэлж, хянадаг бөгөөд энэ байгууллагын Ази, Номхон далайн бүсийн байгууллага (APG)-аас Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог үнэлэх 2 дахь удаагийн Харилцан үнэлгээ 2016 оны 4 дүгээр сараас эхэлсэн бөгөөд үнэлгээний эцсийн үр дүн 2017 оны 7 дугаар сарын бүх гишүүдийн чуулга уулзалтын үеэр гарна.

Энэ удаагийн Харилцан үнэлгээ нь ФАТФ-аас 2012 онд шинэчлэн баталсан 40 Зөвлөмжийн дагуу шинэ аргачлалын дагуу хийгдэж байгаа онцлогтой. Өөрөөр хэлбэл, Харилцан үнэлгээгээр ФАТФ-ын Зөвлөмжийн Техникийн хэрэгжилт (хууль, эрх зүй болон үйл ажиллагааны тогтолцоо)-ийг төдийгүй мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны Үр дүнтэй байдлыг давхар үнэлэх юм. Үнэлгээний ажлын хүрээнд Монголбанк дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- 2016 оны 4 дүгээр сард ФАТФ-ын Зөвлөмжийн Техникийн хэрэгжилтийн хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог танилцуулах, хууль тогтоомж, заавар, журмын орчуулга бүхий тайланг боловсруулан заасан хугацаанд хүргүүлэв,
- 2016 оны 6 дугаар сард мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны Үр дүнтэй байдлын хэрэгжилтийн хүрээнд холбогдох төрийн байгууллага, яам, агентлаг болон мэдээлэх үүрэгтэй этгээдтэй хамтран мэдээлэл боловсруулж хүргүүлэв,

- Холбогдох байгууллагуудтай хамтран Монгол Улсын мөнгө угаах эрсдэлийн үнэлгээний анхны тайланг 2016 оны 10 дугаар сард боловсруулан Монголбанкны цахим хуудсаар дамжуулан олон нийтийн хүртээл болгов,
- 2016 оны 9, 11 дүгээр сард үнэлгээний баг Монгол Улсад 3 долоо хоногийн хугацаанд холбогдох байгууллагуудын төлөөлөлтэй уулзаж тайлангийн газар дээрх шалгалтыг хийж гүйцэтгэв.
- "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль"-иар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Монголбанкны Санхүүгийн мэдээллийн алба нь дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:
- Монголбанкнаас банкуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, үйл ажиллагаанд хийх газар дээрх хяналт шалгалтад мэдээлэл солилцон хамтран ажиллав.
- Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам"-ыг батлуулав.
- Банкуудаас онлайнаар тайлан хүлээн авдаг болсонтой холбогдуулан "Санхүүгийн мэдээллийн албанд банкнаас мэдээлэл ирүүлэх журам"-д Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулж, холбогдох заалтуудыг өөрчлөн найруулав.
- Санхүүгийн мэдээллийн албаны програм хангамжийг боловсруулах ажилд оролцов.
- Эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцох, дэмжлэг үзүүлэх байдлаар хамтран ажиллав.

Санхүүгийн мэдээллийн албанаас банкуудын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг 2016 оноос Монголбанкны Хяналт, шалгалтын газарт шилжив. Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хороотой банк бус санхүүгийн байгууллагад хяналт шалгалт хийхэд нь туршлага хуваалцах, мэдээлэл солилцох замаар нягт хамтран ажиллав (Хүснэгт 1).

Хүснэгт 1. **Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн хяналт шалгалт**

Үзүүлэлт	2013	2014	2015	2016
Банкинд хийсэн хяналт шалгалт	-	10	12	13
Банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд хийсэн хяналт шалгалт	163	151	116	419
Банк болон банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд тавигдсан акт	2	155	12	14
Банк болон банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд өгсөн хугацаат үүрэг даалгавар	77	295	213	393

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Монголбанкны Санхүүгийн Мэдээллийн Алба нь "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль"-ийн дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдээс холбогдох тайланг хүлээн авч ажиллав (Хүснэгт 2).

Хүснэгт 2. **Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн тайлангийн тоо**

Үзүүлэлт	2013	2014	2015	2016
Сэжигтэй гүйлгээний тайлан	285	212	113	282
Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан	755,499	1,962,408	1,223,984	838,110
Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан	60,274	149,682	86,329	90,560
Гаалийн мэдүүлгийн тайлан	3,259	2,347	1,917	1,488

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

2016 онд 282 сэжигтэй гүйлгээний тайлан хүлээн авсан нь 2015 онтой харьцуулахад 2.5 дахин өссөн бол гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлангийн тоо 4.9%-иар өссөн байна. Харин аргачлалд өөрчлөлт орсонтой холбоотойгоор бэлэн мөнгөний гүйлгээний тайлан 32%-иар буурсан байна.

Санхүүгийн мэдээллийн алба нь мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн сэжигтэй гүйлгээний тайлангуудад дүн шинжилгээ хийх, мөнгө угаах буюу терроризмыг санхүүжүүлэх үндэслэлтэй байх

тохиолдолд хуулийн байгууллагад шилжүүлж шалгуулах үндсэн чиг үүргийнхээ хүрээнд дотоодын хууль сахиулах байгууллагуудтай мэдээлэл солилцон хамтран ажиллав (Хүснэгт 3).

Хүснэгт 3. **Санхүүгийн мэдээллийн албаны мэдээлэл солилцсон статистик**

Үзүүлэлт	2013	2014	2015	2016
Дүн шинжилгээ хийгдсэн болон хийгдэж буй Сэжигтэй гүйлгээний тайлан	180	275	209	245
Санхүүгийн мэдээллийн албанаас дотоодын хууль сахиулах байгууллагуудад шалгуулахаар шилжүүлсэн мэдээлэл	10	6	27	166
Мэдээлэл авах зорилгоор дотоодын эрх бүхий байгууллагуудаас Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлсэн хүсэлт	1,197	634	1,248	1,200
Дотоодын эрх бүхий байгууллагуудаас Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлсэн хүсэлтийн дагуу явуулсан хариу	1,066	631	1,241	1,238

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Санхүүгийн мэдээллийн алба нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн дунд сурталчилгаа явуулах хүрээнд 13 удаагийн сургалт (нийт 525 оролцогчдыг хамарсан) зохион байгуулав. Үүнээс 2 удаагийн сургалтыг (110 оролцогч) дангаараа, 11 удаагийн сургалтыг (415 оролцогч) бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан байна.

2016 оны сургалтууд дараахь тулгамдсан сэдвийг хамарчээ. Үүнд:

- Харилцан үнэлгээ хийх аргачлал;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулах;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх олон улсын стандартыг танилцуулах;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхтэй холбоотой батлагдсан хууль, журам зааврын танилцуулга.

Олон улсын санхүүгийн мэдээллийн байгууллагуудын холбоо (Egmont буюу Эгмонт)-ны гишүүний хувьд Монголбанкны Санхүүгийн мэдээллийн алба нь бусад орны байгууллагуудтай мэдээлэл солилцох, Монгол Улсаас гадагшаа гарсан, эсвэл Монгол Улсад орж ирсэн хууль бус мөнгөний урсгал, гэмт хэргээс олсон орлогыг олж илрүүлэх талаар хамтран ажиллав.

4.5 ДОТООД АУДИТ

Монголбанкны Дотоод аудитын газар нь чиг үүргийнхээ дагуу Монголбанкны бүтцийн нэгжүүдэд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулж буй эсэхэд хяналт тавьж, аливаа зөрчлийг илрүүлэн холбогдох арга хэмжээг авах, үүрэг даалгавар өгөх, удирдлагыг мэдээллээр хангах, зайны хяналт хийх, мөн Монголбанкны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэдэг.

Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу газар дээрх иж бүрэн шалгалтыг Төв Монголбанкны газар хэлтэс, алба, төв, орон нутаг дахь хэлтэс, салбаруудыг бүрэн хамруулан хийж, шалгалтын дүнг Монголбанкны Захирлуудын зөвлөл, Хяналтын зөвлөлд цаг хугацаанд нь танилцуулсан. Үүнээс гадна газар, хэлтэс, алба, төвийн зарим үйл ажиллагаанд хэсэгчилсэн болон явцын шалгалтуудыг хийж, холбогдох шийдвэрүүдийг гаргуулан ажиллажээ.

Дотоод аудитын газрын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг илүү боловсронгуй болгох, үйл ажиллагааны үе шат бүрт анхан шатны болон дараалсан хяналтыг тогтмол, тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх, ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, шинэлэг арга барил, хэлбэрээр ажиллах зэрэг ажлуудыг хэрэгжүүлж байна.

4.6 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Монголбанк нь санхүүгийн эрсдэлийн хувьд төвлөрсөн бус, үйл ажиллагааны эрсдэлийн хувьд төвлөрсөн удирдлагын тогтолцоотой ажиллаж байна.

Монголбанк дараах төрлийн санхүүгийн эрсдэлүүдийг үнэлэн удирдаж байна. Үүнд:

•Зээлийн эрсдэл,

•Зах зээлийн эрсдэл,

•Хөрвөх чадварын эрсдэл.

Эрсдэлийн удирдлагын алба (ЭУА) нь ГВАН-ийн удирдлагад Монголбанкны дундын албаны (middle office) үүрэг гүйцэтгэдэг бөгөөд цаашид Монголбанкны санхүүгийн эрсдэлийг бүхэлд нь төвлөрүүлэн удирддаг байхаар үйл ажиллагаагаа өргөтгөхөөр зорьж байна.

Монголбанкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь эрсдэлээс хамгаалах 3 үе шатанд тулгуурласан, нарийн тодорхойлсон чиг үүрэг бүхий засаглалын бүтцийг хамардаг.

Эрсдэлээс хамгаалах 3 үе шат

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А-163 тоот тушаалаар “Монголбанкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам” батлагдсан. Уг журамд үйл ажиллагааны эрсдэлийн тодорхойлолт, түүний ангилал, Монголбанкны нэгжүүдийн гүйцэтгэх үүрэг болон үйл ажиллагааны эрсдэлийг хэрхэн тодорхойлох, үнэлэх, арга хэмжээ авах талаар тусгасан.

ЭУА нь Монголбанкинд үйл ажиллагааны эрсдэлийн соёлыг бий болгох зорилгоор төв болон орон нутгийн салбар, хэлтсүүдийн нийт ажилтнуудад үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын талаар сургалт зохион байгуулж, нэгжүүдэд эрсдэлийг тодорхойлох, үнэлэх тал дээр дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Цаашид Монголбанкны бодлогын шийдвэртэй холбогдон гарах эрсдэл буюу бодлогын эрсдэлийг тодорхойлон үнэлэх чиглэлд өргөжүүлж, бодлогын, санхүүгийн, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг төвлөрүүлэн, эрсдэлийн үнэлгээний бие даасан байдлыг хангасан тогтолцоог бий болгохыг зорьж байна. Ингэснээр банкны үйл ажиллагаа, шийдвэр гаргах үйл явцад олон ургальч хандлагыг бий болгох, эрсдэлийн удирдлагын олон улсын чиг хандлагад нийцтэй тогтолцоотой болох юм.

4.7 БЭЛЭН МӨНГӨНИЙ ХАНГАЛТ

Монголбанкнаас 2016 онд мөнгөн тэмдэгттэй холбоотой дараах үйл ажиллагааг эрхлэв.

Тайлант онд 50-т болон 500-тын шинэ дэвсгэртүүдийн нөөцийг бүрдүүлсэн.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө нэрлэсэн дүнгээрээ 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 823.5 тэрбум төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 117.1 тэрбум төгрөг буюу 16.6 хувиар өссөн байна. Харин тоо ширхэгийн хувьд дэвсгэртийн тоогоор 33.0 сая ширхэгээр буюу 9.9 хувиар өссөнийг дараах хүснэгтээс харж болно.

Хүснэгт 1. **Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний үзүүлэлтүүд**

№	Дэвсгэрт	2015 оны 12 дугаар сарын 31				2016 оны 12 дугаар сарын 31			
		Үлдэгдэл дэвсгэрт (сая төгрөг)	хувь	мянган ширхэг	хувь	Үлдэгдэл дэвсгэрт (сая төгрөг)	хувь	мянган ширхэг	хувь
1	1	30	0.0%	30,302	9.1%	31	0.0%	31,012	8.5%
2	5	136	0.0%	27,242	8.2%	140	0.0%	27,970	7.7%
3	10	680	0.1%	67,958	20.5%	744	0.1%	74,434	20.4%
4	20	1,010	0.1%	50,498	15.2%	1,086	0.1%	54,281	14.9%
5	50	1,982	0.3%	39,641	12.0%	2,242	0.3%	44,849	12.3%
6	100	4,039	0.6%	40,394	12.2%	4,526	0.5%	45,266	12.4%
7	200	35	0.0%	176	0.1%	36	0.0%	182	0.0%
8	500	5,702	0.8%	11,404	3.4%	6,390	0.8%	12,779	3.5%
9	1000	16,278	2.3%	16,279	4.9%	17,962	2.2%	17,962	4.9%
10	5000	43,420	6.1%	8,684	2.6%	54,091	6.6%	10,818	3.0%
11	10000	148,941	21.1%	14,894	4.5%	165,678	20.1%	16,568	4.5%
12	20000	484,264	68.5%	24,213	7.3%	570,665	69.3%	28,533	7.8%
	Нийт	706,517	100.0%	331,685	100%	823,591	100.0%	364,654	100%

Хүснэгт 2. **Банкуудаас хүлээн авсан, банкинд олгосон бэлэн мөнгөний тоо, үнийн дүн**

Он	Банкинд олгосон		Банкнаас хүлээн авсан	
	Нийт дүн (тэрбум төгрөг)	мянган ширхэг	Нийт дүн (тэрбум төгрөг)	мянган ширхэг
2012	1 564,2	213 305	1 663,4	198 521
2013	1 601,6	216 394	1 728,7	202 035
2014	1 377,6	143 936	1 536,1	176 422
2015	1 238,9	190 518	1 352,6	187 536
2016	1 373,5	216 592	1 337,7	195 552
Нийт	**7 155,8**	**980 745**	**7 618,5**	**960 066**

Тайлант онд хөдөө орон нутгийн бэлэн мөнгөний эрэлтийг хангах зорилгоор аймгууд дахь Монголбанкны хэлтэс, салбаруудад 111.6 тэрбум төгрөгийн зузаатгал хүргүүлж, 38.4 тэрбум төгрөгийн сайн болон 25.5 тэрбум төгрөгийн муу мөнгөн тэмдэгтийг төвд татан авсан.

4.8 МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

Монголбанк нь тайлант онд банк хоорондын төлбөр тооцооны систем, банк хоорондын цахим арилжааны систем болон байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашиглагдаж буй цахим мэдээллийн системүүдийн аюулгүй, найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж ажиллалаа.

Монголбанкны Мэдээллийн технологийн газар нь банк хоорондын болон байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашиглагдаж буй цахим мэдээллийн системүүдийн тасралтгүй, найдвартай байдлыг хангаж ажиллахын зэрэгцээ эдгээр системийг сайжруулах, боловсронгуй болгох, шинэ техник, технологийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлууд хийлээ. Тухайлбал, банк хоорондын захын үйл ажиллагаанд ашиглагдаж буй Засгийн газрын болон Төв банкны үнэт цаасны арилжааны програм, банк хоорондын мөнгөний захын програм болон цахим тайлангийн системд нэмэлт сайжруулалт хийж гүйцэтгэлээ. Мөн зээлийн мэдээллийн сангийн болон санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагаанд шаардлагатай програм хангамжийг шинээр хөгжүүлэх ажлыг эхлүүлж, амжилттай хэрэгжүүлж байна.

Байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашиглаж буй мэдээллийн системүүдийг өргөтгөх, сайжруулах ажлууд хийгдэхээс гадна мэдээллийн технологиос хамаарсан эрсдэлийг бууруулах, мэдээллийн системүүдийн тасралтгүй, найдвартай байдлыг дээшлүүлэх, мэдээллийн технологийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн ажлууд хийж гүйцэтгэлээ.

4.9 МОНГОЛБАНКНААС 2016 ОНД БАТАЛСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

Мөнгөний бодлогын чиглэлээр				
1	Төгрөг, юанийн своп хэлцлийн журам	16.06.30	А-161	Банкуудын БНХАУ-ын юаниар төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад дэмжлэг үзүүлэх, ханшийн эрсдэлээс хамгаалах зорилгоор Монголбанкнаас арилжааны банкуудтай төгрөг, юанийн своп хэлцлийг байгуулахад баримтлах зарчим, талуудын эрх үүргийг тодорхойлохтой холбоотой харилцааг зохицуулсан.
2	“Хүүгийн коридор” системийг шинэчлэх тухай	16.08.18	А-214	Мөнгөний бодлогын “хүүгийн коридор” системийг Монголбанкны бодлогын хүүгийн хувь хэмжээнээс +3 (гурав), -1(нэг) нэгжийн хувийн өргөнөөр тэгш бус хэмтэйгээр шинэчлэн тогтоосон.
3	Төв банкны бодлогын хүүгийн хувь хэмжээг тогтоох тухай	16.08.18	А-215	Төв банкны бодлогын хүүг жилийн 4.5 нэгж хувиар өсгөж 15.0 хувиар тогтоосон.
4	Монголбанкнаас банкуудын төгрөгийн заавал байлгах нөөцийн хэмжээнд олгох хүү /Журам хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай/	16.09.30	А-270	Монголбанкнаас банкуудынн төгрөгийн заавал байлгах нөөцийн хэмжээнд олгох хүүг Төв банкны овернаит хадгаламжийн хүүгийн 50 хувьтай тэнцүү хэмжээгээр тогтоосон.
Төлбөрийн системийн чиглэлээр				
1	Төлбөрийн системд мөрдөх мэдээллийн технологийн тасралтгүй, найдвартай ажиллагааны журам	16.01.15	А-20	Энэхүү журмаар мэдээллийн технологийн үйл ажиллагаа саатсаны улмаас төлбөр тооцоо саатах, системийн эрсдэл үүсэх нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэхийн тулд төлбөрийн системийн оператор, оролцогчидын үйл ажиллагаанд мөрдвөл зохих хэм хэмжээ, шаардлагуудыг тодорхойлсон.
2	Төлбөрийн системийн оролцогч хоорондын бага дүнтэй төлбөр тооцооны журам	16.06.20	А-145	Төлбөрийн системийн оролцогч хоорондын бага дүнтэй төлбөр тооцоог үнэн зөв, найдвартай, тасралтгүй гүйцэтгэх үйл ажиллагааг зохицуулсан.
3	Төлбөрийн картын журам	16.06.30	А-160	Төлбөрийн картын Монгол улсын нутаг дэвсгэр дэх үйл ажиллагааг зохицуулах, зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих харилцааг зохицуулсан.

4	Төлбөрийн системийн хяналтын бодлогын баримт бичиг	16.09.28	А-265	Төлбөрийн системийн хяналт нь төлбөр тооцооны системд хяналт тавих, үнэлгээ хийх, шаардлагатай үед өөрчлөлт оруулах замаар төлбөрийн системийн найдвартай, үр ашигтай ажиллагааг хангуулсны үр дүнд үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх олон нийтийн итгэл, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх зорилготой Төв банкны үүрэг юм. Төлбөрийн системийн хяналтын зорилго нь Үндэсний төлбөрийн системийн найдвартай, үр ашигтай, тасралтгүй ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг удирдах замаар төлбөрийн системийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалж, санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.
Банкны Хяналт шалгалгалтын чиглэлээр				
1	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам	16.06.30	А-112-195	Энэхүү журмаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх, мэдээлэхтэй холбоотой эрсдэлд суурилсан тогтолцоог мэдээлэх үүрэгтэй үүрэгтэй этгээдэд бий болгохтой холбоотой харилцааг зохицуулна.
2	Гадаад гүйлгээний өдрийн мэдээ гаргах журам	16.06.09	А-133	Гадаад төлбөр тооцоо хийх зөвшөөрөл бүхий банкнаас хийсэн аливаа гадаад гүйлгээний мэдээллийн агуулгыг тодорхойлох, Монголбанкинд ирүүлэхэд баримтлах харилцааг журамласан.
3	Активыг ангилах, эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам	16.12.09	А-336/400	Энэхүү журмаар Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 27.1-д заасан зээл болон бусад активыг ангилах, Банкны тухай хуулийн 35.5 болон 36.6-д заасан зээл болон бусад актив төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан байгуулах, зарцуулахад тавигдах доод шаардлагыг Монголбанкнаас тогтоох, банкинд мөрдүүлэх үйл ажиллагааг зохицуулна.
Бусад				
2	Орон сууцны ипотекийн зээлийн зарим нөхцөлийг тогтоох тухай	16.03.04	А/32, А-64	Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 04-ны өдрийн 137 дугаар тогтоолоор батлсан “Ипотекийн зээл, санхүүжилтийн ерөнхий журам”-д заасан байршлаас хамаарч ипотекийн зээлийн жилийн хүүг 5 болон 8 хувиар тус тус тогтоох тухай.
3	Орон сууцны ипотекийн санхүүжилтийн хүүгийн хувь хэмжээг тогтоох тухай	16.03.15	А-71	Банкинд олгох найман хувийн хүүтэй орон сууцны ипотекийн санхүүжилтийн хүүг 4 хувиар тогтоосон.
6	Банкуудын хураангуй тэнцлийн маягтыг батлах тухай	16.06.30	А-165	Мөнгө санхүүгийн статистикийг эмхлэн гаргах, олон улсын стандартыг нэвтрүүлэх зорилгоор банкуудын хураангуй тэнцлийн маягтыг батлсан.

7	Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам	16.10.25	А-295	Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Улсын Их Хурлын 2016 оны 40 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн Монголбанкнаас банкинд орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэр олгох, түүний нөхцөлийг тодорхойлох, эргэн төлүүлэхтэй холбоотой харилцааг журамласан.
Нэмэлт, өөрчлөлт орсон эрх зүйн баримт бичгүүд				
1	Журамд өөрчлөлт оруулах тухай	16.03.04	А-65	Санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор УИХ-ын 2015 оны 93 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл”-ийн хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 460 дугаар тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулсан.
2	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	16.06.20	А-146	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны А-14 дүгээр тушаалаар батлагдсан “Урт хугацааны своп хэлцлийн журам”-ы-г боловсронгүй болгох зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулсан.
3	Үйлчилгээний шимтгэлийг ерөнхий нөхцөлд нэмэлт оруулах тухай	16.06.30	А-164	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны А-198 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Монголбанкны үйлчилгээний шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д нэмэлт оруулсан.
4	“Төв банкны репо арилжааны журам”-д өөрчлөлт оруулах тухай	16.08.19	А-213	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны А-42 дугаар тушаалаар батлагдсан “Төв банкны репо арилжааны журам”-д хүүгээр өрсөлдөх репо арилжааны хүүгийн доод хязгаарыг өөрчилсөн.
5	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	16.09.02	А-236	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны А-145 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн системийн оролцогч хоорондын бага дүнтэй төлбөр тооцооны журам”-ын 6 дугаар хэсэг, А-160 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн картын журам”-ын 12 дугаар хэсгүүдэд боловсронгуй болгох зорилгоор тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан.

АУДИТААР БАТАЛГААЖСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

5

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ДАГУУ БЭЛТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН БОЛОН ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

АГУУЛГА

ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУДЫН ТОДРУУЛГУУД

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Санхүүгийн тайланг бэлтгэх нь Монголбанкны Захирлуудын Зөвлөлийн үүрэг байна.

Монголбанк (цаашид “Банк”)-ны санхүүгийн тайлангууд Санхүүгийн Тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн болно. Банкны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг эдгээр санхүүгийн тайлангуудад үнэн зөв бодитой илэрхийлэгдсэнийг Захирлуудын зөвлөл баталгаажуулах үүрэгтэй.

Мөн Захирлуудын зөвлөл нь нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв зохистой хөтөлж явуулахыг хариуцах ба энэ нь Тодруулга 3-т тусгагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу Банкны санхүүгийн байдлыг үнэн зөв тайлагнах үүргийг биелүүлэх боломжийг олгодог.

Үүнээс гадна, Банкны хөрөнгийг хамгаалах, залилан, бусад зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх арга хэмжээг өөрийн эрх мэдлийн хүрээнд авч хэрэгжүүлэх нь Захирлуудын Зөвлөлийн үндсэн үүрэг болно.

Захирлуудын зөвлөл нь (1-ээс 80) дугаар хуудсанд тодруулсан) санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогыг тууштай баримталж, үндэслэлтэй бөгөөд оновчтой үнэлэлт, тооцооллыг ашиглаж, нягтлан бодох бүртгэлийн бүхий л холбогдох стандартуудыг дагаж мөрдсөн гэж үзэж байна.

Захирлуудын Зөвлөлийг төлөөлөн гарын үсэг зурсан:

Н.БАЯРТСАЙХАН
Монголбанкны Ерөнхийлөгч

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

pwc

Хараат бус аудиторын тайлан

Монголбанкны Захирлуудын Зөвлөлд

Хязгаарлалттай дүгнэлт

Бидний дүгнэлтээр, хараат бус аудиторын тайлангийн "Хязгаарлалттай дүгнэлт гаргах үндэслэл" хэсэгт дурьдагдсан учир шалтгааны улмаас эдгээр санхүүгийн тайланд нөлөөлөх болзошгүй нөлөөллийг эс тооцвол, Монголбанк ("Банк" гэх)-ны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон мөн тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бодитойгоор илэрхийлсэн байна.

Бид юунд аудит хийсэн талаар

Дараах бүрэлдэхүүн бүхий Банкны санхүүгийн тайлангуудад бид аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн байдлын тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн ашиг алдагдал болон дэлгэрэнгүй орлогын дэлгэрэнгүй тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн өмчийн өөрчлөлтийн тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн мөнгөн гүйлгээний тайлан болон
- нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд бусад тайлбар мэдээллүүдийг агуулсан санхүүгийн тайлангуудын тодруулгууд;

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Санхүүгийн тайлангийн тодруулга 15-д тодруулсны дагуу Банк нь дотоодын аж ахуйн нэгжүүдээс авах авлагын дүнг векселээр баталгаажуулж нягтлан бодох бүртгэлд хүлээн зөвшөөрсөн байна. Аж ахуйн нэгжүүдээс авах авлагын эргэн төлөлт, барагдуулах байдлыг үнэлэх хангалттай, найдвартай мэдээлэл байхгүй байгаа учир шалтгааны улмаас 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн авлагын дансны үнийн дүнгийн зохистой байдлыг үнэлэх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бид олж авч чадаагүй болно.

Бид Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу аудитын ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагын талаар тус тайлангийн *Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага* хэсэгт тусгасан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь хязгаарлалттай дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК, Сэнтрал Тауэр, 6 давхар, 601 тоот
Жанжин Д.Сүхбаатарын талбай, Сүхбаатар дүүрэг 8-р хороо,
Улаанбаатар хот 14200, Монгол Улс
Утас:+976 70009089 Факс:+976 (11)322068, www.pwc.com/mn

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Хараат бус байдал

Нягтлан бодогчдын олон улсын ёс зүйн стандартын зөвлөл (НБОУЁСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (МНБЁЗД)-ийн дагуу Банкнаас бид хараат бус болно. Бид НБОУЁСЗ-ийн МНБЁЗД-ийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор Банкны засаглал хариуцсан эрх бүхий этгээд болон удирдлагын зүгээс хүлээх үүрэг хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу болон залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэхэд шаардлагатай гэж удирдлага тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага байна.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх явцад удирдлага Банкны үйл ажиллагааг цаашид тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжийг үнэлэх, тухайн чадамжид нөлөөлөх нөхцөл байдлын талаар зохистой үед тодруулах болон Банкны үйл ажиллагааг татан буулгах, үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл зогсоохоос өөр сонголтгүй болсноос бусад тохиолдлуудад нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

Банкны засаглал хариуцсан эрх бүхий этгээд нь санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгааг олж авах мөн бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч, АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл байх тохиолдол бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх боломжтой ба энэ нь санхүүгийн тайланг хэрэглэгчдийн эдгээр тайланд үндэслэн гаргах эдийн засгийн шийдвэрт тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нөлөөлөхүйц байвал материаллаг буруу илэрхийлэл болно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандах, мэргэжлийн холбогдох итгэл үнэмшил бүхий үнэлэлтүүдийг хийдэг. Мөн бид:

- Залилан болон алдааны улмаас санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг илрүүлэн үнэлэх, тэдгээр эрсдэлүүдэд нийцсэн аудитын горимыг тодорхойлон гүйцэтгэх, аудитын дүгнэлт гаргахад үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Залилан нь нууцаар үгсэн тохирох, хуурамч бичиг баримт үйлдэх, санаатайгаар орхигдуулах, хуурамч батламж гаргах эсвэл эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотойгоор үүсдэг тул залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас шалтгаалж үүсэх материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэлээс илүү өндөр байдаг.
- Банкны дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг тодорхойлох зорилгын хүрээнд дотоод хяналтын тогтолцооны ойлголтуудыг аудитын явцад олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцооллуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)

- Банк үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадварт томоохон хэмжээний эргэлзээ үүсч болох нөхцөл байдал, тухайн үйл явдлуудтай холбоотойгоор материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэх болон удирдлага нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр хангахад зөв зохистой нягтлан бодох бүртгэлийн суурийг сонгосон эсэхийг аудитын туршид бүрдүүлсэн нотолгоонд үндэслэн дүгнэдэг. Хэрэв үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжид материаллаг тодорхойгүй байдал оршин байгаа гэж үзсэн тохиолдолд санхүүгийн тайлангуудын холбогдох тодруулгыг аудиторын тайланд тусгах, анхааруулах мөн эдгээр тодруулгууд хангалтгүй гэж үзсэн тохиолдолд дүгнэлтээ өөрчилдөг. Бид дүгнэлтээ аудиторын тайланг гаргах өдрийг хүртэл олж авсан аудитын нотолгоонуудад үндэслэн гаргадаг боловч ирээдүйд болох үйл явдал, нөхцөл байдлуудаас шалтгаалан Банкны үйл ажиллагаа зогсох нөхцөл байдал үүсч болно.

- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд мөн багтдаг.

Гарын үсэг зурсан:

Даваагийн Баярмаа
Гүйцэтгэх захирал
ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Баталсан:

Мэттью Поттл
Партнер

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК
2017 оны 3 дугаар сарын 31-ний өдөр
Улаанбаатар, Монгол Улс

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Сая төгрөгөөр	Тодруулга	2016 оны 12 дугаар сарын 31	2015 оны 12 дугаар сарын 31 (Дахин тайлагнасан)	2014 оны 12 дугаар сарын 31 (Дахин тайлагнасан)
ХӨРӨНГӨ				
Бэлэн мөнгө	7	38,953	53,793	57,990
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	8	1,455,517	1,085,063	1,409,350
Дотоодын банкуудад олгосон зээл	9	1,086,566	1,185,520	2,085,945
Санхүүгийн хөрөнгө оруулалт - борлуулахад бэлэн	10	2,694,922	2,459,044	1,246,939
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	11	1,049,526	1,328,021	1,466,557
Алт ба үнэт метал	12	232,527	420,152	333,959
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	13	10,413	7,895	2,964
Засгийн газрын үнэт цаас	14	326,508	202,218	204,828
Бусад хөрөнгө	15	696,645	404,574	575,116
Үндсэн ба биет бус хөрөнгө	16	28,034	28,773	27,390
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө		4,825	4,665	450
НИЙТ ХӨРӨНГӨ		**7,624,436**	**7,179,718**	**7,411,488**
ӨР ТӨЛБӨР				
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	17	823,629	706,656	809,657
Төв банкны үнэт цаас	18	577,297	1,024,581	853,781
Засгийн газрын хөрөнгө	19	1,008,324	702,456	798,649
Банкуудын хөрөнгө	20	2,671,566	1,818,985	2,803,462
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	13	939,453	272,954	72,668
Гадаад өр төлбөр	21	4,495,336	3,925,777	2,987,888
Бусад өр төлбөр	22	106,752	78,645	81,471
НИЙТ ӨР ТӨЛБӨР		**10,622,357**	**8,530,054**	**8,407,576**
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ				
Дүрмийн сан	23	5,000	5,000	5,000
Хуримтлагдсан алдагдал	23	(3,019,323)	(1,372,114)	(1,019,103)
Бусад нөөц	23	16,402	16,778	18,015
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		**(2,997,921)**	**(1,350,336)**	**(996,088)**
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		**7,624,436**	**7,179,718**	**7,411,488**

2017 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Захирлуудын Зөвлөлийг төлөөлж энэхүү тайланг нийтлэхийг хүлээн зөвшөөрөв.

Н.Баяртсайхан
Монголбанкны Ерөнхийлөгч

Э.Анар
Төлбөр тооцоо, бүртгэлийн газрын захирал

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Сая төгрөгөөр	Тодруулга	2016 оны 12 дугаар сарын 31	2015 оны 12 дугаар сарын 31 (Дахин тайлагнасан)
Хүүгийн орлого	24	228,557	203,780
Хүүгийн зардал	24	(355,850)	(348,013)
Хүүгийн цэвэр зардал		**(127,293)**	**(144,233)**
Алт, үнэт металын арилжааны ашиг	25	100,611	3,101
Алт, үнэт металын ханшийн тэгшитгэлийн алдагдал	26	(804)	(4,242)
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн дахин үнэлгээний ашиг/(алдагдал)	27	(663,980)	(195,356)
Гадаад валютын арилжааны ашиг/(алдагдал)		5,222	(3,048)
Гадаад валютын хөрвүүлгийн ашиг/(алдагдал)	28	(429,763)	32,390
Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн алдагдал		(451,399)	(28,603)
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийг борлуулсаны ашиг		78	65
Болзошгүй алдагдлын нөөц сангийн (зардал)/буцаалт	29	(119,103)	6,396
Үйл ажиллагааны бусад орлого	30	72,320	7,492
Захиргааны ба үйл ажиллагааны бусад зардал	31	(33,915)	(31,356)
ТАЙЛАНТ ЖИЛИЙН АЛДАГДАЛ		**(1,648,026)**	**(357,394)**
Бусад дэлгэрэнгүй орлого:			
Ашиг алдагдалд дахин ангилагдаж болзошгүй зүйлс:			
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт:			
-Бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз/ (гарз)		519	3,211
- Борлуулах үед орлогын тайланд шилжүүлсэн		(78)	(65)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого		**441**	**3,146**
ТАЙЛАНТ ЖИЛИЙН НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ АЛДАГДАЛ		**(1,647,585)**	**(354,248)**

Сая төгрөгөөр	Тодруулга	Дүрмийн сан	Хуримтлагд-сан алдагдал	Бусад сангууд	Нийт өөрийн хөрөнгө
2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн үлдэгдэл	23	**5,000**	**(1,019,103)**	**18,015**	**(996,088)**
Тайлант жилийн алдагдал		-	(357,394)	-	**(357,394)**
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-	3,146	**3,146**
2015 оны нийт дэлгэрэнгүй алдагдал		-	(357,394)	3,146	**(354,248)**
Хуримтлагдсан ашгаас бусад нөөцөд шилжүүлсэн	23	-	4,383	(4,383)	-

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл		**5,000**	**(1,372,114)**	**16,778**	**(1,350,336)**
Тайлант жилийн алдагдал		-	(1,648,026)	-	**(1,648,026)**
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-	441	**441**
2016 оны нийт дэлгэрэнгүй алдагдал		-	(1,648,026)	441	**(1,647,585)**
Хуримтлагдсан ашгаас бусад нөөцөд шилжүүлсэн	23	-	817	(817)	-
2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл		**5,000**	**(3,019,323)**	**16,402**	**(2,997,921)**

2016 болон 2015 онд хуримтлагдсан ашиг/(хуримтлагдсан алдагдал)-аас бусад нөөцөд шилжүүлсэн дүн нь барилгын дахин үнэлгээний нэмэгдлийн буцаалт ба алт, үнэт металын ханшийн тэгшитгэлийн бодит бус ашиг /алдагдлыг шилжүүлсэнтэй холбоотой болно. (Тодруулга 23).

Сая төгрөгөөр	**Тодруулга**	**2016 оны 12 дугаар сарын 31**	**2015 оны 12 дугаар сарын 31 (Дахин тайлагнасан)**
Тайлант жилийн алдагдал:		(1,648,026)	(357,395)
Тохируулгууд:			
Алт ба үнэт металын ханшийн тэгшитгэлийн алдагдал	26	804	4,242
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн дахин үнэлгээний алдагдал	2,27	663,980	195,356
Гадаад валютын хөрвүүлгийн бодит бус алдагдал	28	597,759	58,703
Үндсэн болон биет бус хөрөнгийн элэгдэл	16,31	2,513	2,397
Данснаас хассан үндсэн хөрөнгө	31	25	12
Үндсэн хөрөнгө борлуулсны ашиг	31	(51)	(37)
Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэгсэл борлуулсны олз		(78)	(65)
Болзошгүй алдагдлын нөөц сангийн зардал/(буцаалт)	29	119,103	(6,396)
Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн алдагдал	10	451,399	28,603
Нийгмийн хөгжлийн санд хуваарилсан хөрөнгө	31	-	2,000
Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн орлого	31	(63,246)	-
Хүүгийн орлого	24	(228,557)	(203,780)
Хүүгийн зардал	24	355,850	348,014
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		**251,475**	**71,654**

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтүүд:		
Алт, үнэт металын цэвэр(өсөлт) /бууралт	188,429	(90,435)
Урвуу буцаан худалдан авах хэлцлийн (өсөлт) /бууралт	185,043	139,362
Дотоодын банкуудын хөрөнгийн цэвэр бууралт/ (өсөлт)	344,984	(471,470)
Засгийн газарт олгосон зээлийн өсөлт	(419,674)	-
Засгийн газрын үнэт цаасны цэвэр бууралт	2,426	2,683
Бусад хөрөнгийн цэвэр (өсөлт) / бууралт	(462,164)	241,209
Төв банкны үнэт цаасны цэвэр (бууралт) /өсөлт	(450,304)	170,109
Засгийн газрын хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)	279,103	(96,195)
Дотоодын банкуудын хөрөнгийн цэвэр өсөлт/ (бууралт)	581,892	(984,844)
Бусад өр төлбөрийн өсөлт	(14,814)	(2,188)
Үйл ажиллагаанаас олсон (үйл ажиллагаанд зарцуулсан) хүүгийн өмнөх цэвэр мөнгөн гүйлгээ	**486,396**	**(1,020,115)**
Хүлээн авсан хүү	193,949	187,407
Төлсөн хүү	(330,800)	(389,945)

Сая төгрөгөөр	Тодруулга	2016 оны 12 дугаар сарын 31	2015 оны 12 дугаар сарын 31 (Залруулсан)
Үйл ажиллагаанаас олсон (үйл ажиллагаанд зарцуулсан) нийт цэвэр мөнгөн гүйлгээ		**349,545**	**(1,222,653)**
Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ			
Үндсэн болон биет бус хөрөнгийн худалдан авалт	16	(3,275)	(3,975)
Үндсэн хөрөнгийн борлуулалтаас хүлээн авсан		1,500	216
Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэгслийн худалдан авалт		(2,107,329)	(1,086,007)
Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэгслийн борлуулалтаас хүлээн авсан		2,194,761	1,180,467
Засгийн газрын үнэт цаасны худалдан авалт		(602,289)	-
Засгийн газрын үнэт цаасны борлуулалт болон эргэн төлөлтөөс хүлээн авсан		150,576	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас олсон цэвэр мөнгөн гүйлгээ		**(366,056)**	**90,701**
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөний цэвэр (өсөлт)/ бууралт		116,973	(103,001)
Гадаад өр төлбөрийн төлөлт		(1,515,482)	(7,700,355)
Гадаад өр төлбөрийн татан авалт		1,485,199	8,643,221
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		**86,690**	**839,865**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө		285,235	(36,448)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/ (бууралт)		**355,414**	**(328,534)**
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7	1,137,926	1,466,460
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**7**	**1,493,340**	**1,137,926**

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

1. ТАНИЛЦУУЛГА

Монголбанк (цаашид “Банк”) нь Монгол Улсын Төв банк бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль болон бусад холбогдох хуулиудын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. Монгол Улсын Засгийн газрын 1924 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн тогтоолоор “Монголын худалдаа, аж үйлдвэрийн банк” гэж байгуулагдсан.

Банк нь бүхий л үйл ажиллагаагаа Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулдаг болно. Монголбанкны системд орон нутгийн нийт 17 хэлтэс, салбар болоод Лондон (Их Британи) дахь төлөөлөгчийн газар байдаг.

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд зааснаар Банкны үндсэн зорилго нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээл болон банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар эдийн засгийн хөгжилд тэнцвэртэй дэмжлэг үзүүлэх явдал юм.

Банк нь ашгийн төлөө ажилладаггүй. Төрөөс үүсгэн байгуулсан тусгай хуулийн этгээдийн хувьд Банкны үйл ажиллагааны санхүүгийн үр дүн болон хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгийн бүтэц нь Банкны үйл ажиллагаагаар тодорхойлогддог.

Банк нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн дагуу дараах үндсэн үйл ажиллагааг явуулдаг. Үүнд:

- Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах;
- мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэх (“Засгийн газар” эсвэл ”Төрийн”);
- Банкны үйл ажиллагаанд хяналт тавих;
- Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах;
- Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах;

Хуулинд заасны дагуу Банк нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг нь дэмжих зорилгоор банкуудад зээл олгох, хоёрдогч зах зээл дээр үнэт цаас худалдах, худалдан авах, гадаад валют, үнэт метал худалдах, худалдан авах, дотоодын ба гадаадын зах зээл дээр үнэт метал болон энгийн металлаар хийсэн дурсгалын зоосыг худалдах, Засгийн газрын үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах, Засгийн газар болон Сангийн яам (Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага) гэх мэт бусад төрийн байгууллагууд, Олон улсын байгууллагуудын дансыг Банкинд байршуулах болон өөрийн үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай бусад үйл ажиллагааг явуулдаг.

Банкны дүрмийн санг Монгол Улсын Төр бүрэн эзэмшдэг. Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд заасны дагуу Захирлуудын зөвлөлийн үндсэн үүрэг нь мөнгөний бодлогын зарчмыг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавих явдал юм. Түүнчлэн, Банкны ирэх оны жилийн төсвийг батлах, түүний биелэлт гүйцэтгэлийн талаар олон нийтэд тайлагнах, тайлант жилийн ашгийн хуваарилалтыг хийх зэрэг Монгол Улсын хууль тогтоомжид заасан эрх мэдлийн хүрээнд бусад чиг үүргийг Захирлуудын зөвлөл гүйцэтгэдэг.

Бүртгэгдсэн хаяг ба үйл ажиллагаа явуулж буй байршил. Банкны бүртгэгдсэн албан ёсны хаяг нь: Монгол Улс, Улаанбаатар 46, Бага Тойруу 3, 15160.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ТОГТОЛЦОО, ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ БОЛОН ТОЛИЛУУЛГА

Тайлан бэлтгэх үндэслэл. Эдгээр санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”)-ын дагуу санхүүгийн хэрэгслийг анхлан бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрөх болон үндсэн хөрөнгө, борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийг ашиг алдагдал буюу бодит үнэ цэнийн дагуу бүртгэх, мөн санхүүгийн хэрэгслийг дахин үнэлж бүртгэхээс бусад тохиолдолд түүхэн өртгийн зарчмын дагуу бэлтгэгдэж тайлагнасан болно.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын талаар дор толилуулав. Эдгээр бодлогуудыг өөрөөр заагаагүй тохиолдолд толилуулж буй бүх тайлант үеийн турш мөрдөж хэрэгжүүлсэн (Тодруулга 3).

Тайлагналын мөнгөн нэгж. Энэхүү санхүүгийн тайлангуудыг Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох “төгрөг”-өөр илэрхийлэгдсэн болно.

Санхүүгийн тайланг баталгаажуулсны дараа өөрчлөлт хийх тухай Банкны удирдлага нь санхүүгийн тайланг баталгаажуулсан өдрөөс хойш хугацаанд эдгээр санхүүгийн тайлангуудад өөрчлөлт хийх эрхтэй болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД

Санхүүгийн хэрэгсэл – гол хэмжилтийн нэр томьёо. Санхүүгийн хэрэгслийн ангиллаас хамааран тэдгээрийг дор тайлбарласны дагуу бодит үнэ цэнэ, өртөг эсвэл хорогдуулсан өртгөөр бүртгэлд тусгадаг.

Бодит үнэ цэнэ нь мэдлэг бүхий холбоогүй талууд сайн дураараа хоорондоо хөрөнгө солилцох эсвэл өр төлбөр барагдуулахад бэлэн буй үнийг хэлнэ. Бодит үнэ цэнэ нь санхүүгийн хөрөнгийн хувьд идэвхитэй зах зээл дээр зарласан өнөөгийн худалдаж авах үнэ, санхүүгийн өр төлбөрийн хувьд өнөөгийн худалдах үнэ болно. Идэвхитэй зах зээл гэдэг нь хөрөнгө ба өр төлбөртэй холбоотой гүйлгээ хангалттай их хэмжээгээр тогтмол гардаг, тэдгээрийн үнийн мэдээллийг хэдийд ч авах боломжтой газрыг хэлнэ.Санхүүгийн хэрэгслийн санал болгож байгаа үнэ нь хөрөнгийн зах зээл эсвэл бусад санхүүгийн байгууллагуудаас тогтмол нийтэд зарладаг буюу мэдээлэл нь нээлттэй олдох боломжтой ба эдгээр үнийн дагуу зах зээл дээр холбоогүй этгээдүүдийн хооронд байнгын тогтмол гүйлгээ хийгддэг тохиолдолд санхүүгийн хэрэгслийг идэвхитэй зах зээл дээр санал болгосон гэж үздэг.

Харин зах зээлийн үнийн талаар мэдээлэл олдохгүй тохиолдолд зарим санхүүгийн хэрэгслийг тэдгээрийн бодит үнэ цэнийг хямдруулсан мөнгөн гүйлгээний үнэлгээний загвар эсвэл холбоогүй талуудын хооронд сүүлийн үед хийгдсэн хэлцлийн үнэ, эсвэл санхүүжигч талын санхүүгийн мэдээлэл дээр үндэслэх гэх мэт үнэлгээний бусад аргачлалыг ашиглан тооцдог. Үнэлгээний аргачлалууд нь зах зээлд тогтмол ажиглагдаагүй мэдээлэл ашиглах тохиолдолд таамаглал хийхийг шаардаж болно. Хэрэв энэ мэт таамаглалыг зохистой өөр боломжит хувилбараар өөрчилсөн тохиолдолд орлого, нийт хөрөнгө эсвэл нийт өр төлбөрийн дүнд томоохон өөрчлөлт гарч болохоор бол холбогдох тодруулгуудыг эдгээр санхүүгийн тайлангуудад хийсэн болно.

Өртөг нь хөрөнгийг худалдаж авахад төлсөн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө эсвэл бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх нөхөн төлбөрийн дүн бөгөөд үүнд *гүйлгээний зардлууд* багтдаг. Зах зээл дээр санал болгож буй тодорхой жишиг үнэ байхгүй, бодит үнэ цэнийг нь тодорхойлох боломжгүй өмчийн хэрэгслийг зөвхөн өртгөөр бүртгэж болно (Тодруулга 10).

Гүйлгээний зардлууд нь санхүүгийн хэрэгслийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардал нь гүйлгээг хийгээгүй тохиолдолд үүсэхгүй байх зардлыг хэлнэ. Гүйлгээний зардалд зуучлагч, борлуулагч (борлуулалтын үүрэг гүйцэтгэж буй ажилтнуудын цалин), зөвлөх, брокер, дилерүүдэд төлсөн хураамж шимтгэл, зохицуулах агентлаг, хөрөнгийн биржийн ногдуулсан хураамж төлбөрүүд, мөн шилжүүлэлтэд ногдуулсан татвар хураамжууд хамаарна. Гүйлгээний зардалд өрийн хямдруулалт буюу урамшуулал, санхүүгийн зардлууд, дотоодын захиргааны буюу хадгалалтын зардлууд орохгүй.

Хорогдуулсан өртөг гэдэг нь санхүүгийн хэрэгслийг анхлан хүлээн зөвшөөрсөн дүнгээс аливаа үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хасаж, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүд анх хүлээн зөвшөөрсөн хойшлогдсон гүйлгээний зардал, мөн нэрлэсэн үнээс аливаа урамшууллын эсвэл хямдруулалтын дүнг үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулалт багтана. Хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардал, мөн хуримтлагдсан купон болон үнийн хорогдуулсан урамшуулал ба хямдруулалтыг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулаагүй ба тэдгээрийг санхүүгийн байдлын тайлангийн холбогдох хэсэгт дансны үнээр тусгасан болно.

Үр ашигт хүүгийн арга нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны турш дансны үнээс тооцогдох хүүгийн түвшинг тогтмол байлгахаар (үр ашигт хүүгийн хувь) хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн түвшин нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын орлого, эсвэл гарах зарлагыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэгслийн хүлээгдэж буй хугацаа

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны турш хямдруулж санхүүгийн хэрэгслийн бүртгэлийн цэвэр дүнг гаргаж авах хүүгийн түвшин юм. Үр ашигт хүүг хувьсах хүүтэй хэрэгслийн мөнгөн урсгалын хүүг өөрчлөх дараагийн мөч хүртэл хямдруулах боловч уг хэрэгсэлд тусгагдсан хувьсах хүү дээр нэмэгдэх зээлийн хүүгийн зөрүүг илэрхийлсэн урамшуулал болон хямдруулалтыг, мөн зах зээлийн түвшинд тохируулагдахгүй бусад хувьсах хүчин зүйлүүдээс үл хамаарна. Эдгээр урамшуулал болон хямдруулалтыг тухайн хэрэгслийн хүлээгдэж буй нийт хугацаагаар хорогдуулан тооцно. Өнөөгийн үнэ цэнийн тооцоололд гэрээний талуудын хооронд төлөх эсвэл хүлээн авах бүх хураамжийг оруулах бөгөөд тэдгээр нь үр ашигт хүүгийн нэг бүрэлдэхүүн хэсэг болно.

Санхүүгийн үүсмэл хэрэгслийг анхлан хүлээн зөвшөөрөх. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд нь анхлан бодит үнэ цэнээрээ бүртгэгдэнэ. Бусад бүх санхүүгийн хэрэгслийг анхлан бодит үнэ цэнэ дээр гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр бүртгэдэг. Анх бүртгэх бодит үнэ цэнэ нь гүйлгээ хийгдсэн үнээр хамгийн сайн баталгаажсан байдаг. Анх бүртгэх үед үүсэх олз эсвэл гарзыг бодит үнэ цэнэ болон гүйлгээний үнийн хооронд зөрүү гарсан бөгөөд үүнийг зөвхөн ижил төрлийн хэрэгслийг сүүлийн үед арилжсан талаарх зах зээлийн нээлттэй мэдээллээр баталгаажуулсан эсвэл зөвхөн нээлттэй зах зээлээс авсан мэдээлэл дээр үндэслэж хийсэн үнэлгээний аргачлалаар тооцсон тохиолдлуудад хүлээн зөвшөөрдөг.

Зохицуулах байгууллагаас тогтоосон эсвэл зах зээлийн жишгээр тогтсон ("хэвийн" худалдаа болон худалдан авалт) тодорхой хугацаанд багтаан нийлүүлэх шаардлагатай санхүүгийн хөрөнгийн бүхий л борлуулалт болон худалдан авалтыг арилжаа хийсэн өдөр буюу Банк тухайн санхүүгийн хөрөнгийг нийлүүлэх үүрэг хүлээсэн үед бүртгэнэ. Бусад бүх худалдан авалтыг Банк нь санхүүгийн хэрэгслийн гэрээний тал болсон үед хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасах. Банк санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасдаг: (а) хөрөнгийн төлбөрийг авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ Банк бусдад шилжүүлэн өгсөн эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн дамжуулан өгөх хэлцэлд оролцож (1) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлсэн, эсвэл (2) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлээгүй ч, өөртөө авч үлдээгүй буюу хяналтын эрхийг хадгалж үлдээгүй тохиолдолд. Холбогдох тал хөрөнгийн борлуулалтад нэмэлт хязгаарлалт хийлгүйгээр холбоогүй гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах боломжгүй тохиолдолд хяналтын эрхийг хадгалж үлдсэн гэж үзнэ.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө. Гадаад болон дотоод хөрвөх чадварын өөрчлөлтийг мөнгөн гүйлгээний тайланд тусгах зорилгоор тодорхой хэмжээний мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд түргэн хөрвөх чадвартай, үнэ цэнээ алдах эрсдэл бага бүхий зүйлс багтдаг. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд богино хугацаанд зарцуулж болох гурван сараас бага хугацаатайгаар байршуулсан хугацаатай хадгаламж, хугацаагүй хадгаламж бүхий санхүүгийн хөрөнгө болон төгрөгөөр илэрхийлэгдсэн Засгийн газар, дотоодын банкуудын хугацаагүй хадгаламжууд орно.(Тодруулга 7) Зарцуулалтад хязгаарлалт хийсэн эсвэл хөрвөх чадвар муутайгаас шууд хөрвөдөггүй санхүүгийн хөрөнгийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд оруулаагүй болно. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг үр ашигт хүүгийн аргын тусламжтайгаар хорогдуулсан өртгөөр бүртгэдэг.

Алт ба үнэт метал. Олон улсын стандартын дагуу алт,үнэт металыг гадаадын банкинд биет болон биет бус хэлбэрээр хадгалдаг. Байршуулсан алт нь гадаад валютын нөөцийн нэгээхэн хэсгийг илэрхийлнэ. Эдгээр металууд нь трой унцаар хэмжигдэж бүртгэгдэх ба Банкны албан ханшны дагуу төгрөгөөр илэрхийлэгдэнэ. Алтны арилжааны албан ханш нь Лондонгийн Алтны Захын Холбооноос зарласан

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

үнэт металын ам.долларын ханшийг Банкнаас зарласан албан буюу төгрөг-ам.долларын харьцах ханшаар төгрөгт хөрвүүлснээр илэрхийлэгддэг болно. Алтыг дээр дурдсан байдлаар эзэмшихээс гадна Банк нь Монгол Улс дахь алт олборлогч аж ахуйн нэгж, иргэдээс цэвэршүүлээгүй алт худалдан авч гадаад зах зээлд цэвэршүүлэн худалддаг (Тодруулга 12).

Алтыг бодит үнэ цэнээр нь санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрөх ба ханшийн тэгшитгэлийг өдөр бүр хийдэг. Бодит үнэ цэнийг тогтоохдоо алт ба мөнгөний зах зээлийн үнийг харгалзан үздэг. Ханшийн тэгшитгэлийн бодит бус ашиг, алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрөх ба энэхүү бодит бус ашиг, алдагдлыг жилийн эцэст өөрийн хөрөнгө дэх "Үнэт металын дахин үнэлгээний сан"-д хаадаг (Тодруулга 23). Банк нь алт, мөнгө зэрэг бусад үнэт метал, зоос болон соёлын үнэт зүйлсийг Эрдэнэсийн санд хадгалдаг. Бусад үнэт металыг бараа материалаар бүртгэж өртөг, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь бүртгэдэг.

Гадаад валютын хөрвүүлэг. Банкны үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт нь түүний үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн үндсэн орчны үндэсний мөнгөн тэмдэгт байна. Банкны үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн тэмдэгт нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох "Монгол төгрөг" юм.

Мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг холбогдох тайлант үеийн эцэст төгрөгийн албан ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгжид хөрвүүлж бүртгэнэ. Төлбөр тооцоо хийх болон жилийн эцсийн Төгрөгийн албан ханшид мөнгөн хөрөнгө ба өр төлбөрийг үйл ажиллагааны мөнгөн тэмдэгтэд хөрвүүлэхэд үүсэх ханшийн олз, гарзыг орлогын тайланд (гадаад валютын хөрвүүлгийн ашиг, алдагдлаар) хүлээн зөвшөөрдөг. Түүхэн өртгөөр бүртгэдэг мөнгөн бус зүйлсийг тайлант жилийн хаалтын ханшаар хөрвүүлж бүртгэхгүй. Харин өмчийн хөрөнгө оруулалт зэрэг бодит үнэ цэнэ нь гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг бодит өртгийг тодорхойлсон өдрийн ханшаар хөрвүүлж бүртгэнэ.

2016 оны 12 дугаар сарын 31-нээрх гадаад валют бүхий дүнг хөрвүүлэхэд ашиглагдсан ханш:

	2016 оны 12 дугаар сарын 31 өдөр (Төг)	**2015 оны 12 дугаар сарын 31 өдөр (Төг)**
Ам.доллар	2,489.53	1,995.98
Зээлжих тусгай эрх	3,335.09	2,772.52
Евро	2,605.79	2,182.70
Юань	357.96	307.54
Иен	21.19	16.58

Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө. Банк харилцагч банк руу арилжааны бус зорилгоор мөнгө шилжүүлснээр хөрөнгийн зах зээл дээр бүртгэгдээгүй, дериватив бус, тусгайлан заасан буюу тодорхойлох боломжтой хугацаанд эргүүлэн төлөгдөх авлага үүсэх үед бусад банкуудад байршуулсан хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Эдгээр нь СТОУС-ын хэмжилтийн зорилгоор зээл ба авлага хэмээн ангилагддаг. Бусад банкуудад байршуулсан хөрөнгийг анхлан бодит үнэ цэнэ дээр нь гүйлгээний зардлыг нэмж бүртгэх ба түүнээс хойш үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр нь бүртгэнэ.

Банкууд ба бусад зээлдэгч нарт олгосон зээл, тэдгээрээс авах бусад авлага болон Засгийн газрын үнэт цаас. Банк нь цааш арилжаалах зорилгогүйгээр харилцагчаас хөрөнгийн зах зээл дээр бүртгэгдээгүй, үүсмэл бус авлагыг тусгайлан заасан буюу тодорхойлох боломжтой хугацаанд эргүүлэн төлөгдөх мөнгө шилжүүлсэн үед, Банкууд болон бусад зээлдэгч нарт (жишээ нь Сангийн яам) олгосон зээлийг хүлээн зөвшөөрнө. Эдгээр нь (Сангийн яамнаас гаргасан Засгийн газрын үнэт цаасыг багтаан) СТОУС-ын дагуу зээл ба авлага хэмээн ангилагддаг. Бусад банкуудад байршуулсан хөрөнгийг анхлан бүртгэхдээ **3**

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

бодит үнэ цэнэ дээр нь гүйлгээний зардлыг нэмж хүлээн зөвшөөрөх ба түүнээс хойш үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь бүртгэнэ.

СТОУС 13-д тодорхойлсны дагуу тухайн зээл болон бусад авлагыг үндсэн зах зээлийн хэрэгсэл гэж үзсэн тохиолдолд, зах зээлийн хүүгийн түвшингөөс доогуур олгосон зээл болон бусад авлагыг ан хүлээн зөвшөөрч бүртгэхэд гарах алдагдлыг хүлээн зөвшөөрөхгүй. Харин зах зээлийн хүүгийн түвшингөөс доогуур олгосон тухайн зээл болон бусад авлага нь үндсэн зах зээлийн тодорхойлолтын шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд ашиг эсвэл алдагдлаар тайлагнана. Зээл ба бусад авлагын холбогдох ажил гүйлгээ нь Банкны чиг үүрэг функцүүд болох мөнгөний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, инфляцыг тогтворжуулах, эдийн засгийн өсөлтийг дэмжих болон Монголын банкны салбарын тогтвортой байдлыг хангах зэрэг үйл ажиллагааг хамаарч байвал үндсэн зах зээлийн тодорхойлолтын шаардлагыг хангасан гэж үзнэ.

СТОУС 13-ын дагуу үндсэн зах зээлийн тодорхойлолтын шаардлагыг хангаагүй, Төв банкны үндсэн чиг үүргийг гүйцэтгэхтэй хамааралгүй зээл, бусад авлагыг зах зээлийн хүүгийн түвшингөөс доогуур олгосон тохиолдолд анх хүлээн зөвшөөрч бүртгэхэд алдагдлыг хүлээн зөвшөөрөх ба ашиг эсвэл алдагдлаар тайлагнана. Удирдлагын зүгээс энэ талаар хийсэн итгэл үнэмшил, дүгнэлтийн талаар (Тодруулга 4-гхарна уу).

Зээлдүүлсэн үнэт цаас ба буцаан худалдан авах хэлцлүүд. Харилцагч этгээдэд зээлдэгч буцаан төлөхөөр олгогддог худалдах буцаан худалдан авах гэрээг (“репо хэлцэл”) баталгаажсан санхүүгийн гүйлгээ гэж үздэг. “Репо хэлцэл”-ийн дор худалдсан үнэт цааснуудыг санхүүгийн бүртгэлээс хасдаггүй. Харин хөрөнгө хүлээн авагч гэрээний дагуу тус хөрөнгийг борлуулах болон дахин барьцаанд тавих эрхтэй үед тус хөрөнгийг “Буцаан худалдан авах авлага” гэж ангилахаас бусад тохиолдолд үнэт цаасыг санхүүгийн байдлын тайланд дахин ангилдаггүй.

Зээлдэгчээс Банкинд эргэн төлөхөөр олгосон буцаан худалдах хэлцлийн (“урвуу репо хэлцэл”) дагуу худалдан авсан үнэт цаасыг гадаадын байгууллагаас авах авлага эсвэл дотоодын банкинд олгосон зээлийн аль тохиромжтойгоор нь бүртгэнэ. Буцаан худалдан авах болон худалдах үнийн зөрүүг хүүгийн орлого гэж хүлээн зөвшөөрөх ба үр ашигт хүүгийн түвшингөөр “репо” хэлцлийн хугацааны турш хуримтлуулна.

Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт. Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрч бүртгэснээс хойш нэг буюу олон үйл явдлаас (“гарз учруулсан үйл явдлууд”) шалтгаалан санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг хөрөнгүүдийн ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалын хэмжээ нь өөрчлөгдсөнийг үнэн зөв тооцох боломжтой болсон тохиолдолд л тайлант жилийн орлого, зарлагад хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгөнд үнэ цэнийн бууралтын гарз учруулах үйл явдлуудын бодит нотолгоог тодорхойлоход дараах мэдээллүүдийг харгалзан үзнэ. Үүнд:

- зээлдэгч санхүүгийн мэдэгдэхүйц хүндрэлд орсон;
- зээлдэгч гэрээгээ зөрчсөн;
- зээлдэгч дампуурлаа зарлах буюу бусад санхүүгийн бүтцийн өөрчлөлт хийх магадлалтай;
- зээлдэгчийн санхүүгийн хүндрэлтэй холбоотойгоор үйл ажиллагаа явуулж буй эсвэл тухайн хөрөнгийн зориулалтын зах зээлд тайлант болон ойрын хугацаанд байгууллагад сөрөг нөлөө учруулж болохуйц эдийн засаг, хууль эрх зүйн орчны томоохон хэмжээний өөрчлөлтүүд гарах (жишээ нь, хүүгийн хувийг өөрчлөх эсвэл эргэн төлөгдөх хугацааг сунгах гэх мэт);

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

- анх хүлээн зөвшөөрсөнөөс хойш бүлэг санхүүгийн хөрөнгөөс орж ирэх ирээдүйн мөнгөн урсгал буурсныг тодорхойлж болохуйц мэдээлэл байх гэх мэт.

Банк харьцангуй цөөхөн зээлдэгчид (харилцагчид болон бусад зээлдэгчид)-тэй тул хорогдуулсан өртгөөр бүртгэдэг бүх санхүүгийн хөрөнгүүддээ тусгай үнэлгээ хийдэг, өөрөөр хэлбэл тус бүрд нь үнэ цэнийн бууралтын бодитой нотолгоо байгаа эсэхийг үнэлдэг. Хэрэв үнэ цэнийн бууралт хүлээн зөвшөөрөх бодитой нотолгоо байна гэж үзвэл хүлээн зөвшөөрөх гарзын хэмжээг хөрөнгийн дансны үнэ болон ирээдүйн мөнгөн урсгалын (одоогоор гараагүй байгаа, ирээдүйд хүлэгдэж буй зээлийн алдагдлыг оролцуулахгүй) өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр хэмжинэ.

Хөрөнгийн дансны үнийг хасагдуулгын дансыг ашиглан хорогдуулах ба “Болзошгүй алдагдлын нөөцийн сан” дансанд ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Хүүгийн орлогыг хорогдуулсан дансны үнээс хуримтлуулан тооцох ба үнэ цэнийн бууралтын гарзыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг хямдруулах бөгөөд “Хүүгийн орлого” дансанд тайлант үеийн ашиг алдагдлаар бүртгэнэ.

Зээл ирээдүйд эргэн төлөгдөх ямар нэгэн бодитой чиг хандлага бий болсон мөн бүх барьцаа хөрөнгө нь Банк руу шилжсэн эсвэл Банкны хөрөнгөөр хүлээн зөвшөөрөгдсөн үед зээл нь хасагдуулгын дансны хамт бүртгэлээс хасагдана. Хэрэв үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш болсон үйл явдлын нөлөөгөөр дараагийн жилд нь тооцоолсон үнэ цэнийн бууралтын алдагдал ихсэх эсвэл багасвал өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ

цэнийн бууралтын алдагдлыг хасагдуулгын дансаар дамжуулан өсгөж эсвэл бууруулна. Өмнөх жилүүдэд данснаас хасагдсан зээл эргэн төлөгдвөл тухайн эргэн төлөгдсөн жилдээ ”Болзошгүй алдагдлын сангийн буцаалт” дансанд бүртгэгдэнэ.

Ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг үндсэн хүүгийн аргаар хямдруулан тооцно. Хэрэв зээл нь хувьсах хүүтэй бол үнэ цэнийн бууралтыг тооцох хямдруулалтын хувийг үр ашигт хүүгээр тооцно. Барьцаагаар хангагдсан санхүүгийн хөрөнгийн хувьд ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнээс барьцааг олж авах мөн борлуулахтай холбоотойгоор гарсан зардлыг хасч тооцох ба хөрөнгийг худалдан борлуулах боломжтой эсэхээс үл хамаарна.

Ирээдүйн мөнгөн урсгалыг тооцоолоход ашигласан таамаглалууд болон аргачлалуудыг тогтмол эргэн шалгаснаар бодитоор гарсан зардал болон тооцоолсон дүнгийн хоорондын зөрүүг бууруулдаг.

Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт. Банк тодорхой бус хугацаагаар эзэмшиж буй өрийн үнэт цаас, өмчийн хөрөнгө оруулалтууд (охин компани эсвэл хараат бус компанийн дүрмийн санд оруулсан хөрөнгө оруулалт) нь борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтад багтана. Өрийн үнэт цаасыг анх бодит үнэ цэнэ дээр гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр хүлээн зөвшөөрдөг ба түүнээс хойш бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Борлуулахад бэлэн өрийн үнэт цаасны хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн арга ашиглан тухайн тайлант хугацааны орлогын тайланд тусгана. Бусад бүхий л бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Энэ нь хуримтлагдсан олз эсвэл гарзыг бусад дэлгэрэнгүй орлогын тайлангаас тухайн тайлант үеийн орлогын тайланд шилжүүлсэн үед буюу данснаас хасах эсвэл үнэ цэнэ буурах хүртэл үргэлжилнэ. Өмчийн хөрөнгө оруулалтыг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрдөг ба түүнээс хойш өртгөөс үнэ цэнийн бууралтын санг хассан дүнгээр тусгадаг. Энэ өртөг нь хөрөнгө оруулалтын дүнг хангалттай тодорхойлж чадахгүй болно. (Тодруулга 10).

Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаасыг анх хүлээн зөвшөөрсний дараа тохиосон нэг буюу олон үйл явдлын (“гарз учруулсан үйл явдлууд”) үр дүнд үүссэн үнэ цэнийн бууралтын гарзыг тухайн жилийн орлого, зарлагад хүлээн зөвшөөрнө.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Өмчийн хэрэгслийн бодит үнэ цэнэ өртгөөсөө доош их хэмжээгээр эсвэл тасралтгүй буурах нь тухайн хэрэгсэл үнэ цэнээ алдсаны шинж тэмдэг болно. Худалдан авах өртөг ба тухайн үеийн бодит үнэ цэнийн зөрүүнээс өмнө нь орлогын тайланд тухайн хөрөнгө дээр бүртгэж байсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассанаар хэмжигддэг хуримтлуулсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг бусад дэлгэрэнгүй орлогоос тухайн жилийн ашиг алдагдал руу дахин ангилдаг.

Санхүүгийн үүсмэл хэрэгсэл. Санхүүгийн үүсмэл хэрэгсэлд дотоодын банкуудтай хийсэн гадаад валютын форвард хэлцэл болон гадаад валютын своп, арилжааны банкуудтай байгуулсан гадаад валютын хэлцлүүд багтана. Санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнэ нь эерэг бол хөрөнгөөр, сөрөг байгаа тохиолдолд өр төлбөрөөр тусгагдана. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тухайн жилийн ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Бусад хөрөнгө. Бусад хөрөнгө нь авлага болон урьдчилж төлсөн зардлаас бүрдэнэ. Авлага нь аккруэл суурийн дагуу хорогдуулсан өртгөөр бүртгэгдэнэ. Авлагыг гэрээний дагуу эрх үүссэн үед хүлээн зөвшөөрнө. Урьдчилж төлсөн зардлыг төлбөр хийгдсэн үед хүлээн зөвшөөрч тухайн ажил үйлчилгээ нь хийгдсэний дараа дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэнэ. Хэрэв Банкинд тухайн авлага нь төлөгдөхгүй гэдгийг батлах хангалттай нотолгоо бий бол, авлагын дүнгээс эргэн төлөгдөхгүй хэмжээг тооцсон дүнгээр найдваргүй авлагын санг байгуулж, авлагын дүнг эргэн төлөгдөх боломжтой хэмжээ хүртэл нь бууруулна. Үнэ цэнийн бууралтыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Банк авлагын үнэ цэнийн бууралтын нотлох баримтыг цуглуулахдаа мөн л хорогдуулсан өртгөөр бүртгэдэг санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тооцдог аргачлалаа ашигладаг.

Барилга болон бусад үндсэн хөрөнгө. Барилгыг дор дурдсанчлан дахин үнэлэгдсэн өртгөөс хуримтлагдсан элэгдлийг, мөн шаардлагатай бол үнэ цэнийн бууралтын зардлыг хассан дүнгээр тусгадаг. Банк эзэмшиж буй барилгыг анхны өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Барилга байгууламжийн дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү байгаа эсэхийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлж баталгаажуулдаг. Дансны үнэ дахин үнэлгээгээр нэмэгдсэн тохиолдолд нэмэгдсэн дүнгээр бусад дэлгэрэнгүй орлогыг болон өөрийн хөрөнгийн дахин үнэлгээний санг нэмэгдүүлнэ. Тухайн хөрөнгийн өмнө үүссэн нэмэгдлийг хааж буй дахин үнэлгээний бууралтыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгөд өмнө хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нөөцийг бууруулна; харин бусад бүх бууралтыг тухайн жилийн орлого зарлагад хүлээн зөвшөөрнө. Дахин үнэлгээгээр нэмэгдсэн дүн бодитоор хэрэгжих үед барилга байгууламжийн дахин үнэлгээний нөөцийг хуримтлагдсан алдагдал эсвэл хуримтлагдсан ашигт шууд хаана. 2015 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр барилга байгууламжийн дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү байхгүй гэж удирдлага үзэж байна.

Банк эзэмшиж буй тоног төхөөрөмжийг үнэ цэнийн бууралтын алдагдал болон элэгдлийг өртгөөс хассан дүнгээр бүртгэнэ. Урсгал засварын зардлыг гарсан тухай бүрт нь зарлагдана. Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн аль нэг бүрэлдэхүүн хэсгийг сольсон томоохон зардлыг капиталжуулж, сольсон хэсгийг ашиглалтаас хасна.

Үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг удирдлага тайлант үе бүрийн эцэст үнэлдэг. Ийм шинж тэмдэг илэрсэн тохиолдолд удирдлага хөрөнгийн бодит үнэ цэнээс тухайн хөрөнгийг борлуулах зардлыг хассан дүн эсвэл түүний ашиглалтын үнэ цэнийн дүнгийн аль ихээр нь нөхөх өртгийг тооцож, дансны үнийг нөхөх өртөг хүртэл бууруулж гарзыг тухайн жилийн орлого, зарлагад бүртгэдэг (хэрэв тухайн өөрийн хөрөнгө дэх хөрөнгийн дахин үнэлгээний сангийн дүнгээс давсан тохиолдолд).

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ, бодит үнэ цэнэ эсвэл борлуулах өртгийн тооцоололд өөрчлөлт орсон бол өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах бичилт хийдэг.

Олз, гарзыг тодорхойлхдоо борлуулалтаас олсон орлогыг бүртгэлийн дүнтэй харьцуулдаг ба олз, гарзыг тухайн жилийн орлого, зарлагад (бусад үйл ажиллагааны орлого, зардлын хэсэгт) бүртгэнэ.

Элэгдэл. Дуусаагүй барилгыг элэгдүүлэхгүй. Харин, үндсэн хөрөнгийн бусад зүйлсийн хувьд тэдгээрийн өртгийг доор тооцоолсон ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар үлдэх өртөг хүртэл нь элэгдүүлнэ:

	Ашиглалтын хугацаа, жилээр
Барилга	40 – 60 жил
Тавилга, оффисын тоног төхөөрөмж	8 – 10 жил
Компьютер, тоног төхөөрөмж	5 – 10 жил
Тээврийн хэрэгсэл	6 – 8жил

Банк ашиглаглалтын хугацаа нь дуусч байгаа хөрөнгийн үлдэх өртгийг тооцохдоо тухайн үед борлуулалтаас олох боломжтой үнээс борлуулалтын зардлыг хассан дүнгээр авдаг. Хөрөнгийн үлдэгдэл өртөг, ашиглалтын хугацааг тайлант үе бүрийн эцэст дахин үнэлж, шаардлагатай гэж үзвэл тохируулга хийнэ.

Биет бус хөрөнгө. Банкны биет бус хөрөнгө нь тодорхой ашиглалтын хугацаатай ба капиталжуулсан компьютерын програм хангамжийн лицензүүд үүнд багтсан байна. Худалдаж авсан компьютерын програм хангамжийн лицензүүдийг авч ашиглахад бэлэн болгоход гарсан зардлаар бүртгэлд тусгасан. Биет бус хөрөнгийг 4 жилийн ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар хорогдуулна.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө ба зоосны хэмжээг 1993 оны 9 дүгээр сард Банкнаас нэвтрүүлсэн төлбөр тооцоонд ашиглагдаж буй цаасан мөнгөн тэмдэгт болон зоосыг нэрлэсэн үнээр илэрхийлдэг. Банк нь бусад банкууд болон харилцагчид бэлэн мөнгө олгох үед гүйлгээнд байгаа бэлэн мөнгө ба зоосыг нэрлэсэн үнийн дагуу өр төлбөрөөр бүртгэдэг. Банк бэлтгэл сан болон гүйлгээний касст буй төгрөгийн бэлэн мөнгийг гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөнд оруулж тооцдоггүй.

Төв Банкны үнэт цаас. Банкны гаргасан үнэт цаас нь бодит үнэ цэнээрээ анх бүртгэгдэх ба түүнээс хойш хугацаанд үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцохдоо эдгээрийг гаргах эсвэл үүсэх үеийн хөнгөлөлт эсвэл урамшуулал, үр ашигт хүүг бүрдүүлж буй зардлуудыг авч үзнэ.

Засгийн газрын хөрөнгө. Засгийн газар болон бусад төрийн байгууллагуудын данс нь Засгийн газар болон бусад харилцагчдад төлөх үүсмэл бус өр төлбөр ба үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр бүртгэгдэнэ. Засгийн газрын хөрөнгийн дийлэнх нь Герман улсын Засгийн газар (КФВ), Азийн Хөгжлийн Банкны санхүүжилттэй хөтөлбөрийн хүрээнд Сангийн яамнаас авсан урт хугацаат зээлтэй холбоотой. (Тодруулга 19).

Гадаад өр төлбөр. Гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өр төлбөр нь анх бодит үнэ цэнээр бүртгэгдэх ба түүнээс хойш үр ашигт хүүгийн аргаар, хорогдуулсан өртгөөр бүртгэгдэнэ. Гадаад төлбөрийн дийлэнх хэсгийг Хятадын Ардын Банк (Хятадын Төв банк)-аас авсан хэлэлцээр хамаарна. (Тодруулга 21).

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дотоодын банкуудын хөрөнгө. Банкинд харилцагч банкуудаас мөнгө шилжин орж ирэхэд нь дотоодын банкуудын хадгаламжийг хүлээн зөвшөөрдөг. Үүсмэл бус өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Болзошгүй алдагдлын нөөцийн сан. Энэ нь өр төлбөрийн цаг хугацаа болон дүн нь тодорхойгүй санхүүгийн бус өр төлбөр юм. Банкинд өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулийн дагуу, эсвэл хууль эрх зүйн дагуу үүрэг хариуцлага хүлээх болсон, мөн уг үүрэг хариуцлагыг шийдвэрлэх явцад эдийн засгийн өгөөж агуулсан зарлагын урсгал гарах өндөр магадлалтай болон энэхүү үүргийг хүлээх нь найдвартай тооцоологдож, мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжтой болсон тохиолдолд нөөцийн санг тооцож бүртгэнэ.

Олон Улсын Валютын Сантай хамтын ажиллагаа. Монгол Улс болон Олон Улсын Валютын Сангийн (ОУВС) харилцаа нь Банкны үндсэн үүргээс шалтгаалж Банк нь ОУВС-тай хамтран ажилладаг. Банкны санхүүгийн тайланд СТОУС-ын дагуу хөрөнгө болон өр төлбөрийн тодорхойлолтын нөхцөлийг хангасан ОУВС хөтөлбөртэй холбоотой тооцоог хүлээн зөвшөөрсөн байдаг. Мөн Банк нь СТОУС-ын хүрээнд хөрөнгө болон өр төлбөрийн тодорхойлолтод нийцэхгүй ОУВС-д хамаарал бүхий тооцоог өөрийн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхгүй.

ОУВС-тай холбоотой хөрөнгө ба өр төлбөрүүд. Эдгээр санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрөгдсөн ОУВС-тай холбоотой хөрөнгөд Зээлжих Тусгай Эрх (ЗТЭ) багтана (Тодруулга 8). ОУВС-д өгөх өр төлбөрт ЗТЭ-ийн хуваарилалт бүхий өр төлбөрүүд багтана (Тодруулга 21).

ЗТЭ-ээр бүртгэгдсэн хөрөнгө, өр төлбөрүүдийг тайлант өдрийн ЗТЭ-ийн төгрөгтэй харьцах албан ханшаар хөрвүүлсэн. Төгрөг, ЗТЭ-ийн албан ханшийг ОУВС-ийн тогтоосон ЗТЭ, ам.долларын ханшийн мэдээлэл болон Банкны тайлант хугацааны ам.доллар болон төгрөгийн албан ханшид үндэслэн тооцсон.

ОУВС-д нийлүүлсэн хувь хөрөнгө. Энэхүү хувь хөрөнгөд тулгуурлан Монгол Улс нь ОУВС-ийн гишүүн орны хувьд зээлж авч болох тусгай төрлийн хөрөнгийн хуваарилалтын дүн болно. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь улс орон тус бүрийн хувьд өөр байдаг бөгөөд эдийн засгийн хэмжээ, цар хүрээнд тулгуурлан ОУВС-ийн Удирдах Зөвлөлөөс тогтоодог. Гишүүн байгууллагын саналын эрх, тусгай сангаас хүртэх санхүүгийн нөөцийн хязгаар болон зээлжих тусгай эрх (оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн)-д үндэслэн квот ногдох оролцогчийн хувь хүртэх хувь хязгаарыг тодорхойлдог. Монгол Улсын хувь нийлүүлсэн хөрөнгийн дийлэнх хэсгийг МУ-ын Сангийн яамны зүгээс баталгаажуулсан үнэт цааснаас бүрдэх ба энэхүү үнэт цаас нь хүүгүй. Мөн үлдэх хэсгийг ОУВС-д өгөх төлбөрүүдээс бүрдэх ба данс №1, №2 энэ талаар тодруулсан болно. Зээлжих тусгай эрхийн хуваарилалтын хувьд 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 72.3 сая ЗТЭ (2015 онд 51.1 сая ЗТЭ) байна. Сангийн яам нь өрийн бичиг гаргаж энэхүү квотын төлбөрийг хийдэг тул Сангийн яамны актив хөрөнгөнд бүртгэгдэнэ.

ОУВС-д гаргасан үнэт цаас. Эдгээр үнэт цаас нь ОУВС-гийн зүгээс Монгол Улсын үндэсний валютад хуваарилагдах хувийг төлөөлөх ба дээр дурдсан хувь нийлүүлсэн хөрөнгийн тооцоонд үндэслэн баталгаажуулсан өрийн бичиг юм. Сангийн яам нь ОУВС-тай зээлийн эрхийн ашиглалтын талаар гэрээ хийсэн байгуулсан тохиолдолд өрийн бичгээр баталгаажуулдаг.

ОУВС-ийн данс №1 болон №2. Сангийн худалдан авалт, дахин худалдан авалт болон хувь нийлүүлсэн хөрөнгийн ажил гүйлгээ гүйцэтгэхэд данс №1-г ашигладаг. Монгол төгрөгөөр гүйцэтгэх ажил гүйлгээнд данс №2-г ашигладаг. Данс №1 болон №2 нь 2015 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр материаллаг бус үлдэгдэлтэй байна.

Дүрмийн сан. Дүрмийн сан нь Өөрийн хөрөнгөнд багтдаг (Тодруулга 23).

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Ерөнхий нөөцийн сан. Төв банк /Монголбанк/-ны тухай хуулиар жилийн цэвэр орлогын хамгийн багадаа 40 хувийг ерөнхий нөөцийн санд хуваарилах ба үлдсэн хэсгийг (ө.х. хамгийн ихдээ 60 хүртэлх хувийг) Улсын Төсвийн данс руу шилжүүлж болно. Ерөнхий нөөцийн сан нь зөвхөн тодорхой хугацааны туршид хуримтлуулсан ба Банк өөрөө захиран зарцуулах бүрэн эрхтэй цэвэр ашгийг агуулдаг. Энэ санд Улсын төсөвт хуваарилсан болон цаашид хуваарилах дүнг оруулдаггүй. Учир нь эдгээр нь Засгийн газарт тухайн тайлант жилдээ шилждэг.Тайлант хугацааны бодит бус ашиг, алдагдал гарсан үйл ажиллагааны алдагдлыг нөхөх хангалттай нөөц байхгүй тохиолдолд ерөнхий нөөц сангаас нөхдөг болно. Ерөнхий нөөц сан 2015 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тэг үлдэгдэлтэй байна.

Бусад нөөц. Бусад нөөцөд гадаад валют, алт, үнэт метал, барилгын дахин үнэлгээний сан болон борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний санг оруулдаг (Тодруулга 23). Банк нь Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн дагуу гадаад валют, алт үнэт металын ханшийн тэгшитгэлийн бодит бус ашиг, алдагдлыг гадаад валют болон мөнгөжсөн алт, үнэт металын дахин үнэлгээний санд жил бүрийн эцэст шилжүүлдэг ба харин бодит бус алдагдлыг холбогдох сангуудаар хаадаг.

Свопын хэлэлцээртэй холбоотой үүрэг хариуцлага. Банкинд зээлтэй холбоотой үүрэг хариуцлага байдаг ба үүнд аккредитив болон Хятадын Ардын банк (БНХАУ-ын Төв Банк, цаашид "ХАБ" гэх) –тай байгуулсан хэлэлцээр орно. Хэлэлцээр нь ХАБ-аас Банкинд юаниар олгосон санхүүжилт болон Банкнаас ХАБ-д төгрөгөөр олгосон санхүүжилт юм (Тодруулга 32).

Тайлант жилийн эцэст төлбөрийн үүрэг хариуцлага нь 1) анхны хүлээн зөвшөөрөлтийн хорогдуулалтыг тооцоогүй төлбөрийн тооцооны үлдэгдэл болон 2) тайлант жилийн эцэст төлбөрийн үүрэг хариуцлагыг дуусгавар болгоход шаардагдах мөнгөний зарлагын хамгийн сайн итгэл үнэмшлээр тооцоолсон дүн хоёрын аль ихээр нь хэмжигддэг. Хэрэв дуусгавар болгоогүй төлбөрийн үүрэг хариуцлагын дүнд хураамж авдаг бол энэ нь тухайн үүргийн хүчинтэй хугацаанд харгалзуулан орлого гэж хүлээн зөвшөөрдөг.

Орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт. Хүүгийн орлого, зардлыг өрийн хэрэгсэл бүрийн хувьд аккруэл суурь дээр үндэслэн үр ашигт хүүгийн аргаар тооцоолон бүртгэнэ. Энэ арга нь талуудын хооронд гэрээний дагуу төлөгдсөн эсвэл хүлээн авсан бүх хураамж, гүйлгээний зардал болон бүх үнийн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд хойшлуулан хүүгийн орлого эсвэл зардал болгон бүртгэдэг.

Бусад бүх шимтгэл, хураамж болон бусад орлого, зардлын зүйлүүдийг аккруэл суурь дээр үндэслэн тухайн ажил гүйлгээний гүйцэтгэлтэй уялдуулан хүлээн зөвшөөрөх бөгөөд гүйцэтгэлийг нийт тохирсон үйлчилгээнээс бодитоор үзүүлсэн байгаа үйлчилгээний хувь хэмжээгээр тооцдог.

Бэлэн мөнгийг хэвлэхтэй холбогдож гарсан зардлууд. Банк нь Монгол Улсын цаасан мөнгөн дэвсгэрт болон зоосон мөнгийг гүйлгээнд гаргадаг. Цаасан мөнгөн дэвсгэрт болон зоосыг хэвлүүлэхтэй холбоотой урьдчилж гарсан зардал нь "Бусад хөрөнгө" хэсэгт бүртгэх ба тэдгээрийг үйлдвэрлэлээс Банкны нөөц санд шилжих үед зардал гэж хүлээн зөвшөөрдөг.

Ажилтны зардал болон холбогдох шимтгэлүүд. Цалин хөлс болон цалинтай холбоотой бусад зардлуудыг (ээлжийн амралт, өвчтэй байх үеийн нөхөн олговор, шагнал урамшуулал болон мөнгөн бус тэтгэмж гэх мэт) Банк ажилтнуудын холбогдох ажил үйлчилгээ үзүүлсэн жилд харгалзуулан зардал гэж хүлээн зөвшөөрдөг. Ээлжийн амралтын мөнгө, нөхөн олговортой бусад богино хугацаат чөлөө авалтыг, ажилтнуудад ирээдүйд нөхөн олговортой чөлөө авах эрхийг үүсгэх үйлчилгээг үзүүлсэн үед, харин өвчний улмаас чөлөө авах гэх мэт нөхөн олговортой богино хугацаат чөлөө авах үе тус бүрд нь хүлээн зөвшөөрдөг болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Ажилтнуудын тэтгэмж. Банк нь өөрийн дотоод, дүрэм журам дээр үндэслэн Нийгмийн хөгжлийн сан, ажилтнуудын ажлын нөхцөл байдлыг сайжруулах, нийгмийн халамжийн асуудлыг шийдэх үүднээс тодорхой хөрөнгийг нийгмийн хөгжлийн санд хуваарилж, хуримтлуулдаг. Эдгээр дансдыг тэтгэмж, нөхөн олговор, ажилтнуудын гүйцэтгэлд суурилсан цалин урамшуулал, ажилтнуудын нийгэм халамжийн хүрээнд бусад хэрэгцээг хангахад зэрэгт ашигладаг. Удирдлага нь 2015 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Нийгмийн хөгжлийн сангийн дүн нь эдгээр богино болон урт хугацаат төлбөрүүдийг төлөх бүрэн боломжтой, мөн хүлээн зөвшөөрсөн тэтгэвэр, тэтгэмжийн өр төлбөр нь тухайн тайлант өдрөөр тэтгэвэр тэтгэмжийн үүргүүдийн өнөөгийн үнэ цэнээс хүлээн зөвшөөрөгдөөгүй байгаа үнэлгээний тооцоо (актуар)-ны олз гарз болон гарсан үйлчилгээний зардлыг хассан дүнгээс материаллаг хэмжээгээр зөрөхгүй гэж үзэж байна.

Банкны дотоод журамд үндэслэн Банк ажилтандаа тэтгэвэрт гарах үед нь (тэтгэвэрт гарахаас өмнө Банкинд удаан ажилласан жилээс хамааруулан) цалингийн тодорхой тогтоосон хэмжээгээр олгох үүрэгтэй байдаг. Эдгээр өр төлбөрүүдийг Банк Нийгмийн хөгжлийн санд хуримтлуулдаг (Тодруулга 22). Удирдлага нь 2015 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Нийгмийн хөгжлийн сангийн дүн нь эдгээр богино болон урт хугацаат төлбөрүүдийг төлөх бүрэн боломжтой, мөн хүлээн зөвшөөрсөн тэтгэвэр, тэтгэмжийн өр төлбөр нь тухайн тайлант өдрөөр тэтгэвэр тэтгэмжийн үүргүүдийн өнөөгийн үнэ цэнээс хүлээн зөвшөөрөгдөөгүй байгаа үнэлгээний (актуар)-ны тооцоо олз, гарз болон үзүүлсэн үйлчилгээний зардлыг хассан дүн нь материаллаг хэмжээгээр зөрөхгүй гэж үзэж байна.

Орлогын албан татвар. Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу Банк нь орлогын албан татвараас чөлөөлөгдсөн байдаг.

Санхүүгийн байдлын тайланг хөрвөх чадварын байдлаар тодруулах нь. Банк нь үйл ажиллагааны тодорхой циклгүй бөгөөд санхүүгийн байдлын тайланд эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө, өр төлбөрийг тусад нь тайлагнадаггүй болно. Харин үүний оронд хөрөнгө, өр төлбөрийг тэдгээрийн хөрвөх чадварын дараалаар тодруулдаг. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүдийг мөр тус бүрийн хувьд тайлант хугацааны эцсээс 12 сараас дотогш эсвэл дээш хугацаанд төлөгдөх эсвэл хүлээн авах эсэхээр нь дараах хүснэгтэд нэгтгэж тодруулав.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

	2016 оны 12 дугаар сарын 31			2015 оны 12 дугаар сарын 31		
	Төлөгдөх болон хүлээн авах дүн			Төлөгдөх болон хүлээн авах дүн		
Сая төгрөгөөр	Тайлант хугацаанаас 12 сарын дотор	Тайлант хугацаанаас 12 сарын дараа	Нийт	Тайлант хугацаанаас 12 сарын дотор	Тайлант хугацаанаас 12 сарын дараа	Нийт
Бэлэн мөнгө	38,953	-	38,953	53,793	-	53,793
Гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө	1,454,397	1,120	1,455,517	1,084,137	926	1,085,063
Санхүүгийн хэрэгсэл – борлуулахад бэлэн	320,500	2,374,422	2,694,922	424,381	2,034,663	2,459,044
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	896,203	153,323	1,049,526	1,328,021	-	1,328,021
Алт ба үнэт метал	232,527	-	232,527	420,152	-	420,152
санхүүгийн үүсмэл хэрэгсэл	10,313	100	10,413	5,743	2,152	7,895
Засгийн газрын үнэт цаас	1,460	325,048	326,508	105,650	96,568	202,218
Дотоодын банкуудад олгосон зээл	1,077,695	8,871	1,086,566	293,506	892,014	1,185,520
Бусад хөрөнгө	29,158	667,487	696,645	6,982	397,592	404,574
Үндсэн болон биет бус хөрөнгө	-	28,034	28,034	-	28,773	28,773
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	4,825	-	4,825	4,665	-	4,665
НИЙТ ХӨРӨНГӨ	**4,066,031**	**3,558,405**	**7,624,436**	**3,727,030**	**3,452,688**	**7,179,718**
Гүйлгээнд гарсан бэлэн мөнгө	(823,629)	-	(823,629)	(706,656)	-	(706,656)
Төв банкны үнэт цаас	(577,297)	-	(577,297)	(1,024,581)	-	(1,024,581)
Засгийн газрын хөрөнгө	(974,580)	(33,744)	(1,008,324)	(675,674)	(26,782)	(702,456)
Дотоодын банкуудын хөрөнгө	(2,671,566)	-	(2,671,566)	(1,818,985)	-	(1,818,985)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	(223,764)	(715,689)	(939,453)	(8,093)	(264,861)	(272,954)
Гадаад өр төлбөр	(4,495,336)	-	(4,495,336)	(3,925,777)	-	(3,925,777)
Бусад өр төлбөр	(42,634)	(64,118)	(106,752)	(1,191)	(77,454)	(78,645)
НИЙТ ӨР ТӨЛБӨР	**(9,808,806)**	**(813,551)**	**(10,622,357)**	**(8,160,957)**	**(369,097)**	**(8,530,054)**

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтүүд. Банк нь 2016 оноос эхлэн практик хэрэглээний үүднээс санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнийг тооцоолох аргачлалыг НББ-ийн бодлогод тусган өөрчилсөн. Тус өөрчлөлтийг санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнийг илэрхийлэх илүү бодитой аргачлал болсон гэж удирдлага үзэж байгаа. Тус бодлогын өөрчлөлтийн үр дүнд өмнөх тайлант жил эсвэл энэ оны эхний үлдэгдэлд нөлөөлөх байдлын талаар холбогдох тооцоолол, үнэлэлт хийх практик хэрэглээний нөхцөл байдлаас шалтгаалан тус бодлогын өөрчлөлтийг 2016 оны эхнээс хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Иймд бодлогын хэрэгжилт нь өмнөх тайлант онуудад нөлөөлөөгүй. Харин тайлант хугацааны нөлөөллийн хувьд санхүүгийн үүсмэл хэрэгслийн хувьд оны эхний үлдэгдэл болон хуримтлагдсан алдагдлын дүн 768 сая төгрөгөөр тус бүр буурсан байна.

Өмнөх тайлант жилийн тайлангийн залруулга. 2017 онд удирдлага нь 2016 оны санхүүгийн тайланг СТОУС-ын шаардлагад нийцүүлэхийн тулд Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон зарим гүйлгээний бүртгэлийг өөрчилсөн. Үүнээс үүдэн ННБОУС 8 “НББ-ийн бодлого, НББ-ийн тооцооллын өөрчлөлтүүд болон алдаа” –ын дагуу эдгээр санхүүгийн тайланд дараах залруулгууд хийгдсэн болно. Үүнд:

Санхүүгийн үүсмэл хэрэгслийг илүү дүнгээр тайлагнасан. Удирдлага санхүүгийн үүсмэл хэрэгслийн тодорхой гүйлгээнүүдийн мөн чанар болон өмнөх жилүүдэд ашигласан үнэлгээний аргачлалыг тохиромжтой байсан эсэх талаар нарийн үнэлгээг гүйцэтгэж шалгасан. Шалгалтын үр дүнд урт хугацаат санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн бодит үнэ цэнийг тооцохдоо хямдруулалтын хүчин зүйлсийг харгалзаж үзээгүйгээс болж 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн тайланд санхүүгийн үүсмэл хэрэгслийн хөрөнгө 1,079 сая төгрөг, өр төлбөр 152,041 сая төгрөг, мөн санхүүгийн хэрэгслүүдээс үүссэн гарзын дүнг 134,219 сая төгрөгөөр тус тус илүү тайлагнасныг удирдлага тогтоосон болно. Дээрх шалтгааны улмаас 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар өр төлбөр 17,042 сая төгрөг, хөрөнгө 300.0 сая төгрөгөөр илүү тус тус тайлагнасан байжээ.

Дотоодын үнэт цааснуудын хүүгийн орлогыг илүү дүнгээр тайлагнасан. 2014 онд Банк нь дотоодын байгууллагын харилцагч нарт тодорхой шалгуур нөхцөлүүдийг хангасан тохиолдолд зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлийг олгосон бөгөөд 350,000 сая төгрөг бүхий өрийн бичгээр баталгаажуулсан. Эдгээр хөрөнгийн хүүгийн шалгуур нөхцөл хангагдах байдлыг гэрээний нөхцөл, үйл ажиллагааны тодорхой нөхцөл байдлыг холбогдох мэдээлэлд тулгуурлан үнэлсэн ба удирдлага эдгээр зээлдэгчид заасан нөхцөлийг хангах байдлыг өндөр магадлалтай гэж дүгнэсэн. Ийм учраас зах зээлийн түвшингөөс доогуур олгосон хүүгийн түвшинг тус зээлийг олгосон өдрөөс эхлэн тооцож мөрдөнө. Банкны удирдлага Монгол улсад ижил төстэй санхүүгийн хэрэгслийн хувьд энэ нь зах зээлийн хүүг төлөөлж чадахгүй байгаа байдлыг харгалзан 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд 84,574 сая төгрөгийн алдагдалыг анх хүлээн зөвшөөрсөн байх ёстой гэсэн тооцоог хийсэн. Тухайн зээлийн хүүгийн орлогыг зах зээлийн хүүгийн түвшинг харгалзуулан тооцоход 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 1,538 сая төгрөг байсан нь 2015

оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар өөрийн хөрөнгийн цэвэр нөлөөлөл 83,036 сая төгрөг байв. Үүнтэй нэгэн адилаар, 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн жилийн эцсийн дэлгэрэнгүй орлогын тайланд зах зээлийн ханшаар тооцож хүүгийн орлогыг 10,198 сая төгрөг гэж залруулж тайлагнасан болно. Шаардлагатай тохиолдолд өмнөх жилийн холбогдох дүнгүүдийг тайлант жилийн хувьд зөв тайлагнахын тулд залруулсан болно. Эдгээрийг дэлгэрэнгүй орлогын тайланд дахин ангиллыг хийж тодруулсан болно. Үүнд :

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Алт, үнэт метал арилжааны цэвэр ашиг, алдагдлыг тайлагнах нь. Алт, үнэт металыг арилжааны ашиг, алдагдлыг цэвэр дүнгээр (ашгаас алдагдлыг хассан дүнгээр) тайлагнадаг ба мөн 2015 оны дэлгэрэнгүй орлогын тайланд хоёр салангид мөрөөр тайлагнасан болно. Тухайлбал, алт, бусад үнэт металын арилжааны ашиг, алдагдал болон алт, бусад үнэт металын ханшийн тэгшитгэлийн бодит бус ашиг, алдагдал гэж тайлагнасан.

Гадаад валютын хөрвүүлгийн цэвэр ашиг, алдагдлыг тайлагнах: "Гадаад валютын хөрвүүлгийн цэвэр ашиг буюу олзоос гарзыг хасаж цэвэр дүнгээр тайлагнадаг ба дэлгэрэнгүй орлогын тайланд салангид гурван мөрийн дагуу тайлагнасан болно. Үүнд: Гадаад валютын арилжааны ашиг алдагдал, гадаад валютын ханшийн хөрвүүлэгийн ашиг алдагдал, болон санхүүгийн хэрэгслийн дахин үнэлгээний бодит бус ашиг/алдагдал гэж 2016 оны санхүүгийн тайланд тайлагнасан болно.

Үйл ажиллагааны болон бусад зардлуудыг тайланд тусгах: 2015 онд үйл ажиллагааны болон бусад зардлууд нь удирдлагын ба бусад зардалд тайлагнагсан.

Дээрх цэвэр нөлөөллийг 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн байдлын тайланд тусгасанг харуулбал:

Сая төгрөгөөр	**2015 оны 12 сарын 31 (өмнө тайлагнаснаар)**	**Тохируулга**	**Тодруулга**	**2015 оны 12 сарын 31 (дахин тайлагнасан)**
Хөрөнгө				
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	8,974	(1,079)	13	7,895
Бусад хөрөнгө	477,413	(72,839)	15	404,574
Өр төлбөр				
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	424,995	(152,041)	13	272,954
Өөрийн хөрөнгө				
Хуримтлагдсан алдагдал	(1,450,237)	78,123	23	(1,372,114)

Эхний үлдэгдэлд хийсэн холбогдох залруулга болон дахин ангиллууд нь 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн ашиг/ алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хэрхэн нөлөөлснийг харуулбал дараах байдалтай байна:

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Сая төгрөгөөр	**2015 (өмнө тайлаг-наснаар)**	**Тохи-руулга**	**Дахин ангилал**	**Тод-руулга**	**2015 он (дахин тайлагнасан)**
Хүүгийн орлого	193,582	10,198	-	24	203,780
Алт ба үнэт металын арилжааны ашиг	-	-	3,101	25	3,101
Алт ба үнэт металын арилжааны цэвэр олз / (гарз)	(1,141)	-	1,141		-
Алт, үнэт металын ханшийн тэгшитгэлийн алдагдал	-	-	(4,242)	26	(4,242)
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн дахин үнэлгээний бодит бус алдагдал	(338,009)	134,219	8,434	27	(195,356)
валютын ханшийн цэвэр ашиг, / (алдагдал)	37,776	-	(37,776)		-
Гадаад валютын арилжааны ашиг/ (алдагдал)	-	-	(3,048)		(3,048)
Гадаад валютын хөрвүүлгийн ашиг/ (алдагдал)	-	-	32,390	28	32,390
Үйл ажиллагааны болон бусад зардал	(9,684)	-	9,684		-
Удирдлагын болон бусад үйл ажиллагааны зардал	(21,672)	-	(9,684)	31	(31,356)
ТАЙЛАНТ ЖИЛИЙН АЛДАГДАЛ	**(139,148)**	**144,417**	**-**		**5,269**

Санхүүгийн байдлын тайлан дахь эхний үлдэгдэлд хийсэн залруулгууд болон дахин ангиллуудыг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр харуулбал дараах байдалтай байна:

Сая төгрөгөөр	**2015 оны 01 сарын 01 (өмнө тайлагнаснаар)**	**Тохируулга**	**Тодруулга**	**2015 оны 01 сарын 01 (дахин тайлагнасан)**
Хөрөнгө				
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	3,264	(300)		2,964
Бусад хөрөнгө	658,152	(83,036)		575,116
Өр төлбөр				
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	89,710	(17,042)		72,668
Өөрийн хөрөнгө				
Хуримтлагдсан алдагдал	(952,809)	(66,294)	23	(1,019,103)

Эдгээр санхүүгийн тайлангуудад холбогдох тайлант жилд тохируулга болон дахин ангиллыг мөнгөн гүйлгээний тайлангийн үзүүлэлтүүдэд хийгдсэн болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Банк нь санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнг дараа жилийн санхүүгийн жилд хөрөнгө, өр төлбөрийн хувьд хэрхэн нөлөө үзүүлэх талаар ач холбогдол бүхий таамаглал, үнэлэлтүүдийг хийдэг. Удирдлага нь өөрсдийн туршлага болон ирээдүйн үйл явдлын талаарх нөхцөл байдалд зохистой гэж үзсэн үнэлэлт, таамаглал зэрэг бусад хүчин зүйлүүдэд суурилан тооцооллыг тогтмол хянадаг болно. Мөн удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх явцад ач холбогдол бүхий тооцооллуудаас гадна тодорхой үнэлэлтүүдийг хийдэг. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үнэлэлтүүд болон дараагийн санхүүгийн жилд хөрөнгө болон өр төлбөрийн тайлагнасан дүнгүүдэд томоохон (мэдэгдэхүйц) хэмжээний тохируулга хийх шаардлага үүсэж болох ба дараах зүйлс хамаарна. Үүнд:

Сангийн яамнаас авсан зээлийн болон дотоодын банкинд олгосон зээлийн анхлан хүлээн зөвшөөрөлт. Банк 16,119 сая төгрөг (2015 онд 14,121 сая төгрөг)-ийн Сангийн яамнаас авсан зээлтэй ба энэхүү хөрөнгийн эх үүсвэр нь Германы улсын Засгийн газраас Монгол улсын Засгийн газарт буюу Сангийн яаманд олгосон бүс нутгийн хөгжлийг дэмжих Азийн Хөгжлийн Банк болон Германы улсын (KfW) Засгийн газрын санхүүжилт. Энэ эх үүсвэр нь маш бага буюу жилийн 0.75-1 хувийн хүүтэй, сонгогдсон эдийн засгийн секторууд болон бусад бага хүү шаардлагатай өөр бусад тусгай зорилтуудыг хангах зорилгоор зээлдүүлэх нөхцөлтэй. Бид энэхүү зээлийг анхны хүлээн зөвшөөрөлт болон эхэлж бүртгэхдээ ашиг бүртгэх шаардлагатай эсэхийг харгалзан үзсэн. Ингэхдээ эдгээр зээлийг харилцан тохиролцсон төсөлд заасан тусгай зорилготой зах зээлд зориулсан буюу нийтийн ашиг сонирхолд үйлчлэх хүүгүй эсвэл маш бага хүүтэй зээлийн хэрэгсэл хэмээн удирдлага үзсэн.

Энэхүү зээлийн эх үүсвэрийг ашиглан тодорхой шалгуур хангасан арилжааны банкуудад бага хүүгээр санхүүжилт хийх буюу зээл олгох боломжтой байна. Бид эдгээр зээлийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс алдагдал хүлээх эсэхийг харгалзан үзсэн. Эдгээр зээлүүд нь харилцан хамааралгүй талуудын хооронд хийгдсэн гүйлгээ тул бидний хийсэн дүгнэлтээр эдгээр зээлүүд нь зах зээлийн хүүтэй ба анхны хүлээн зөвшөөрөлтийн үед аливаа алдагдал хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж үзсэн. Энэхүү дүгнэлтийг хийхдээ бид эдгээр зээлүүд нь тусдаа зах зээлийн сегментийн гүйлгээ (жишээ нь үндсэн зах зээл) болохыг мөн харгалзан үзсэн.

Дотоодын банкуудад олгосон зээлийн үнэ цэнийн бууралт. Банк нь зээлийн багцын хувьд үнэ цэнийн бууралт гарсан эсэхийг тогтмол тооцолдог. Банк нь багц дахь зээл тус бүрийн хувьд үнэ цэнийн бууралт үүссэн эсэхийг тухайн зээлээс ирээдүйд орж ирэх мөнгөн урсгал буурна гэсэн мэдээлэлд үндэслэн тооцдог. Тухайн зээлдэгчийн төлбөрийн чадварт сөрөг өөрчлөлт орсон, актив хөрөнгөнд сөргөөр нөлөөлж болохуйц өөрчлөлтүүд эдийн засгийн нөхцөлд байдалд гарсан зэрэг зүйл дээрх мэдээллийн үндэс болж болно. Эдгээрийг илтгэх нотолгоо нь, Банкны хөрөнгөнд үндэсний болон орон нутгийн чанартай эдийн засгийн нөхцөл байдлуудад сөргөөр нөлөөлөх өөрчлөлтүүдийн үр нөлөөгөөр зээлдэгчид нь зээлийн төлбөрийг эргэн төлөх чадвар талаар зохистой ашиглагдахуйц мэдээллийг оруулна.

Тухайн зээл нь дангаараа их хэмжээтэй зээлийн үнэ цэнийн бууралт гарсан байгаа эсэхийг зээлийн барьцаа хөрөнгийн хангалт болон зээлийн эргэн төлөлтийг ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг хорогдуулан тооцох аргын тусламжтайгаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Удирдлага өөрт байгаа бүхий л мэдээлэл, тухайлбал, Хяналт шалгалтын газарт байгаа банкуудын төлбөрийн чадвар, хөрвөх байдлын үзүүлэлтүүд, чанаргүй зээл болон Монгол улсын банк санхvvгийн салбарын нөхцөл байдал зэрэг мэдээллүүдийг харгалзан авч үзсэн болно. Санхүүгийн тайлан батлах өдөр хүртэлх хугацаанд Банкнаас дотоодын банкууд авсан зээлтэй холбоотойгоор ямар нэг үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илрүүлээгүй болно. Үүний үр дүнд 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх зээлийн болзошгүй алдагдлын нөөц санг байгуулах шаардлагагүй гэж удирдлага үзсэн (2015 оны хувьд тэг).

Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ. Банк эрсдэлийн удирдлагын зорилгоор бусад банкуудтай үүсмэл хэрэгслийн хэлцлүүдийг тогтмол хийдэг. Эдгээр үүсмэл хэрэгслийг бодит үнэ цэнээр бүртгэдэг. 2014 оны эхний улирлаас эхлэн Банк нь дотоодын банкуудтай урт хугацааны шинэ своп хэлцлүүдийг хийж эхэлсэн. Эдгээр нь 1-5 хүртэлх жилийн хугацаатай урт хугацаат төгрөг/ам.долларын своп хэлцлүүд болно. Банк нь форвард хэлцлийн үнийг тооцохдоо төгрөгийн овернайт репо санхүүжилтийн хүү болон Чингис бондын өгөөжийн хувийг ашиглан тогтоодог. Үүнтэй холбоотойгоор урт хугацаатай хэлцлийн талаар зах зээлийн мэдээлэл байхгүй болно. Форвард хэлцлийн үнэ нь тогтмол арилжаалагддаг богино хугацаат үүсмэл хэрэгслийн үнээс бага байна (Тодруулга 13)

Удирдлага дээрх санхүүгийн хэрэгслийг анх хүлээн зөвшөөрөхөд олз, гарз үүсэх эсэхийг харгалзан үзсэн ба хэлцлүүд зах зээлд оролцогчдын хувьд сайн дурын үндсэн дээр явагдсан тул олз гарз үүсэхгүй гэж удирдлага үзсэн. Мөн тус үнэлэмж, дүгнэлтийг хийхэд үндсэн зах зээлийн хэрэгслийг илэрхийлж байна гэж удирдлага үзсэн болно.

Банк нь дотоодын банкуудтай урт хугацаат своп гэрээ байгуулсан ба сөрөг нөхцөл байдлаас (тааламжгүй) шалтгаалан холбогдох алдагдлыг хүлээн зөвшөөрсөн (Тодруулга 27).

Санхүүгийн хэрэгслийн анхны хүлээн зөвшөөрөлт. Банк нь Засгийн газартай хамтран хэрэгжүүлсэн үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд төгрөгийн зээлийг дотоодын банкуудад 2012 оны 11 дүгээр сараас олгож эхэлсэн. Эдгээр зээлүүдийг Засгийн газраас тогтоосон нөхцөлөөр олгосон ба Банк нь эдгээр зээлүүдийн нөхцөлийг тодорхойлоход ямар нэгэн эрхгүй байсан болно. Мөн тус хөтөлбөрт хамрагдах компаниудыг Засгийн газар нь тодорхойлж, тогтоосон бөгөөд Банкнаас санхүүжилтийг нь өгсөн зээлийг арилжааны банкуудаар дамжуулан компаниуд хүлээн авах эрхтэй. Үүний үр дүнд дотоодын банкуудад олгосон зээлийн хүүгийн түвшин нь жилийн 0.89-4 хувь байх боломжийг Засгийн газар бүрдүүлсэн. Бид эдгээр зээлүүдийн хүүг зах зээлийн хүүтэй адилтгах үзэж, анх хүлээн зөвшөөрөх үед аливаа ашиг, алдагдал хүлээн зөвшөөрөх шаардлагатай эсэхийг үнэлж үзсэн. Энэхүү зээл нь Төв банкны үндсэн үүрэг болох мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, инфляцыг тогтворжуулах зорилгын хүрээнд зах зээлд мөнгөний нийлүүлэлтийг хийсэн бөгөөд зээлүүд тусдаа зах зээлийн сегментийн гүйлгээ (жишээ нь үндсэн зах зээл) мөн болохыг бид харгалзаж үзсэн. Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд дотоодын банкуудад олгосон зээлийн үлдэгдэл нь 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,055,978 сая төгрөг, 2015 онд 882,451 сая төгрөг байна (Тодруулга 9), холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар Тодруулга 3-г харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хадгаламжийн даатгалын корпорацид (ХДК)-д олгосон санхүүгийн дэмжлэг (зээлийн) анхны хүлээн зөвшөөрөлт. Банк нь Төрийн банкинд үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн хүрээнд Хадгаламжийн даатгалын корпорацид 119,900 сая төгрөгийг жилийн 0.5 хувийн хүү болон 85,000 сая төгрөгийг жилийн тэг хүүтэй 2013 оны 9 дүгээр сарын 30-ний өдөр олгосон. Монгол улсын банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилго болон банкны системийн дахин санхүүжилтийг эцсийн шатны зээлдэгчийн хувьд зохион байгуулсан онцлог байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр удирдлага тус санхүүгийн дэмжлэг бүхий зээл үндсэн зах зээлийн хүүгийн түвшинг илэрхийлнэ гэж дүгнэсэн. Эдгээр зээлийн үлдэгдэл 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 114,212 сая төгрөг болон 2015 онд 119,911 мянга төгрөг байна (Тодруулга 15).

Зах зээлийн түвшингөөс доогуур олгосон бусад санхүүгийн хэрэгслийн анхны хүлээн зөвшөөрөлт. НББОУС 39-д санхүүгийн хэрэгслийг анх хүлээн зөвшөөрөх дүн нь түүний бодит үнэ цэнэ байна гэж заасан. Санхүүгийн хэрэгсэл нь идэвхитэй зах зээл дээр арилжаалагддаггүй болон эсвэл зах зээлийн бус хүүгээр олгогдсон тохиолдолд бодит үнэ цэнийг холбогдох үнэлгээний аргуудыг ашиглаж тодорхойлж болно. Тус үнэлэмжийг хийхдээ холбоогүй талуудын хооронд хийгдсэн ижил төсөөтэй ажил гүйлгээ болон үр ашигт хүүгийн аргыг ашиглана. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (Тодруулга 3)-д тодруулсны дагуу, удирдлага нь зах зээлийн түвшингөөс доогуур олгосон бусад санхүүгийн хэрэгслийн анхны хүлээн зөвшөөрөлтийн хувьд ашиг, алдагдлыг хүлээн зөвшөөрөх эсэхийг үнэлсэн бөгөөд Төв банкны үндсэн чиг үүрэг болон мөн чанарын хувьд төлөөлж чадахгүй байгаа дараах ажил гүйлгээнүүдийг олж илрүүлсэн болно.

- Банк нь 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Хөгжлийн банкны нийт 133,749 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 4 хувийн хүүтэй буюу зах зээлийн үнээс доогуур хүү бүхий өрийн бичиг эзэмшиж байв. Эдгээр өрийн бичгийн анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ 105,146 сая төгрөг байсан нь Хөгжлийн банкны үнэт цаасны нэрлэсэн үнэ болон бодит үнэ цэнийн хоорондын зөрүү болох 28,603 сая төгрөгийг тайлант хугацааны ашиг/алдагдалд хүлээн зөвшөөрсөн. (Тодруулга 10).
- “Сайн” хөтөлбөрийг санхүүжүүлэхийн тулд Банк 453,712 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 1-3 хувийн хүүтэй засгийн газрын үнэт цаасыг худалдан авсан. Удирдлага эдгээрийг 123,668 сая төгрөгийн бодит үнэ цэнэ бүхий санхүүгийн хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн ба анхны хүлээн зөвшөөрөлтийн гарз нь 330,044 сая төгрөг байсан. Энэ гарзыг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрсөн (Тодруулга 14)
- Банк нь дотоодын харилцагч нарт тодорхой шалгуур нөхцөлүүдийг хангасан тохиолдолд зах зээлийн хүүг зах зээлийн хүүгээс доор болтол бурулах боломжтой зээлийг зээлийг өрийн бичиг барьцаалж 2014 онд 350,000 сая төгрөг, 2016 онд 465,000 сая төгрөгийн зээл олгосон байна. Үүнд гэрээний нөхцөл, үйл ажиллагааны нөхцөл байдлыг холбогдох мэдээлэлд тулгуурлан үнэлсэн байна. Удирдлага эдгээр зээлдэгчид заасан нөхцөлийг хангах магадлал өндөр гэж дүгнэсэн байна. Тийм учраас зах зээлийн түвшингөөс доогуур олгосон хүүгийн түвшин нь үр ашигт хүүгийн түвшинтэй тэнцүү байх ба тус зээл олгосон өдрөөс эхлэн хүлээн зөвшөөрөгдөнө. Иймд Банкны удирдлага 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд 84,574 сая төгрөгийн алдагдлыг анх хүлээн зөвшөөрсөн ба тухайн өдрөөр авлагын хувьд бодит үнэ 265,426 сая төгрөг байна гэсэн тооцоог хийсэн. Мөн тухайн зээлийн бодит үнэ цэнэ нь 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар анх хүлээн зөвшөөрөх үеийн байдлаар 371,722 сая төгрөг, мөн өдрөөр хүүгийн орлогыг зах зээлийн түвшингөөс доогуур олгосон хүүгийн түвшинг харгалзуулан тооцоход 93,278 сая төгрөгний алдагдлыг хүлээж байна. (Тодруулга 15)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

- 2016 онд Банк 100,000 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 14 хувийн хүүтэй буюу зах зээлийн үнээс доогуур хүүтэй засгийн газрын үнэт цаас худалдаж авсан. Энэ үнэт цаасны анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ 95,349 сая төгрөг байсан ба анхны хүлээн зөвшөөрөлтийн алдагдал нь 4,651 сая төгрөг байсан. Тус алдагдлыг зах зээлийн хүүгээс доогуур хүүгээр авсан санхүүгийн хөрөнгийн алдагдалд тооцож, 2016 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн ашиг эсвэл алдагдлаар хүлээн зөвшөөрсөн.(Тодруулга 14)
- Банк 2016 онд урвуу буцаан худалдан авах хэлцэл хийсэн. Энэ гэрээ нь 2016 оны 9 сарын 30-ны өдрийг хүртэл жилийн хувьсах хүүгээс 3 хувь хүүг хасаж тооцох ба 2017 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс жилийн 7.5 хувь тогтмол хүүтэй болсон. Удирдлага тус хэлцлийг зах зээлийн хүүгээс доогуур хүү гэж үзэж байгаа бөгөөд 2016 оны 12 сарын 31-ний байдлаар, хүлээн зөвшөөрөх анхны бодит үнэ цэнэ нь 150,000 сая төгрөг, хүлээн зөвшөөрөлтийн алдагдал нь 23,426 сая төгрөг байсан (Тодруулга 11)

Зах зээлийн хүүгээс доогуур үнэлэгдэх хөрөнгүүдийн анх хүлээн зөвшөөрсөн алдагдлыг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх ашиг эсвэл алдагдлаар хүлээн зөвшөөрсөн байна.

Дээрх ажил гүйлгээний анхны хүлээн зөвшөөрөлтийн хувьд алдагдлын хэмжээг тодорхойлохдоо, холбогдох ажил гүйлгээний талаарх мэдээллийг хооронд нь харьцуулах болон дараах итгэл үнэмшлүүдэд үндэслэн дүгнэлтийг хийсэн. Үүнд :

- Банкны бодлогын хүү нь Монгол улсын Засгийн газар болон тухайн зээлдэгчийн хувьд эрсдэл гарсан тохиолдолд арилжааны банкуудад олгосон санхүүжилт нь зах зээлийн хүүгийн түвшинг ойролцоогоор илэрхийлж төлөөлөхүйц байна гэж үзсэн;
- Банкны бодлогын хүү нь жилд 2 хувиар ахиуц байдлаар нэмэгдсэн байгаа нь дотоодын компаниудад өрийн бичгээр баталгаажиж олгогдсон төгрөгийн зээлийн хүүгийн түвшиний эрсдэлийг ойролцоогоор илэрхийлнэ гэж үзсэн.

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт. *Б*анк борлуулахад бэлэн өмчийн хөрөнгө оруулалтад бодит үнэ цэнэ нь их хэмжээгээр буюу удаан хугацаанд тогтмол буурч байх үед үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрдөг. “Их хэмжээгээр” буюу “удаан хугацаанд” гэдгийг тодорхойлоход тодорхой үнэлэмжүүд шаардагдана. Эдгээр үнэлэмжийг хийхдээ Банк түүхэн үнийн хөдөлгөөн, үргэлжлэх хугацаа, цар хүрээ, хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ өртгөөсөө хэр зэрэг *бага байгаа зэргийг харгалзан үздэг.*

Хадгаламжийн даатгалын корпорацид (ХДК)-д олгосон санхүүгийн дэмжлэгийн үнэ цэнийн бууралт. Төрийн банкны хувьцааг худалдан авах Засгийн газрын шийдвэрийн хүрээнд Банк 2014 онд ХДК-д богино хугацаат санхүүгийн дэмжлэг олгосон. Үүний үр дүнд ХДК нь Төрийн банк ХХК-ийн 75 хувийг эзэмших болсон. Гэрээнд зааснаар, Төрийн банк ХХК-ийн хувьчлалын орлогоос тухайн санхүүгийн дэмжлэгийг эргэн төлүүлнэ гэж заасан байдаг. 2014 онд Төрийн банк хувьчлагдах эсэх нь тодорхойгүй байсан ч Банк нь ХДК-д санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. 2015 он болон 2016 онд хувьд болзошгүй алдагдлын нөөц санд хөдөлгөөн гараагүй болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

2017 оны эхний улирал болон 2016 оны жилийн эцсийн байдлаар ХДК-д олгосон зээлийн эргэн төлөлтийн магадлал болон тодорхой бус байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 114,212 сая төгрөг бүхий болзошгүй алдагдлын нөөцийн санг 100 хувь хүлээн зөвшөөрсөн. (Тодруулга 15) Удирдлагын зүгээс 2015 оны 12 дугаар 31-ний өдрийн байдлаар Банкны 2015 оны санхүүгийн тайланг батлах үед ямар ч үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрөх шаардлага байхгүй байсан гэж үзсэн болно. Ингэж дүгнэх болсон үндэслэл нь 2015 оны 12 дугаар 31-ний өдөр болон 2016 оны 12 дугаар 31-ний өдрөөр тухайн зээлийг санхүүгийн тайланг батлах үеийн байдлаар эргэн төлөгдөх нөхцөл байдлыг олж авч болох мэдээллүүдэд үндэслэн хийсэн болно.

Эрх хүлээн авагч томилогдсон банкуудад тавих хяналт. Банк Эрх хүлээн авагч томилсон банкуудад хяналт тавьж байгаа эсэх болон улмаар Банкны санхүүгийн тайланд нэгтгэгдэх хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо Банк болон тухайн банкуудын хоорондын харилцааны бодит байдлын талаар үнэлэлт хийсэн. Уг үнэлэлтийг хийхдээ дараах байдлыг харгалзан үзсэн:

- Банк нь хуулийн шаардлагын дагуу Эрх хүлээн авагч томилсон;
- Эрх хүлээн авагч нь зөвхөн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн байр сууринаас хандаж банкийг татан буулгах тодорхой зорилготой ба тухайн банкны ямар нэгэн стратегийн шийдвэрийг гаргадаггүй;
- Эрх хүлээн авагч нь хуулиар тодорхойлсон хүрээнд ажиллах ба өр барагдуулах дараалыг мөн хуулиар тодорхойлсон. Иймд, Эрх хүлээн авагч нь Банкны үр өгөөжид нөлөөлөх зорилгоор тодорхой шийдвэр гаргах эрхгүй болно;
- Хэдийгээр Банк Эрх хүлээн авагчийн хүрээнд банкуудад зээл олгож болох боловч энэхүү зээлийг хадгаламж эзэмшигчдийн хадгаламжийг эргүүлэн төлөх баталгааны хуулийн дагуу Засгийн газрын үүргийг биелүүлэхийн тулд Засгийн газрын нэрийн өмнөөс олгох болно. Ийм учраас эдгээр зээлийн авлагын үр өгөөж нь Засгийн газрын бондын хэлбэртэй байна гэж удирдлага үзэж байна;
- Эрх хүлээн авагчийн үйл ажиллагаанаас авсан үр өгөөж бага байна.

Дээрх зүйлүүд дээр үндэслэн хэдийгээр Банк нь эрх хүлээн авсан банкуудын үйл ажиллагааг удирдах эрхтэй боловч өөрийн эрхээ үр ашигт нөлөөлөх зорилгоор ашиглаж болохгүй ба тэдгээр үр ашиг нь эрх хүлээн авсан банкны гүйцэтгэлээс хамаардаггүй болно. Иймд удирдлага эдгээр банкуудыг санхүүгийн тайланд нэгтгэх шаардлага байхгүй гэж үзэж байна.

Хадгаламжийн даатгалын корпораци (ХДК)-д тавих хяналт. Банк Хадгаламжийн даатгалын корпораци (ХДК)-д хяналт тавьж байгаа эсэх болон улмаар Банкны санхүүгийн тайланд нэгтгэгдэх хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо Банк болон ХДК-ийн хоорондын харилцааны бодит байдлын талаар үнэлэлт хийсэн. Уг үнэлэлтийг хийхдээ дараах байдлыг харгалзан үзсэн. Үүнд:

- ХДК-ийн эрх мэдэл,
- ХДК-ийн үйл ажиллагаа дахь оролцооноос өгөөж хүртэх нөхцөл байдал, ХДК дахь өөрийн эрх мэдлээ ашиглан Банкны хүртэх ашгийн хэмжээнд нөлөөлөх чадвар. Банк ХДК-ийн үйл ажиллагаанд шууд оролцож чаддаг бол Банк ХДК-д эрх мэдэлтэй гэж үзнэ. ХДК-ийн дүрмийн дагуу Үндэсний хороо нь долоон гишүүнээс бүрдэх бөгөөд Банкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Үндэсний хорооны гишүүн бөгөөд дарга нь байна. Үндэсний хорооны бусад зургаан гишүүд нь:

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

- Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга;
- Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга; ХДК-ийн Гүйцэтгэх захирал;

Гурван гишүүнийг Банкны Ерөнхийлөгч, Сангийн сайд болон Банкуудын холбооноос нэр дэвшүүлнэ, харин Банкны Ерөнхийлөгч болон Сангийн сайдын хамтарсан тушаалаар томилно.(Банкуудын холбоо нь банкуудаас бүрдэх бөгөөд Банк ордоггүй байна.) Корпорацитай холбоотой бүх шийдвэр нь Үндэсний хорооны долоон гишүүний саналаар батлагдах ба аль нэг гишүүн нь ХДК-ийн үйл ажиллагааг удирдах давуу эрхгүй байна. Банкны Тэргүүн дэд ерөнхийлөгч нь Үндэсний хороог даргалах боловч ХДК-ийн үйл ажиллагааг дангаар удирдах эрхгүй. Мөн Банк бусад гурван гишүүдийг томилох хязгаарлагдмал эрхтэй байгаа нь ХДК-д хяналт болон нөлөөгүй гэдгийг илэрхийлж байна. Иймд Удирдлага ХДК-ийн үйл ажиллагааг санхүүгийн тайландаа нэгтгэх шаардлагагүй гэж үзсэн болно.

Тасралтгүй байх зарчим. Удирдлага нь эдгээр санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн. 2015 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны өөрийн хөрөнгө сөрөг, өр төлбөртэй гарсан ба Банк нь Үндэсний мөнгөн тэмдэгтийг гаргагч бүхий этгээд тул төгрөгийн хувьд хөрвөх чадварын эрсдэлд орохгүй гэж үзсэн бөгөөд урьдчилан харах болон ирээдүйд тасралтгүй байх зарчмын дагуу Банк үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхгүй байх эрсдэл тохиолдохгүй гэдэгт удирдлага итгэлтэй байна.

Барилгын дахин үнэлгээ. Банк нь барилга байгууламжийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад орлогод дахин үнэлсэн дүнгээр бүртгэдэг. Банк 2013 онд барилгын бодит үнэ цэнийг үнэлүүлэхээр хараат бус үнэлгээний байгууллагатай гэрээ байгуулсан. Барилгуудыг тухайн хөрөнгийн шинж чанар, байршил, нөхцөл байдал гэх мэт зах зээлийн бусад хүчин зүйлүүдэд тохируулан үнийг харьцуулах замаар зах зээлийн үнэлгээний сууриар үнэлсэн. Удирдлага нь 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар барилгын бодит үнэ цэнийг бүртгэлийн дүнгээс их өөрчлөгдөөгүй гэж үнэлсэн ба энэхүү үнэлгээ нь удирдлагаас барилгуудтай холбоотойгоор өөрсдийн хуримтлуулсан туршлага болон (Тодруулга 16)-д үзүүлсэн бусад таамаглалуудын талаарх үнэлэмжийг хийхийг шаарддаг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

5. ШИНЭ БУЮУ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРСОН СТАНДАРТУУДЫН ТАЙЛБАР, ХЭРЭГЖИЛТ

2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Банкны мөрдөж буй болон шинээр батлагдсан стандартууд, тэдгээрийн тайлбарууд:

СТОУС 14, Зохицуулах байгууллагатай холбоотой хойшлуулсан данс (2014 оны 01 сард батлагдсан ба 2016 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). СТОУС 14-өөр СТОУС-ыг анх удаа хэрэглэж байгаа этгээд өмнө нь мөрдөж байсан нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн зарчмын дагуу үнэ ханшийн зохицуулалттай холбоотой дүнг цаашид үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрч бүртгэхийг зөвшөөрсөн. СТОУС-ыг өмнө нь нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлантай анх удаа СТОУС-ын нэвтрүүлж байгаа этгээдийн санхүүгийн тайланг хянагдах байдлыг хангах үүднээс үнэ ханшийн зохицуулалттай холбоотой дүнг бусад санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс тусад нь тайлагнахыг стандартад зааж өгсөн.

СТОУС 11-д орсон нэмэлт өөрчлөлт – Хамтарсан үйл ажиллагаан дахь ашиг сонирхлыг эзэмших ажил гүйлгээг бүртгэх (2014 оны 5 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан ба 2016 оны 01 дүгээр сарын 01-нээр эхэлж буй болон түүнээс хойших санхүүгийн тайланд дагаж мөрдөнө. Энэхүү өөрчлөлтөөр бизнесийн хамтарсан үйл ажиллагааны хувь ашгийг хэрхэн бүртгэх талаар зааж өгсөн. Дээрх стандартын нэмэлт өөрчлөлт Банкны санхүүгийн тайланд ямар нэгэн материаллаг нөлөө үзүүлэхгүй.

НББОУС 16 болон НББОУС 38-д орсон нэмэлт өөрчлөлт- Элэгдэл болон хорогдлыг тооцох аргыг илүү тодорхой болгох нь (2014 оны 5 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан ба 2016 оны 01 дүгээр сарын 01нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Энэхүү өөрчлөлтөөр хөрөнгийг ашиглаж буй үйл ажиллагаанаас бий болсон орлогод тухайн хөрөнгийн эдийн засгийн үр өгөөжийн ашиглалтаас гадна өөр бусад хүчин зүйлс нөлөөлсөн байдаг тул орлогод суурилсан аргаар үндсэн хөрөнгийг элэгдүүлэх нь тохиромжгүй гэж НББОУС-ын зөвлөл оруулж өгсөн. Дээрх стандартын нэмэлт өөрчлөлт Банкны санхүүгийн тайланд ямар нэгэн материллаг нөлөө үзүүлэхгүй.

НББОУС 16 болон НББОУС 41-д орсон нэмэлт өөрчлөлт - Хөдөө аж ахуй: Биологийн хөрөнгө (2014 оны 6 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан ба 2016 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Усан үзэмний мод, резины мод болон тосны мод нь үйлдвэрлэлийн шинж чанартай тул үндсэн хөрөнгөөр бүртгэнэ гэж нэмэлт өөрчлөлт оруулсан. Тиймээс дээрх өөрчлөлтийг НББОУС 16-д оруулж НББОУС 41-ээс хассан. Гэхдээ биологийн ургамлыг ургуулах хугацаанд НББОУС 41-ийг баримтална. Дээрх стандартын нэмэлт өөрчлөлт Банкны санхүүгийн тайланд ямар нэгэн материаллаг нөлөө үзүүлэхгүй.

НББОУС 27-д орсон нэмэлт өөрчлөлт-Бие даасан санхүүгийн тайлан дахь өртгийн арга (2014 оны 8 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан ба 2016 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр аж ахуйн нэгж нь бие даасан санхүүгийн тайландаа охин компани, хараат компани, хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтыг өртгийн аргаар бүртгэх боломжтой болсон. Дээрх стандартын нэмэлт өөрчлөлт Банкны санхүүгийн тайланд ямар нэгэн материаллаг нөлөө үзүүлэхгүй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

5. ШИНЭ БУЮУ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРСОН СТАНДАРТУУДЫН ТАЙЛБАР, ХЭРЭГЖИЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

СТОУС 2014-үүдэд тухайн жил бүр хийгддэг сайжруулалтууд- (2014 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр батлагдсан ба 2016 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайлангуудад дагаж мөрдөнө). Дээрх өөрчлөлтөд 4 стандарт хамрагдсан. СТОУС 5-д, ашиглах эрхийг шилжүүлэх хэлбэр өөрчлөгдсөн (жишээ нь борлуулах ангиллаас эздэд хуваарилах ангилалд шилжүүлэх эсвэл эсрэгээрээ) нь уг хөрөнгийг зарж борлуулах эсвэл эздэд хуваарилах төлөвлөгөөг өөрчилсөн гэж үзэхгүй бөгөөд тийм байдлаар бүртгэхгүй гэж нэмж өгсөн. СТОУС 7-ийн тодруулгын шаардлагын дагуу, шилжүүлсэн санхүүгийн хөрөнгөтэй холбоотой гэрээний нөхцөлүүдэд шилжүүлэгчийн зүгээс цаашид уг санхүүгийн хөрөнгөтэй холбоотой оролцоо байгаа эсэхийг удирдлага тодорхойлоход илүү дөхөмтэй болгосон. НББОУС 34-өөр шаардаагүй тохиолдолд, завсрын тайлангуудад СТОУС 7-ийн дагуу санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг цэвэршүүлж толилуулахгүй байх боломжтой гэж заасан. НББОУС 19-д орсон нэмэлт өөрчлөлтөөр ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн өр төлбөрийг хорогдуулах хүүгийн түвшин тодорхойлохдоо өндөр зэрэглэлтэй байгууллагын гаргасан бонд, эсвэл уг бонд байхгүй бол засгийн газрын бондын хүүг авахдаа уг өрийн хэрэгслийг гаргасан улсын валют биш тухайн өрийн хэрэгсэл гарсан валютаарх өрийн хэрэгслийн хүүг суурь болгоно гэж заасан. НББОУС 34 –ийн дагуу "завсрын санхүүгийн тайлан мэдээнд толилуулсан мэдээ" гэж бичихдээ санхүүгийн тайлангаас тухайн мэдээлэл байгаа хэсгийг зааж өгнө гэж нэмж оруулсан. Дээрх стандартын нэмэлт өөрчлөлт Банкны санхүүгийн тайланд ямар нэгэн материаллаг нөлөө үзүүлэхгүй.

НББОУС 1-д орсон санхүүгийн тайлангийн толилуулгатай холбоотой нэмэлт өөрчлөлт (2014 оны 12 сард батлагдсан ба 2016 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Өөрчлөлтөөр материаллаг байдал гэсэн ойлголтыг дэлгэрүүлж дараах байдлаар тайлбарласан: СТОУС-ын дагуу тодруулах шаардлагатай тусгай зүйлсийн жагсаалтад орсон эсвэл хамгийн багадаа тухайн зүйлийг тодруулна гэж заасан байсан ч хэрэв тухайн тодруулгаар харуулсан мэдээлэл нь материаллаг бус бол СТОУС-ын дагуу заавал толилуулах шаардлагатай зүйлсийг ч тодруулахгүй байж болно гэж заасан.

Мөн, стандартаар санхүүгийн тайлан дахь дэд бүлгийн нийт дүнгийн талаар шинэ заавар өгсөн. Үүнд: (i) дэд бүлгийн нийт дүнг бүрдүүлж буй зүйлс нь СТОУС-ын дагуу хэмжигдэж хүлээн зөвшөөрөгдсөн байх;(ii) дэд бүлгийн тоог бүрдүүлж буй зүйлсийн нэрсийг тусгаж, харахад ойлгомжтой цэвэрхэн байдлаар толилуулна; (iii) тайлант үеүдэд толилуулах байдлыг тууштай хадгалах; (iv)СТОУС-ын дагуу дэд бүлгийг бүрдүүлж буй зүйлсэд дэд бүлгийн нийт дүн болон үндсэн бүлгийн нийт дүнгээс илүү ач холбогдол өгөхгүйгээр толилуулах. Дээрх стандартын нэмэлт өөрчлөлт Банкны санхүүгийн тайланд ямар нэгэн материллаг нөлөө үзүүлэхгүй.

СТОУС 10, СТОУС 12 болон НББОУС 28-д орсон нэгтгэл хийхээс чөлөөлөгдөх нэмэлт өөрчлөлт (2014 оны 12 дугаар сард батлагдсан ба 2016 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгж нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхэлдэг охин компаниа тайлант үеийн ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжинэ гэж нэмэлт өөрчлөлт оруулсан. Мөн, хэрэв охин компанийн эцсийн эсвэл завсрын толгой компани олон нийтийн хүртээл болгох зорилгын нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг бол нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргахаас чөлөөлөгдөнө гэснийг охин компанийн эцсийн болон завсрын толгой компанийн санхүүгийн тайландаа охин компанийг нэгтгэсэн эсвэл СТОУС 10-ын дагуу тайлант үеийн ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр охин компанийг бүртгэсэн эсэхээс үл хамааран нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхээс чөлөөлөгдөх талаар илүү нарийн тодорхойлж өгсөн. Дээрх стандартын нэмэлт өөрчлөлт Банкны санхүүгийн тайланд ямар нэгэн материллаг нөлөө үзүүлэхгүй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

5. ШИНЭ БУЮУ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРСОН СТАНДАРТУУДЫН ТАЙЛБАР, ХЭРЭГЖИЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойшхи тайлант хугацаанд заавал мөрдөх стандартууд ба тайлбарууд шинээр батлагдаж, хэвлэн нийтлэгдсэн ба эдгээрийг Банк хугацаанаас нь өмнө хэрэгжүүлж эхлээгүй.

СТОУС 9, "Санхүүгийн хэрэгсэл:Ангилал ба хэмжилт" (2014 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан ба 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс эхэлсэн болон үүнээс хойших санхүүгийн тайланд дагаж мөрдөнө.) Энэхүү стандартын гол агуулгаас дурдвал:

- Санхүүгийн хөрөнгүүдийг дараагийн тайлант үе бүртхорогдуулсан өртгөөр нь хэмжих; бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бүртгэгдэх бодит үнэ цэнээр нь хэмжих болон тайлант үеийн ашиг эсвэл алдагдалд бодит үнэ цэнийн дагуу бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүд гэж 3 ангилна.
- Өрийн хэрэгслийг ангилах нь аж ахуйн нэгжийн санхүүгийн хөрөнгийг удирдах бизнесийн модель болон гэрээнд заасан мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн зээл болон хүүгийн төлбөр байх эсэхээс хамаарна. Хэрэв өрийн хэрэгсэл нь зөвхөн үндсэн зээл болон хүүгийн төлбөрийг авах зорилготой байвал хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Хэрэв аж ахуйн нэгж нь өрийн хэрэгслийг үндсэн зээлийн төлбөр болон хүүг авах мөн шаардлагатай тохиолдолд зарах зорилгоор эзэмшиж байвал бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бүртгэгдэх бодит үнэ цэнээр нь хэмжих санхүүгийн хөрөнгө гэж ангилна.
- Үндсэн зээл болон хүүгийн төлбөрийн мөнгөн гүйлгээгүй санхүүгийн хөрөнгийг тайлант үеийн ашиг алдагдалд бодит үнэ цэнийн зөрүү нь бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүд гэж ангилна (жишээ нь
- дериватив). Нуугдмал деривативыг санхүүгийн хөрөнгөөс салгаж үзэхгүй болсон ба зөвхөн үндсэн зээл болон хүүгийн төлбөрийн нөхцөлийг хангаж буй эсэхийг үнэлнэ.
- Бүх өмчийн хэрэгслийг дараагийн тайлант үеүдэд үргэлж бодит үнэ цэнээр хэмжинэ. Хэрэв санхүүгийн хөрөнгийг арилжаалах зорилгоор эзэмшээгүй бол бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бүртгэгдэх ангиллын сонголтыг хийж болох ба энэ сонголтыг буцаах боломжгүй. Хэрэв өмчийн хэрэгслийг арилжаалах зорилготой бол тайлант үеийн ашиг алдагдалд бодит үнэ цэнийн зөрүүг нь бүртгэнэ.
- НББОУС 39-ийн ангилал болон хэмжилтийн ихэнх шаардлагууд нь СТОУС 9-д шилжихдээ өөрчлөгдөөгүй. Гол өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бүртгэгдэх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөрийн зээлийн эрсдэлийн тайланд өөрчлөлтийн нөлөөний талаар тусгах шаардлагатай гэж заасан.
- СТОУС 9-д үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрөх шинэ загвар болох ирээдүйд учирч болох зээлийн гарзын загварыг нэвтрүүлсэн. Эхний хүлээн зөвшөөрөлтөөс хойш санхүүгийн хөрөнгийн зээлийн чанарт гарах өөрчлөлтөд үндэслэсэн "3 үе шат"-ны арга байна гэж заасан. Практикийн хувьд шинэ аргаар үнэ цэнэ нь бууraагүй санхүүгийн хөрөнгийг (дансны авлагын хувьд авлага хаагдах хүртэл буюу хугацаанд үндэслэхгүйгээр учирч болох эрсдэлийн гарзын сан байгуулна) анх хүлээн зөвшөөрөхдөө ирэх 12 сард учирч болох зээлийн гарзыг тэр даруйд нь хүлээн зөвшөөрнө гэж заасан. Зээлийн эрсдэлд томоохон сөрөг өөрчлөлт гарсан тохиолдолд 12 сарын биш хугацаагүй учирч болох зээлийн гарзын сан байгуулна. Энэхүү загварт түрээс болон дансны авлагыг арай энгийн байдлаар авч үзсэн.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

6. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ШИНЭЭР БАТЛАГДСАН МЭДЭГДЛҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хэйджийн бүртгэлийг аж ахуйн нэгжийн эрсдэлийн удирдлагатай уялдахуйц байхаар нэмэлт өөрчлөлт оруулсан. СТОУС 9-д макро хейджийг хэрхэн бүртгэх талаар тусгаагүй тул СТОУС 9-ийн хэйджийн бүртгэл эсвэл НББОУС 39-ийн хэйджийн бүртгэлийг үргэжлүүлэн ашиглах талаар нягтлан бодох бүртгэлдээ тусгах сонголтыг аж ахуйн нэгжид үлдээсэн.Банк шинээр гарсан стандартын санхүүгийн тайланд нөлөөлөх байдлыг үнэлж байгаа. СТОУС 9 нь ихэнх санхүүгийн байгууллагуудад нөлөөлөх юм.

СТОУС 15, Харилцагчтай байгуулсан гэрээний орлого (2014 оны 5 дугаар сарын 28-нд батлагдсан ба 2017 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Шинэ стандартаар бараа, ажил үйлчилгээг харилцагчид шилжүүлсэн үед ажил гүйлгээний үнээр орлогыг заавал хүлээн зөвшөөрнө гэсэн үндсэн зарчмыг танилцуулсан. Салгаж болохуйц багцын бараа, ажил үйлчилгээний орлогыг салгаж бүртгэнэ, гэхдээ гэрээний хөнгөлөлт, урамшууллыг холбогдох зүйлд нь заавал хуваарилж бүртгэнэ гэж заасан. Харилцагчтай байгуулсан гэрээний эрсдэлийг бууруулахтай холбоотой гарсан зардлыг капиталжуулж гэрээний орлого олох хугацаанд хорогдуулна. Дээрх стандартын нэмэлт өөрчлөлт Банкны санхүүгийн тайланд ямар нэгэн материллаг нөлөө үзүүлэхгүй.

СТОУС 15 Нэмэлт өөрчлөлт, Харилцагчдтай хийсэн гэрээний орлого (2016 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан, 2018 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайланд дагаж мөрдөнө).). Тус өөрчлөлт стандартын үндсэн зарчим нь өөрчлөөгүй боловч дараах зарчмуудыг хэрэглэх шаардлагатай гэж заасан. Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь гүйцэтгэлийн үүргийг хангалтыг гэрээнд (сайн, үйлчилгээний хангагчийг) хэрхэн тодорхойлох, болон тодруулах; компани нь үндсэн болон агент (эсвэл үйлчилгээг үзүүлэгч) (үйлчилгээний зохион байгуулах үүрэг нь сайн) байгаа эсэхийг хэрхэн тогтоох; , хэрхэн тусгай зөвшөөрөл олгох орлого үед буюу цаг хугацааны хувьд хаана хүлээн зөвшөөрөх ёстой эсэхийг тодорхойлоход ашиглахыг заасан. Үүнээс гадна шинэ стандартыг анх мөрдөх явцад нэмэлт хоё ртусламжийг олгосон нь компанийн зардал болоод нарийн төвөгтэй байдлыг хөнгөвчилсөн. Дээрх стандартын нэмэлт өөрчлөлт Банкны санхүүгийн тайланд ямар нэгэн материаллаг нөлөө үзүүлэхгүй.

СТОУС 16 “Түрээс” (2016 оны 01 сард батлагдсан ба 2019 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Шинэ стандартаар түрээсийн хүлээн зөвшөөрөлт, дараа үеийн хэмжилт, тайлагнал болон тодруулгыг хэрхэн бэлтгэх талаар зарчмуудыг зааж өгсөн. Бүх түрээсийн хувьд түрээслэгч түрээсийн хөрөнгийг ашиглах эхлэх үеэс эхлэн хөрөнгийг ашиглах эрхийг эзэмших ба хэрэв түрээсийн төлбөрийг олон удаагийн төлбөрөөр хийх бол түрээслэгч түрээслүүлэгчээс санхүүжилт авсан гэж үзнэ. Тиймээс НББОУС 17-д заасны дагуу түрээсийг үйл ажиллагааны болон санхүүгийн түрээс гэж ангилна гэж заасан байсныг хасаж түрээсийн бүртгэлийн нэг л загварыг НББОУС 16-аар танилцуулсан. Түрээслэгч а) 12 сараас дээш хугацаатай бүх төрлийн түрээстэй холбоотой хөрөнгө өр төлбөр бүртгэх, б) орлогын тайланд түрээсийн хөрөнгийн элэгдлийг түрээсийн төлбөрийн хүүгийн зардлаас тусад нь тайлагнана. НББОУС 17-д заасан түрээслүүлэгчтэй холбоотой бүртгэлийн заалтын ихэнх хэсгийг НББОУС 16-д оруулсан. Тиймээс түрээслүүлэгч түрээсийг шинж чанараас нь хамааруулан санхүүгийн болон үйл ажиллагааны түрээсийн аль нэгээр нь бүртгэнэ. Дээрх стандартын нэмэлт өөрчлөлт Банкны санхүүгийн тайланд ямар нэгэн материллаг нөлөө үзүүлэхгүй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

6. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ШИНЭЭР БАТЛАГДСАН МЭДЭГДЛҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

СТОУС 10 болон НББОУС 28-д орсон нэмэлт өөрчлөлтүүд-Хөрөнгө оруулагч, түүний хараат компани болон хамтарсан үйлдвэрийн хооронд хөрөнгө борлуулах болон хандивлах (2014 оны 9 дүгээр сарын 11-ны өдөр батлагдсан ба 2016 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойшхи санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Хөрөнгө оруулагч, түүний хараат компани болон хамтарсан үйлдвэрийн хооронд хөрөнгө борлуулах болон хандивлах ажил гүйлгээг хэрхэн бүртгэх талаар СТОУС 10 болон НББОУС 28-д ялгаатай байдлаар тусгасан байдлыг арилгахад чиглэгдсэн. Өөрчлөлтийн үр дүнд, хөрөнгө борлуулах эсвэл хандивлах ажил гүйлгээ нь бизнесийн шинж чанартай бол олз, гарзыг нийт дүнгээр хүлээн зөвшөөрнө гэж заасан. Бизнесийн үйл ажиллагаанд ашиглагддаггүй хөрөнгийг хараат компани эзэмшиж байсан ч хөрөнгө борлуулах болон хандивлах ажил гүйлгээний олз, гарзыг хэсэгчлэн хүлээн зөвшөөрнө. Дээрх стандартын нэмэлт өөрчлөлт Банкны санхүүгийн тайланд ямар нэгэн материллаг нөлөө үзүүлэхгүй.

Бодит бус олзод хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрөх – НББОУС 12-т орсон нэмэлт өөрчлөлт. Нэмэлт өөрчлөлтөөр өрийн хэрэгслээс үүссэн бодит бус гарзад хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрөх шалгуур үзүүлэлтүүдийг илүү тодорхой болгосон. Байгууллага нь өрийн хэрэгслийг зах зээлийн хүүгээр хорогдуулсан мөнгөн гүйлгээнээс үүссэн бодит бус гарзад хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгийн эдийн засгийн үр өгөөж нь өрийн хэрэгслийн эзэмшигч ирээдүйд олз хүртэж уг олзод татвар төлөхгүй байснаар бий болох юм. Дээрх стандартын нэмэлт өөрчлөлт Банкны санхүүгийн тайланд ямар нэгэн материаллаг нөлөө үзүүлэхгүй.

Тодруулгын шаардлагад орсон өөрчлөлтүүд – НББОУС 7-д орсон өөрчлөлт (2016 оны 01 дүгээр сарын 29-ны өдөр батлагдсан ба 2017 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайлангуудад дагаж мөрдөгдөнө). НББОУС 7-д санхүүжилтийн үйл ажиллагааны өр төлбөрийн хөдөлгөөнийг тодруулгад тусгахыг нэмэлт өөрчлөлтөөр оруулсан. Дээрх стандартын нэмэлт өөрчлөлт Банкны санхүүгийн тайланд ямар нэгэн материаллаг нөлөө үзүүлэхгүй.

Хувьцаанд суурилсан төлбөр- СТОУС 2-т орсон өөрчлөлтүүд (2016 оны 6 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан ба 2018 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайлангуудад дагаж мөрдөгдөнө). Өөрчлөлтийн гол санаа нь зах зээлийн бус гүйцэтгэлийг харгалзах үзэх хугацааны талаарх нөхцөл нь мөнгөөр төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөрийн гүйлгээнд өмчөөр төлөгдөхтэй ижил маягаар нөлөөлнө.Өөрчлөлтөөр зах зээлийн бус үйл ажиллагааны хэрэгжих нөхцөлүүд нь өмчийн хэрэгслээр төлөгдөх урамшууллын нэгэн адилаар мөнгөөр төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээний хэмжилтэд нөлөөлөхийг зааж өгсөн. Нэмэлт өөрчлөлт нь мөн аж ахуйн нэгж цэвэр дүнгээр тооцоо хийх гүйлгээнээс өмчийн хэрэглүүрийн (эсрэг тохиолдолд хувьцаанд суурилсан төлбөртэй холбоотой татварын өрийг барагдуулсны төлөө хэрэгжсэний дараа гаргах) тодорхой хэсгийг суутгаж авах гүйлгээний ангиллыг тодруулж өгсөн. Ийм зохицуулалт бүхий хэрэгслийг бүхэлд нь өмчийн хэрэгслээр төлөгдөх байдлаар ангилж болно.

Эцэст нь хэлэхэд, нэмэлт өөрчлөлт нь өмчийн хэрэгслээр төлөгдөхөөр болж өөрчлөгдсөн мөнгөөр төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөрийн нягтлан бодох бүртгэлийг дараах байдлаар тодруулсан: (а) хувьцаанд суурилсан төлбөрийг өмчийн хэрэглүүрт нэмэлт өөрчлөлт оруулсан өдрийн бодит үнэ цэнээр хэмжих, (б) өр төлбөрийг өөрчлөлт орсны дараа данснаас хасах, (в) өмчийн хэрэгслээр төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөрийг өөрчлөлт орох өдөр хүртэлх үйлчилгээ үзүүлсэн хэмжээгээр хүлээн зөвшөөрөх, мөн (г) өөрчлөлт орсон өдрөөрх өр төлбөрийн дансны үнэ болон мөн өдрөөрх өмчид хүлээн зөвшөөрөгдсөн дүн хоорондын зөрүүг нэн даруй орлогын тайланд хүлээн зөвшөөрөх. Дээрх стандартын нэмэлт өөрчлөлт Банкны санхүүгийн тайланд ямар нэгэн материаллаг нөлөө үзүүлэхгүй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

6. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ШИНЭЭР БАТЛАГДСАН МЭДЭГДЛҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

СТОУС 4-ийн нэмэлт өөрчлөлт нь Стандартад заасан байгаа түр зуурын хэлбэлзлийг зохицуулах сонголтууд дээр нэмэлтээр оруулж ирсэн. Дээрх стандартын нэмэлт өөрчлөлт Банкны санхүүгийн тайланд ямар нэгэн материаллаг нөлөө үзүүлэхгүй.

Даатгалын гэрээ СТОУС 4-ийг Санхүүгийн хэрэгсэл СТОУС 9-ийн хамт хэрэглэх, СТОУС 4-ийн өөрчлөлтүүд (2016 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан ба түр чөлөөлөгдөх сонголтыг хэрэглэж буй эсвэл СТОУС 9-ийг хэрэглэж эхэлсэн бөгөөд үечилсэн аргыг ашиглаж буй компаниудын хувьд хэрэглэж байгаа аргаас нь хамааранд 2018 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайлангуудад дагаж мөрдөгдөнө). Өөрчлөлт нь Санхүүгийн тайлангийн хэрэгслийн шинэ стандарт болох СТОУС 9-ийг хэрэгжүүлэх, СТОУС 4-ийн оронд гаргахаар Стандартын Хорооны ажиллаж буй шинэ стандартыг хэрэгжиж эхлэхээс өмнө гарч болох асуудлуудыг хөндсөн. Энэ асуудлуудад тайлагнасан үр дүнгийн түр зуурын тогтворгүй байдлын талаар тусгасан. Өөрчлөлт нь 2 аргыг танилцуулж байгаа ба үүнд үечилсэн арга болон хойшлуулах арга орно. Шинэ стандарт нь даатгалын гэрээ гаргадаг бүх компаниудад даатгалын гэрээний шинэ стандарт гарахаас өмнө СТОУС 9-ийг хэрэглэж байхад гарч болох тогтворгүй байдлын талаар ашиг алдагдалд хүлээн зөвшөөрөхөөс илүүтэйгээр бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөх сонголт өгсөн.Мөн өөрчлөгдсөн стандарт үйл ажиллагаа нь даатгалын гэрээтэй илүү холбоотой компаниудад СТОУС 9 ийг 2021 он хүртэл ашиглахгүй байж болох түр чөлөөлөлт өгсөн. СТОУС 9-ийг ашиглахыг хойшлуулж буй компаниудын хувьд одоо мөрдөж буй Санхүүгийн хэрэгсэл буюу НББОУС 39-ийг үргэлжлүүлэн ашиглана. СТОУС 4-ийн одоогийн хувилбарт орж буй өөрчлөлтүүд нь түр зуурын тогтворгүй байдлын талаар холбогдох зохицуулахыг хийх бололцоог олгосон.

2014-2016 онуудад СТОУС-уудад хийгдсэн сайжруулалтууд (2016 оны 12 дугаар сарын 08-ны өдөр батлагдсан ба СТОУС 12-ын өөрчлөлт 2017 оны 01 дүгээр сарын 01-нээрх, СТОУС 1 болон НББОУС 28-ын өөрчлөлт 2018 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайлангуудад дагаж мөрдөгдөнө). Тус сайжруулалт нь 3 стандартад нөлөөлсөн. СТОУС 12-т тусгагддаг охин компаниуд, хамтарсан үйлдвэр болон хараат компаниудын нэгтгэсэн санхүүгийн мэдээллүүдтэй болон СТОУС 5 –ыг хэрэглэдэг борлуулахад бэлэн болон зогсоох гэж буй үйл ажиллагаанд ангилагдсан байгууллагын бусад байгуулагууд дахь ашиг сонирхолтой холбоотойгоос бусад тодруулгуудад тавигдах шаардлагуудыг онцлох замаар СТОУС 12 тодруулгын шаардлагуудын цар хүрээг илүү тодорхой болгох өөрчлөлт орсон. СТОУС 1 -ийн өөрчлөлт нь Санхүүгийн хэрэгслүүд, ажилчдад олгох тэтгэмжийг болон хөрөнгө оруулагч нэгжүүдийн тодруулгын шаардлагыг СТОУС мөрдөхөөс түр хугацаагаар чөлөөлсөн заалт байсныг уг богино хугацааны чөлөөлөлт зорилгынхоо дагуу хэрэглэгдсэний дараа болиулна. НББОУС 28хөрөнгө оруулсан хамтарсан үйлдвэрүүд, хамтын хөрөнгө оруулалтын сангууд, хөрөнгө оруулалттай холбоотой даатгалын сангууд болон хөрөнгө оруулалтын нэгдсэн сангуудыг НББОУС 28-ын дагуу бодит үнэ цэнийг хэмжихэд хөрөнгө оруулалтаар тус бүрээр нь авч үзэх сонголт өгсөн. Мөн байгууллага хөрөнгө оруулагч бүхий нэгж биш мөртлөө хараат компани болон хамтарсан үйлдвэртэй тохиолдол мөн хөрөнгө оруулагч нэгж гэж үздэг.

НББОУС 28 хараат болон хамтарсан компаниа өмчийн аргаар бүртгэх байсан ч хөрөнгө оруулагч нэгжийг бодит үнэ цэнийн аргын тусламжтайгаар хэмжих боломжийг хэвээр үлдээхийг зөвшөөрсөн болно. Тус өөрчлөлт мөн тус сонголт хөрөнгө оруулалт тус бүрээр байж болохыг тодруулж өгсөн. Удирдлага одоогоор тус өөрчлөлтийг Банкны санхүүгийн тайланд нөлөөлөх нөлөөллийг үнэлж байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

6. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ШИНЭЭР БАТЛАГДСАН МЭДЭГДЛҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Гадаад валютаарх гүйлгээ болон Урьдчилгааг авч үзэх- СТОУС-ын Тайлбар 22 (2016 оны 12 дугаар сарын 08-ны өдөр батлагдсан ба 2018 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайлангуудад дагаж мөрдөгдөнө). Тус тайлбар нь гадаад валютаар хийгдсэн урьдчилгаанаас үүссэн мөнгөн бус хөрөнгө ба өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхөө болих үед үүсэх холбогдох хөрөнгө болон орлого эсвэл зарлагын анхлан хүлээн зөвшөөрөлтөд зөв ханшийг хэрэглэхийн тулд гүйлгээний өдрийг хэрхэн зөв тогтоох асуудлыг хамардаг. НББОУС 21-ийн дагуу холбогдох хөрөнгө болон орлого эсвэл зарлагын анхлан хүлээн зөвшөөрөлтөд зөв ханшийг хэрэглэхийн тулд тогтоосон гүйлгээ хийгдсэн өдөр нь урьдчилгаанаас гарч ирсэн мөнгөн бус хөрөнгө ба өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрсөн өдөр байна.

Хэрэв үүнд урьдчилгаа гэж үзэх олон удаагийн төлбөр өгсөн эсвэл авсан байвал байгууллага гүйлгээ хийгдсэн тухайн өдөр бүрийг тодорхойлох ёстой. СТОУСТ 22 нь урьдчилгаанаас зөвхөн мөнгөн бус хөрөнгө эсвэл өр төлбөр хүлээн зөвшөөрч байгаа үед л хэрэглэгдэнэ.СТОУСТ нь мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө өр төлбөрийн тодорхойлолтын талаарх зааварчилгааг өгдөггүй. Урьдчилгаа болох төлбөрийг авах эсвэл өгөх үед ерөнхийдөө мөнгөн бус хөрөнгө эсвэл өр төлбөр үүсдэг боловч мөнгөөр төлөгдөх хөрөнгө эсвэл өр төлбөр мөн үүсч болдог. Байгууллага өөрсдийн үнэлэмжээр мөнгөн эсвэл мөнгөн бус зүйлсүүдийг тодорхойлно. Банк одоогоор энэ шинэ стандартын санхүүгийн тайланд нөлөөлөх нөлөөллийг үнэлж байна.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө–НББОУС 40-ийн өөрчлөлтүүд (2016 оны 12 дугаар сарын 08-ны өдөр батлагдсан ба 2018 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойших санхүүгийн тайлангуудад дагаж мөрдөгдөнө). Дуусаагүй барилгад байгаа хөрөнгийг шилжүүлэх мөн шилжихэд тавигдах шаардлагуудыг тодруулж өгсөн. НББОУС 40-д дуусаагүй барилгад байгаа Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг шилжих шилжүүлэхэд уг өөрчлөлт орохоос өмнө тодорхой зааварчилга байгаагүй. Энэ өөрчлөлтөөр өмнө нь бараа материалд ангилагдаж байсан дуусаагүй барилгад байгаа хөрөнгийг ашиглах зориулалт нь өөрчлөгдөнө гэсэн нотолгоо байгаа бол хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөд шилжүүлэхийг хориглохгүй гэдгийг тодруулж өгсөн. Мөн уг хөрөнгийг ашиглах зориулалт нь өөрчлөгдсөн гэсэн нотолгоотой, тус хөрөнгө нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн шалгуурыг хангасан талаар үнэлэлт хийгдсэн бол шилжүүлэлт хийгдэж болно гэдгийг тодруулж өгсөн. Ийм ашиглах зориулалтын өөрчлөлт нь нотолгоотой байх ёстой. Өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайлангуудад материаллаг өөрчлөлт үзүүлэхгүй гэж үзэж байна.

Дээр дурдсанаас бусдаар шинэ стандартууд болон өөрчлөлтүүд нь Банкны санхүүгийн тайлангуудад томоохон нөлөө үзүүлэхгүй болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

7. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Сая төгрөгөөр	Тодруулга	2016 оны 12 дугаар сарын 31	2015 оны 12 дугаар сарын 31
Бэлэн мөнгө		38,953	53,793
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө:			
- Богино хугацаат хадгаламж	8	844,408	183,361
- Хугацаагүй хадгаламж	8	466,869	781,784
-Зээлжих тусгай эрхийн хадгаламж	8	143,110	118,988
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		**1,493,340**	**1,137,926**

Дээрх дүнгүүдийг мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө гэж тайлагнасан.

2016 оны 12 дугаар сарын 31-нээрх Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд тооцогдох санхүүгийн хөрөнгийн үлдэгдлийн зээлийн эрсдэлийн чанарыг Стандарт энд Пүүрс, Фич, Мүүдийс үнэлгээний агентлагийн өгсөн зэрэглэлийн дагуу нэгтгэсэн байдлаар харуулбал:

Сая төгрөгөөр	Хугацаагүй хадгаламж	Гадаад валютаарх богино хугацаат хадгаламж
Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь бууraагүй		
- Ааа зэрэглэлтэй	2,830	211,418
- Аа1 зэрэглэлтэй	19,977	-
- Аа2 зэрэглэлтэй	207,389	376,134
- Аа3 зэрэглэлтэй	162,100	256,856
- А1 зэрэглэлтэй	74,573	-
- А2 зэрэглэлтэй	-	-
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд багтсан гадаадын байгууллагад байршуулсан хөрөнгө, Зээлжих Тусгай Эрхийн хадгаламжийг оруулахгүйгээр	**466,869**	**844,408**

2015 оны 12 дугаар сарын 31-нээрх мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд тооцогдох санхүүгийн хөрөнгийн үлдэгдлийн зээлийн эрсдэлийн чанарыг Стандарт энд Пүүрс, Фич, Мүүдийс үнэлгээний агентлагийн өгсөн зэрэглэлийг нэгтгэн харуулбал:

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

7. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Сая төгрөгөөр	**Хугацаагүй хадгаламж**	**Гадаад валютаарх богино хугацаат хадгаламж**
Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй		
- Ааа зэрэглэлтэй	-	2
- Аа1 зэрэглэлтэй	24,075	-
- Аа2 зэрэглэлтэй	161,237	183,359
- Аа2 зэрэглэлтэй	120,128	-
- А1 зэрэглэлтэй	475,932	-
- А2 зэрэглэлтэй	-	-
- Ваа1 зэрэглэлтэй	412	-
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд багтсан гадаадын байгууллагад байршуулсан хөрөнгө, Зээлжих тусгай эрхийн хадгаламжийг оруулахгүйгээр	**781,784**	**183,361**

Хэрэв Төв банк эсвэл харилцагч олон улсын санхүүгийн байгууллагын хувьд зэрэглэл байхгүй бол (Жишээ нь Английн Төв банк) тэдгээрийн зэрэглэлийг холбогдох улсын зээлжих зэрэглэлийн дагуу үнэлнэ. Бэлэн мөнгө болон ОУВС дахь ЗТЭ-ийн хадгаламжийн хувьд Банк нь зээлийн эрсдэл хүлээгээгүй болно.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн газар зүйн болон мөнгөн тэмдэгтийн эрсдэлийн шинжилгээ, хүүгийн эрсдэлийн шинжилгээ, дуусгавар хугацааны талаах холбогдох шинжилгээг (Тодруулга 34)-өөс харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

8. ГАДААДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ

Сая төгрөгөөр	2016 оны 12 дугаар сарын 31	2015 оны 12 дугаар сарын 31
Богино хугацаат хадгаламж	844,408	183,361
Хугацаагүй хадгаламж	466,869	781,784
Хязгаарлагдсан бэлэн мөнгө	964	801
Зээлжих тусгай эрхийн хадгаламж	143,110	118,988
Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө	156	125
Бусад хувь хөрөнгө	10	4
Нийт гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө	**1,455,517**	**1,085,063**

Богино хугацаат хадгаламж. Эдгээр дүнгүүдэд гадаадын Төв банкуудад болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан ам.доллар, фунт стерлинг, юаны эхний төлөгдөх хугацаа нь 59 өдрөөс өмнө байх богино хугацаат хадгаламжууд.

Хугацаагүй хадгаламж. Энэ дүнд гадаадын Төв банкуудад болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах дансны үлдэгдлүүд байна.

Зээлжих тусгай эрх. Энэхүү үлдэгдэл нь Олон улсын валютын санд Монгол улсаас төлөх хувь хэмжээтэй холбоотой нөөцийн хөрөнгийг нөхөх зээлжих тусгай эрхийн хадгаламжийг харуулна. 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 42.9 сая ЗТЭ (2015 онд 42.9 сая ЗТЭ) дүнтэй байсан бөгөөд энэ нь хүүтэй болно.

Хязгаарлагдсан бэлэн мөнгө. Уг данс нь гуравдагч талын хүсэлтээр Цюрихийн харьяа Шүүхээс хязгаарлалт тогтоосон 397,703 щвейцар франк буюу 964 сая төгрөг (2015 онд 801 сая төгрөг). Дэлгэрэнгүй мэдээллийг (Тодруулга 32)-оос харна уу.

Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө. Энэ нь Дэлхийн банкны гишүүнчлэлийн нөхцөлийн дагуу Дэлхийн банкинд байршуулсан хадгаламж болон түүнд оруулсан хувь хөрөнгө юм. Энэ дүн нь харгалзах өр төлбөрийн дүнтэй таарч байгаа ба түүнд хүү тооцдоггүй (Тодруулга 21). Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын Төв банк болон бусад нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудад байршуулсан тул энэ хөрөнгөд үнэ цэнийн бууралт хэзээ ч болдоггүй.

Бусад хувь хөрөнгө. Уг данс нь Монгол Улс Свифт сүлжээнд гишүүнээр элсэхэд оруулсан хувь хөрөнгө. Дээрх бүх хөрөнгүүд үнэ цэнийн бууралтгүй бөгөөд удирдлагын зүгээс энэхүү хөрөнгө эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын Төв банкууд болон бусад нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудад байршуулсан байгаа тул бүрэн эргэн төлөгдөнө гэж үзэж байна. Эдгээр хөрөнгийн аль нь ч барьцаа хөрөнгөөр баталгаажаагүй. Удирдлага эдгээр хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны дүнтэйгээ ойролцоо дүнтэй гэж үзэж байна. Газар зүйн болон зээлийн эрсдэлийн чанарын шинжилгээ, валютын ханш, хүү болон дуусгавар хугацааны шинжилгээг (Тодруулга 34)-өөс харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

9. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ

Сая төгрөгөөр	**2016 оны 12 сарын 31**	**2015 оны 12 сарын 31**
Үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрийн зээл	1,055,978	882,451
Барьцаат зээл	14,400	285,000
Бусад зээл	16,332	18,069
Үнэ цэнийн бууралтын нөөцөөс өмнөх дотоодын банкуудад олгосон нийт зээл	**1,086,710**	**1,185,520**
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын алдагдлын нөөц	(144)	-
Дотоодын банкуудад олгосон нийт зээл	**1,086,566**	**1,185,520**

Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл

Банк нь Засгийн газартай хамтран хэрэгжүүлсэн үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд шатахууны жижиглэн худалдааны үнийг тогтворжуулах, өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах, хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах, барилгын салбарыг дэмжих, орон сууцны үнийг тогтворжуулах, нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, эрчим хүчний үнэ тарифыг тогтворжуулах гэсэн 5 дэд хөтөлбөрийн хүрээнд төгрөгийн зээлийг дотоодын банкуудад олгосон.

Эдгээр дэд хөтөлбөрийн хэрэгжих хугацааг Засгийн газар болон Банк хамтран баталсан бөгөөд Банк дотоодын банкинд олгох зээлийн хүү, эцсийн зээлдэгчид хүрэх зээлийн хүүг тус тус тогтоосон. Харин энэхүү хөтөлбөрт хамрагдах компаниудыг Засгийн газрын холбогдох яамд тодорхойлсон бөгөөд дотоодын банкууд тэдгээр компаниудад зээлийн шинжилгээ хийж, зээл олгох шийдвэр гаргасан тохиолдолд Банкнаас санхүүжилтийг нэхэмжлэн авч, компаниудад дамжуулан олгосон.

Ипотекийн зээлийн хөтөлбөрт оролцогч талуудтай байгуулсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн ерөнхий гэрээ”, дотоодын банкуудтай байгуулсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн гэрээ”-ний дагуу Банк дотоодын банкуудад ипотекийн хөтөлбөрийн хүрээнд олгосон санхүүжилтийн төлбөрийн 90 хувьд нь МИК Актив ТЗК-иас гаргасан давуу эрхтэй ИЗББ-ыг хүлээн авч, 10 хувийг харилцах данснаас буцаан төлүүлсэн.

Улсын Их Хурлын 2014 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 69 дүгээр тогтоолын дагуу Банк 2014 оны 12 дугаар сараас “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-өөс үе шаттай гарч эхэлсэнтэй холбогдуулан дотоодын банкуудад нэмэлт эх үүсвэр олгохыг зогсоосон.

Банк 2016 онд үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд зөвхөн ипотекийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг олгосон бөгөөд оны эцсийн байдлаар 1,018,005 сая төгрөгийн (2015 онд 659,640 сая төгрөг) санхүүжилтийн үлдэгдэлтэй байна. Банкнаас дотоодын банкуудад олгосон ипотекийн зээлийн санхүүжилтийн хүү жилийн 2 хувь болон 4 хувь байсан болно.

Банк 2015 онд 4 төрлийн зээлийг үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон бөгөөд хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрийн хүрээнд мах, гурилын үнэ тогтворжуулах хөтөлбөр, барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хүрээнд барилгын материалын дотоодын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрүүд багтана.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

9. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Удирдлага үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хувьд хэрэгжүүлсэн эдгээр зээлийг анх хүлээн зөвшөөрөх үед ямар нэгэн алдагдлыг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж дүгнэсэн. (Тодруулга 4 болон 3)-т удирдлагын зүгээс хийсэн холбогдох дүгнэлт болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар харна уу.

Барьцаат зээл

Нийт 14,400 сая төгрөг (2015 онд 285,000 сая төгрөг)-ийн жилийн 12.5 хувь (2015 онд жилийн 14-15 хувь)-ийн хүүтэй барьцаат зээлийг дотоодын банкинд олгосон. Тус зээл нь харгалзах банкны хувьд зээлийн барьцаагаар хангагдсан болно.

Төгрөгөөр олгосон зээл

“Бусад зээл”-ийн нэг хэсэг болох төгрөгөөр олгосон зээлд Азийн хөгжлийн банк (АХБ)-ны дэмжлэгтэйгээр дотоодын банкуудад олгосон 3,112 сая төгрөгийн (2015 онд 3,389 сая төгрөг) зээл, Герман улсын Засгийн газрын (КФВ) дэмжлэгтэйгээр дотоодын банкуудад олгосон 7,209 сая төгрөгийн (2015 онд 7,393 сая төгрөг) зээл багтаж байна.

Азийн хөгжлийн банк (АХБ)-ны зээлийг ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор дотоодын банкуудаар дамжуулан олгосон. АХБ-ны ажлын байр нэмэгдүүлэх төсөлтэй холбоотой зээл нь үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинэ ажлын байрыг бий болгох зорилготой. Зээл нь жилийн 7 хувь (2015 онд жилийн 10 хувь)-ийн хүүтэй бөгөөд эргэн төлөлтийн хугацаа олгосон өдрөөс хамаарч ялгаатай байгаа болно.

Монгол улсын жижиг, дунд бизнесүүдийг дэмжих зорилгоор дотоодын банкуудаар дамжуулан олгосон зээл нь Герман улсын Засгийн газар (КФВ)-ын I болон II хөтөлбөрүүдээр дамжин хэрэгждэг.

Банкны зээлийн эрсдэл нь зээлдэгчдийн зээлийн эргэн төлөлтөөс хамаарахгүй бөгөөд Банк зээлийн төлөх хугацаа болмогц тухайн дотоодын банкны Монголбанкин дахь данснаас хөрөнгийг шууд татах эрхтэй. Энэ зээлтэй холбоотой хийгдсэн удирдлагын үнэлэмж, дүгнэлтийг (Тодруулга 4)-өөс харна уу.

Гадаад валютын зээл. “Бусад зээл”-ийн нөгөө хэсэг болох гадаад валютаар олгосон зээлийн дийлэнх хувийг Герман улсын Засгийн газрын (КФВ) Монгол улсын жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг дэмжих хөтөлбөрийн дотоодын банкуудад олгосон 5,010 сая төгрөг (2015 онд 6,519 сая төгрөг)-ийн зээл, банкуудын мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, банкны системийг сайжруулах АХБ-ны хөтөлбөрийн 879 сая төгрөг (2015 онд 751 сая төгрөг)-ийн зээл тус бүр бүрдүүлж байна.

Герман улсын Засгийн газраас Монгол улсын жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг дэмжих зорилгоор дотоодын банкуудад олгосон зээл нь бие даасан хоёр тусдаа КФВ хөтөлбөрөөр хэрэгжиж байна. Эдгээр зээл нь жилийн 1.25-1.75 хувийн хүүтэй бөгөөд ямар нэгэн үнэт цаасаар баталгаажаагүй. Эдгээр хөтөлбөрийн зээлийг дотоодын гурван банкаар дамжуулан КФВ-ийн тогтоосон тодорхой шалгуурт нийцсэн зээлдэгчдэд олгосон.

Иймээс эргэн төлөлтийн хугацаа нь олгосон өдрөөс хамааран ялгаатай байна. Энэ зээлтэй холбоотой хийгдсэн удирдлагын үнэлэмжийг (Тодруулга 4)-өөс харна уу.

Зээлийн гэрээний дагуу Банк зээлийн төлөх хугацаа болмогц тухайн дотоодын банкны Банк дахь данснаас шууд татах эрхтэй. Дотоодын банкны ажилтнуудын ур чадварыг дээшлүүлж, банкуудын програм хангамжийг сайжруулах зорилготой зээл нь Монгол улс болон Азийн хөгжлийн банкны хооронд байгуулагдсан гэрээний дагуу “Ди-Эй-Ай” (Тайланд) Лимитед компанийн зохион байгуулсан сургалтыг санхүүжүүлэх зорилгоор олгогдсон. Энэхүү зээлийн эргэн төлөгдөх хугацаа нь 14 жил.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

9. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2016 оны хэмжээнд зээлийн үнэ цэнийн бууралтын сангийн хөдөлгөөнийг доор харуулав:

Сая төгрөгөөр	**Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл**	**Барьцаат зээл**	**Бусад зээл**	**Нийт**
2016.01.01-ний байдлаар	**-**	**-**	**-**	**-**
Зээлийн үнэ цэнийн бууралтын нөөц				
(Тодруулга29)	-	(144)	-	**(144)**
(Буцаалт)/Үнэ цэнийн бууралтын нөөц	-	-	-	**-**
2016.12.31-ний байдлаар үнэ цэнийн бууралтын нөөц	**-**	**(144)**	**-**	**(144)**

2015 оны зээлийн болзошгүй алдагдлын нөөцийн сангийн хөдөлгөөнийг доор харуулав:

Сая төгрөгөөр	**Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл**	**Барьцаат зээл**	**Бусад зээл**	**Нийт**
2015.01.01-ний байдлаар	**-**	**-**	73,812	**73,812**
Зээлийн болзошгүй алдагдлын нөөцийн **сан**				
Бусад хөрөнгөд дахин ангилагдсан (Тодруулга 15)	-	-	(73,662)	**(73,662)**
(Буцаалт)/ болзошгүй алдагдлын нөөц Тодруулга 30)	-	-	(150)	**(150)**
2015.12.31-ний байдлаар болзошгүй алдагдлын нөөц	**-**	**-**	**-**	**-**

2015 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийн хүрээнд олгосон зээл, төгрөгөөр болон гадаад валютаар олгосон зээлийн хувьд үнэ цэнэ бууралтын шинж тэмдэг илрээгүй тул үнэ цэнийн бууралтын алдагдлын сан байгуулаагүй болно (Тодруулга 4).

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

9. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн эрсдэлийн шинжилгээг дор үзүүлэв:

Сая төгрөгөөр	**Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл**	**Барьцаат зээл**	**Бусад зээл**	**Нийт**
Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй				
- Саа1 зэрэглэлтэй	218,776	-	6,182	**224,958**
- Саа2 зэрэглэлтэй	630,787	-	8,182	**638,969**
- Зэрэглэлгүй	206,415	-	1,968	**208,383**
Нийт хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй	**1,055,978**	**-**	**16,332**	**1,072,310**
Дангаараа үнэ цэнэ нь буурсан нийт зээл				
- 30-аас доош хоногоор хугацаа хэтэрсэн	-	14,400	-	**14,400**
Дангаараа нийт үнэ цэнэ нь буурсан зээл	**-**	**14,400**	**-**	**14,400**
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын нөөц	-	(144)	-	**(144)**
Нийт дотоодын банкуудад олгосон зээл	**1,055,978**	**14,256**	**16,332**	**1,086,566**

2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийн эрсдэлийн үзүүлэлтийг дор үзүүлэв:

Сая төгрөгөөр	**Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл**	**Барьцаат зээл**	**Бусад зээл**	**Нийт**
Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй				
- В3 зэрэглэлтэй	591,684	245,000	14,810	**851,494**
- Зэрэглэлгүй	290,767	40,000	3,259	**334,026**
Нийт хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй	**882,451**	**285,000**	**18,069**	**1,185,520**
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын нөөц	-	-	-	**-**
Нийт дотоодын банкуудад олгосон зээл	**882,451**	**285,000**	**18,069**	**1,185,520**

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

9. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Тодруулга 34-т тусгаснаар Монгол улсын томоохон банкуудыг олон улсын зэрэглэл тогтоогч байгууллагын зүгээс үнэлсэн байдлаар эрэмбэлсэн. Дээрх шинжилгээ олон улсын зэрэглэл олгогч байгууллагуудын хамгийн бага үнэлгээ өгсөн байдалд суурилсан болно. Зэрэглэл олгогдоогүй байгаа Монгол улсын бусад банкуудын хувьд Банк тухайн банкны хамгийн сүүлийн үеийн санхүүгийн мэдээллүүд, санхүүгийн байдал, өөрийн хөрөнгийн зохистой байдал, холбогдох хөрөнгүүдийн зээлийн чанарыг үнэлэхэд зориулсан бусад мэдээллүүдийг харгалзан авч үздэг болно.

Банкуудад олгосон төгрөгийн зээлүүд байрьцаатай бөгөөд бусад бүх зээлүүд нь барьцаагүй байна. Барьцаат зээлд Засгийн газрын үнэт цаас болон тухайн банкны зээлийн багцын гүйцэтгэлийг барьцаалсан.

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх барьцаа хөрөнгийн талаарх мэдээлэл:

Сая төгрөгөөр	**Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл**	**Барьцаат зээл**	**Бусад зээл**	**Нийт**
Барьцаагүй	1,055,978	-	16,332	**1,072,310**
Бизнесийн зээлээр барьцаалагдсан зээл	-	14,400	-	**14,400**
Барьцаат хөрөнгөтэй зээл	**-**	**14,400**	**-**	**14,400**
Болзошгүй алдагдлын нөөцийн сангаас өмнөх дотоодын банкуудад олгосон нийт зээл	**1,055,978**	**14,400**	**16,332**	**1,086,710**

2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх барьцаа хөрөнгийн талаарх мэдээлэл:

Сая төгрөгөөр	**Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл**	**Барьцаат зээл**	**Бусад зээл**	**Нийт**
Барьцаагүй	882,451	-	18,069	**900,520**
Арилжааны зээлээр барьцаалагдсан	-	285,000	-	**285,000**
Барьцаа хөрөнгөтэй зээл	**-**	**285,000**	**-**	**285,000**
Болзошгүй алдагдлын нөөцийн сангаас өмнөх дотоодын банкуудад олгосон нийт зээл	**882,451**	**285,000**	**18,069**	**1,185,520**

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

10. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ - БОРЛУУЛАХАД БЭЛЭН

Сая төгрөгөөр	2016 оны 12 сарын 31	2015 оны 12 сарын 31
Өрийн үнэт цаас - борлуулахад бэлэн:		
ОУ-ын Төлбөр Тооцооны банкны Бонд (ам.доллар)	223,981	119,726
АНУ-ын Засгийн газрын үнэт цаас	253,165	201,675
Рамп Хөрөнгө оруулалтын данс	252,800	201,187
Давуу эрхтэй ИЗББ	1,917,155	1,819,314
Хөгжлийн банкны үнэт цаас	36,087	105,945
Өмчийн үнэт цаас - борлуулахад бэлэн:		
МИК ХК-д оруулсан өмчийн хөрөнгө оруулалт, бодит үнэ цэнээр	5,139	5,055
Өмчийн хөрөнгө оруулалт, өртгөөр	6,595	6,142
Нийт санхүүгийн хөрөнгө оруулалт – борлуулахад бэлэн	**2,694,922**	**2,459,044**

Олон улсын төлбөр тооцооны банкны (ОУТТБ) бонд. Өрийн үнэт цаас ба бондын зах зээлийн үнэд тулгуурласан бодит үнэ цэнээр хэмжигддэг. Дээрх бүх бондууд жилийн 0,55 хувийн хүүтэй богино хугацаатай буюу дуусах хугацаа нь хамгийн ихдээ 42 хоног хүртэлх хугацаатай. Банк эдгээр бондыг өндөр нэр хүндтэй ОУТТБ-ын хувьд бага эрсдэлтэй гэж үзэж хөрөнгө оруулсан. Энэ хөрөнгө оруулалтууд хугацаа хэтрээгүй, үнэ цэнэ нь бууraагүй болно (Тодруулга 34)-с харна уу.

АНУ-ын Засгийн газрын үнэт цаас. Санхүүгийн жилийн эцсээрх уг хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл 102 сая ам.доллар буюу 253,165 сая төгрөг (2015 онд 101 сая ам.доллар буюу 201,675 сая төгрөг) байна. Уг бондын хугацаа нь 5 сараас 3 жил ба жилийн 0.4 -1.4 хувийн хүүтэй болно. Энэ хөрөнгө оруулалт нь хугацаа хэтрээгүй, үнэ цэнэ нь бууraагүй гэж үзэж байгаа бөгөөд барьцаагүй болно (Тодруулга 34)-с харна уу.

"Рамп" Хөрөнгө оруулалтын данс. Гадаад валютын нөөцийн удирдлагыг сайжруулах зорилгоор Монголбанк нь Дэлхийн банкны "Нөөцийн удирдлагыг сайжруулах зөвлөгөө ба нөөцийн удирдлага" төслийг 2011 оноос хэрэгжүүлсэн.

2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл нь 0.3 сая ам.доллар буюу 697 сая төгрөг (2015 онд 0,3 сая ам.доллар буюу 615 сая төгрөг)- бүхий мөнгөн хөрөнгө, 101 сая ам.доллар буюу 252,103 сая төгрөг (2015 онд 100 сая ам.доллар буюу 200,572 сая төгрөг)-ийн үнэт цааснаас бүрдэж байна. Хөрөнгө оруулалтын дансны бүртгэлийг АНУ-ын Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкинд байршуулсан.

Хөрөнгө оруулалтын данс дахь үнэт цаасны ихэнхи хувийг АНУ-ын Засгийн газрын бонд болон бусад орны Засгийн газрын байгууллагаас гаргасан үнэт цаас бүрдүүлж байна.

Хөрөнгө оруулалтын данс дахь өрийн үнэт цаасны зээлийн эрсдэлийн чанарыг Стандарт энд Пүүрс, Мүүдийс болон Фичийн рейтингээр үнэлэхэд Аа3-аас Ааа зэрэглэлтэй байсан.

МИК ОССК ХХК-ийн охин компаниудын гаргасан ипотекийн зээлээр баталгаажсан бонд. Банк нь 2013 оны 6 дугаар сарын 14-ний өдөр МИК ОССК ХХК болон дотоодын банкуудтай "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн ерөнхий гэрээ"-г байгуулсан. Уг гэрээний хүрээнд Банк дотоодын банкуудад олгосон бага хүүтэй зээлийн төлбөрт МИК Актив ТЗК-иас гаргасан давуу эрхтэй ИЗББ-ыг хүлээн авсан бөгөөд энэ талаар (Тодруулга 9)-ийг харна уу. Тус бонд нь 20 хүртэлх жилийн хугацаатай, жилийн 4.5 хувийн хүүтэй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

10. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ - БОРЛУУЛАХАД БЭЛЭН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хөгжлийн банкны үнэт цаас. Үнэт цаасны нийт нэрлэсэн үнэ 60,000 сая төгрөг бөгөөд 6 жилийн хугацаатай 4 хувийн купонтой (2015 онд 133,749 сая төгрөг, 3-6 жилийн хугацаатай, 4 хувийн хүүтэй). Хүүгийн төлбөр нь хагас жил тутамд төлөгдөх нөхцөлтэй. Эдгээр үнэт цаасыг анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ нь 31,397 сая төгрөг (2015 онд 105,146 сая төгрөг) байсан. 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэрлэсэн үнэ болон бодит үнэ цэнийн зөрүү 28,603 сая төгрөг бүхий үнэ цэнийн бууралтыг ашиг, эсвэл алдагдлаар 2015 оны тайланд хүлээн зөвшөөрсөн.

МИК Холдинг ХК-д оруулсан өмчийн хөрөнгө оруулалт. Банк МИК Холдинг ХК-ийн 421,241 ширхэг энгийн хувьцааг (нийт хувьцааны 2.03 хувь) эзэмшдэг бөгөөд тайлант санхүүгийн жилийн эцэст тус хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ 5,139 сая төгрөг (2015 онд 421,241 хувьцаа 5,055 сая төгрөгийн бодит үнэтэй) байв. Эдгээр үнэт цааснуудын бодит үнийн зөрүүгийн олз ба гарз нь өөрийн хөрөнгийн бусад нөөцийн хэсэгт хүлээн зөвшөөрсөн. (Тодруулга 23)-аас харна уу.

Өмчийн хөрөнгө оруулалт, өртгөөр. Үүнд Олон улсын хөрөнгө оруулалтын банк, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны банк болон Монголын банкуудын холбоонд оруулсан хөрөнгө оруулалтууд багтана. Зах зээлийн үнэ байхгүйгээс уг хөрөнгө оруулалтуудыг өртгөөр нь бүртгэсэн. Удирдлага эдгээр хөрөнгө оруулалтуудын бодит үнэ цэнэ дансны үнээсээ материаллаг хэмжээний зөрүү байхгүй байна гэж үзсэн. Цаашлаад, удирдлага эдгээр хөрөнгө оруулалтуудад үнэ цэнийн бууралтын нөөц сан байгуулах шаардлагагүй гэж үзсэн.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

11. УРВУУ БУЦААН ХУДАЛДАН АВАХ ХЭЛЦЭЛ

Сая төгрөгөөр	**2016.12.31**	**2015.12.31**
Нью-Йоркийн Холбооны Нөөцийн банк	845,195	827,134
Дотоодын банкууд – Төгрөгөөр	204,331	400,035
Дотоодын банкууд- Гадаад валютаар	-	100,852
Нийт буцаан худалдан авах нөхцөлтэй гэрээний дүн	**1,049,526**	**1,328,021**

Нью-Йоркийн Холбооны Нөөцийн банк Банк Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкинд байршуулсан хадгаламжийн хувьд "Автомат хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-т хамрагдсан. Энэхүү хөтөлбөрийн дагуу 250,000 ам.доллараас давсан дүнг Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкны буцаан худалдан авах гэрээнд (буцаан худалдан авах репо) хөрөнгө гэж оруулсан болно.

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр буцаан худалдан авах репо гэрээнд оруулсан хөрөнгө оруулалт нь 339 сая ам.доллар буюу 845,195 сая төгрөг байна. Энэхүү хөрөнгө оруулалт дөрөв хоногийн хугацаатай бөгөөд жилийн 0.46 хувийн хүүтэй. Холбогдох хөрөнгө оруулалтыг байнга барьцаагаар баталгаажуулдаг боловч тус хөтөлбөрийн дагуу үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийснийг тодорхойлох нь хүндрэл бэрхшээлтэй байна (Тодруулга 34)-өөс харна уу.

Эдгээр урвуу буцаан худалдан авах хэлцлийн хугацаа хэтрээгүй бөгөөд үнэ цэнэ нь буураагүй болно. 2015 ба 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Мүүдийс, Стандарт ба Пүүрс болон Фичийн зэрэглэлийн хувьд Аа1 зэрэглэлтэй байна.

Дотоодын банкууд. Дотоодын банкуудтай байгуулсан "Төгрөгийн" буцаан худалдан авах гэрээнүүд нь Төв банкны үнэт цаас болон Засгийн газрын үнэт цааснуудаар баталгаажсан урт болон богино хугацаат зээлийг илэрхийлдэг.

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дотоодын банкууд дахь төгрөгийн овернайт буцаан худалдан авах хэлцлийн дүн 50,770 сая төгрөг (2015 онд 400,035 сая төгрөг, 5 хоногийн хугацаатай, 15 хувийн хүүтэй) байсан бөгөөд жилийн 17 хувийн хүүтэй байсан. Энэ гэрээ нь Төв банкны үнэт цаасаар баталгаажсан.

Төгрөгийн буцаан худалдан авах нөхцөлтэй гэрээ нь 173,425 сая төгрөгийн 3-6 жилийн хугацаатай, 7,5 хувийн хүүтэй Хөгжлийн банкнаас гаргасан үнэт цаасаар баталгаажсан дотоодын банкуудтай хийсэн урт хугацааны гэрээнүүдийг илэрхийлнэ. Бодит үнэ цэнийн хувьд анх хүлээн зөвшөөрөх үед 150,000 сая төгрөг байсан. Бодит үнэ цэнэ болон нэрлэсэн үнийн зөрүү болох 23,426 сая төгрөг 2016 оны ашиг, эсвэл алдагдлаар хүлээн зөвшөөрөгдсөн. Эдгээрийн хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

12. АЛТ БА ҮНЭТ МЕТАЛ

Сая төгрөгөөр	2016.12.31	2015.12.31
Үнэлгээгээр		
Алт	159,004	153,097
Мөнгө	1,047	343
Өртгөөр		
Алт олборлогчдоос худалдан авсан алт,мөнгө	43,920	258,366
Замд яваа цэвэршүүлэхээр ачуулсан алт	22,677	2,603
Зоос, түүх соёлын үнэт зүйлс	5,879	5,743
Нийт алт ба үнэт метал	**232,527**	**420,152**

Мөнгөжсөн алт нь Английн Төв банк болон Скотиа Мокатта банкинд байршдаг. Бусад үнэт метал (мөнгөжөөгүй алт, мөнгө, алтан гулдмай, мөнгөний хүдэр), зоос түүх соёлын үнэт зүйлсийг Банкны эрдэнэсийн санд хадгалдаг. Мөн цэвэршүүлэхээс өмнөх алтыг дотоодын олборлогчдоос худалдан авсан мөнгөжөөгүй алтыг мөн хадгалагдаг болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

13. САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЭЛ

Санхүүгийн үүсмэл хэрэгсэл нь дотоод болон гадаадын банкуудтай байгуулсан гадаад валютын своп хэлцлүүдийн бодит үнэ цэнийг илэрхийлдэг. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд нь зах зээлийн хүүгийн хэлбэлзэл, гадаад валютын ханш болон бусад хувьсагчуудаас шалтгаалан тааламжтай (хөрөнгө), тааламжтай бус (өр төлбөр) нөхцөл байдалтай байдаг. Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн хэрэгслүүд нь нийт дүнгээрээ байнга мэдэгдэхүйц хэмжээгээр хэлбэлзэж байдаг.

Санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнийг Банкны Ерөнхийлөгчийн 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А-358 дугаар тушаалаар батлагдсан зах зээлийн үнийн тооцооллын дагуу бодсон. Доорх хүснэгт нь хөрөнгө өр төлбөрөөр хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнийг харуулж байна:

Сая төгрөгөөр	**2016.12.31**	**2015.12.31**
Гадаад валютын форвард ба своп: тайлант хугацааны эцсээрх бодит үнэ цэнэ		
- Санхүүгийн хөрөнгийн ашиг алдагдлаарх бодит үнэ цэнэ	10,413	7,895
- Санхүүгийн өр төлбөрийн ашиг алдагдлаарх бодит үнэ цэнэ	(939,453)	(272,954)
Санхүүгийн хөрөнгийн ашиг алдагдлаарх цэвэр бодит үнэ цэнэ	**(929,040)**	**(265,059)**

Доорх хүснэгт нь тайлант хугацааны эцсээрх Банкны гадаад валютын форвард ба своп хэлцлийн авлага, өглөгийн бодит үнэ цэнийг харуулж байна. Хүснэгтэнд харилцагч талын позици (ба төлбөр)-тэй цэвэршүүлээгүй бохир позицыг харуулсан бөгөөд холбогдох тайлант хугацааны хойших цаг хугацаанд хийгдэх төлбөр тооцоо бүхий хэлцлүүдийг мөн багтаасан болно.

	2016		**2015**	
Сая төгрөгөөр	**Тааламжтай бодит үнэтэй хэлцлүүд**	**Тааламжгүй бодит үнэтэй хэлцлүүд**	**Тааламжтай бодит үнэтэй хэлцлүүд**	**Тааламжгүй бодит үнэтэй хэлцлүүд**
Гадаад валютын форвард ба своп: тайлант хугацааны эцсээрх бодит үнэ цэнэ				
- Ам.долларын авлага (+)	59,373	-	9,977	151,042
- Ам.долларын өглөг (-)	(267,398)	(3,174,178)	(420,021)	(1,769,990)
- Төгрөгийн авлага (+)	125,698	2,234,725	366,453	1,498,037
- Төгрөгийн өглөг (-)	(50,400)	-	(9,971)	(182,854)
- Юаны авлага (+)	143,140	-	61,457	30,811
- Юаны өглөг (-)	-	-	-	-
Гадаад валютын свопын цэвэр бодит үнэ цэнэ	**10,413**	**(939,453)**	**7,895**	**(272,954)**

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

14. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС

Сая төгрөгөөр	**2016.12.31**	**2015.12.31**
Засгийн газрын үнэт цаас, хорогдуулсан өртгөөр	326,508	202,218
Засгийн газрын нийт үнэт цаас	**326,508**	**202,218**

Банк Засгийн газрын үнэт цаасыг урамшуулалтай, хямдруулалттай, эсвэл нэрлэсэн үнээр анхдагч болон хоёрдогч зах зээлээс (2015 урамшуулалтай) худалдан авдаг. Үнэт цаасны нэрлэсэн үнэ 108,800 сая төгрөг (2015 онд 93,000 сая төгрөг) бөгөөд жилийн 9.63-14 хувийн хүүтэй, 1.7-2 жилийн хугацаатай (2015 онд 5 жил).

Мөн Банк Засгийн газрын хэрэгжүүлсэн “Сайн” хөтөлбөрийн дагуу 453,712 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 1.0-3.0 хувийн хүүтэй, 3-15 жилийн хугацаатай Засгийн газрын үнэт цаас худалдан авсан. Эдгээр үнэт цаасны бодит үнэ цэнэ анх хүлээн зөвшөөрөх үед 124,668 сая төгрөг байсан. Бодит үнэ цэнэ болон нэрлэсэн үнийн зөрүү болох 330,044 сая төгрөгийг 2016 оны ашиг, эсвэл алдагдлаар хүлээн зөвшөөрсөн. Үүнтэй холбоотойгоор удирдлагын зүгээс хийсэн үнэлэмж болон нягтлан бодох бүртгэлийг бодлогын талаар (Тодруулга 3 болон 4)-өөс харна уу.

(Тодруулга 4)-т тайлагнаснаар Засгийн газрын үнэ цаасны нэрлэсэн үнэ нь 100,000 сая төгрөг байсан бөгөөд жилийн 14 хувь байсан зах зээлийн хүүгийн түвшнөөс доогуур байна. Тухайн үнэт цаасны анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ 95,349 сая төгрөг байсан бөгөөд анхны хүлээн зөвшөөрөлтийн гарз нь “нэг дэх өдрийн хувьд” 4,651 сая төгрөг байсан бөгөөд 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн ашиг, эсвэл алдагдлаар хүлээн зөвшөөрсөн.

Эдгээр үнэт цааснууд хорогдуулсан өртгөөр хэмжигддэг. Бүх дээрх үлдэгдлүүд хугацаа хэтрээгүй, үнэ цэнэ нь буураагүй бөгөөд үнэт цаасаар баталгаажаагүй. Холбоотой талын талаарх дэлгэрэнгүйг (Тодруулга 33)-аас харна уу. Эдгээр үнэт цаасны бодит үнэ цэнийн дэлгэрэнгүйг (Тодруулга 35)-аас харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

15. БУСАД ХӨРӨНГӨ

Сая төгрөгөөр	**2016.12.31**	**2015.12.31**
Бусад санхүүгийн хөрөнгө		
Хадгаламжийн даатгалын корпорациас авах авлага	199,212	204,911
Татан буугдсан Анод банкнаас хүлээн авсан хөрөнгө	66,430	67,646
Аж ахуйн нэгжүүдээс авах авлага	53,374	52,657
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авах авлага	21,765	17,450
Өрийн бичгээрх авлага	698,944	284,136
Хасах нь: Болзошгүй алдагдлын нөөцийн сан	(346,732)	(222,757)
Бусад санхүүгийн бус хөрөнгө		
Урьдчилж төлсөн зардал	2,184	149
Бусад	1,755	618
Хасах нь: Болзошгүй алдагдлын нөөцийн сан	(287)	(236)
Нийт бусад хөрөнгө	**696,645**	**404,574**

Өрийн бичгээр авлага нь дотоодын компаниудаас гаргасан доорх өрийн бичгүүдийг илэрхийлж байна. Үүнд:

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банк 815,000 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй дотоодын таван (5) компанийн болон дотоодын банкны гаргасан өрийн бичгүүдийг эзэмшиж байна. Өрийн бичгийг байрцаалж дотоодын байгууллагад олгосон зээлийн нийт цэвэр дүн 563,001 сая төгрөг болно. Эдгээр өрийн бичгүүд нь 5-6 жилийн хугацаатай бөгөөд гэрээгээр тодорхойлж заасан хүүгийн түвшинтэй болно. Өрийн бичгийн гэрээнүүд нь тодорхой нөхцөл хангагдсан тохиолдолд хүүгийн түвшин буурах нөхцөлтэйгээр баталгаажсан, тухайлбал, эдгээр гэрээнүүд анхны хүүгийн түвшин өндөр байхаар заасан боловч тодорхой нөхцөл байдал хангагдсан тохиолдолд зээлийн хүүг зах зээлийн хүүгийн түвшин хүртэл бууруулах боломжтой. Банкны удирдлага болон хуулийн газар эдгээр гүйлгээг Төв банкны болон Монгол улсын бусад холбогдох хуулийн заалтуудыг зөрчөөгүй гэж үзэж байгаа болно. Эдгээр өрийн бичгийн барьцаанд энгийн хувьцаа, уул уурхайн тоног төхөөрөмж болон лицензийн хамт барьцаалсан байна.

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зарим нэг компаниуд нь хүү бууруулах нөхцөлийг хангасан байсан. Үүнтэй холбоотойгоор удирдлагын зүгээс хийсэн үнэлэмжийн талаар (Тодруулга 4).

Тодруулга 4-д дурдсанчлан, удирдлагын зүгээс хүү бууруулах тодорхой нөхцөл байдал хангах магадлалыг өндөр тухайлбал, өрийн бичиг авлагын гаргах үеийн (жишээ нь 100 хувьтай дөхөхүйц) гэж үнэлсэн бөгөөд бага хүүгээр төлөгдөнө гэж үзсэн.

Хадгаламжийн даатгалын корпорациас авах авлага ХДК-аас авах авлага нь 114,200 сая төгрөгийн зээл болон 85,000 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгээс бүрдэнэ. 114,200 сая төгрөгийн зээл нь 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр бүрэн төлөгдөх нөхцөлтэй бөгөөд 85,000 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг нь “Төрийн банк” ХХК-ийн хувьчлалын орлогоос 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдөр эргэн төлөгдөх нөхцөлтэй байсан.

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр “Төрийн банк” ХХК нь хувьчлагдаагүй бөгөөд санхүүгийн дэмжлэг нь төлөгдөөгүй байна. 2015 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар энэхүү санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдөх эсэх нь тодорхойгүйн улмаас Банк нийт дүнгээр нь буюу 85.0 тэрбум төгрөгөөр үнэ цэнийн бууралтын нөөц байгуулсан (Тодруулга 4).

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

15. БУСАД ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

ХДК-д олгосон 114,200 сая төгрөгийн зээл нь Монгол улсын банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор олгогдсон. Гэрээний холбогдох заалтын дагуу 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр эргэн төлөгдөнө. 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон өмнөх тайлант хугацааны байдлаар тус зээлийг холбоотой ямар ч үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байхгүй гэж үзсэн. Удирдлага 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тухайн авлагыг цуглуулахтай холбоотой тодорхой бус нөхцөл байдал маш их өндөр байна гэж дүгнэсэн. Үүний үр дүнд, удирдлагын зүгээс 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нь 114.200 сая төгрөгийн үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх шийдвэрийг 2016 оны тайлант жилд гаргасан (Тодруулга 4).

Татан буугдсан Анод банкнаас авах авлага 2015 онд Анод банкны эрх хүлээн авагчийн хугацаа дуусах үед 2015 болон 2016 онуудад эргэн төлөгдсөн 7,232 сая төгрөгөөс гадна 73,662 сая төгрөгийн дансны үнэтэй хөрөнгийг хүлээн авсан. Эдгээр хөрөнгүүдийн хувьд 66.430 төгрөг сая төгрөг (2015 онд 67.646 сая төгрөг) үнэ цэнийг бууралтыг санг 100 хувь байгуулсан, хөрөнгүүд бүхэлдээ Анод банкны харилцагчиддаа олгосон зээлийн багц болон бусад хөрөнгөөс бүрдэж байсан.

Аж ахуйн нэгжүүдээс авах авлагад Өрийн бичгийн авлагад, Банктай хийсэн алтны опшин хэлцлийнхээ үүргийг өмнөх жилд биелүүлээгүй алт олборлогч компаниудаас авах 35,659 сая төгрөг (2015 онд 37,525 сая төгрөг)-ийн авлага багтаж байгаа бөгөөд эдгээр авлагын дүнд найдваргүй байдлыг тооцон болзошгүй алдагдлын нөөцийн санг бүрэн байгуулсан. Түүнчлэн бусад аж ахуйн нэгжүүдээс авах авлагын хувьд 2015 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 17,715 сая төгрөг (2015 онд 15,080 сая төгрөг)-ийг найдваргүйд тооцсон байна. Нөөц сан байгуулсан гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалж үнийн дүнд холбогдох өөрчлөлт гарсан болно.

Гадаадын санхүүгийн байгууллагаас авах зарга Холбогдох гадаад институтүүд үйл ажиллагаагаа зогсоосон учир эргэн төлөгдөхгүй гэж үзэн бүтэн дүнгээр болзошгүй алдагдлын нөөцийн санг байгуулсан.

Бусад санхүүгийн бус хөрөнгө Бусад санхүүгийн бус хөрөнгүүд нь ихэвчлэн эргэн төлөлтүүд, ажилтнуудад олгосон урьдчилгаа, хангамжийн материал, бичиг хэргийн материал болон борлуулахад бэлэн хөрөнгүүдээс бүрдэнэ. 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар урьдчилсан төлбөрт зардлын дүн нь дийлэнх хэсгийг бүрдүүлж байна. Энэ нь 2016 оны тайлант үед төлбөр төлөгдсөн боловч 2017 онд хүргүүлэх төлөвтэй байгаа шинэ мөнгөн тэмдэгт захиалгатай холбоотой ажил гүйлгээний дүн болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

15. БУСАД ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Болзошгүй алдагдлын нөөцийн сан 2016 ба 2015 оны турш хийгдсэн бусад хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтын алдагдлын нөөцийн хөдөлгөөнийг дор харуулав:

Сая төгрөгөөр	Өрийн бичиг	ХДК-аас авах авлага	Анод банкнаас авах авлага	Бусад ААН-үүдээс авах авлага	Гадаадын санхүүгийн байгууллагаас авах зарга	Санхүүгийн бус хөрөнгө	Бусад	Нийт
2016 оны 01 дүгээр сарын 01-нээрх үнэ цэнийн бууралтын нөөц	**-**	**85,000**	**67,646**	**52,661**	**17,450**	**77**	**159**	**222,993**
Гадаад валютаарх болзошгүй алдагдлын нөөцийн сангийн хөрвүүлэлт	-	-	-	11,532	4,334	-	-	**15,866**
Тайлант хугацаанд байгуулсан болзошгүй алдагдлын нөөцийн сан	5,944	114,200	-	-	-	-	57	**120,201**
Цуглуулах боломжгүйгээс тайлант хугацаанд данснаас хассан	-	-	-	(10,799)	-	-	-	**(10,799)**
Тайлант хугацааны болзошгүй алдагдлын нөөцийн сангийн буцаалт	-	-	(1,216)	(20)	-	-	(6)	**(1,242)**
2016 оны 12 дугаар сарын 31-нээрх болзошгүй алдагдлын нөөцийн сан	**5,944**	**199,200**	**66,430**	**53,374**	**21,784**	**77**	**210**	**347,019**

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

15. БУСАД ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2015 оны санхүүгийн хөрөнгийн болзошгүй алдагдлын нөөцийн сангийн хөдөлгөөнийг дор харуулав:

Сая төгрөгөөр	Өрийн бичиг	ХДК-аас авах авлага	Анод банкнаас авах авлага	Бусад ААН-үүдээс авах авлага	Гадаадын санхүүгийн байгууллагаас авах зарга	Санхүү-гийн бус хөрөнгө	Бусад	Нийт
2015 оны 01 дүгээр сарын 01-нээрх үнэ цэнийн бууралтын нөөц	**-**	**85,000**	**-**	**50,141**	**16,485**	**77**	**320**	**152,023**
Гадаад валютаарх болзошгүй алдагдлын нөөцийн сангийн	-	-	-	2,585	965	-	4	**3,554**
Тайлант хугацаанд байгуулсан болзошгүй алдагдлын нөөцийн сан	-	-	-	57	-	-	-	**57**
Тайлант хугацаанд данснаас хассан	-	-	73,662	-	-	-	-	**73,662**
Тайлант хугацаанд эргэн төлөгдсөн	-	-	(6,016)	(122)	-	-	(165)	**(6,303)**
2015 оны 12 дугаар сарын 31-нээрх болзошгүй алдагдлын нөөцийн сан	**-**	**85,000**	**67,646**	**52,661**	**17,450**	**77**	**159**	**222,993**

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

16. ҮНДСЭН ХӨРӨНГӨ БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Сая төгрөгөөр	Барилга байгууламж	Дуусаагүй барилга	Тавилга, компьютер төхөөрөмж	Нийт биет хөрөнгө	Биет бус хөрөнгө	Нийт үндсэн хөрөнгө
2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар өртөг	47,338	38	8,361	**55,737**	2,267	**58,004**
Хуримтлагдсан элэгдэл/хорогдол	(25,113)	-	(3,788)	**(28,901)**	(1,713)	**(30,614)**
2015 оны 01 дүгээр сарын 01-нээрх дансны үнэ	**22,225**	**38**	**4,573**	**26,836**	**554**	**27,390**
Нэмэгдсэн	452	1,872	1,520	**3,844**	131	**3,975**
Хасагдсан-өртгөөр	(1,489)	-	(817)	**(2,306)**	(5)	**(2,311)**
Акталсан-өртгөөр	-	-	(69)	**(69)**	-	**(69)**
Шилжүүлсэн	(19)	(363)	382	**-**	-	**-**
Элэгдэл/хорогдол	(863)	-	(1,280)	**(2,143)**	(254)	**(2,397)**
Хасагдсан-хуримтлагдсан элэгдлээс	1,311	-	812	**2,123**	5	**2,128**
Акталсан- Хуримтлагдсан элэгдлээс	-	-	57	**57**	-	**57**
2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар өртөг эсвэл үнэлгээ	46,282	1,547	9,377	**57,206**	2,393	**59,599**
Хуримтлагдсан элэгдэл/хорогдол	(24,665)	-	(4,199)	**(28,864)**	(1,962)	**(30,826)**
2015 оны 12 дугаар сарын 31-нээрх дансны үнэ	**21,617**	**1,547**	**5,178**	**28,342**	**431**	**28,773**
Нэмэгдсэн	1,862	-	1,413	**3,275**	-	**3,275**
Хасагдсан-өртгөөр	(22)	(1,465)	(1,134)	**(2,621)**	(227)	**(2,848)**
Акталсан-өртгөөр	(577)	-	(26)	**(603)**	-	**(603)**
Шилжүүлсэн	(866)	-	(1,416)	**(2,282)**	(232)	**(2,514)**
Элэгдэл/хорогдол	22	-	1,123	**1,145**	227	**1,372**
Хасагдсан-хуримтлагдсан элэгдлээс Акталсан-Хуримтлагдсан элэгдлээс	559	-	20	**579**	-	**579**
2016 оны 12 дугаар сарын 31-нээрх өртөг	47,545	82	9,630	**57,257**	2,166	**59,423**
Хуримтлагдсан элэгдэл	(24,950)	-	(4,472)	**(29,422)**	(1,967)	**(31,389)**
2016 оны 12 дугаар сарын 31-нээрх дансны үнэ	**22,595**	**82**	**5,158**	**27,835**	**199**	**28,034**

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

16. ҮНДСЭН ХӨРӨНГӨ БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2013 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хараат бус үнэлгээчин болох “Хөрөнгийн үнэлгээний компаниудын консорциум” Банкны барилгын хамгийн сүүлийн үнэлгээг гүйцэтгэсэн.

Эдгээр барилгуудын бодит үнэ цэнэ нь 2015 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дансны үнэтэйгээ ойролцоо байсан гэж удирдлага үзэж байна.

Хэрэв дундаж үнэ одоогийн дансны үнийг тогтоохдоо авч үзсэн үнээс 20 хувиар илүү болсон тохиолдолд барилга байгууламж болон бусад нөөцөд багтадаг дахин үнэлгээний нөөцийн дансны үнэ 2016 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 4,519 сая төгрөг (2015 онд 4,323 сая төгрөг)-өөр өснө. Удирдлага Банкны дахин үнэлгээний нөөцийн бодит үнэ цэнэ 2016 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 4,519 сая төгрөг (2015 онд 4,323 сая төгрөг)-өөр буурна гэж үзсэн. Удирдлага Банкны барилга байгууламжийн үнэлгээ барилгын үнэ буурах (барилга, тоног төхөөрөмж, биет бус хөрөнгө болон өмч) нь одоогийн эдийн засгийн нөхцөл байдлын хувьд ерөнхийдөө буурах нь тун бага магадлалтай тул санхүүгийн тайлан хэрэглэгчдийн үүднээс авч үзвэл Санхүүгийн тайланд материаллаг хэмжээний нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

Эдгээр барилга байгууламжууд 2016 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар өртгийн зарчмын дагуу хүлээн зөвшөөрөгдсөн ба дансны үнэ нь 11,327 сая төгрөг (2015 онд 13,989 сая төгрөг) байсан.

2015 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр ямар нэг үндсэн болон биет бус хөрөнгө зээлийн барьцаанд байхгүй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

17. ГҮЙЛГЭЭНД ГАРГАСАН БЭЛЭН МӨНГӨ

Сая төгрөгөөр	**2016.12.31**	**2015.12.31**
Гүйлгээнд гаргасан цаасан тэмдэгт	834,024	804,072
Тоолж шалгаагүй цаасан тэмдэгт	(10,415)	(97,430)
Гүйлгээнд гаргасан зоосон тэмдэгт	20	14
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	**823,629**	**706,656**

2015 оны 12 дугаар сарын 31, 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө:

Сая төгрөгөөр	**Эхний үлдэгдэл**	**Нэмэгдсэн**	**Хасагдсан**	**Эцсийн үлдэгдэл**
Гүйлгээнд гаргасан цаасан тэмдэгт	804,072	2,140,575	(2,110,623)	834,024
Гүйлгээнд гаргасан зоосон тэмдэгт	14	6	-	20
Тоолж шалгаагүй цаасан тэмдэгт	(97,430)	(2,669,322)	2,756,337	(10,415)
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	**706,656**	**(528,741)**	**645,714**	**823,629**

18. ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААС

Сая төгрөгөөр	**2016.12.31**	**2015.12.31**
Төв банкны үнэт цаас	577,297	1,024,581
Нийт Төв банкны үнэт цаас	**577,297**	**1,024,581**

Энэхүү үлдэгдэл нь Банкнаас дотоодын банкуудад гаргасан үнэт цаасыг илэрхийлнэ. Эдгээр үнэт цаасны дуусах хугацаа нь 7-87 хоног (2015 онд 7-28 хоног) бөгөөд 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар жилийн 14-17 хувийн (2015 онд жилийн 13 хувь) хүүтэй байна. Банк нь Төв банкны үнэт цаасыг инфляцын түвшинг хянахын тулд илүүдэл мөнгийг эдийн засгийн эргэлтээс гаргах зорилгоор ашигладаг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

19. ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨРӨНГӨ

Сая төгрөгөөр	**2016.12.31**	**2015.12.31**
Сангийн яаманд төлөх зээлийн өр төлбөр:		
- Германы Засгийн газар (КФВ)	16,119	14,121
- Азийн Хөгжлийн Банк (АХБ)	9,334	8,084
- Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА)	8,541	6,678
Сангийн яамны харилцах, хадгаламж	974,330	673,573
Төрийн Байгууллагуудад төлөх Нийт Өр Төлбөр	**1,008,324**	**702,456**

Сангийн яамны дансууд. Эдгээр харилцах дансууд нь Банкинд байршуулсан Сангийн яамны харилцах данснууд юм. Эдгээр дансууд нь хугацаагүй бөгөөд хүү тооцдоггүй.

Олон улсын байгууллагуудаас авсан зээллэгтэй холбоотойгоор Сангийн яаманд төлөх өр төлбөр. Эдгээр нь Монгол Улсын Засгийн газраас "КФВ" (Герман улсын Засгийн газрыг төлөөлж), Азийн Хөгжлийн Банктай (АХБ) болон Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА)-тай байгуулсан зээлийн гэрээтэй холбоотой. Энэхүү зээлд Монгол Улсын Сангийн яам санхүүгийн төлөөлөгчөөр, Банк нь энэ төслийг хэрэгжүүлэгчээр ажиллаж байна.

КФВ газраас авсан зээл нь жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилготой 1995 он болон 2003 оны хөтөлбөрийн дагуу олгогдсон. Эдгээр зээлүүд нь еврогоор олгогдсон бөгөөд жилийн 0.75 хувийн хүүтэй, 30 жилийн хугацаатай. Зээлийн үндсэн төлөлт 2005 оноос эхэлсэн ба 2012 оноос эхлэн хоёр дахь хөтөлбөрийн үндсэн төлбөр төлөгдөж эхэлсэн.

АХБ-аас авсан зээл нь Монголд ядуурлыг бууруулах, хувийн бизнесийн салбарыг хөгжүүлэх, Засгийн газарт болон төрийн бус байгууллагууд, банкуудад зөвлөгөө өгөх, сургалт явуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор олгогджээ. Зээл нь жилийн 1 хувийн хүүтэй, 27-30 жилийн (2015 онд 27-30 жил) хугацаатай байна.

Сангийн яам нь Засгийн газрыг төлөөлөн хэрэгжүүлэгч агентын үүрэг гүйцэтгэдэг учир Банк КФВ болон АХБ-д төлбөр тооцоонд шууд хариуцлага хүлээхгүй. Гэхдээ эдгээр зээлийн төслүүдийг хэрэгжүүлэгчийн хувьд Банк нь зээлийн хөрөнгийг дотоодын банкуудад оновчтой хуваарилах үүрэгтэй бөгөөд тэдгээр дотоодын банкууд нь КФВ болон АХБ-ны шалгуурт тэнцсэн зээлийн эцсийн хэрэглэгчдэд хүргэх үйл ажиллагааг хариуцна.

Сангийн яам ба Банк хоорондын гэрээний дагуу Банк нь Сангийн яамнаас КФВ болон АХБ-ны гэрээний ижил нөхцөлтэйгээр эдгээр зээлүүдийг авсан байна. Банк нь эдгээр зээлийн хөрөнгийг өөрийн дансанд байршуулж буйн хувьд, КФВ ба Сангийн яамны хоорондын төлбөр тооцоог зохицуулах үүрэгтэй. Энэхүү зээлийн хөрөнгөөс дотоодын банкуудад олгогдсон зээлийн дэлгэрэнгүйг (Тодруулга 9)-с харна уу. Эдгээр өр төлбөрүүдтэй холбоотой удирдлагын үнэлэмжийг (Тодруулга 4)-с харна уу.

Олон улсын хөгжлийн ассоциацаас Сангийн яамны авсан зээл нь хувийн хэвшлийг дэмжих төсөл болон санхүүгийн чадавхыг дээшлүүлэх төслүүдэд зориулагдсан бөгөөд Сангийн яамнаас жилийн 1-3 хувийн хүүтэй, 2015 болон 2016 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар тусгай нөхцөлийн (ковенант) зөрчил байхгүй болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

20. ДОТООДЫН БАНКУУДЫН ХӨРӨНГӨ

Сая төгрөгөөр	**2016.12.31**	**2015.12.31**
Харилцах дансууд:		
- төгрөгөөр	943,882	1,225,029
- валютаар	1,304,359	533,326
Хугацаатай хадгаламж	423,325	60,630
Нийт дотоодын банкны хадгаламж	**2,671,566**	**1,818,985**

Холбогдох дансууд нь дотоодын банкуудаас Банкинд зайлшгүй байлгах нөөц болон бусад төрлийн хадгаламжуудаас бүрдэх бөгөөд тэдгээрийн хадгаламж эзэмшигчиддээ төлөх өр төлбөрийн тодорхой хувиар тооцогддог.

Гадаад валютын хугацаатай хадгаламж нь дотоодын банкуудаас жилийн 0.55-0.64 хувийн (2015 онд 6.532 хувь)-ийн хүүтэй, 7-60 өдрийн хугацаатай (2015 онд 371 өдөр) байршуулсан ам.долларын хадгаламж болно.

21 ГАДААД ӨР ТӨЛБӨР

Сая төгрөгөөр	**2016.12.31**	**2015.12.31**
ХАБ-тай байгуулсан хэлэлцээр	4,332,068	3,550,766
Токио Мицубиши банкны зээл (банктай байгуулсан алт худалдах, худалдан авах урьдчилгаа санхүүжилтийн гэрээ)	-	239,554
ЗТЭ-ийн хуваарилалт	162,609	135,180
Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө	156	125
ОУХА-д оруулсан хувь хөрөнгө	39	34
Дэлхийн банкны харилцах данс	460	110
АХБ-ны харилцах данс	4	8
Нийт Гадаадын байгууллагуудад төлөх өр төлбөр	**4,495,336**	**3,925,777**

Хятадын Ардын банктай байгуулсан своп хэлцэлцээр. Энэхүү данс нь Хятадын ардын банктай хийсэн своп хэлцлийн дагуу авсан 3 сараас 12 сарын хугацаатай юанийн санхүүжилт бөгөөд Банк дотоодын банкуудыг юаниар санхүүжүүлэхэд ашигладаг. Хүү нь Шанхай-Интер банкны санал болгосон хүүгийн түвшин дээр 200 Суурь нэгж нэмсэнтэй тэнцүү.

Сингапур дахь Токио Мицубиши банктай байгуулсан алт, худалдах, худалдан авах урьдчилгаа санхүүжилтийн гэрээ. Энэ гэрээний санхүүжилт 2014 онд авсан 1 жилийн хугацаатай ам.долларын зээл ба алт олборлогчдоос алт худалдан авахад зарцуулахад ашигласан. Энэ санхүүжилт 2016 онд бүрэн төлөгдсөн бөгөөд хүүгийн түвшин нь ЛИБОР+310 суурь нэгж байсан.

Зээлжих тусгай эрхийн хуваарилалт ОУВС-ын гишүүн орнуудад ОУВС-д оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн ЗТЭ хуваарилсан. Энэ хуваарилалт нь Банкны ОУВС-д өгөх өр төлбөрийг илэрхийлэх ба Тодруулга 8-д энэ талаар тодруулсан. Хуваарилалтын цэвэр хуримтлал нь 162,609 сая төгрөг буюу 48,757 сая ЗТЭ (2015 онд 135,180 сая төгрөг буюу 48,757 сая ЗТЭ)-тэй тэнцүү байна.

Дэлхийн банк ба Олон улсын хөгжлийн агентлагт оруулсан хувь хөрөнгө Энэ үлдэгдэл нь Банкнаас Дэлхийн банк болон Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА)-т оруулсан хувь хөрөнгө юм.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

22. БУСАД ӨР ТӨЛБӨР

Сая төгрөгөөр	**2016.12.31**	**2015.12.31**
Бусад санхүүгийн өр төлбөр		
Дотоодын банкуудын дүрмийн сангийн төвлөрүүлсэн хөрөнгө	19,346	4,015
Банк бус санхүүгийн байгууллагаас байршуулсан хөрөнгө	10,827	7,370
Бусад өглөг	12,461	10,314
Бусад өр төлбөр		
Нийгмийн хөгжлийн сан	5,958	8,595
Аккредитивийн заргатай холбоотой байгуулсан сан	58,161	48,351
Нийт бусад өр төлбөр	**106,753**	**78,645**

Дотоодын банкуудын дүрмийн санд анх төвлөрүүлсэн хөрөнгө. Монгол Улсын дотоодын банкуудын дүрмийн санг нэмэгдүүлэх зорилгоор тусгай зориулалтын дансанд анх төвлөрүүлсэн хөрөнгө юм. Эдгээр дансуудыг тухайн дотоодын банкууд хөрөнгө оруулалт хийхээс өөр зорилгоор ашиглахыг хязгаарласан.

Банк бус санхүүгийн байгууллагаас байршуулсан хадгаламж. Банк бус санхүүгийн байгууллагаас байршуулсан хадгаламж нь Үнэт цаасны төлбөр тооцооны төв, Хадгаламжийн даатгалын корпорацийн харилцах дансуудаас бүрдэнэ.

Нийгмийн хөгжлийн сан. Банк дотоод журмынхаа дагуу тодорхой хэмжээний хөрөнгийг өөрсдийн ажилтнуудын ажлын болон амьжиргааны нөхцөлийг сайжруулах зорилгоор Нийгмийн хөгжлийн санд хуваарилдаг. Энэхүү хөрөнгө Банкны ажилтанд тэтгэмж, тусламж олгох, ажлын үзүүлэлтээр урамшуулах, ажилтны нийгмийн байдлыг хангах үүднээс орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай үед

нь санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд зориулагдсан байна. Банкны удирдлага санхүүгийн жилийн эцсээр Нийгмийн хөгжлийн санд хуваарилсан хөрөнгийг хүлээгдэж буй үүргээ биелүүлэхэд хангалттай гэж үзсэн.

Аккредитивийн заргатай холбоотой байгуулсан нөөц сан. Энэ сан нь 2008 онд Швейцари болон Герман улсын шүүхэд эдгээр орнуудад үйл ажиллагаа явуулж байсан 2 санхүүгийн байгууллагын аккредивийн хугацаа нь хэтэрсэн төлбөрөөс үүдэлтэй хуулийн заргын хариуцагчаар татагдсантай холбоотой үүсгэсэн болзошгүй алдагдлын нөөцийн сан юм. Банк аккредитивийн гэрээгээр хүлээсэн үүргийг авч үзсэн ба нэхэмжлэлийн алдагдал үүсэх магадлалаас шалтгаалан 2009 онд бүрэн дүнгээр эрсдэлийн сан байгуулсан. Эдгээр сангуудад 2016 болон 2014 онуудад гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөөнөөс бусад зүйлд хөдөлгөөн гараагүй болно.

Эдгээр аккредитивтэй холбогдуулан Банк нь тодорхой хувь хүн болон байгууллагуудыг залилан, гэрээний зөрчил (санхүүгийн тайланг луйврын аргаар буруу толилуулах, хариуцлага алдаж буруу толилуулах, гэрээний зөрчил, нөхөн төлбөр, шударга бусаар эд хөрөнгө олж авах) гэх мэт хууль зөрчсөн үндэслэлээр АНУ-ын өмнөд Флоридагийн дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Эдгээр хувь хүн болон байгууллагуудаас нэхэмжилж буй дүн нь Банкны дээр дурдсан заргын үнийн дүнгээс давж байгаа болно. Хэрэг Банкны талд шийдэгдэх хандлагатай байгаа хэдий ч хариуцагчид авлагыг бүрэн хэмжээгээр барагдуулна гэсэн хангалттай баталгаа байхгүй байна. Тиймээс Банк санхүүгийн тайланд энэхүү авлагыг хүлээн зөвшөөрөөгүй боловч нэхэмжилсэн төлбөрөө барагдуулахаар тууштай ажиллаж байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

23. ДҮРМИЙН САН БОЛОН БУСАД НӨӨЦ САНГУУД

Сая төгрөгөөр	2012.12.31	2011.12.31
Дүрмийн Сан	5,000	5,000

Банк нь 100 хувь Төрийн өмчлөлд байдаг. Дүрмийн сан нь Банкны өөрийн хөрөнгийг илэрхийлнэ.

Борлуулахад бэлэн нөөц. Энэхүү нөөц нь борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтуудын бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс бүрдэнэ.

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц. Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар Банкны барилгын дахин үнэлгээнээс үүссэн илүүдлийг өөрийн хөрөнгийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний санд тайлагнана. Дэлгэрэнгүйг (Тодруулга 16)-аас харна уу.

Гадаад валютын дахин үнэлгээний сан. Энэхүү сан нь гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн ханшийн тэгшитгэлээс үүссэн бодит бус ашгийг бүртгэж, ирээдүйн ханшийн эрсдэлээс хамгаалах зориулалтаар ашиглагддаг.

Мөнгөжсөн алт, үнэт метал дахин үнэлгээний сан. Энэхүү сан нь мөнгөжсөн алт, үнэт металын ханшийн тэгшитгэлээс үүссэн бодит бус ашгийг бүртгэж, ирээдүйн ханшийн эрсдэлээс хамгаалах зориулалтаар ашиглагддаг.

Бусад нөөцийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

Сая төгрөгөөр	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний сан	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний сан	Үнэт металлын дахин үнэлгээний сан	Нийт
2015 оны 01 дүгээр сарын 01-нээр	(220)	12,049	6,186	18,015
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын бодит дахин үнэлгээний алдагдал	3,211	-	-	3,211
Борлуулах үед ашиг алдагдал руу шилжүүлсэн	(65)	-	-	(65)
Хуримтлагдсан алдагдал руу шилжүүлсэн		(141)	(4,242)	(4,383)
2015 оны 12 дугаар сарын 31-нээр	**2,926**	**11,908**	**1,944**	**16,778**
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний алдагдал	519	-	-	519
Борлуулах үед ашиг алдагдал руу шилжүүлсэн	(78)	-	-	(78)
Хуримтлагдсан алдагдал руу шилжүүлсэн	-	(13)	(804)	(817)
2016 оны 12 дугаар сарын 31-нээр	**3,367**	**11,895**	**1,140**	**16,402**

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

24. ХҮҮГИЙН ОРЛОГО БА ЗАРДАЛ

Сая төгрөгөөр	2016	2015
Хүүгийн орлого		
Дотоодын үнэт цаас	87,104	35,907
Санхүүгийн хөрөнгө оруулалт – борлуулахад бэлэн	44,698	60,015
Дотоодын банкуудад олгосон зээл	34,300	78,491
Засгийн газрын үнэт цаас	33,563	26,420
Буцаан худалдан авах гэрээ	25,279	658
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	3,613	2,289
Нийт хүүгийн орлого	**228,557**	**203,780**
Хүүгийн зардал		
Гадаадын банкнаас авсан зээл	(189,030)	(207,042)
Төв банкны үнэт цаас	(92,976)	(74,197)
Дотоодын банкуудын заавал байлгах нөөцийн биелэлтэд олгосон урамшуулал	(55,864)	(44,912)
Засгийн газрын байгууллагуудын хадгаламж	(8,797)	(2,618)
Дотоодын банкуудын хадгаламж	(3,575)	(4,210)
Бусад хүүгийн зардал	(5,608)	(15,034)
Нийт хүүгийн зардал	**(355,850)**	**(348,013)**
Цэвэр хүүгийн зардал	**(127,293)**	**(144,233)**

25. АЛТ БА ҮНЭТ МЕТАЛЫН АРИЛЖААНЫ АШИГ

Сая төгрөгөөр	2016	2015
Мөнгөжсөн алт, үнэт металын арилжааны алдагдал	(113)	(2,080)
Мөнгөжсөн алт, үнэт металын ханшийн тэгшитгэлийн бодит ашиг	36,618	6,395
Алт ба үнэт металын арилжааны бусад ашиг, алдагдал	64,106	(1,214)
Алт ба үнэт металлын арилжааны ашиг	**100,611**	**3,101**

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

26. АЛТ, ҮНЭТ МЕТАЛЫН ХАНШИЙН ТЭГШТГЭЛИЙН АЛДАГДАЛ

Алт, үнэт металын ханшийн тэгшитгэлийн бодит бус ашиг, алдагдлыг илэрхийлэх ба тайлант жилд 804 сая (2015 онд 4,242 сая төгрөг) төгрөгийн алдагдалтай байв.

27. САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЛИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ АШИГ, АЛДАГДАЛ

Сая төгрөгөөр	**2016**	**2015**
Своп хэлцлийн дахин үнэлгээний бодит бус ашиг, алдагдал	(494,978)	(442,469)
Тайлант болон өмнөх үеийн своп хэлцлийн дахин үнэлгээний бодит бус ашиг, алдагдал	(169,003)	247,113
Санхүүгийн хэрэгслийн цэвэр алдагдал	**(663,981)**	**(195,356)**

Тайлант жилд своп хэлцлийн эхний өдрийн бодит алдагдал 494,978 сая төгрөг (2015 онд 442,469 сая төгрөг) байна.

28. ГАДААД ВАЛЮТЫН ХӨРВҮҮЛГИЙН АШИГ, АЛДАГДАЛ

Сая төгрөгөөр	**2016**	**2015**
Гадаад валютын хөрвүүлгийн бодит ашиг	167,996	91,093
Гадаад валютын хөрвүүлгийн бодит бус алдагдал	(597,759)	(58,703)
Гадаад валютын хөрвүүлгийн (алдагдал) / ашиг	**(429,763)**	**32,390**

29. БОЛЗОШГҮЙ АЛДАГДЛЫН НӨӨЦИЙН САНГИЙН (ЗАРДАЛ)/БУЦААЛТ

Сая төгрөгөөр	**Тодруулга**	**2016**	**2015**
Дотоодын банкуудад олгосон зээл	9	(144)	150
Бусад хөрөнгүүд	15	(118,959)	6,246
Үнэ цэнийн бууралт (нөөц)/буцаалт		**(119,103)**	**6,396**

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

30. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО

Сая төгрөгөөр	**2016**	**2015**
"Ирээдүйн тэтгэврийн нөөц сан"-гийн орлого	62,760	-
Хураамж ба шимтгэлийн орлого	4,927	3,677
Дотоодын банкуудаас авсан торгуулийн орлого	3,384	1,944
Үндсэн хөрөнгийн түрээсийн орлого	534	548
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	51	37
Дундын хөрөнгөөс олсон орлого	-	875
Бусад үйл ажиллагааны орлого	664	411
Нийт бусад үйл ажиллагааны орлого	**72,320**	**7,492**

Ирээдүйд авах тэтгэврийн сан болон ирээдүйд хийх хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Улсын Их Хурлын 12 дугаар тогтоолоор "Ирээдүйн тэтгэврийн сан"-ийн хууль батлагдсан. Хуулийн 3.2 заалтын дагуу Сангийн гол хөрөнгө нь МИК-ийн ИЗББ бонд (Тодруулга 10) үндсэн төлбөр, хүүгийн орлого, арилжааны банкуудад олгогдсон орон сууцны зээлийн үндсэн дүн болон хүүгийн орлогоос бүрдэнэ. Иймд, тус хуулийн дагуу Монголбанк нь 2016 оны 3 сарын 11-ний өдөр 2,460,771 сая төгрөгийн хөрөнгийг Засгийн газарт шилжүүлсэн болно Гэвч Санг татан буугдаж, УИХ-ын 2016 оны 9 дүгээр сарын 9-нд батлагдсан 40-р тогтоолын дагуу ба өмнө нь тухайн санд шилжүүлсэн хөрөнгө болох 2,523,531 сая төгрөгийг Монголбанкид 2016 оны 10 дугаар сарын 17-нд буцаан шилжүүлсэн. Банк руу шилжсэн нийт хөрөнгө болох 2,523,531 сая төгрөг болж өссөн нь шинээр байгуулсан 8 ба 9 дэхь тусгай зориулалтын компани(МИК-ийн бонд)-тай холбоотой. Энэ үед олсон хүүгийн орлого "Ирээдүйн тэтгэврийн сан"-гийн орлогоор хүлээн зөвшөөрөгдсөн.

Банк нь өөрийн тавьсан шаардлагын дагуу арилжааны банкуудаас заавал байлгах нөөцийг авч байршуулдаг. Заавал байлгах нөөцийн хэмжээг 14 хоногоор тооцдог (Тодруулга 20). 2016 оны 12 дугаар сарын 31-нээрх дотоодын банкуудын байршуулсан заавал байлгах нөөцөөс олсон хүүгийн орлогын дүн 3,385 сая төгрөг (2015 онд 1,944 сая төгрөг) байсан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

31. ЗАХИРГААНЫ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ЗАРДАЛ

Сая төгрөгөөр	2016	2015
Цалингийн зардал	11,095	9,489
Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн элэгдэл/хорогдол	2,514	2,397
Харилцаа холбоо, ашиглалтын зардал	1,649	1,526
Хуулийн болон мэргэжлийн үйлчилгээний хөлс	1,643	1,133
Харуул хамгаалалтын зардал	1,301	1,177
Тээврийн болон албан томилолтын зардал	863	588
Зар сурталчилгааны зардал	813	843
Сургалтын зардал	498	510
Гишүүнчлэл болон мэргэжлийн үйлчилгээний зардал	414	374
Нийгмийн хөгжлийн сангийн зардал	-	2,000
Мөнгөн тэмдэгт хэвлүүлэх зардал	5,078	811
Алтны санхүүжилттэй холбоотой зардал	4,296	6,891
Алт тээвэрлэх хүргүүлэх зардал	1,944	1,054
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	25	12
Бусад зардал	1,782	2,551
Нийт захиргааны болон үйл ажиллагааны бусад зардал	**33,915**	**31,356**

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

32. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Шийдэгдээгүй хэрэг. Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад Банкны эсрэг зарга мэдүүлэх явдал гарах боломжтой. Щвейцар болон Герман улсуудад үйл ажиллагаа явуулдаг хоёр санхүүгийн байгууллагатай хийсэн аккредитивийн гэрээтэй холбоотой шүүхийн маргаанд 2008 оноос хойш Банк хариуцагчаар татагдан, шүүх үйл ажиллагаа үргэлжилж байгаа. Эдгээр хэргүүд дээр шүүхэд аккредитивийн гэрээний дагуу өөрийн хүлээсэн үүргийн хүрээнд байр сууриа баттай хамгаалж байгаа. Үүнтэй холбогдуулан Банк 2009 онд нийт дүнгээр (хүүг оруулан) нь болзошгүй алдагдлын нөөцийн сан байгуулсан. (Тодруулга 22)-с харна уу.

Эдгээр аккредитивтэй холбогдуулан Банк нь тодорхой хувь хүн болон байгууллагуудыг залилан, гэрээний зөрчил (санхүүгийн тайланг луйврын аргаар буруу толилуулах, хариуцлага алдаж буруу толилуулах, гэрээний зөрчил, нөхөн төлбөр, шударга бусаар эд хөрөнгө олж авах) гэх мэт хууль зөрчсөн үндэслэлээр АНУ-ын өмнөд Флоридагийн дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Эдгээр хувь хүн болон байгууллагуудаас нэхэмжилж буй дүн нь Банкны дээр дурдсан заргын үнийн дүнгээс давж байгаа болно. Хэрэг Банкны хувьд нааштай шийдэгдэх хандлагатай байгаа хэдий ч хариуцагчид авлагыг бүрэн хэмжээгээр барагдуулна гэсэн хангалттай баталгаа байхгүй байна Тиймээс Банк санхүүгийн тайланд энэхүү авлагыг хүлээн зөвшөөрөөгүй боловч нэхэмжилсэн төлбөрөө барагдуулахаар тууштай ажиллаж байна.

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дээрх заргуудаас өөр ямар нэгэн материаллаг гарз учруулах нэхэмжлэгчээр дуудагдсан шүүн таслах хуулийн хэргийн талаар удирдлагад мэдээлэл байхгүй байна. Иймд дээрх аккредитивтэй холбоотой болзошгүй алдагдлын сангаас өөр ямар нэг санг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж үзсэн.

Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг. Банк нь Монгол Улсын Засгийн газар эсвэл тэдгээрийн харьяа байгууллагуудын хүсэлтээр Монгол улсын хувьд чухал ач холбогдол бүхий салбарт (бараа үйлчилгээ экспортлох гэх мэт) зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг хүлээдэг. Эдгээр хэрэгслүүдийн гол зорилго нь Засгийн газар болон холбогдох талуудыг шаардлагатай эх үүсвэрээр хангахад оршино.

Гаргасан аккредитивүүд нь зээл болон аккредитивын хэмжээнээс ашиглагдаагүй үлдсэн хэсгийг илэрхийлнэ, доорх мэдээлэлд анхаарал хандуулна уу. Банк ийм зээлтэй холбоотой төлбөрийн үүргийн хувьд уг зээлээс ашиглагдаагүй үлдсэн хэмжээгээр алдагдал хүлээх эрсдэлтэй юм. Гэвч ихэнх зээл нь зээлийн эрсдэл багатай харилцагчдад олгогддог тул энэхүү болзошгүй алдагдлын хэмжээ нь нийт ашиглагдаагүй байгаа төлбөрийн үүргийн хэмжээнээс бага байна. Зээлтэй холбоотой төлбөрийн хариуцлагын хэмжээг дор харуулав:

Сая төгрөгөөр	**2016.12.31**	**2015.12.31**
Болзошгүй өр төлбөр		
Импортын аккредитивүүд	(281,016)	(411,390)
Төлбөрийн үүрэг хариуцлага		
Хятадын ардын банкинд өгөх ашиглаагүй зээлийн шугамын эх үүсвэр	(4,500,000)	(4,500,000)
Нийт зээлтэй холбоотой үүрэг хариуцлага	**(4,781,016)**	**(4,911,659)**

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

32. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Импортын аккредитивүүд Импортын аккредитив нь Монгол Улсын Засгийн газарт импортын гэрээ хэлцэлтэй холбоотойгоор олгогдоно. Импортын аккредитивээр Банк Монгол Улсын Засгийн газрын эсвэл төрийн байгууллагуудын өмнөөс тэдгээрт болон Засгийн газрын хүсэлтээр бусад байгууллагуудад үйлчилгээ үзүүлсэн ба бараа бүтээгдэхүүн нийлүүлсэн гадаадын хуулийн этгээдүүдэд төлбөр шилжүүлэх үүрэг хүлээнэ.

Банкны удирдлага аккредитив, зээлийн шугамын үүрэг хариуцлагын бодит үнэ цэнийг материаллаг бус хэмээн дүгнэсэн. Ашиглагдаагүй байгаа зээлийн шугам болон аккредитивийн нийт гэрээт үлдэгдэл нь ирээдүйн бэлэн мөнгөний шаардлагыг заавал бий болгохгүй. Учир нь эдгээр санхүүгийн хэрэгслүүд нь ямар нэгэн санхүүжилтгүйгээр хугацаа нь дуусах буюу цуцлагдах боломжтой.

Хятадын Ардын банктай байгуулсан своп хэлэлцээр. Банк нь 2011 оны 5 дугаар сард Хятадын Ардын банктай “Хятадын юань/Монгол төгрөг солилцох своп хэлэлцээр”-ийн гэрээ байгуулсан ба гэрээг 2014 оны 8 дугаар сард шинэчлэн баталсан. Төв банкууд уг мөнгийг хоёр улсын хоорондох худалдааг санхүүжүүлэх, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор богино хугацаанд хөрвөх чадварыг хангах болон гэрээгээр тохирсон бусад зорилгоор ашиглах боломжтой.

Гэрээний дагуу Хятадын Ардын банк болон Банк нь хятадын юаниар төгрөг, монгол төгрөгөөр юань худалдан авах, худалдах хэлцлийг цаашид тодорхой хугацаанд хийх боломжтой.

Гэрээнд зааснаар энэхүү хөрөнгийн ашиглах хугацаа 12 сар хүртэл байна. Хөрөнгө ашиглах зөвшөөрлийг нэг тал нь нөгөө талаас авах ёстой ба тухайн ашиглах хөрөнгийн дээд хэмжээ нь Банкны хувьд гэрээний дүн болох 15,000 сая юань, Хятадын Ардын банкны хувьд 4.5 их наяд төгрөгөөр хязгаарлагдана.

Хөрөнгийг ашиглах банк хөрөнгийн хэмжээндээ гэрээнд заагдсан хүүг тооцон төлөх үүрэгтэй. Банк юань ашигласан тохиолдолд, хүүгийн түвшин нь Шанхай-Интер банкны санал болгосон түвшин (“ШИБОР”) дээр 200 үндсэн оноо нэмсэнтэй тэнцэх ба ашиглах хугацааны турш тооцно. Харин Хятадын Ардын банк төгрөг ашигласан тохиолдолд, харгалзах ашиглалтын хугацаанд хүүгийн түвшин нь банк хоорондын төгрөгийн жигнэсэн дундаж хүүгийн түвшинтэй тэнцүү байна.

2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банк 4.5 тэрбум юанийн хүсэлт гаргасан ба 4 тэрбум юанийг эргүүлэн төлсөн. Банкны зээлтэй холбоотой үүрэг хариуцлага нь ашиглагдсан дүн болох 12 тэрбум юань (4,295,520 сая төгрөг) ба ашиглагдаагүй дүн болох 3 тэрбум юань буюу 1,073,880 сая төгрөг байгаа нь Банкны хувьд цаашид хүлээн авч болох санхүүжилтийн үүргийг илэрхийлнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

33. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Банкны хувьцаа эзэмшигчид, Ерөнхийлөгч нар, Захирлуудын зөвлөлийн гишүүд, тэдгээрийн гэр бүлийн гишүүд ба бусад нэг хяналтын дор байдаг эсвэл нэг тал нөгөө талыг хянах эрхтэй буюу нөгөө талд санхүүгийн ба үйл ажиллагааны шийдвэр гаргахад нь мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг талуудыг ерөнхийдөө холбоотой талууд гэж үздэг.

Банк 2016 оны 4 дүгээр улирлын байдлаар дараах холбоотой талуудтай хийсэн гүйлгээ болон данснуудын үлдэгдлийг тодруулгад тусгасан. Үүнд: Засгийн газар (Сангийн яам зэрэг удирдлагыг нь Улсын Их Хурал болон Засгийн газраас томилдог байгууллагуудыг оролцуулна), Хөгжлийн банк, Сангийн яам ба ХДК хамаарна. ХДК нь бүрэн төрийн өмчит бөгөөд үйл ажиллагааных нь бүх шийдвэр Банкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн тэргүүлдэг Үндэсний Хорооны долоон гишүүний саналаар батлагдах ёстой.

Банк НББОУС 24-т орсон өөрчлөлт болох “Төрийн байгууллагуудын тодруулгад тавигдах шаардлагыг хэсэгчлэн чөлөөлөх“ заалтыг ашигласан. Иймд төрийн байгууллагуудтай хийсэн материаллаг бус гүйлгээнүүдийг тус санхүүгийн тайланд тусгаагүй болно.

2016 онд холбоотой талуудтай хийсэн орлого зарлагын гүйлгээнүүд дараах байдалтай байна:

Сая төгрөгөөр	**Засгийн газар**	**Төрийн банк**	**Хөгжлийн банк**	**ХДК**	**Нийт**
Хүүгийн орлого	33,563	2,139	6,866	611	**43,179**
Хүүгийн зардал	(8,797)	(17,879)	(18)	-	**(26,694)**
Хураамж шимтгэлийн орлого	418	171	3	-	**592**
Нийт	**25,184**	**(15,569)**	**6,851**	**611**	**17,077**

2016 оны 12 дугаар сарын 31-нээрх холбоотой талуудтай хийсэн гүйлгээнүүдийн дансны үлдэгдэл доорх байдалтай байна:

Сая төгрөгөөр	**Засгийн газар**	**Төрийн банк**	**Хөгжлийн банк**	**ХДК**	**Нийт**
Засгийн газрын үнэт цаас	326,508	-	-	-	**326,508**
Хөгжлийн банкны үнэт цаас			36,087	-	**36,087**
Дотоодын банкуудад олгосон зээл	-	113,301	-	-	**113,301**
Төв банкны үнэт цаас	-	(53,932)	-	-	**(53,932)**
Дотоодын банкуудын хөрөнгө	-	(220,708)	(5,322)	-	**(226,030)**
Санхүүгийн бус байгууллагуудын хөрөнгө	-	-	-	(2,931)	**(2,931)**
Засгийн газрын хөрөнгө	(1,008,324)	-	-	-	**(1,008,324)**
Нийт	**(681,816)**	**(161,339)**	**30,765**	**(2,931)**	**(815,321)**

2015 онд холбоотой талуудтай хийсэн орлого зарлагын гүйлгээнүүд дараах байдалтай байна. Үүнд:

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

33. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Сая төгрөгөөр	Засгийн газар	Төрийн банк	Хөгжлийн банк	ХДК	Нийт
Хүүгийн орлого	26,420	4,692	1,407	600	**33,119**
Хүүгийн зардал	(2,618)	(19,570)	(2)	-	**(22,190)**
Хураамж шимтгэлийн орлого	235	523	1,944	-	**2,702**
Нийт	**24,037**	**(14,355)**	**3,349**	**600**	**13,631**

2015 оны 12 дугаар сарын 31-нээрх холбоотой талуудтай хийсэн гүйлгээнүүдийн дансны үлдэгдэл доорх байдалтай байна:

Сая төгрөгөөр	Засгийн газар	Төрийн банк	Хөгжлийн банк	ХДК	Нийт
Засгийн газрын үнэт цаас	202,218	-	-	-	**202,218**
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт	-	-	105,945	-	**105,945**
Дотоодын банкуудад олгосон зээл	-	54,972	-	-	**54,972**
Санхүүгийн бус байгууллагуудад олгосон зээл	-	-	-	119,911	**119,911**
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	-	22	-	-	**22**
Бусад хөрөнгө	4,500	20	-	-	**4,520**
Төв банкны үнэт цаас	-	(9,972)	-	-	**(9,972)**
Банкуудын хөрөнгө	-	(246,178)	(3,048)	-	**(249,226)**
Санхүүгийн бус байгууллагуудын хөрөнгө	-	-	-	-	**-**
Засгийн газрын хөрөнгө	(702,456)	-	-	-	**(702,456)**
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл		(382)	-	-	**(382)**
Бусад өглөг		(62)	-	(1,972)	**(2,034)**
Нийт	**(495,738)**	**(201,580)**	**102,897**	**117,939**	**(476,482)**

Бизнесийн ердийн үйл ажиллагааны үр дүнд дээр дурдсан үлдэгдэл дүнгүүд үүссэн болно. Холбоотой талуудын төлсөн болон хүлээн авсан хүү нь ердийн арилжааны хүүгээр тооцогдсон. Холбоотой талд олгосон зээлээс бусад тайлант жилийн эцсээрх үлдэгдэл дүнгүүд барьцаагаар хангагдаагүй болно. Холбоотой талуудын өглөг эсвэл авлагад зориулж ямар нэгэн хүлээн авсан эсвэл гаргасан баталгаа байхгүй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

33. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банкны үндсэн удирдлагын цалин болон бусад тэтгэмжийн талаарх мэдээллийг дор толилуулав.

Сая төгрөгөөр	**2016**	**2015**
Цалин хөлс	656	570
Тэтгэмжүүд	136	117
Нийгмийн болон тэтгэврийн санд төлсөн шимтгэл	87	76
Бусад олговор	113	77
Нийт дүн	**992**	**840**

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Банкны үйл ажиллагаа нь ямагт эрсдэлтэй байдаг ба эдгээрийг зөв тодорхойлж хэмжиж хянаж байснаар эрсдэлийг хязгаарлаж, дотоод хяналтын бодлогоор удирддаг. Эрсдэлийг зохистой удирдах нь банкуудын үйл ажиллагааг хэвийн явуулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, тухайлбал, инфляцыг зохистой түвшинд барих мөнгөний зөв бодлого явуулахад чухал ач холбогдолтой. Эрсдэлүүд нь банкны гол зорилгодоо хүрэх чадварыг хязгаарлах үр дагавартай байж болно. Ийм өндөр үр дагавартай эрсдэл Банкинд илүүтэй илрэх бөгөөд гадаад валютын хөрвүүлгээс хүлээх санхүүгийн гэнэтийн алдагдал нь үүний нэг жишээ болно. Санхүүгийн алдагдал нь бүхий л төрлийн санхүүгийн эрсдэлээс хамааралтай үүсдэг.

Үүнээс гадна Банк нь зээлийн, хөрвөх чадварын, зах зээлийн, үйл ажиллагааны, нэр хүндийн, зэрэг эрсдэлд өртөж болно. Одоогийн банкны эрсдэлийн удирдлага нь төвлөрсөн бус ба газар, хэлтэс тус бүр тэдгээрийн үйл ажиллагаанд учирсан аливаа эрсдэлээс сэргийлэх бодлогыг баримталдаг. Банк нь Монгол улсын Төв банк учраас түүний эрсдэлүүд онцгой байдаг ба тэдгээр эрсдэлүүдийг Банк стратеги төлөвлөлтийн үйл явцаар дамжуулан хянаж, илрүүлж байдаг. Үүнээс гадна Банк нь эрсдэлийн хяналтын стратегийг боловсруулах ба зарчим, хүрээ, бодлого хязгааруудыг хэрэгжүүлэх ажлыг ерөнхийлөн хариуцах “Эрсдэлийн хороо”-г байгуулах боломжийг идэвхтэй судалж байна. Одоогоор Хөрөнгө оруулалтын хороо нь эрсдэлийн стратегийг боловсруулж, шаардлагатай хязгаарыг тогтоох үүрэгтэй байхад Эрсдэлийн удирдлагын алба болон зах зээлийн газар нь үүнтэй холбоотой зарчмууд, үйлчлэх хүрээ, бодлого, хязгаарыг хэрэгжүүлдэг.

Эрсдэлийн Удирдлагын бүтэц. Захирлуудын зөвлөл нь эрсдэлийг хянах ба энэ асуудлаар эцсийн хариуцлагыг хүлээнэ. Гэхдээ эрсдэлийг тодорхойлох, удирдах, хянах үүрэг бүхий бие даасан нэгжүүд байдаг.

Захирлуудын Зөвлөл. Захирлуудын Зөвлөл ерөнхий эрсдэлийн удирдлага болон эрсдэлийн стратеги, бодлогыг батлахаас гадна эрсдэлтэй холбоотой асуудлаар Банкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгчид зөвлөмж өгдөг.

Хяналтын Зөвлөл. Хяналтын зөвлөл нь Банкны дотоод бүтэц, зохион байгуулалтад харьяалагддаггүй бөгөөд бие даасан хяналт тавьж, Банк доторх ерөнхий эрсдэлийн үйл явцыг нь хянах үүрэгтэй.

Хөрөнгө оруулалтын хороо. Хөрөнгө оруулалтын хороо нь Банкны санхүүгийн эрсдэлийг удирдах үүрэгтэй хамгийн үндсэн нэгж бөгөөд Захирлуудын Зөвлөл болон Ерөнхийлөгчид санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлогын талаар зөвлөмж өгдөг. Хөрөнгө оруулалтын хорооны бүрэлдэхүүнд Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, зах зээлийн газрын захирал, Төлбөр тооцоо бүртгэлийн газрын захирал, Эрсдэлийн удирдлагын албаны захирал нар багтдаг.

Хөрөнгө оруулалтын хороо нь тайлант оны “Жилийн хөрөнгө оруулалтын бодлого”-ыг хэлэлцэж, зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшинг тодорхойлдог. Энэхүү зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшинд үндэслэн улсын гадаад валютын нөөцийн бүтцийг гарган Ерөнхийлөгчид танилцуулж, батлуулдаг байна. Үүнд гадаад валютын нөөцийн бүтэц, түүний зохистой хэлбэлзэл, хөрөнгийн хуваарилалт, хөрөнгө оруулалтын хугацаа, боломжит хэрэгсэл, харилцагч байгууллагад тавьсан хязгаарлалт зэргийг тусгасан байдаг. Мөн Ерөнхийлөгч гадаад валютын нөөцтэй холбоотой харилцагч банк санхүүгийн байгууллагуудын жагсаалт, тэдгээрт тавих лимитийг улирал тутамд батлах ба энэ нь гадаад валют, зээл, хөрвөх чадвар, хүүгийн түвшний эрсдэлийг удирдах гол арга хэрэгсэл болдог юм.

Захирлуудын зөвлөл “Жилийн хөрөнгө оруулалтын бодлого”-ыг хэлэлцэж холбогдох санал гаргадаг Захирлуудын зөвлөлөөс оруулсан санал нь гадаад валютын нөөцийн бүрэлдэхүүн хэсгүүд, хүлээн зөвшөөрөхүйц хэлбэлзэл, хөрөнгийн хуваарилалт болон хүлээн зөвшөөрөх түвшин, хөрөнгө оруулалтын

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

үргэлжлэх хугацаа, тохирох арга хэрэгслүүд, харилцагч талууд болон тэдгээрийн хязгаарлалтуудыг тусгасан байдаг.

Банкны санхүүгийн эрсдэлүүдэс гадаад валютын нөөцийн эрсдэл нь хамгийн чухал байдаг. Тиймээс Хөрөнгө оруулалтын хороо болон холбогдох газруудын үйл ажиллагаа нь гадаад валютын улсын нөөцтэй холбоотой эрсдэлийг удирдахад түлхүү чиглэгдсэн байна. Хөрөнгө оруулалтын хорооны өөр нэгэн үүрэг бол Эрсдэлийн удирдлагын алба, бусад холбогдох газруудад хяналт тавих,санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн санхүүгийн эрсдэлийн бодлогын хэрэгжилт нийцтэй байгаа эсэх хянах үүрэгтэй байдаг. Санхүүгийн эрсдэлийн удирдах зорилгоор ашигласан аргуудыг доор толилуулав.

Эрсдэлийн Удирдлагын Алба. Эрсдэлийн удирдлагын алба ("ЭУА") нь гадаад валютын улсын нөөцтэй холбоотой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, бусад эрсдэлтэй холбоотой үйл ажиллагаанд хараат бус хяналт тавих үүрэгтэй. Мөн гадаад валютын нөөцийн удирдлага, эрсдэлийн бодлого боловсруулах, бенчмаркийн биелэлтийг хангуулах, лимитийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг эрхэлдэг. Мөн түүнчлэн ЭУА гадаад валютын улсын нөөцийн эрсдэл, бүртгэлийн системтэй холбоотой эрсдэлийн арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлэх үүрэгтэй.

Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын журамд зааснаар, нөөцийн удирдлагын үндсэн зорилго нь төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, төгрөгийн ханшийг тогтвортой байлгах, төлбөрийн тэнцлийн алдагдлыг хямралын үед санхүүжүүлэх, богино хугацаат гадаад өр төлбөрийг барагдуулахад шаардлагатай зохих хэмжээний гадаад валютын нөөцийг бүрэлдүүлэн бэлэн байлгахад оршино. Гадаад валютын улсын нөөцийн гол зорилго нь:

- Мөнгөний бодлогыг дэмжих
- Зах зээлийн валютын ханшийн хэт хэлбэлзлийг зохицуулах
- Засгийн газрын гадаад валютын өр төлбөрт баталгаа гаргах
- Улс орны хэмжээнд тохиолдсон гамшиг болон онцгой байдлын үед мөнгөний эх үүсвэр болгон хэрэглэгдэх зэрэг болно.

Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийг бодлоготойгоор удирдаж, хянах нь гадаад валютын нөөцийн эрсдэлийн удирдлагын дээрх зорилгод дэмжлэг болно. Гадаад эрсдэлийг хянах зорилгоор Банк нь гадаад активыг сонгох, хуваарилах стратегийг тодорхойлдог. Үүнд нөөцийг байршуулах чөлөөтэй хөрвөх валютыг сонгох, валютуудын бэлэн байлгах хэмжээ, ямар бүтэцтэй байлгах, хөрвөх чадварын болон аюулгүй байлгах шаардлагуудад нийцүүлж хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийг ямар түвшинд барих, хүүгийн эрсдэлийг хянахын тулд хэрэгслүүдийн хугацаа ямар байх ёстой гэх мэт параметрүүдийг тогтоох зэрэг багтдаг.

Зах зээлийн газар. Зах зээлийн газар нь хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүнд: хөрөнгийн багцын бүтэц буюу хөрөнгийн бүрдэл хэсэг, хэрэгслүүд, харилцагч талууд, дуусгавар хугацаа, гадаад валютын нөөцийн хязгаарлалт зэргийг удирдах, хянах үүрэг хамаарна..

Дотоод аудит. Банк нь зорилгодоо хүрэх, бодлого, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд Банкны үйл ажиллагаа дахь эрсдэлийн удирдлагын тогтолцоо зохистой, үр ашигтай эсэхийг шалгах,үнэлэх нь Дотоод аудитын газар (ДАГ)-ын эрхэм зорилго юм. Банкны мөрдөж буй бодлого, холбогдох горимуудын төлөвлөлт болон зохион байгуулалт, зохицуулалт, хэрэгжилттэй холбоотой үйл ажиллагааны, эрсдэлийн удирдлагад хяналт тавих санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийн бүрэн санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийн иж бүрэн байдал, аюлгүй байдлыг хангах зэрэг үйл ажиллагаануд , аюлгүй байдлыг хангах зэрэг үйл ажиллагаануд нь холбогдох хууль, журамд нийцэж буй эсэхийг шалгах үүрэг бүхий нэгж болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

ДАГ нь эрсдэлийн ерөнхий болон тусгайлсан үнэлгээг хийдэг. Эрсдэлийн зэрэгт нь тааруулан дотоод боловсон хүчний нөөцийг зохистой хуваарилах үүднээс урт хугацааны болон жилийн төлөвлөгөөг боловсруулах ба эрсдэлийн ерөнхий үнэлгээг тодорхойлж гүйцэтгэдэг бол эрсдэлийн тусгайлсан үнэлгээг тодорхой нэг асуудал үүссэн цаг тухай бүр хийдэг. ДАГ нь Банкны 2016 оны хяналт, шалгалтын ажлын хөтөлбөр, жилийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд үйл ажиллагааны хэсэг нэг бүрийн болзошгүй болон бодит эрсдэлийн зэргийг тусган харуулж чадах шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж хяналт шалгалтын ажлын дэс дараалыг тогтоосон байна. Энэ зорилгын үүднээс тодорхой зарим нэг шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулдаг ба шалгах гэж буй үйл ажиллагаанаас хамааран шалгуур үзүүлэлтийн төрөл нэг бүр дээр зохих жигнээсэн оноог гаргана. Үйл ажиллагааны хэсэг нэг бүр дээр жинлэсэн онооны нийт дүнг гаргаж, тэдгээрийг эрсдэлийн зэргээр нь өндөр, дунд, бага гэж ангилна.

Дотоод хяналтын системийг үнэлэх ажил нь дотоод аудитын ажлын маш чухал хэсэг юм. Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь зохистой горимууд, чадварлаг гүйцэтгэл байгаа эсэхийг баталгаажуулах түүнчлэн санхүүгийн тайлагналын системийн найдвартай байдал, бүх үйл ажиллагаануудын хууль журмын нийцлийг баталгаажуулах явдал юм. ДАГ нь хяналтын дүгнэлт болон өөрсдийн зөвлөмжүүдийг Ерөнхийлөгч болон Хяналтын зөвлөлд тайлагнадаг. Шалгалт бүрийн эцэст ДАГ Банкны удирдлагуудтай шалгалтын үр дүнг хэлэлцэж, удирдлагын авч хэрэгжүүлсэн арга хэмжээг эргэн хянадаг.

Зээлийн Эрсдэл. Зээлийн эрсдэл нь гэрээ байгуулсан хэрэглэгч, үйлчлүүлэгч, гуравдагч талууд үүргээ биелүүлж чадахгүйд хүрснээс үүдэн алдагдал хүлээж болох нэг төрлийн эрсдэл юм. Санхүүгийн хөрөнгөө нэмэгдүүлэх зорилгоор гуравдагч талуудтай хийсэн ажил гүйлгээ болон банкны зээл олголтоос үүдэн зээлийн эрсдэл бий болдог. Зээлийн эрсдэлийг удирдахдаа хөрөнгө оруулалт хийх хөрөнгөө зөв сонгох, нэг төрлийн хөрөнгөнд хийх хөрөнгө оруулалтын хэмжээнд хязгаар тогтоох арга замаар удирддаг. Хөрөнгө оруулалтын төрөл, гуравдагч талуудаас хамааралтай үүдэх зээлийн эрсдэлийн түвшний хязгаарыг удирдлагаас ойр ойрхон тогтоож жил тутам тогтмол хяналт тавьдаг.

Банк санхүүгийн хөрөнгийн зээлжих чанарыг олон улсын үнэлгээний байгууллагаас тогтоосон жишигт тулгуурладаг бол тухайн гадны байгууллагад (жишээ нь Төв банк) тусгайлан тогтоосон зээлдэгчийн зэрэглэл байхгүй тохиолдолд тухайн орны зэрэглэлийг ашиглана. Банк нь хэрвээ олон улсын зах зээлийн байдал тогтворгүй байвал системийн эрсдэлд орохоос зайлсхийж тухайн байгууллагуудын үнэлгээг үл харгалзан үйл ажиллагаагаа зогсоох шаардлагатай.

Зээлийн эрсдэлийг бууруулахын тулд гадаад валютын нөөцийг Ааа-с Аа3 болон Ааа зэрэглэлтэй Засгийн газар (эсвэл Төв банк)–ын болон олон улсын байгууллагуудын үнэт цаасанд хөрөнгө оруулдаг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хадгаламж болон мөнгөний зах зээлийн хэрэгслүүдэд учрах зээлийн эрсдэл нь олон улсын үнэлгээний байгууллагуудаас А3 болон түүнээс дээш зэрэглэл авсан харилцагчидтай ажил гүйлгээ явуулах замаар хязгаарлагдаж байна. Хэрэв харилцагч нь нэгээс дээш үнэлгээний байгууллагаас үнэлгээ (рейтинг) авсан бол хамгийн бага үнэлгээнд нь үндэслэдэг.

Дотоодын мөнгөний бодлогын үйл ажиллагааны хувьд Банк зээлийн эрсдэлээ бууруулахын тулд барьцаа хөрөнгийг түлхүү хэрэглэдэг. Төв банкнаас санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгийн жагсаалтад заасан үндсэн төрлийн барьцаа хөрөнгүүдийг дор дурдав:

1. Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)
2. Богино хугацаат Засгийн газрын үнэт цаас
3. Банкны хүлээн зөвшөөрсөн санхүүгийн байгууллагуудын өрийн бичгүүд
4. Санхүүгийн байгууллагуудын гаргасан зээл

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүх зээлдэгч банкууд хангах үүрэгтэй ба хэрэв дотоодын зээлдэгч банкууд энэхүү харьцаануудаас нэгийг биелүүлээгүй тохиолдолд Банк тухайн банкинд олгох буюу олгосон зээлийн үйл ажиллагааг цуцалдаг. Банк болзошгүй алдагдлаас хамгаалах зорилгоор барьцаа хөрөнгийн үнэлгээнд эрсдэлийн хямдруулалт хийдэг.

Монголын томоохон банкууд нь олон улсын үнэлгээний байгууллагуудаар зэрэглэлээ тогтоолгодог учир дотоодын банкуудад байршуулсан санхүүгийн хөрөнгийг энэхүү үнэлгээн дээр тулгуурлан хянана. Үнэлэгдээгүй банкуудын хувьд, Банк тэдгээр банкуудын сүүлийн үеийн санхүүгийн мэдээлэл, Банкны Хяналт шалгалтын газраас гаргаж буй санхүүгийн харьцааны шинжилгээ болон хамааралтай хөрөнгийн зээлийн эрсдэлийг үнэлэхэд хэрэглэдэг мэдээлэл болон бусад мэдээлэлд тулгуурлан дүгнэлт гаргадаг. Одоогоор Банк нь өөрийн боловсруулсан зээлийн үнэлгээний системийг банкуудад байршуулсан санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэлийг үнэлэхдээ ашиглаагүй байна.

Цаашилбал, ГВУН-ийн хувьд бүх харилцагчдад зээлийн хязгаар тогтоосон бөгөөд энэ нь зээлдэгчийн зэрэглэл, хөрөнгө, бусад хүчин зүйлд үндэслэнэ. Хөрөнгө оруулалтын хороог хасаж, Монголбанкны Ерөнхийлөгч нь зээлийн хязгаарыг улирал бүр тогтоох бөгөөд зээл нь тухайн хязгаартаа байгаа эсэхийг Эрсдэлийн удирдлагын алба өдөр тутам хянана.

Банк өөрийн зээлийн эрсдэлийг хянахын тулд санхүүгийн хөрөнгийнхөө, ялангуяа банкуудад олгосон зээл болон бусад санхүүгийн хөрөнгө (Тодруулга 8 болон 13) -ийн насжилтын шинжилгээг хийж зээлээ эргэн төлөх чадвар нь муудаж буй харилцагчдын талаарх мэдээллийг Захирлуудын Зөвлөлд танилцуулах бөгөөдтус хурал дээр хэлэлцэн үзэж, холбогдох шийдвэрийг гаргана.

Тодруулга 32-д толилуулснаар Банк нь тодорхой хэмжээний зээлтэй холбоотой үүрэг хариуцлага хүлээсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газар эсвэл тэдгээрийн харьяа байгууллагуудын хүсэлтээр Монгол улсын хувьд чухал ач холбогдол бүхий (бараа, үйлчилгээ экспортлох гэх мэт) зээлийн үүрэг хүлээдэг. Энэхүү хэрэгслийн гол зорилго нь Засгийн газарт болон бусад төрийн байгууллагуудад санхүүжилтийн хөрөнгийг хангалттай байлгахад оршино. Нээсэн аккредитивүүд нь Банк өмнөөс нь төлбөрийг нь барагдуулах зайлшгүй үүрэг хүлээснийг илэрхийлдэг ба эдгээр хэрэгслийн эрсдэл нь зээлийн эрсдэлтэй ижил юм. Энэ төрлийн эрсдэлийг зээлтэй ижил аргаар бууруулж болно. Зээлтэй холбоотой үүрэг нь Хятадын Ардын банктай хийсэн гэрээтэй холбоотой (Тодруулга 31) ба ашиглаагүй хэмжээгээр эрсдэл тодорхойлогдоно. Хийсэн шинжилгээндээ үндэслэн Банкны удирдлага нь энэ төрлийн харилцагчаас үүдэлтэй зээлийн эрсдэлд орох магадлал нь бага хэмээн дүгнэжээ.

Банк зээлийн эрсдэлд өртөх хамгийн их магадлал нь санхүүгийн байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн бүртгэлээрх дүнд нөлөөлдөг. Зээлийн эрсдэл нь Тодруулга 9-д үзүүлсний дагуу барьцаа хөрөнгөөр багасч болно. Аккредитивууд болон своп хэлэлцээрийн ашиглах хэмжээг нэмэх хүсэлтээс үүдэх үүргийн хувьд зээлийн эрсдэлийн дээд хэмжээ нь энэхүү үүрэг, хариуцлагын дүнгээр илэрхийлэгдэнэ. (Тодруулга 31).

Зах зээлийн эрсдэл. Зах зээлийн эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн орж ирэх мөнгөн урсгалын дүн нь зах зээлийн хувьсагчууд болох хүү болон валютын хөрвүүлгээс шалтгаалан хэлбэлзэх эрсдэлийг хэлнэ. Зах зээлийн болон эргэн төлөгдөх чадварын эрсдэлийг тодорхойлохдоо удирдлагын гол анхаардаг зүйлийн нэг нь гадаадын байгууллагуудад төлөх өр төлбөр болон импортын бүтцэд зөрүүг тодорхойлох явдал юм. Банк энэхүү эрсдэлийг мэдрэмтгий байдлын шинжилгээг ашиглан удирдаж хянадаг. Гадаад валютын төвлөрлийг эс тооцвол Банкинд зах зээлтэй холбоотой өөр ноцтой зах зээлийн эрсдэл байхгүй байна. Одоогоор Банк нь үнийн бусад эрсдэлд онцгой байдлаар өртөөгүй болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Ханшийн эрсдэл. Ханшийн эрсдэл нь санхүүгийн хэрэгслийн үнэ цэнэ нь валютын ханшны хэлбэлзлээс үүдэн өөрчлөгдөж байх эрсдэлийг хэлнэ. Ханшийн эрсдэлийг гадаад валютын багцыг төрөлжүүлэх замаар удирдаж болох ба дараах параметрүүдээр тодорхойлно:

- Гадаад валютын нөөцийн удирдлага;
- Гадаад валютын нөөц болон урт ба богино хугацаат хөрөнгө оруулалтын багцуудыг гадаад валютаарх холбогдох хөрөнгүүдийн валютуудын хамгийн их байх хэмжээ

Гадаад валютын нөөцийг бүрдүүлэх валютын бүтцийг Захирлуудын зөвлөлөөс жил бүр баталдаг.

Доорх хүснэгт нь 2016 оны 12 дугаар сарын 31-нээр Банкны мөнгөн хөрөнгө, өр төлбөрийг ханшийн эрсдэлд мэдэгдэхүйц оруулж буй валют болон ЗТЭ-ийг харуулж байна

Сая төгрөгөөр	Монгол төгрөг	Ам.доллар	Юань	Евро	ЗТЭ	Бусад	Нийт
Бэлэн мөнгө	46	35,172	26	1,418	-	2,291	**38,953**
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	-	701,493	266,154	210,228	143,110	134,532	**1,455,517**
Дотоодын банкуудад олгосон зээл	1,080,675	879	-	5,012	-	-	**1,086,566**
Санхүүгийн хөрөнгө оруулалт - борлуулахад бэлэн	1,953,242	729,946	-	-	-	-	**2,683,188**
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	204,331	845,195	-	-	-	-	**1,049,526**
Алт ба үнэт метал	-	-	-	-	-	160,051	**160,051**
Засгийн газрын үнэт цаас	326,508	-	-	-	-	-	**326,508**
Бусад санхүүгийн хөрөнгө	692,993	-	-	-	-	-	**692,993)**
Нийт санхүүгийн хөрөнгө	**4,257,795**	**2,312,685**	**266,180**	**216,658**	**143,110**	**296,874**	**7,493,302**
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(823,629)	-	-	-	-	-	**(823,629)**
Төв банкны үнэт цаас	(577,297)	-	-	-	-	-	**(577,297)**
Засгийн газрын хөрөнгө	(680,813)	(284,626)	(13,460)	(17,002)	(9,334)	(3,089)	**(1,008,324)**
Дотоодын хөрөнгө	(943,882)	(1,458,116)	(105,101)	(81,575)	-	(82,892)	**(2,671,566)**
Гадаад өр төлбөр	(503)	(156)	(4,332,068)	-	(162,609)	-	**(4,495,336)**
Бусад санхүүгийн өр төлбөр	(42,634)	-	-	-	-	-	**(42,634)**
Нийт санхүүгийн өр төлбөр	**(3,068,758)**	**(1,742,898)**	**(4,450,629)**	**(98,577)**	**(171,943)**	**(85,981)**	**(9,618,786)**
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	2,310,023	(3,382,203)	143,140	-	-	-	**-**
Цэвэр позиц	**3,499,060**	**(2,812,416)**	**(4,041,309)**	**118,081**	**(28,833)**	**210,893**	**(3,054,524)**

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгт нь 2015 оны 12 дугаар сарын 31-нээр Банкны мөнгөн хөрөнгө, өр төлбөрийг ханшийн эрсдэлд мэдэгдэхүйц оруулж буй валют болон ЗТЭ-ийг харуулж байна

Сая төгрөгөөр	Монгол төгрөг	Ам.доллар	Юань	Евро	ЗТЭ	Бусад	Нийт
Бэлэн мөнгө	52	52,686	60	561	-	434	**53,793**
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	-	161,864	119,029	161,241	118,988	523,941	**1,085,063**
Дотоодын банкуудад олгосон зээл	1,178,248	752	-	6,520	-	-	**1,185,520**
Санхүүгийн хөрөнгө оруулалт - борлуулахад бэлэн	1,925,259	522,588	-	-	-	-	**2,447,847**
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	400,035	927,986	-	-	-	-	**1,328,021**
Алт ба үнэт метал	-	-	-	-	-	153,440	**153,440**
Засгийн газрын үнэт цаас	202,218	-	-	-	-	-	**202,218**
Бусад санхүүгийн хөрөнгө	404,043	-	-	-	-	-	**404,043**
Нийт санхүүгийн хөрөнгө	**4,109,855**	**1,665,876**	**119,089**	**168,322**	**118,988**	**677,815**	**6,859,945**
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(706,656)	-	-	-	-	-	**(706,656)**
Төв банкны үнэт цаас	(1,024,581)	-	-	-	-	-	**(1,024,581)**
Засгийн газрын хөрөнгө	(350,907)	(328,397)	-	(14,744)	(8,082)	(326)	**(702,456)**
Банкуудын хөрөнгө	(1,225,029)	(352,327)	(37,828)	(135,136)	-	(68,665)	**(1,818,985)**
Гадаад өр төлбөр	(153)	(239,679)	(3,550,766)	-	(135,179)	-	**(3,925,777)**
Бусад санхүүгийн өр төлбөр	(21,699)	-	-	-	-	-	**(21,699)**
Нийт санхүүгийн өртөлбөр	**(3,329,025)**	**(920,403)**	**(3,588,594)**	**(149,880)**	**(143,261)**	**(68,991)**	**(8,200,154)**
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	1,671,665	(2,028,992)	92,268	-	-	-	**(265,059)**
Цэвэр позиц	**2,452,495**	**(1,283,519)**	**(3,377,237)**	**18,442**	**(24,273)**	**608,824**	**(1,605,268)**

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дараах хүснэгтэнд тайлант хугацааны эцэст гадаад валютын болон ЗТЭ-ын ханшийн харьцангуй боломжит өөрчлөлтөд ашиг, алдагдал болон өөрийн хөрөнгийн үзүүлэх мэдрэмтгий байдлыг харуулсан. Хүснэгт дэх сөрөг утгатай дүнгүүд нь ашиг, алдагдал дахь болзошгүй цэвэр бууралтыг илэрхийлэх ба эерэг утгатай дүнгүүд нь боломжит цэвэр өсөлтийг илэрхийлнэ.

Эрсдэлийн нөлөөний хэмжээ нь Банкны үндсэн үйл ажиллагааны мөнгөн нэгж (төгрөг) болон ЗТЭ-д хамаарагдах мөнгөн нэгжээс бусад валютын хувьд тооцоологдсон болно.

Хүүгийн түвшний эрсдэл. Хүүгийн түвшины хэлбэлзлээс ирээдүйд орж ирэх мөнгөн урсгал эсвэл санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ өөрчлөгдөх эрсдэлийг болно. Хүүгийн түвшний эрсдэлийг удирдах гол зорилго нь хөрөнгө оруулалт тус бүрээс эрсдэлийн хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд тогтвортой үр ашиг хүртэх явдал юм.

Сая төгрөгөөр	**2016.12.31-нээрх Ашиг/ алдагдал болон өөрийн хөрөнгө дэх нөлөө**	**2015.12.31-нээрх Ашиг/ алдагдал дахь нөлөө**
Ам.доллар 25 хувиар чангарахад (2015: 15%)	(703,104)	(192,528)
Ам.доллар 25 хувиар сулрахад (2015: 15%)	703,104	192,528
Юань 25 хувиар чангарахад (2015: 15%)	(1,010,327)	(506,586)
Юань 25 хувиар сулрахад (2015: 15%)	1,010,327	506,586
Евро 25 хувиар чангарахад (2015: 15%)	29,520	2,766
Евро 25 хувиар сулрахад (2015: 15%)	(29,520)	(2,766)
ЗТЭ 25 хувиар чангарахад (2015: 15%)	(7,208)	(3,641)
ЗТЭ 25 хувиар сулрахад (2015: 15%)	7,208	3,641
Бусад валют 25 хувиар чангарахад (2015: 15%)	52,723	91,324
Бусад валют 25 хувиар сулрахад (2015: 15%)	(52,723)	(91,324)

Банкны хөрөнгө болон өр төлбөрийн ихэнх хувь нь тогтмол хүүгийн түвшинтэй эсвэл хүүгүй байгаа нь хүүгийн түвшний эрсдэлийг ихээхэн хэмжээгээр буруулдаг. Стратегийн харьцуулсан үзүүлэлтийг тодорхойлох явцдаа, хүүгийн түвшингийн эрсдэлийг багасгах зорилгоор Банк гадаад валютын нөөцийн багцдаа хугацааг нь зааж өгдөг. Энэхүү хугацааны хэрэгжилтийг өдөр бүр хянадаг. Хөрөнгө оруулалтын хугацаа нь хөндлөн шинжилгээний (investment horizon) аргаар тодорхойлогдоно. Хөрөнгө оруулалтын хугацааг 1 жилээр, хамгийн бага үр өгөөжийн түвшинг сөрөг үр өгөөжөөр (1 жилийн хугацаанд үр өгөөжийн өөрчлөлт сөрөг бол), сөрөг үр өгөөжийн хүлээн зөвшөөрөх боломж 5 хувиас ихгүй байхаар өөрийн эрсдэлийн түвшинг тодорхойлж, ирээдүйн өгөөжийг таамаглах аргаар зохистой хугацааг тооцдог.

Дараах хүснэгтэд Банкны хүүгийн түвшний эрсдэлийн байдлыг харуулжээ. Энэ хүснэгтэд Банкны санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг дансны үлдэгдэл дүнгээр, мөн гэрээнд заасан хүүгийн түвшин өөрчлөгдсөн буюу зээлийн хугацаа дуусгавар болсон өдрүүдийн аль түрүүнд болсноор ангилан үзүүлсэн байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Сая төгрөгөөр	Хугацаагүй ба 1 сараас бага	1-6 сар	6-12 сар	12 сараас дээш	Нийт хүүтэй	Хүүгийн мэдрэмтгий байдалгүй	Нийт
2016.12.31-нээрх							
Нийт санхүүгийн хөрөнгө	2,725,121	460,789	753,928	3,514,985	**7,454,823**	48,892	**7,503,715**
Нийт санхүүгийн өр төлбөр	(4,240,025)	(4,463,879)	(34,639)	(749,433)	**(9,487,976)**	(1,070,263)	**(10,558,239)**
2016.12.31-нээрх цэвэр хүүгийн мэдрэмтгий байдлын зааг	**(1,514,904)**	**(4,003,090)**	**719,289**	**2,765,552**	**(2,033,153)**	**(1,021,371)**	**(3,054,524)**
2015.12.31-нээрх							
Нийт санхүүгийн хөрөнгө	1,556,770	210,851	185,558	3,412,187	**5,365,366**	1,502,474	**6,867,840**
Нийт санхүүгийн өр төлбөр	(1,982,679)	(3,555,636)	(302,985)	(312,151)	**(6,153,451)**	(2,319,657)	**(8,473,108)**
2015.12.31-нээрх цэвэр хүүгийн мэдрэмтгий байдлын зааг	**(425,909)**	**(3,344,785)**	**(117,427)**	**3,100,036**	**(788,085)**	**(817,183)**	**(1,605,268)**

Доорх хөрөнгө болон өр төлбөрийн хувь хувьсах хүүгээр хуримтлагдсан хүү бодогддог: ЗТЭ (Тодруулга 8), ЗТЭ-ийн хуваарилалт, банк болон Хятадын Ардын банкнаас авсан зээлүүд (Тодруулга 21). Хэрэв 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бусад бүх хувьсагчийн хувьд тогтмол хүүгийн түвшин 200 суурь нэгжээр доогуур байвал тухайн жилийн алдагдлын хэмжээ (Хятадын ардын банкнаас авсан хувьсагч хүүтэй зээлийн хүүгийн өр төлбөр бага байсны үр дүнд) 10,166 сая төгрөг (2015 онд 3,940 сая төгрөг) -өөр бага байх байсан. Хэрэв хүүгийн түвшин бусад бүх хувьсагчийн хувьд тогтмол боловч 200 суурь нэгжээр илүү байвал хувьсагч хүүтэй зээлийн хүүгийн өр төлбөр их байсны үр дүнд тухайн жилийн алдагдлын хэмжээ 10,166 сая төгрөг (2015 онд 3,940 сая төгрөг) -өөр илүү байх байсан.

Банкны актив хөрөнгө болон өр төлбөрийн дийлэнх хэсэг нь тогтмол хүүтэй эсвэл хүүгүй бөгөөд Банк нь хувьсагч хүүтэй материаллаг актив хөрөнгө болон өр төлбөр байхгүй тул удирдлага 2016 оны хүүгийн түвшний эрсдэлийн нөлөөлөл их биш гэж Банкны удирдлагууд үзсэн. Банк өөрийн санхүүгийн хэрэгслийн хүүгийн түвшинг хянаж байдаг. Доорх хүснэгтэнд харгалзах тайлант өдрөөрх хүүгийн түвшинг удирдлагын тайланд үндэслэн нэгтгэсэн. Хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цааснуудын хувьд хүүгийн түвшин нь тайлант өдрийн байдлаар дуусгавар өдөр хүртэлх хугацааны өгөөжийг зах зээл дээрх түвшинг илэрхийлнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

	2016					2015			
Жилийн хүү	**Төгрөг**	**Ам. доллар**	**Евро**	**Юань**	**Бусад**	**Төгрөг**	**Ам. доллар**	**Евро**	**Бусад**
Хөрөнгө									
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	0.0%	0.20%	0.0%	0.0%	0.07%	0.0%	0.16%	0.33%	0.56%
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт	-	1.18%	-	-	0.0%	-	0.28%	-	-
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	-	0.17%	-	-	-	-	0.12%	-	-
Засгийн газрын үнэт цаас	8.97%	-	-	-	-	8.97%	-	-	-
Дотоодын банкуудад олгосон зээл	6.31%	3.98%	1.25%	-	-	16.20%	5.50%	1.25%	-
Өр төлбөр									
Төв банкны үнэт цаас	15.00%	-	-	-	-	12.25%	-	-	-
Засгийн газрын хөрөнгө	0.0%	4.79%	0.75%	-	1.28%	0.0%	3.00%	0.75%	1.28%
Гадаад өр төлбөр	0.0%	0.0%	0.0%	6.04%	1.35%	0.0%	0.0%	0.0%	1.35%

Хүснэгт дэх “-“ тэмдэг нь Банк харгалзах валютаар, харгалзах хөрөнгө, өр төлбөргүйг илтгэнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Газар зүйн эрсдэлийн төвлөрөл. 2016 оны 12 дугаар сарын 31, 2015 оны 12 дугаар сарын 31-нээрх Банкны санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн газар зүйн төвлөрлийг доорх хүснэгтээр харуулав:

Сая төгрөгөөр	Монгол	ЭЗХАБ-ын орнууд	ОУВС	ЭЗХАБ-ын бус орнууд	Нийт
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	38,953	-	-	-	38,953
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламж	-	1,036,561	-	418,956	1,455,517
Дотоодын банкуудад олгосон зээл	1,086,566	-	-	-	1,086,566
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт	1,953,242	729,946	-	-	2,683,188
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	204,331	845,195	-	-	1,049,526
Алт ба үнэт металл	-	160,051	-	-	160,051
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	10,413	-	-	-	10,413
Засгийн газрын үнэт цаас	326,508	-	-	-	326,508
Бусад санхүүгийн хөрөнгө	692,993	-	-	-	692,993
Нийт санхүүгийн хөрөнгө	**4,313,006**	**2,771,753**	**-**	**418,956**	**7,503,715**
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(823,629)	-	-	-	(823,629)
Төв банкны үнэт цаас	(577,297)	-	-	-	(577,297)
Засгийн газрын хөрөнгө	(1,008,324)	-	-	-	(1,008,324)
Банкуудын хөрөнгө	(2,671,566)	-	-	-	(2,671,566)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	(939,453)	-	-	-	(939,453)
Гадаад өр төлбөр	-	(659)	(162,609)	(4,332,068)	(4,495,336)
Бусад санхүүгийн өр төлбөр	(42,634)	-	-	-	(42,634)
Нийт санхүүгийн өр төлбөр	**(6,062,903)**	**(659)**	**(162,609)**	**(4,332,068)**	**(10,558,239)**
2016.12.31-нээрх цэвэр позиц	**(1,749,897)**	**2,771,094**	**(162,609)**	**(3,913,112)**	**(3,054,524)**
Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг (Тодруулга31)	**(281,016)**	**-**	**-**	**(4,500,000)**	**(4,781,016)**

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банкны санхүүгийн хөрөнгө өр төлбөрийн 2015 оны 12 дугаар сарын 31-нээрх газар зүйн төвлөрөл:

Сая төгрөгөөр	Монгол	ЭЗХАБ-ын орнууд	ОУВС	ЭЗХАБ-ын бус орнууд	Нийт
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	53,793	-	-	-	53,793
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламж	-	845,580	118,988	120,495	1,085,063
Дотоодын банкуудад олгосон зээл	1,185,520	-	-	-	1,185,520
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт	500,887	522,588	-	-	2,447,847
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	500,887	827,134	-	-	1,328,021
Алт ба үнэт метал	-	153,440	-	-	153,440
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	7,271	624	-	-	7,895
Засгийн газрын үнэт цаас	202,218	-	-	-	202,218
Бусад санхүүгийн хөрөнгө	404,043	-	-	-	404,043
Нийт санхүүгийн хөрөнгө	**4,278,991**	**2,349,366**	**118,988**	**120,495**	**6,867,840**
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(706,656)	-	-	-	(706,656)
Төв банкны үнэт цаас	(1,024,581)	-	-	-	(1,024,581)
Засгийн газрын хөрөнгө	(702,456)	-	-	-	(702,456)
Банкуудын хөрөнгө	(1,818,985)	-	-	-	(1,818,985)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	(272,954)		-		(272,954)
Гадаад өр төлбөр	(21,699)	-	(135,180)	(3,790,597)	(3,925,777)
Бусад санхүүгийн өр төлбөр		-	-	-	(21,699)
Нийт санхүүгийн өр төлбөр	**(4,547,331)**	**-**	**(135,180)**	**(3,790,597)**	**(8,473,108)**
2015.12.31-нээрх цэвэр позиц	**(268,340)**	**2,349,366**	**(16,192)**	**(3,670,102)**	**(1,605,268)**
Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг (Тодруулга 31)	**(411,390)**	**-**	**-**	**(4,500,000)**	**(4,918,659)**

Бусад эрсдэлийн төвлөрөл Банкны удирдлага дээр дурдсан харилцагчдын хязгаар бүрт зээлдэгчдийн талаарх тайлан мэдээллийг авах замаар зээлийн эрсдэлийн төвлөрлийг судалж, хяналт тавьдаг. 2015 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банкинд ийм төрлийн томоохон эрсдэлийн төвлөрөл байхгүй байна.

Төлбөрийн чадварын эрсдэл Санхүүгийн хэвийн болон хүнд нөхцөл байдалд өөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй байх эрсдэлийг төлбөрийн чадварын эрсдэл гэнэ. Гадаад валютын хөрвөх чадварын эрсдэл нь Банкинд учирдаг хамгийн гол эрсдэлүүдийн нэг юм. Импортоос ихээхэн хамааралтай, Засгийн газрын гадаад өрийг байнга төлж байх шаардлагатай, дотоодын зах зээл дээрх валютын эрэлт, нийлүүлэлт байнга хэлбэлзэж байдаг нөхцөл байдлын үед төлбөрийн чадвар нь гадаад валютын нөөцийн удирдлагын авч үзэх ёстой чухал асуудал юм.Төлбөрийн чадварыг удирдахын тулд Банк гадаад валютын нөөцийн багцыг хоёр дэд багцад хуваадаг. Үүнд:

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

- Богино хугацаат хөрөнгө оруулалтын багц (бэлэн мөнгөний удирдлага эсвэл төлбөрийн чадварын багц орно): Энэ багцыг зээлийн өр төлөх, валютын зах зээлийн үйл ажиллагааг тогтвортой болгох зорилгоор ашигладаг. Уг багцбэлэн мөнгө, овернайт ба хугацаагүй хадгаламжаас бүрдэнэ. Энэхүү багц нь мөн хугацаат хадгаламжид,өндөр төлбөрийн чадвар (эргэн төлөгдөх чадвар) бүхий мөнгөний зах зээлийн хэрэгсэлд долоо хоногоос 12 сар хүртэлх дуусах хугацаа бүхий үнэт цаасанд болон мөнгөжсөн алтанд хөрөнгө оруулалт болон хийгддэг байна.
- Урт хугацаат хөрөнгө оруулалтын багц: Энэ багц нь дунд хугацааны, өндөр төлбөрийн чадвар бүхий Засгийн газрын бонд, үнэт цаас зэрэг санхүүгийн үүсмэл хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийдэг байна.Хөрөнгө оруулалтын хороо гадаад валютын багцын хязгаарыг санал болгодог. Төлбөрийн чадварын эрсдэлийг бууруулахын тулд Төрийн гадаад валютын нөөцийн удирдлагын журмын дагуу дараах хөрөнгийн бүтцийг дагаж мөрддөг:
- Нийт хөрөнгийн тогтоосон хязгаарын тодорхой хувиас багагүй хэсгийг богино хугацаат (1 жил хүртлэх) хөрөнгө болгон харилцах данс болон валютаар илэрхийлэгдсэн бэлэн мөнгө хэлбэрээр байршуулах;
- Нийт хөрөнгийн тогтоосон хязгаарын тодорхой хувиас багагүй хэсгийг богино хугацаат (1 жил хүртлэх) хөрөнгө болгон 6 сар хүртэлх хугацаатай хадгаламжийн хэлбэрээр байршуулах.

Гадаад арилжааны алдагдлын хязгаар 400,000 ам.доллар, арилжааны нэгжийн хязгаар 100,000 ам.доллар байх бөгөөд нэг удаагийн арилжааны хязгаар 50,000 ам.доллар байна.

Дараах хүснэгтэд 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг гэрээнд заасан дуусах хугацаагаар нь харуулсан. Дуусгавар хугацааны тайланд тусгасан дүнгүүд нь санхүүгийн түрээсийн баталгаа (ирээдүйн санхүүгийн төлбөрийг хасахаас өмнөх), нийт зээлийн үүрэг, нийт санхүүгийн түрээсийн үүрэг зэргийг хамруулж гэрээнд заасан, хямдруулаагүй мөнгөн гүйлгээ болно. Санхүүгийн байдлын тайланд дүнгүүд нь хямдруулсан мөнгөн гүйлгээн дээр үндэслэсэн байх тул хямдруулаагүй мөнгөн гүйлгээ нь тайланд тусгасан дүнгээс зөрүүтэй байна. Дуусах хугацааны шинжилгээний зорилгоор үүсмэл санхүүгийн хөрөнгийг холимог санхүүгийн хэрэгслүүдээс салгахгүй.

Аккредитивийг дэмжихэд шаардагдах төлбөрийн чадварын хэмжээ нь дуусах хугацааны шинжилгээнд харуулсан өр төлбөрийн хариуцлагын хэмжээнээс бага юм. Учир нь Банк гуравдагч талыг эдгээр гэрээн дээр үндэслэн хөрөнгө татна гэж үздэггүй байна. Доорх дуусгавар хугацааны шинжилгээний хүснэгт дэх одоогийн нийт гэрээнд үндэслэсэн өр төлбөрийн хэмжээ нь ирээдүйд шаардлагатай мөнгөний хэмжээг илэрхийлэхгүй. Учир нь ихэнх энэ төрлийн гэрээт өр төлбөр нь ямар нэгэн санхүүжилтгүйгээр хугацаа нь дуусах буюу цуцлагддаг.

Өр төлбөрийн дүн тодорхой заагаагүй тохиолдолд тодруулсан дүнг тайлант хугацааны эцсээрх нөхцөл байдлын үндсэн дээр тодорхойлно. Гадаад валютаар хийсэн төлбөрийг тайлант хугацааны эцсийн спот ханшаар шилжүүлэн тооцно.

Санхүүгийн хэрэгслийн дуусгавар хугацааны шинжилгээг 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доорх хүснэгтэд харуулав:

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Сая төгрөөр	**Хугацаагүй ба 1 сараас бага**	**1-6 сар**	**6-12 сар**	**12 сараас дээш**	**Нийт**
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	823,629	-	-	-	**823,629**
Төв банкны үнэт цаас	577,297	-	-	-	**577,297**
Засгийн газрын хөрөнгө	974,581	1,288	1,280	42,747	**1,019,896**
Дотоодын банкуудын хөрөнгө	2,671,628	-	-	-	**2,671,628**
Гадаад өр төлбөр	199,816	4,362,738	-	-	**4,562,554**
Бусад санхүүгийн өр төлбөр	42,634	-	-	-	**42,634**
Нийт төлөгдсөн своп болон форвард:					
- орох урсгал	461,027	507,540	134,110	1,460,259	**2,562,936**
- гарах урсгал	(530,274)	(617,105)	(168,749)	(2,175,848)	**(3,491,976)**
Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг					
ХАБ-тай байгуулсан хэлэлцээрийн ашиглагдагүй санхүүжилт	4,500,000	-	-	-	**4,500,000**
-Бусад болзошгүй өр төлбөр	281,016	-	-	-	**281,016**
Санхүүгийн үүрэг хариуцлагын хүрээнд ирээдүйн хугацаанд төлж болзошгүй өр төлбөрүүд	**10,001,354**	**4,254,461**	**(33,359)**	**(672,842)**	**13,549,614**

Санхүүгийн хэрэгслийн дуусгавар хугацааны шинжилгээг 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доорх хүснэгтэнд харуулав:

Сая төгрөөр	**Хугацаагүй ба 1 сараас бага**	**1-6 сар**	**6-12 сар**	**12 сараас дээш**	**Нийт**
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	706,656	-	-	-	706,656
Төв банкны үнэт цаас	1,026,800	-	-	-	1,026,800
Засгийн газрын хөрөнгө	671,207	1,194	1,242	39,304	712,947
Банкуудын хөрөнгө	1,758,355	-	63,105	-	1,821,460
Гадаад өр төлбөр	138,554	3,135,503	712,121	-	3,986,178
Бусад санхүүгийн өр төлбөр	21,699	-	-	-	21,699
Нийт төлөгдсөн своп болон форвард:					
- дотогш урсгал	361,340	190,175	74,000	1,492,262	2,117,777
- гадагш урсгал	(364,221)	(187,958)	(75,685)	(1,754,972)	(2,382,836)
Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг		-	-	-	
-ХАБ-тай байгуулсан хэлэлцээрийн ашиглагдаагүй санхүүжилт	4,500,000	-	-	-	4,500,000
-Бусад болзошгүй өр төлбөр	411,390	-	-	-	411,390
Санхүүгийн үүрэг хариуцлагын хүрээнд ирээдүйн хугацаанд төлж болзошгүй өр төлбөрүүд	**9,231,780**	**3,138,914**	**774,783**	**(223,406)**	**12,922,071**

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дотоодын банкуудын хадгаламж болон засгийн газрын байгууллагуудад өгөх өр төлбөрүүдийн ихэнх хэсэг нь Банкны үйл ажиллагааг санхүүжүүлэх тогтвортой эх үүсвэр болон үндсэн хадгаламжийг илэрхийлж байна. Үүнтэй адилаар Банк хэдийгээр гэрээний дагуу төлбөр хийх хугацааг хойшлуулах эрхгүй боловч гүйлгээнд байгаа бэлэн мөнгө мөн санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг илэрхийлж байна.

Банк нь хөрвөх чадварыг удирдах өр төлбөрүүдийн гэрээгээрх хямдруулаагүй дуусгавар хугацаанд суурилдаг шинжилгээг ашигладаагүй. Үүний оронд Банк санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнийн тооцоолсон дуусгавар хугацааг болон үүнээс үүдэх тооцоолсон хөрвөх чадварын заагийг хянадаг.

Санхүүгийн өр төлбөрийн тооцоолсон дуусгавар хугацаа нь банкинд байршуулсан их хэмжээний хадгаламж (ихэвчлэн төрийн байгууллагууд болон дотоодын банкуудаас байршуулсан) болон гүйлгээн дэх бэлэн мөнгөнөөс шалтгаалаад гэрээний дуусгавар хугацаанаасаа өөр байж болно. Санхүүгийн өр төлбөрийг төлөх шаардлага гарахад борлуулахад бэлэн байдаг санхүүгийн хөрөнгө нь борлуулагдахаар хүлээгдэж буй өдөртөө үндэслэн дуусгавар хугацааны шинжилгээнд хамрагдана. Үнэ цэнийн бууралттай зээл нь ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалынхаа цаг хугацаанд тулгуурлах ба үнэ цэнийн бууралтын сангийн дүнгээр дансны үнийг цэвэршүүлсэн дүнгээр багтдаг.

Санхүүгийн хэрэгслүүдийн дуусгавар хугацааны шинжилгээг 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доорх хүснэгтэд харуулав:

Сая төгрөгөөр	Хугацаагүй ба 1 сараас бага	1-6 сар	6-12 сар	12 сараас дээш	Нийт
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	38,953	-	-	-	38,953
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	1,454,397	-	-	1,120	1,455,517
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт	191,788	81,461	47,251	2,362,688	2,683,188
Буцаан худалдан авах гэрээ	896,203	-	-	153,323	1,049,526
Алт ба үнэт метал	160,051	-		-	160,051
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	1,340	8,973	-	100	10,413
Засгийн газрын үнэт цаас	1,460	-	-	325,048	326,508
Дотоодын банкуудад олгосон зээл	663	370,355	706,677	8,871	1,086,566
Бусад санхүүгийн хөрөнгө	29,158	-	-	663,835	692,993
Нийт санхүүгийн хөрөнгө	**2,774,013**	**460,789**	**753,928**	**3,514,985**	**7,503,715**
Өр төлбөр					
Бэлэн мөнгө	(823,629)	-	-	-	(823,629)
Төв банкны үнэт цаас	(577,297)	-	-	-	(577,297)
Засгийн газрын хөрөнгө	(974,580)	-	-	(33,744)	(1,008,324)
Банкуудын хөрөнгө	(2,621,745)	(49,821)	-	-	(2,671,566)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	(70,587)	(118,538)	(34,639)	(715,689)	(939,453)
Гадаад өр төлбөр	(199,816)	(4,295,520)	-	-	(4,495,336)
Бусад санхүүгийн өр төлбөр	(42,634)	-	-	-	(42,634)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Нийт санхүүгийн өр төлбөр	**(5,310,288)**	**4,463,879**	**(34,639)**	**(749,433)**	**(10,558,239)**
Хөрвөх чадварын цэвэр зөрүү	**(2,536,275)**	**(4,003,090)**	**719,289**	**2,765,552**	**(3,054,524)**

Санхүүгийн хэрэгслүүдийн дуусгавар хугацааны шинжилгээг 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харуулав:

Сая төгрөгөөр	**Хугацаагүй ба 1 сараас бага**	**1-6 сар**	**6-12 сар**	**12 сараас дээш**	**Нийт**
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	53,793	-	-	-	53,793
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	1,084,137	-	-	926	1,085,063
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт	255,033	95,492	73,856	2,023,466	2,447,847
Буцаан худалдан авах гэрээ	1,328,021	-	-	-	1,328,021
Алт ба үнэт металл	153,440	-	-	-	153,440
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	2,154	2,754	835	2,152	7,895
Засгийн газрын үнэт цаас	-	2,432	103,218	96,568	202,218
Дотоодын банкуудад олгосон зээл	175,684	110,173	7,649	892,014	1,185,520
Бусад санхүүгийн хөрөнгө	6,982	-	-	397,061	404,043
Нийт санхүүгийн хөрөнгө	**3,059,244**	**210,851**	**185,558**	**3,412,187**	**6,867,840**
Өр төлбөр					
